

12-р сар 2020

Засгийн газрын ажлын хэсэгт зориулсан тайлан

ЗГХЭГ-ЫН 2020 ОНЫ 28 ТООТ ТУШААЛААР БАЙГУУЛАГДСАН

1-Р ХЭСЭГ

НИЙГМИЙН НӨЛӨӨЛЛИЙН
ҮНЭЛГЭЭХИЙХ
АРГАЧЛАЛЫНТӨСӨЛ,
ТАНИЛЦУУЛГА

2-Р ХЭСЭГ

НИЙГМИЙН НӨЛӨӨЛЛИЙН
ҮНЭЛГЭЭНИЙ ЭРХ ЗҮЙН
ОРЧНЫ СУДАЛГААНЫ
ТАЙЛАН, ЗӨВЛӨМЖ



Economic
and Social
Research Council



Монгол Улс, Улаанбаатар хот
Их Британи, Оксфорд
2020 он

Нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх аргачлалын төсөл, танилцуулга, Нийгмийн нөлөөллийн үнэлгээний хууль эрх зүйн орчны судалгааны тайлан, зөвлөмж:
Монгол улсын Засгийн газрын ажлын хэсгийн хэрэгцээнд зориулсан тайлан

Зөвлөх багийн гишүүд

Д.Тэгшбаяр. Хуульч мэргэжилтэй, хууль зүйн шинжлэх ухааны магистр (LLM) санхүүгийн гэмт хэрэг, мөнгө угаахтай тэмцэх мэргэжилтэн. Санхүү, эдийн засгийн сургуулийн багш. Сүүлийн 5 орчим жил уул уурхай, байгаль орчны эрх зүйн чиглэлийн анализ, дүн шинжилгээ хийж байгаа туршлагатай.

П.Байгалмаа. Эрх зүйч мэргэжилтэй, МУИС-ийн хууль зүйн шинжлэх ухааны бакалавр, магистр (LLM) зэрэгтэй, 2003 оноос хойш орон нутгийн иргэдийн хөгжил, эмэгтэйчүүд, нутгийн иргэдэд түшиглэсэн менежмент, малчдын нийгмийн асуудал, хүүхдийн эрхийн чиглэлээр ажиллаж, 2015 оноос хойш уул уурхайн компаниудын засаглал, компани ба орон нутгийн иргэд хоорондын харилцаа, нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговрын талаар үндэсний болон олон улсын хэмжээний харьцуулсан судалгаа хийж байна.

Л.Пүрэвдулам. Байгаль орчны мэргэжилтэн. МУИС-ийн гадаргын ус судлалаар бакалавр, Австралийн Күйнсландын Их Сургуулийн байгаль хамгаалал, байгалийн нөөцийн менежментийн магистрын зэрэгтэй. Уул уурхайн салбарт байгаль орчны чиглэлээр 10 орчим жил ажилласан туршлагатай.

Ж.Санчир. Умард Дакотагийн Их Сургуулийн улс төрийн философи, нийтийн удирдлагын бакалавр, Лондон Коллеж Их Сургуулийн судалгааны арга зүйн магистр зэрэгтэй.

Н.Баярсайхан. Иргэний нийгэм, хүний эрхийн эксперт. 2001 оноос хойш хүний эрх, нутгийн иргэдийн эрх ашиг, байгаль орчны болон хөгжих эрхийн чиглэлээр ажиллаж байгаа. Хил хязгааргүй Алхам ТББ-ын тэргүүн, ТАН эсвлийн гишүүн. Бодлогын болон стратегийн баримт бичиг боловсруулах, хуулийн нөлөөлөл, нийтийн эрх ашгийн өмгөөлөл хийх, үндэсний онцлогт нийцсэн сургалтын модуль, арга зүй боловсруулах, нутгийн иргэд эрхээ хамгаалахад дэмжиж ажилладаг.

Монгол Улс, Улаанбаатар
Их Британи, Оксфорд

2020 оны 9 сарын 29

Монгол Улсын уул уурхай салбарын “Нийгмийн нөлөөллийн үнэлгээ” хийх аргачлал боловсруулахад энэхүү тайлан эхний алхам болж, хувь нэмрээ оруулна гэдэгт итгэж байна. Нийгмийн нөлөөллийн үнэлгээний аргачлалын төсөл болон хууль эрх зүйн судалгаа, зөвлөмжийг Монгол улсын үндэсний зөвлөхүүд, Оксфордын Их сургуулийн судлаачид, олон улсын экспертүүдтэй хамтран ажиллаж Монгол улсын онцлогт тохируулан боловсруулав.

ЗГХЭГ-аас БОНБУ-ний тухай хуулийн 7-р зүйлийг хэрэгжүүлэх, “Нийгмийн нөлөөллийн үнэлгээ” хийх аргачлал боловсруулах зорилгоор 2020 оны 2 сарын 14-нд ажлын хэсэг байгуулсан юм. Монгол Улсын ЗГХЭГ болон Оксфордын Их сургууль, тус сургуулийн Газарзүй, байгаль орчны сургуулийн Говийн загвар төсөл, Хил хязгааргүй алхам ТББ-ын идэвхтэй хамтын ажиллагааны хүрээнд Тогтвортой хөгжлийн зорилтыг хангах, хүртээмжтэй хөгжлийг бий болгоход чиглүүлэн олон улсын стандартын дагуу хараат бус, нотолгоонд суурилсан Нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал боловсруулахаар зорин ажиллаж байгаа билээ.

Тус тайлан нь ажлын хэсгийн хэрэгцээнд зориулан боловсруулагдсан бөгөөд оролцогч талуудын саналыг тусгаж хэлэлцүүлэх, турших зэргээр сайжруулж, эцэслэн боловсруулах цаашдын үйл ажиллагааны эхлэл болж байгаа юм.

Уг ажлыг бодит ажил болгоход ихээхэн хүчин зүтгэл гаргаж, хувь нэмрээ оруулсан ЗГХЭГ-ын салбарын удирдлага, зохицуулалтын газрын дарга хатагтай Ш.Мөнхцэрэн, Хил хязгааргүй алхам ТББ-ын тэргүүн хатагтай Н.Баярсайхан болон Монголын зөвлөх баг, олон улсын экспертүүд, хэлэлцүүлэг, хурлын оролцогчдод чин сэтгэлийн талархал илэрхийлье.



Др. Ариэлл Ахерн
Газарзүй, байгаль орчны сургууль
Оксфордын Их сургууль

Талархал

Монгол Улсын ЗГХЭГ-ын тэргүүн дэд дарга Б.Ганбатын 2020 оны 02 сарын 14-ний өдрийн 28 тоот тушаалаар уул уурхай, газрын тосны үйл ажиллагаанаас хүн ам, хот суурин газрын хэвийн амьдрал, ахуйд нөлөөлж буй нөлөөллийн бүсийг тогтоох, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгохтой холбоотой асуудлыг судалж, санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулж, ахлагчаар ЗГХЭГ-ын Стратегийн удирдлага, зохицуулалтын газрын дарга Ш.Мөнхцэрэн, гишүүдэд УУХҮЯ-ны Геологи, уул уурхайн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Мөнхтөр, БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын дарга П.Цогтсайхан, МХЕГ-ын Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтын газрын дарга Н.Батбаяр, Говийн загвар төслийн төлөөлөл, Хил хязгааргүй алхам ТББ-ын тэргүүн Н.Баярсайхан, нарийн бичгийн даргаар ЗГХЭГ-ын Стратегийн удирдлага, зохицуулалтын газрын референт Д.Болд нарыг томилсон билээ. Тус ажлын хэсэг Оксфордын Их сургууль болон Говийн загвар төсөл (Gobi framework), Хил хязгааргүй алхам ТББ-тай хамтран ажиллах явцад уг асуудлын цөм болох Нийгмийн нөлөөллийн үнэлгээний аргачлал боловсруулсаны дараагаар тухайн төслийн хувь хүн, гэр бүл, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх, эерэг нөлөөллийг дэмжихэд чиглэсэн хариу арга хэмжээ авах, зөрчигдсэн эрхийг сэргээх менежментийн төлөвлөгөөний зөвхөн нэг хэсэг нь нүүлгэн шилжүүлэлт хийх, нөхөх олговор олгох арга хэмжээ бөгөөд Нийгмийн нөлөөллийн үнэлгээ нь цогц арга хэмжээ, үйл явц юм гэж тодорхойлсон болно.

Уг шийдвэрийн үндсэн дээр Оксфордын Их Сургууль, Говийн загвар төслөөс үндэсний зөвлөх багийг сонгон шалгаруулж 2020 оны 5 сарын 25-аас, Оксфордын Их сургууль, Цюрихийн Их сургууль болон нийгмийн нөлөөллийн үнэлгээний чиглэлээр ажилладаг судлаачдын дэмжих багийг бүрдүүлэн нийт 4 сарын хугацаанд ажиллаж, эцсийн тайланг бид 9 сарын 25-нд ЗГХЭГ-т хүлээлгэн өгсөн болно. Уг хугацаанд ЗГХЭГ-ын ажлын хэсгээс Хил хязгааргүй алхам ТББ-тай хамтран Нийгмийн нөлөөллийн үнэлгээний онлайн сургалтыг Оксфордын Их сургуулиар дамжуулан Монгол улсад зохион байгуулах, зөвлөх багийг хөдөө орон нутагт ажиллуулах, яам агентлагуудтай уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулахад дэмжиж ажилласанд талархал илэрхийлье.

Зөвлөх баг БОАЖЯ, УУХҮЯ, ХНХЯ, АМГТГ, МХЕГ болон БОННУ-ний эрх бүхий үнэлгээний компаниуд, тусгай зөвшөөрөл эзэмшигч ААНБ-ын төлөөлөл, БОАЖЯ-ны БОННУ-ний мэргэжлийн зөвлөлийн экспертүүд, уул уурхайн нөлөөллийн бүсийн иргэд, орон нутгийн захиргааны албан хаагчид, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл оролцсон нийт 12 удаагийн уулзалт хэлэлцүүлэгээр 200 гаруй хүмүүсийн санал сонсож, 136 санал зөвлөмжийг багцалж 1) Нийгмийн нөлөөллийн үнэлгээний аргачлалын төсөл болон 2) Нийгмийн нөлөөллийн үнэлгээний аргачлалыг хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчны үнэлгээ, зөвлөмжийн тайланд тусгалаа (дэлгэрэнгүйг саналын товъёогоос харна уу).

Нийгмийн нөлөөллийн үнэлгээ нь сүүлийн 50 орчим жилийн хугацаанд олон улсад байгаль орчны нөлөөллийн үнэлгээний бүрэлдэхүүн хэсэг болон хөгжин төлөвшиж буй шинэлэг зохицуулалтын нэг юм. Уг ажил нь Монгол улсын практикт тодорхой хэмжээгээр хийгдэж буй боловч хуулийн нарийвчилсан зохицуулалтгүй, үнэлгээний тодорхой аргачлалгүй байгаа билээ. Монгол Улсын судлаачид, шийдвэр гаргагчид, үнэлгээний компаниудын аль аль нь энэ чиглэлээр суралцаж, шинэ тутам байгааг харгалзан үзэж, зөвлөх багаас аргачлалын төсөл боловсруулахдаа дараах зарчмыг баримталж ажилласан болно. Үүнд, **нэгдүгээрт**, үндэсний холбогдох хууль тогтоомж, журам, аргачлалын одоогийн зохицуулалтад дүгнэлт хийж, цаашид боловсронгуй болгох эрх зүйн зөвлөмж боловсруулах, **хоёрдугаарт**, Нийгмийн нөлөөллийн үнэлгээнд сөрөг болон эерэг өөрчлөлт, нөлөөллийн аль алиныг авч үзэх, **гуравдугаарт**, олон улсын стандарт, сайн туршлагаудаас суралцах, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, хүний эрхийн нийтлэг үнэт зүйлс, бизнесийн ёс зүйн зарчимд нийцүүлэх, **дөрөвдүгээрт**, эрдэс баялгийн салбарын бизнес болон нүүдэлчин соёл, өв уламжлалт ахуйн нэг талбарт зэрэгцээ хөгжих онцлог зохицол бүхий үндэсний онцлогт нийцсэн, хэрэглэхэд ойлгомжтой, хялбар аргачлал бүхий суурь зохицуулалт болохуйц аргачлал боловсруулах, **тавдугаарт**, салбарын төрийн болон

мэргэжлийн байгууллагууд, компаниуд, орон нутгийн иргэд, засаг захиргаа, олон улсын болон дотоодын судлаач, иргэний нийгмийн төлөөлөл, экспертүүд зэрэг сонирхогч олон талуудын санал, зөвлөмжийг тусган, байнга сайжруулахад анхаарсан болно.

Энэхүү Нийгмийн нөлөөллийг үнэлэх аргачлалы төслийг, эрх зүйн орчны үнэлгээний зөвлөмж дагуу “одоогийн байгааг дордуулахгүй”-ээр цаашид илүү сайжруулах шаардлагатай гэдгийг зөвлөх багийн зүгээс онцлон дурьдаж байна. Зөвлөх баг аргачлалыг боловсруулахдаа өөрсдийн судалгаа, туршлагад тулгуурлах, оролцогч талуудаар хэлэлцүүлэх, ганцаарчилсан болон фокус бүлгийн уулзалт хийснээс гадна дараах ажлыг хийж гүйцэтгэв. (1) Дотоодын эрх зүйн баримт бичиг, үнэлгээтэй холбоотой журам, аргачлалыг нарийвчлан судлах, олон улсын сайн туршлага, хууль эрх зүй, аргачлал, түүнтэй холбоотой судалгааны өгүүлэл, бүтээл зэрэг баримт бичгийн судалгаа явуулав. Энэ үе шатанд олон улсад мөрдөгдөж буй аргачлалуудыг судлах, тэдгээрийн давуу болон сул талыг гаргах замаар Монгол орны нөхцөлд тохирох хувилбаруудыг тодорхойлов. (2) Судалгааны материал, сайн туршлага судлах явцад Нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх аргачлалын ерөнхий загвар гаргасан боловч тэдгээрийн агуулга, нарийвчлалын байдал харилцан адилгүй байсан тул багийн гишүүд өөрсдийн хамтарсан судалгаанд үндэслэж “Олон улсын нөлөөллийн үнэлгээ эрхлэгчдийн холбоо”-ноос гаргасан зөвлөмж, аргачлал болон хүний эрхийн суурь зарчим, олон улсын нийгэм, байгаль орчин, бизнесийн чиглэлээрх гэрээ конвенцийн суурь зарчмуудыг баримтлан боловсруулалт хийлээ. (3) Монгол улсад Нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх оролцогч талуудад туслах, ажлыг хөнгөвчлөх үүднээс үнэлгээнд ашиглах боломжтой, зохицох арга зүйг тодорхойлж, оруулав. Нийгмийн нөлөөллийн үнэлгээг Монгол улсад бүртгэлтэй, тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж орон нутгийн төлөөллийн хамтаар хийж гүйцэтгэнэ гэж бид авч үзсэн ба нөлөөллийн үнэлгээ хийх талуудын чадавх харилцан адилгүй гэдгийг анхаарч аргачлалын үе шат, ашиглах арга зүй зэргийг зохистой хэмжээнд аль ч талд ойлгомжтой байдлаар оруулахыг эрмэлзсэн болно. Түүнчлэн энэ үе шатанд нийгмийн нөлөөллийн үнэлгээг хийхэд баримтлах нийтлэг болон үйл ажиллагааны зарчмуудыг дэлгэрэнгүй судалж, Монгол орны хувьд зайлшгүй дагаж мөрдөх шаардлагатай зарчим, хүрээг тодорхойлж гаргав.

Уг ажилд онол, арга зүйн дэмжлэг үзүүлж, байнга тусалж дэмжиж ажилласан Оксфордын ИС-ийн Байгаль, нийгэм, хүрээлэн буй орчны засаглалын магистрын хөтөлбөрийн захирал, Газар зүй, байгаль орчны сургуулийн багш, доктор Ариэлл Ахерн, Швейцарийн Цюрихийн ИС-ийн нийгмийн антропологийн ахлах багш, доктор И.Бямбабаатар, Говийн загвар төслийн баг болон судлаач Стивен Лезак, Их Британий Зөвлөлдөх хүрээлэнгийн зөвлөх, доктор Эмма Вилсон, профессор Доун Чатти болон зөвлөх багийн өдөр тутмын үйл ажиллагаанд зохион байгуулалт, удирдлага чиглэлээр хангаж, үндэсний онцлог, нүүдэлч малчдын өв соёлд нийцүүлэх, хүний эрхэд суурилсан, жендэрийн мэдрэмжтэй аргачлал болгоход үнэтэй санал зөвлөмж өгч байсан Хил хязгааргүй алхам ТББ-ын тэргүүн, хүний эрхийн зүтгэлтэн Н.Баярсайхан, тус байгууллагын ажилтан Л.Мөнхзул нарт чин сэтгэлийн талархал илэрхийлье. Мөн Оксфордын Бодлого тодорхойлох оролцоог дэмжих сүлжээний тэтгэлэгт хөтөлбөрийн (OPEN) дэмжлэгээр 6 сарын 8-9 болон 7 сарын 28-нд зохион байгуулсан Нийгмийн нөлөөллийн үнэлгээний сургалтанд оролцогчдод болон сургалт явуулсан Оксфордын багш, профессорууд, экстертуудэд чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Зөвлөх багийн гишүүд

1-р хэсэг

НИЙГМИЙН НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ
АРГАЧЛАЛЫН ТӨСӨЛ, ТАНИЛЦУУЛГА

Хуудас 1 - 67

2-р хэсэг

ННҮ-НИЙ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ СУДАЛГААНЫ
ТАЙЛАН, ЗӨВЛӨМЖ

Хуудас 69 -178

1-Р ХЭСЭГ

**ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН
БОЛОН**

ХОЛБОГДОХ ДЭД БҮТЦИЙН ТӨСӨЛД

**НИЙГМИЙН НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ
АРГАЧЛАЛ**

Аргачлалын бүтэц

Нэр томъёоны тайлбар

Нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх аргачлалын танилцуулга

НЭГ.НИЙГМИЙН НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, БАРИМТЛАХ ЗАРЧИМ

- 1.1. Нийгмийн нөлөөллийн үнэлгээний зорилго
- 1.2. Нийгмийн нөлөөллийг үнэлэх, тайлан боловсруулахад баримтлах зарчим

ХОЁР. НИЙГМИЙН НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ

- 2.1. Нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийгдэх төсөл
- 2.2. Нийгмийн нөлөөллийн үнэлгээний хамрах хүрээ
- 2.3. Нийгмийн нөлөөллийн үнэлгээний үе шат

ГУРАВ. НИЙГМИЙН НӨЛӨӨЛЛИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

- 3.1. Нийгмийн нөлөөллийн төлөв байдлын үнэлгээний гол зорилго, үндэслэл, цар хүрээг тодорхойлох
- 3.2. Нийгмийн нөлөөллийн төлөв байдлыг тодорхойлоход шаардлагатай нэмэлт судалгаа хийх
- 3.3. Судалгааны мэдээллийг эмхэтгэн нийгмийн нөлөөллийн төлөв байдлын үнэлгээний тайлан боловсруулах

Дөрөв. НИЙГМИЙН НӨЛӨӨЛЛИЙН ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ

- 4.1. Нийгмийн нөлөөллийн ерөнхий үнэлгээг хариуцан гүйцэтгэгч
- 4.2. Төсөлд Нийгмийн нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлгэх хүсэлт гаргах
- 4.3. Нийгмийн нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийхэд тавигдах шаардлага

Тав. НИЙГМИЙН НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭ

- 5.1. Бэлтгэл хангах, хамтарсан баг бүрдүүлэх;
- 5.2. Суурь мэдээлэл бүрдүүлэх;
- 5.3. Мэдээлэлд боловсруулалт хийх;
- 5.4. Нөлөөллийн бүсийн иргэд иргэд, оршин суугчдаас албан ёсоор санал авч, хэлэлцүүлэг зохион байгуулна
- 5.5. Эерэг ба сөрөг нөлөөллийг үнэлэх;
- 5.6. Нийгмийн нөлөөллийн менежментийн төлөвлөгөө боловсруулах;
- 5.7. Нөлөөллийн бүсийн иргэдийг мэдлэг мэдээллээр хангах, оролцоог хангах;
- 5.8. Үнэлгээний тайлан бэлтгэх;
- 5.9. Сонсох ажиллагаа явуулах болон Багийн ИНХ-ын хуралдаанаар БО,НННҮ-ний тайлангийн төслийг хэлэлцүүлэх, санал авах;
- 5.10. Батлагдсан БО,НННҮ тайланг ил тод нээлттэй болгох;

ЗУРГАА. САНАЛ, ГОМДОЛ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ МЕХАНИЗМ

ДОЛОО. ХАВСРАЛТ:

- a. Нийгмийн нөлөөллийн үнэлгээний арга зүй
- b. Нийгмийн нөлөөллийн найривчилсан үнэлгээ хийхэд анхаарах зөвлөмжүүд

Товчилсон үгийн тайлбар

ААНБ- аж ахуйн нэгж, байгууллага

БОАЖНХ- Байгаль орчин, аялал жуулчлал, ногоон хөгжил

ННҮ- нийгмийн нөлөөллийн үнэлгээ

НННҮ- нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ

БОНННҮ- байгаль орчин, нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ

БОНБҮТХ- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль

Багийн ИНХ- Багийн Иргэдийн Нийтийн Хурал

СГХШМ- Санал гомдол хянан шийдвэрлэх механизм

ЭЕШ- Элсэлтийн ерөнхий шалгалт

Нэр томъёоны тайлбар

- *Эрдэс баялгийн салбар* гэж метал, түүхий эд, эрдэс, эрдсийн хольцыг газрын гүнээс хайх, гаргах, ашиглахтай холбоотой хайгуул, олборлолтын үйл ажиллагаа болон ашигт малтмал, газрын тос, байгалийн хий, цацраг идэвхт ашигт малтмал, түгээмэл тархацтай ашигт малтмалыг боловсруулах, баяжуулах үйлдвэрлэл эрхлэх, бичил уурхайгаар ашигт малтмал олборлохтой холбоотой цогц үйл ажиллагааг тус тус хэлнэ.
- *Нийгмийн нөлөөллийн үнэлгээ (Social Impact Assessment)* гэж аливаа бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, төслийн дунд болон урт хугацаанд нийгэмд үзүүлэх эерэг, сөрөг, шууд болон шууд бус нөлөөлөлд дүн шинжилгээ, мониторинг хийх, удирдах, нийгмийн нөлөөллийн ерөнхий үнэлгээ ба нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хамруулсан үйл явцыг;
- *Нөлөөллийн бүс (Area of Influence)* гэж төслийн үйл ажиллагааны улмаас хувь хүн, өрх, нийгмийн бүлгүүд, бизнес эрхлэгчид, жижиг дунд бизнес эрхлэгчид, төрийн болон бусад байгууллагуудын үйл ажиллагаанд үзүүлж буй амьдрах орчин, нөхцөл, соёл, уламжлал, шашин шүтлэг, хөдөлмөр эрхлэлт, орлого, хүний эрх зэрэг нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, нөлөөлөлд өртөх бүс нутгийг;
- *Шууд нөлөөлөл (Direct Impact)* гэж тухайн төслийн үйл ажиллагаанаас орон нутгийн иргэдэд шууд мэдрэгдэж буй нөлөөлөл (таамаг буюу төсөөлөл бус)-ийг хэлэх ба үүнд дуу чимээ, тоос, орчны бохирдол зэргийг хамруулахыг;
- *Дам буюу шууд бус нөлөөлөл (Indirect Impact)* гэж тухайн төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчин, амьдрах орчинд гарч буй өөрчлөлтийн улмаар шууд бус байдлаар амьдралын чанар, хүн амын орлого, амьжиргаа, эдийн засаг, шашин шүтлэг, соёл, уламжлал, хүний эрхэд гарч буй өөрчлөлтийг;
- *Нөхөн олговор (Compensation)* гэж төслийн сөрөг нөлөөллөөс зайлсхийх боломжгүй нөхцөлд төсөл хэрэгжүүлэгчийн зүгээс тухайн орон нутгийн нөлөөлөлд өртөх иргэн, өрх болон олон нийтэд олгох мөнгөн ба мөнгөн бус төлбөр нөхөн олговрыг;
- *Санал, гомдол хянан шийдвэрлэх үйл ажиллагаа (Grievance Mechanism)* гэж тухайн төсөл, төсөлд хамаарах бусад үйл ажиллагааны талаарх мэдээлэл авах, санал бодлоо илэрхийлэх, мөн эрх, ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзсэн гомдолтой иргэн, ажилчин, иргэний нийгмийн болон бусад байгууллагуудын хандаж асуудлаа шийдвэрлүүлэх боломж бүхий шүүхийн бус хянан шийдвэрлэх үйл явцыг хэлнэ. Энэ нь иргэн, байгууллагын шүүхэд хандаж, эрхээ хамгаалуулах эрхийг хаахгүй бөгөөд санал, гомдол гаргагч талуудаас ямар нэгэн зардал гарахгүй байхаар зохицуулах нь чухал юм.
- *Үйл ажиллагаа явуулах нийгмийн зөвшөөрөл (Social License to Operate)* гэж аливаа төслийг хэрэгжүүлэхийн тулд орон нутгийн иргэд, холбогдох байгууллагуудын түвшинд хүлээн зөвшөөрөгдөн, хуулиар тавигддаг албан ёсны тусгай зөвшөөрөл авахыг;

ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН ТӨСӨЛ БОЛОН ХОЛБОГДОХ ДЭД БҮТЦИЙН ТӨСӨЛД НИЙГМИЙН НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ АРГАЧЛАЛЫН ТАНИЛЦУУЛГА

Эрдэс баялгийн салбар гэдэг нь метал, түүхий эд, эрдэс, эрдсийн хольцыг газрын гүнээс хайх, гаргах, ашиглахтай холбоотой хайгуул, олборлолтын үйл ажиллагаа болон ашигт малтмал, газрын тос, байгалийн хий, цацраг идэвхт ашигт малтмал, түгээмэл тархацтай ашигт малтмалыг боловсруулах, баяжуулах үйлдвэрлэл эрхлэх, бичил уурхайгаар ашигт малтмал олборлохтой холбоотой цогц үйл ажиллагааг ойлгодог.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7-р зүйлийн 7.7 дахь хэсэгт “Нөлөөллийн үнэлгээний журам, аргачлалыг Засгийн газар батлах бөгөөд уг журам, аргачлалд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээтэй холбоотой асуудал, үнэлгээний шинжилгээ, хянан магадлагаа болон мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагаа, нийгэм, эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний талаарх зохицуулалтыг тусгана” гэж 2012 онд зааж өгсөн. Энэ заалтын дагуу 2012 оноос хойш хийгдсэн БОННУ-д нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийхдээ зөвхөн тухайн төслөөс бий болох а/. ажлын байрны тоо; б/. улс, орон нутагт төлөх татвар; в/. үйлдвэрийн ажлын байран дахь хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн арга хэмжээний талаар үнэлж тайлан боловсруулж, түүнийг Байгаль орчин аялал жуулчлалын яамны мэргэжлийн зөвлөл нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийснээр тооцож баталж ирсэн. Энд буруутгах арга байхгүй бөгөөд нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал журам батлагдаагүй, мөн байгаль орчны салбарын мэргэжилтэн нийгмийн салбарын нөлөөллийг үнэлэх боломжгүй юм.

Мөн Ашигт малтмалын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсэгт “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагааны явцад худаг, өвөлжөө, хувийн болон нийтийн зориулалттай орон байр бусад барилга байгууламж болон түүх, соёлын дурсгалт зүйлсэд гэм хор учруулсан бол хохирлыг нь өмчлөгч, эзэмшигчид бүрэн хэмжээгээр нөхөн төлөх бөгөөд шаардлагатай тохиолдолд тэдгээрийг шилжүүлэн байрлуулахтай холбогдсон зардлыг хариуцна” гэж заасан бөгөөд яг энэ заалтыг Газрын тосны тухай хууль, Цөмийн энергийн тухай хууль, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд тусгасан байдаг. Гэвч өнөөг болтол энэ хуулийн заалт хэрэгжээгүй, хэрэгжих боломж нь мөн хязгаарлагдмал байсаар ирлээ. Учир нь Нүүлгэн шилжүүлэх эсэх, нөхөн олговор олгохын өмнө нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийгдсэн байх ёстой бөгөөд энэ ажил орхигдсоноос нөлөөллийн бүсийн хүн ам, иргэд албадан нүүлгэлтэд өртөх, төрсөн нутаг газраасаа шахагдах, бэлчээрээ алдах улмаар иргэний болон эдийн засаг, нийгэм, соёлын, улс төрийн бүх төрлийн эрх зөрчигдөх томоохон шалтгаан болсоор ирсэн. Үндсэндээ төр нь эрдэс баялгийн салбарын бизнесээс хүн амынхаа тогтвортой хөгжил, нийгмийн хамгааллыг хамгаалж чадахгүй байсаар байна.

Нөхөн олговор олгох, нүүлгэн шилжүүлэх зарчмыг тодорхойлох, сөрөг нөлөөллийг арилган, зөрчигдсэн эрхийг сэргээхтэй холбоотой тодорхой зохицуулалтуудыг бий болгох эхний алхам бол төсөл хэрэгжүүлэгчдэд нийгмийн нөлөөллийн үнэлгээг олон улсын стандартад нийцүүлэн хийх, сөрөг нөлөөллөөс зайлсхийх, улмаар арилгах цогц арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлж хэвших явдал юм.

Иймд уг арга зүйг боловсруулахдаа орон нутаг, иргэд болон нүүдэлчин малчдын амьдралын хэв маяг, хэрэгцээ шаардлага, төслийн үйл ажиллагаанаас үүдэлтэй эерэг болон сөрөг нөлөөллийг тодорхойлон үнэлж, бодитой дүгнэлт гаргах, төсөл хэрэгжих эсэх шийдвэр гаргах, төсөл хэрэгжих бол сөрөг нөлөөллөөс зайлсхийх хэрэгжихүйц тодорхой арга хэмжээг санал болгох аргачлал боловсруулав.

Нийгмийн нөлөөллийн үнэлгээг, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээтэй хамт, зэрэгцээ байдлаар гүйцэтгэж “Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний нэгдсэн нэг тайлан” боловсруулах нь зүйтэй гэж үзэв. Иймд Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай хамтран, байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг цогцоор нь боловсруулах, баталгаажуулах, хэрэгжилтийг хангах болон хянах явцыг хамтран гүйцэтгэхээр боловсрууллаа.

Өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Байгаль орчны үнэлгээний аль ч хууль тогтоомжид нийгмийн нөлөөллийг үнэлэх, хянан батлах зохицуулалт хангалтгүй тул энэ хүрээнд баригдах, засварлах замаар энэхүү аргачлалыг боловсруулах боломжгүй байлаа. Мөн ОУ-ын хүний эрхийн суурь зарчмууд, ТХЗ-ийн зорилтууд хангагдахад эрдэс баялгийн салбарын төсөл хөтөлбөрүүд нь дэмжлэг болох хувь нэмэр оруулах, мөн бизнес эрхлэгчид үүрэг хариуцлага хүлээх механизм болохуйц үнэлгээ байхад тус аргачлалыг анхаарч боловсруулсан.

Манай улсын хувьд аливаа төсөл хөтөлбөрт Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийж тодорхой туршлага сургамжийг хуримтлуулж, эрх зүйн зохицуулалтаа хэд хэдэн удаа боловсронгуй болгож сайжруулж ирсэн мөн үнэлгээний засаглал, тогтолцооны хувьд ч төлөвшиж байна. Харин эрдэс баялгийн салбарын төсөл болон холбогдох дэд бүтцийн төсөлд нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх нь харьцангуй шинэ ойлголт, шинэ хандлага чадавх нөөц, салбар дундын “амьд” зохицуулалтыг шаардаж байна.

Ийм ч учраас Нийгмийн нөлөөллийн үнэлгээний аргачлал, журмыг боловсруулж батлах ажил 9 жил хүлээгдсэн байх талтай. Нийгмийн нөлөөллийн үнэлгээний энэ аргачлалд Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг хамтад нь хийж, нэг тайлан, нэг менежментийн төлөвлөгөө, хяналт шинжилгээний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх нь зүйтэй гэж байгаа ч өнөөг болтол орхигдож ирсэн Нийгмийн нөлөөллийн үнэлгээний аргачлалыг тухайлан чухалчилж боловсруулсан.

Нийгмийн нөлөөллийн үнэлгээний аргачлалд үнэлгээний гол зорилго, баримтлах зарчим, хамрах хүрээ, үнэлгээг гүйцэтгэх дараалал, ашиглах аргазүй, эрсдэлийн эрчмийг тодорхойлох, сөрөг нөлөөллийг арилгах хариу арга хэмжээг төлөвлөх, үр дүнг тооцох ба тайлагнах зэрэг багтсан бөгөөд өөрчлөлт, нөлөөллийг хувь хүн, өрх гэр, нутгийн хүн амд нөлөөлөх магадлалаар үнэлэхээр боловсруулсан.

Нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх эрхийг шалгуурын дагуу олгох бөгөөд мэргэжлийн байгууллага, тухайн салбарын эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, бие даасан шинжээч, мэргэжилтнүүд болон төслийн нөлөөллийн бүсийн иргэдийн оролцоотойгоор эрсдлийг тооцож, үнэлгээг төсөл хэрэгжихээс өмнө хийхээр зохицуулав.

ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН БОЛОН ХОЛБОГДОХ ДЭД БҮТЦИЙН ТӨСӨЛД НИЙГМИЙН НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ АРГАЧЛАЛ

НЭГ. НИЙГМИЙН НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, БАРИМТЛАХ ЗАРЧИМ

1.1. Нийгмийн нөлөөллийн үнэлгээний зорилго

Эрдэс баялгийн болон түүнийг дагасан дэд бүтцийн /хүнд үйлдвэрийн төсөл, дэд бүтцийн хөгжлийн/ төслүүдийн нийгэмд үзүүлэх эерэг болон сөрөг нөлөөллийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг тодорхойлох, шалгуур үзүүлэлтийн дагуу нөлөөллийг иргэдийн оролцоотой үнэлэх, үр дагавраас урьдчилан сэргийлэх, арилгах /бууруулах арга хэмжээ нь байгаль орчны үнэлгээнд хамаарна, харин нийгэмд үзүүлж буй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах арга хэмжээ байна/ арга хэмжээг тодорхойлоход оршино.

Төсөл тус бүрийн газар зүйн байршил, олборлож буй ашигт малтмалын төрөл, түүнийг олборлох технологийн онцлог, үйл ажиллагааны цар хүрээ зэрэг ялгаатай байдлаас шалтгаалан тухайн орон нутгийн иргэдэд үзүүлж буй нөлөөлөл, цар хүрээ, эрчим харилцан адилгүй байдаг салбарын онцлогоос хамааран нийгмийн нөлөөллийг тодорхойлох, үнэлэх арга зүй, тэдгээрийн сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх, зайлсхийх, арилгах хариу арга хэмжээ өөр өөр байх тул төслийн нөлөөллийг бодитоор үнэлж Нийгмийн Нөлөөллийн Үнэлгээний (ННҮ) тайлан боловсруулахад зайлшгүй баримтлах наад захын шаардлагыг энэхүү аргачлалд багтаасан болно.

Эрдэс баялгийн салбарын төсөлд хийгдэх ННҮ-ний тайлан, төлөвлөгөө боловсруулахад тогтвортой хөгжлийн зорилтуудын үзэл санаа, олон улсын хүний эрхийн зарчмууд, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үнэлгээний стандарт, хэм хэмжээг жишиг болгож, шинжлэх ухаанч, бодит мэдээлэлд тулгуурласан арга зүйг ашиглах үндсэн шаардлага тавигддаг.

1.2. Нийгмийн нөлөөллийг үнэлэх, ННҮ-ний тайлан боловсруулахад баримтлах зарчим

Нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийхдээ дараах суурь болон үйл ажиллагааны зарчмуудыг бүхий л үе шатанд мөрдөж ажиллана.

1.2.1. Үнэлгээний компани үнэлгээ хийхдээ баримтлах суурь зарчим

- Хууль дээдлэх, хүн бүр аюулгүй, эрүүл орчинд амьдрах эрхийг аль болох хөндөхгүй байх, иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хүндэтгэх;
- Нас, хүйс, хэл, яс үндэс, ажил, мэргэжил, шашин шүтлэг, хөрөнгө чинээ, нийгмийн байдал, тусгай хэрэгцээт иргэн гэх мэт ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч тэдгээрийн хүний эрх, эрхэм чанарыг хүндэтгэн үзэх;
- Тухайн орон нутагт байнга болон түр оршин суугч, төслийн нөлөөлөлд өртөж буй хэн бүхэн өөрсдийн амьдрал ахуйд нөлөө үзүүлэх төрийн аливаа шийдвэр гаргалтад бодитой оролцох эрх, мэдээлэл авах, хөгжих эрхийг хүндэтгэн хангах;
- ННҮ-ний тайлан, төлөвлөгөө нь орон нутгийн иргэд, удирдлагууд, судлаачид, бусад сонирхсон оролцогч талуудыг хамруулж, бүх талын жигд, хүртээмжтэй оролцоог хангаж зөвшилцсөн баримт бичиг болсон байх. Тухайн төсөл, төслийн үйл ажиллагаа болон төсөлтэй холбоотой шийдвэр гаргалтад оролцсоноос үүдэх аливаа дарамт шахалт, сүрдүүлэг, хүч хэрэглэх явдал, төөрөгдүүлсэн худал мэдээлэл өгөх, нэр хүндэд халдах зэрэг ялгаварлан гадуурхалтаас ангид байх;

- Нүүдэлчин, бэлчээрийн уламжлалт, мал аж ахуй эрхэлж байгаа иргэдийн алслагдмал, тархай бутархай байршил зэрэг үндэсний өвөрмөц онцлог байдлыг хүндэтгэн үзэж, иргэдийг өөрсдийн амьдралд нөлөөлөх шийдвэрийг гаргах үйл явцад оролцуулах, үүний тулд хангалттай хугацаанд үнэн зөв, бодитой, хүртээмжтэй мэдээллээр хангах, төслөөс гарч болох эрсдэлээс сэргийлэх, урьдчилан таамаглах замаар өрхийн аж ахуйгаа удирдах боломжийг эртнээс олгох;
- Нүүдлийн мал аж ахуй эрхлэгчид нь үндэсний өв уламжлал, соёлын өвийг тээгч төдийгүй үндэсний аж үйлдвэрийн түүхий эд бэлтгэн нийлүүлэгч, стратегийн хүнс, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэгчид болохыг онцгойлон хүлээн зөвшөөрч хүндэтгэх зарчмыг баримтална.
- Үнэлгээний бүхий л үйл явц, шийдвэр гаргалт шударга, ялгаваргүй, ил тод, нээлттэй байх

1.2.2. Үйл ажиллагаанд баримтлах зарчим /ННҮ- хийх, тайлан, төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, хянах/

- Төсөл, холбогдох үйл ажиллагааны эерэг, сөрөг нөлөөлөлд шууд болон шууд бусаар өртөх, өртөх магадлалтай орон нутгийн иргэд, бусад сонирхсон оролцогч талуудад төслийн талаархи мэдээллийг ННҮ-ний тайлан боловсруулж эхлэхээс тайлан батлагдах бүхий л шатанд хүргэх, үзэл бодлоо илэрхийлэх, санал дүгнэлт гаргах хугацаа, оролцоог бодитоор хангах боломжийг хангалттай бүрдүүлэх;
- ННҮ хийх тайлан, төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, хянах/ бүхий л хугацаанд оролцогч сонирхсон талуудын хамтын оролцоонд суурилсан хяналт мониторинг хийх боломжийг бүрдүүлэх, засан сайжруулах тасралтгүй үйл явц байх;
- ННҮ- хийхэд зохих мэдлэг чадвар, туршлага бүхий, бэлтгэгдсэн мэргэжилтнүүдийг ажиллуулах, иргэдийн чадавхийг бэхжүүлэх замаар бодитой оролцоог хангахад төсөл хэрэгжүүлэгч, ННҮ-ний хамтарсан баг хүчин чармайлт гаргах;
- ННҮ-ний бүх үе шатанд жөндөрийн эрх тэгш байдлыг хангах, эрэгтэй, эмэгтэйчүүдийн ялгаатай хэрэгцээ, тэдэнд учирч болзошгүй эрсдэл ялгаатай тусч нөлөөлөхийг тус бүрээр авч үзэх;
- Орон нутгийн иргэд төрж өссөн газар нутаг, байгаль орчиндоо өнө удаан хугацаанд, үе уламжлан амьдарч, дасан зохицсон, малчдын аж амьдрал ба эдийн засгийн эх үүсвэр болсон малын оршихуй онцгой хамааралтайг хүндэтгэж, энэ нь тэдний амьжиргаа, орлого болон шашин шүтлэг, итгэл үнэмшил бусад эдийн бус баялагийг аль болох хөндөхгүй сөрөг нөлөөлөл үзүүлэхээс урьдчилан сэргийлэхэд нь төсөл хэрэгжүүлэгч ААНБ-ын бодлого, төлөвлөлтийг чиглүүлэх;
- Нүүлгэн шилжүүлэлт нь хамгийн сүүлд авах эцсийн арга хэмжээ болохын хувьд орон нутгийн иргэдийг нутгаас нь аль болох нүүлгэхгүйгээр төслийг хэрэгжүүлэх, зайлшгүй шаардлагатай тохиолдолд нөхөн олговрын хамгийн боломжит хувилбар бүхий хөтөлбөрийг холбогдох хууль тогтоомж болон олон улсын стандартын хүрээнд хэрэгжүүлэх;
- Төсөл хэрэгжүүлэгч ААНБ бүр Нүүлгэн шилжүүлэлтийн хөтөлбөр болон нөлөөллийн бүсийн иргэд төдийгүй төслийн үйл ажиллагаа болон төслийн ханган нийлүүлэгчид, гэрээлэгчид, ажилчидтай холбоотой аливаа санал гомдлыг барагдуулах үүрэгтэй, иргэдэд хүртээмжтэй, хялбар Санал гомдол хянан шийдвэрлэх механизм (СГХШМ)-ийг бий болгон үр ашигтай, ил тод нээлттэй ажиллуулахыг нийгмийн нөлөөллийн үнэлгээнд заах
- ННҮ-ний дагуу сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, зайлсхийх, хариу арга хэмжээ авах менежментийн төлөвлөгөө боловсруулахдаа тэдгээрийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчим, стандарт, үндэсний хууль тогтоомж, хөтөлбөрүүд, түүнчлэн аймаг, нийслэл, сум, дүүргийн хөгжлийн хөтөлбөрүүдтэй уялдуулах, бизнес эрхлэгчид хүний эрхийг зөрчихгүй байх хүчин чармайлтыг дэмжих;

- Төсөл хэрэгжүүлэгчийн зүгээс тухайн төслөөс орон нутагт бий болгох үр өгөөжийг нэмэгдүүлэхэд идэвх санаачилга гаргах, орон нутгийн иргэд, орон нутгийн засаг захиргаатай харилцан үр ашигтай түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлэх;
- Төсөл хэрэгжүүлэгчийн зүгээс орон нутгийн иргэдийн амьжиргааг дэмжих хөтөлбөрүүд боловсруулж хэрэгжүүлэх, ингэхдээ иргэдийн амьжиргааг өмнөх байдлаас нь дордуулахгүй, харин урт хугацаандаа сайжруулах, тогтвортой хөгжлийг дэмжих зарчим баримтална.

Дээрх зарчмуудыг хэр хангасан нь БО, НННУ (Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ)-ний тайланд ерөнхий шинжээч дүгнэлт гаргах, мэргэжлийн зөвлөл тухайн тайланг батлахад баримтлах үндсэн шалгуур үзүүлэлт байх болно.

Энэхүү аргачлалд хэрэглэсэн нэр томъёог Нийгмийн нөлөөллийн үнэлгээний журамд тодорхойлсноор ойлгоно.

ХОЁР. НИЙГМИЙН НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ

2.1. Нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийгдэх төсөл

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ гэдэгт: байгаль орчны стратегийн үнэлгээ, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хамаарна гээд хуулийн хавсралтад байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийх төслийн ангиллын нэгдүгээрт **уул уурхайн төсөл**, хоёрдугаарт **хүнд үйлдвэрийн төсөл**, тавдугаарт **дэд бүтцийн хөгжлийн төсөлд** үнэлгээ хийхээр заасан.

Энэхүү аргачлалаар БОНБУ-ний тухай хуулийн хавсралтад заасан эрдэс баялгийн салбарын болон холбогдох дэд бүтцийн (барилга, зам, цахилгаан станц, далан гэх мэт) төслийн нийгэмд үзүүлж болзошгүй нөлөөллийг үнэлнэ.

Эрдэс баялгийн болон түүнийг дагасан дэд бүтцийн /хүнд үйлдвэрийн төсөл, дэд бүтцийн хөгжлийн төсөлд/ төслүүдээс нийгэм, хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд ноцтой хохирол учирч болох бөгөөд тэдгээр эрсдэлийг эрт тодорхойлон үнэлэх хэрэгцээ улам бүр тулгамдсан асуудал болж байна. Дэлхийн Тогтвортой хөгжлийн зорилтууд тэдгээрт нийцүүлэн гаргасан МУ-ын Алсын хараа 2050 бодлого нь Хэнийг ч хөгжлийн гадна орхихгүй уриатай бөгөөд эрдэс баялгийн салбар нь эдгээр бодлогуудыг хэрэгжүүлэхэд бодитой дэмжлэг үзүүлдэг салбар байх, бүх ард түмний мэдэлд буй байгалийн баялагт түшиглэсэн бизнесийн салбарын хувьд хүнийг хөгжлийг дэмжих, уур амьсгалын өөрчлөлтөд үзүүлэх нөлөөллийг бууруулахад МУ-ын оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэхэд болон Ногоон хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд гол үүрэг гүйцэтгэх салбар болохын хувьд Нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх шаардлага үүсээд удаж байна.

2.2. Нийгмийн нөлөөллийн үнэлгээний хамрах хүрээ

Нийгмийн нөлөөллийн үнэлгээ нь дараах хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- Нийгмийн нөлөөллийн төлөв байдлын үнэлгээ
- Нийгмийн нөлөөллийн ерөнхий үнэлгээ
- Нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ байна.

Нийгмийн нөлөөллийн үнэлгээ нь дээрх үнэлгээнээс гадна Нийгмийн нөлөөллийн менежментийн төлөвлөгөөг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, гомдол шийдвэрлэх, хэрэгжилт хангагдаагүй нөхцөлд хариуцлага хүлээлгэх зэрэг механизмыг бүрдүүлсэн цогц арга хэмжээ байна.

Энэхүү Нийгмийн нөлөөллийн үнэлгээний аргачлал гэдэг нь Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны А-117 дугаар тушаалын 2 дугаар хавсралт “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”-тай зэрэгцэн хийгдэх, нийгмийн нөлөөллийг үнэлэх аргачлал юм. Тиймээс Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлалын нийгмийн нөлөөллийн хэсэг хэмээн ойлгож, тухайн нийгмийн нөлөөллийг үнэлэх хэсэг тус бүрийг Зураг 1-т зааснаар энэ аргачлалын дагуу гүйцэтгэнэ.

Нийгмийн нөлөөллийн үнэлгээ нь эрдэс баялгийн салбарт хэрэгжүүлэх төсөл болон түүнийг дагасан дэд бүтцийн төсөлд тухайн төслийн онцлог, технологийн шийдэл, үйл ажиллагааны цар хүрээ, газар нутгийн экосистемийн онцлог, хэрэгжих хугацаа зэрэг ялгаатай хүчин зүйлсээс шалтгаалан нөлөөллийн хамрах хүрээгээ тодорхойлно. Тухайн төслийн үйл ажиллагаанаас гарах эерэг ба сөрөг нөлөөлөл нь **а/ хувь хүн, б/ өрх гэр, в/ нутгийн хүн амд** хэрхэн нөлөөлөхийг тус тусад нь үнэлэх ба хамгийн наад зах нь дор дурдсан нийгмийн асуудлуудыг зайлшгүй тодорхойлж, үнэлсэн байна. Үүнд:

1. Амьдралын хэв маягт гарч буй/гарч болзошгүй өөрчлөлт, нөлөөлөл

- Орлогын эх үүсвэрийн төрөл, хэлбэр орлогоо олж авах үйл явцад гарах
- Гэр бүлийн гишүүдийн хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн хуваарь
- Уламжлалт байдлаар мал маллах хэлбэр, хэв маягт гарч буй өөрчлөлт, алдаж буй/болзошгүй боломжууд
- Уламжлалт, дасан зохицсон газар нутаг, айл саахалтаас холдсон г м өөрчлөлтөөс амьдралын хэв маягт гарч буй/ гарч болзошгүй өөрчлөлт
- Амьжиргааны өртөг, амьдралын чанар
- Гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүйн эрх
- Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт
- Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт
- Өдөр тутмын гэр, аж ахуйн ажлын ачаалал, нэгж хөдөлмөрт зарцуулах цагийн өөрчлөлт зэрэг

2. Хувийн болон гэр бүлийн өмчийн эрхийн байдалд гарч буй/ гарч болзошгүй өөрчлөлт, нөлөөлөл

- Газар эзэмших, бэлчээр ашиглах эрх, гэрчилгээжүүлэлт (өвөлжөө, хаваржааны газар)-ийн эрхийн баталгаа
- Уламжлалт байдлаар отор нүүдлээр газар ашиглаж ирсэн эрхэд гарсан/гарч болзошгүй өөрчлөлт
- Хүн амын амьжиргааны түвшин, амьдралын чанар түүний тогтвортой хөгжих эрхэд гарсан/гарч болзошгүй өөрчлөлт
- Газар, бэлчээр, ус, ой, ойн дагалдах баялаг, эмийн ургамал болон хүнсний ургамал ашиглах хэлбэр, боломж, нөөцөд үзүүлж болзошгүй болон гарч буй өөрчлөлт
- Идээшиж дассан нутгаас нүүснээр малын тоо толгой, сүргийн бүтэц, чанарт үзүүлэх нөлөөлөл түүнээс гарах/ гарч болзошгүй сөрөг ур дагавар
- Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний зах зээлд хүрэх, өвөлжөө хаваржаандаа тогтвортой амьдрах боломжид гарсан/гарч болзошгүй өөрчлөлт
- Мал, малын түүхий эдийн зах зээлийн үнэд үзүүлэх сөрөг нөлөөллөөс гарч буй болон гарч болзошгүй үр дагавар

3. Орон нутгийн шийдвэр гаргалтад оролцох боломжид гарсан/гарч болзошгүй өөрчлөлт, нөлөөлөл

- Орон нутгийн иргэд өөрсдийн орон нутагт хэрэгжихээр төлөвлөж буй эрдэс баялгийн салбарын төслүүдийн талаар мэдээлэл авах эрхэд одоо болон ирээдүйд үзүүлэх сөрөг/ үзүүлж болзошгүй үр дагавар
- Орон нутгийн иргэд өөрсдийн амьдралд нөлөөлөх шийдвэр гаргалтанд оролцох боломж, сонголт хийх эрхэд гарч буй /гарч болзошгүй үр дагавар
- Багийн дарга, багийн ИНХ, аймаг, сумын ИТХ, Засаг дарга нар болон төрийн албан хаагчид нь иргэн, хуулийн этгээдээс санал сонсох, иргэдийг мэдээллээр хангах зорилгоор сонголт, хэлэлцүүлэг явуулж буй байдалд гарсан/ гарах өөрчлөлт
- Иргэд өөрсдийн санал, гомдлыг орон нутгийн засаг захиргаа болон төсөл хэрэгжүүлэгчид илэрхийлэх, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх боломж, чадавх, цаг хөрөнгөд гарсан/ гарах өөрчлөлт,

4. Үнэт зүйлс, соёл болон итгэл үнэмшилд гарсан/гарч болзошгүй өөрчлөлт, нөлөөлөл

- Байгаль, мал аж ахуйгаас хамааралтай амьдарч буй нутгийн иргэд, тэдгээрийн гэр бүл, нутгийн хамт олны ирээдүйдээ итгэх итгэл үнэмшил, хамтын харилцаа, хамтын хөгжил
- Хэл, хэлний аялга, өвөрмөц, нутгийн хэллэг ондоошилд гарсан/гарах өөрчлөлт энэ нь үнэт зүйлийн алдагдал, хохирол болох эсэх
- Үндэсний баяр, тэмдэглэлт өдрүүд, тэдгээрийг тэмдэглэх хэлбэр, хэв маяг, зан үйл, өв соёл
- Үндэсний болон үндэстэн ястны болон малчин өв соёлын илэрхийлэл болох хувцасны соёлд гарах/гарсан өөрчлөлт ,
- Уламжлалт, стратегийн Хоол хүнс, хүнсний аюулгүй байдлын хэрэглээнд гарах, үйлдвэрлэл бэлтгэл, хүртээмжид гарах/ гарсан өөрчлөлт
- Ёс, зан заншил, уламжлал, нийтлэг үнэт зүйлс зэрэг амьдралын хэв шинж, үнэт зүйлсээ хадгалах, хөгжүүлэх, өвлүүлэхэд гарсан/ гарч болзошгүй өөрчлөлт
- Шашин шүтлэг, итгэл үнэмшил: тэдгээрийн биет бус зүйл түүнд үзүүлэх эрсдэл, өөрчлөлт /ихэсийн газар ариун хамгаалалттай байх, овоо тахиснаар бороо хур орох, морины овоонд мөргөж хурдан удам үл тасрах гм итгэл үнэмшил/
- Биет ба биет бус соёлын өвийн хамгаалалт, аюулгүй байдал: малын бэлчээрт дуулах, гийнгоолох, исгэрч нутгийн уул усаа баясгаж хийморийг сэргээж уул усаа аргадаг заншил, малаа хужирлаж малдаа тарга авахуулах, арьс нухангаа биеэ чангаруулах г м тухайн нутаг нутгийн заншлууд орно/

5. Төрийн үйлчилгээ авах болон төрийн үйлчилгээ хүргэх, авахад чанар, хүртээмж, зардалд гарсан/гарч болзошгүй өөрчлөлт, нөлөөлөл

- Иргэдийн мэдээлэл авах: мэдлэг хуримтлуулах, мэдээлэл солилцох уламжлалт хэлбэрийн сул болон давуу тал түүний сул талыг хэрхэн арилгах, улмаар түүнд гарах өөрчлөлт төрийн үйлчилгээ үзүүлэхэд болон иргэд төрөөс авах үйлчилгээг хүн/цаг болон гарах зардлын хамтаар хоёр урсгалаар харах
- Эрүүл мэндийн үйлчилгээ: Сумын хүний болон мал эмнэлгийн зардал, эмийн сангийн төсөв хувьсах зардлаар оногддог тул уурхайн төсөл хэрэгжсэнээр ЭМ-ийн байгууллагад ямар нөлөөлөл үзүүлэх, зардал багассанаар нутгийн тэр дундаа малчин иргэд хувийн эмнэлэгт очих, хувийн эмийн сангаар үйлчлүүлэхэд гарах зөрүү зардал, мөн малчин түргэн дуудахад тусгай зөвшөөрөлтэй талбай тойрох гм нөлөөллийг ННУ хийх суурь зарчим, үйл ажиллагааны зарчимд нийцүүлэн харах
- Боловсролын үйлчилгээний чанар, хүртээмж: боловсролын үйлчилгээ гэдэг нь зөвхөн нөлөөлөлд өртөж буй малчин өрхийн хүүхдийн ЕБС болон их дээд сургуульд суралцах асуудал биш юм. Харин тухайн уул уурхайн төсөл түүний үйл

- ажиллагаатай зэрэгцэн МАА-аа, амжиргаагаа эрсдэлгүй авч явах амьдрах ухааны боловсрол түүний тасралтгүй байх, чанартай, хүртээмжтэй байх ойлголт юм.
- Тусгай хэрэгцээ бүхий өрхийн гишүүд: Өндөр настан, хүүхэд, ганц бие эцэг, эх, орлого багатай иргэдийн амжиргаа, орлогын эх үүсвэрт гарах/ гарч болзошгүй өөрчлөлтийг нэг бүрчлэн үнэлэх. Тусгай хэрэгцээ бүхий иргэдтэй төсөл хэрэгжүүлэгчийн зүгээс хэзээ ч ганцаарчилсан уулзалт хийж зөвшөөрөл авах, ямар нэг гэрээ хийж болохгүй, заавал эрх зүйн туслалцаа авах, зөвлөлдөх хангалттай хугацаа, боломжийг олгож байх ёстой.
 - Гэмт хэрэг, зөрчил, осол аваар: Уул уурхайн төсөл дагасан хүн амын механик өсөлтөөс гэмт хэрэг, осол аваарын тоо өсдөг, хулгай залилан зэрэг нийгмийн зөрчил, гэмт хэрэг өсдөг. Энэ нь тухайн төрийн байгууллагын ачааллыг нэмэгдүүлдгийг үнэлэх. Мөн шилжиж ирсэн хүн ам нутгийн хүн хооронд төслийн үр шим хүртэхтэй үүдэлтэй иргэн хоорондын маргаан өсдөг. Уурхайд бэлчээр, усаа алдсан малчид өөр баг, суманд нүүж очиход бэлчээр усны зөрчилдөөн нь амь насаа эрсдэлд оруулах хүртэл хэрэг гардаг ч энэ нь иргэн хоорондын маргаан болдог. Энэ нөлөөллийг үнэлж судлахыг энэ хэсэгт ойлгоно.
 - Гэр бүлийн хүчирхийллийн бүртгэл болон албан бус мэдээлэл: Энэ нь итгэл үнэмшил болсон газар ус нь эрсдэлд орсноор эрчүүдийн стресс нэмэгдэж сэтгэл гутралд ордог. Үүнийгээ гэр бүлдээ, өөрийн өмчдөө гаргасныг иргэний танхай, балмад үйлдэл болгож хардаг. Иймд энэ эрсдлийг бүх төсөлд урьчилан/ болзошгүй нөлөөлөл гэж үзэн нөлөөллийн бүсийн иргэдийг чадавхжуулах, мэдлэгжүүлэх, төслийн талаар аль болох эртнээс эрсдлийн мэдээлэл өгөх, ойлгуулах улмаар өрхийн аж ахуйгаа хэрхэн зохицуулж удирдах, стресс уур бухимдалд хүрэлгүйгээр тогтмол уулзалт ярилцлага хийх, байнга сонсох ажлыг төсөл хэрэгжүүлэгчийн “ННҮ-ний Менежментийн төлөвлөгөө”-д оруулж хэрэгжүүлэх арга замыг тусгах;
 - Орон нутгийн иргэд, орон нутгийн удирдлага хоорондын харилцаа: Энд ННҮ хийх үеийн нөхцөл байдалд СВОТ шинжилгээ хийхийн зэрэгцээ мэдээлэл хүргэх, авах, харилцааны хэлбэрийг үнэлэх. Цаашид төсөл хэрэгжсэнээр гарах өөрчлөлтүүдтэй холбоотой хэрхэн хүртээмжтэй, чанартай, итгэл үнэмшил төрөхүйц, иргэдийн оролцоо болон хөгжих эрхийг хангахын тулд “хамтарсан баг”-ын оролцоотой зураглаж шинэ харилцааны стратеги гаргаж талуудын чиг үүрэг, хариуцлагыг гаргах ойлголт. /Хамтын ажиллагааны гэрээ байгуулах, төслийн мэдээллийг ил тод нээлттэй болгох тогтмол арга хэмжээнүүд, багийн ИНХ, багийн өдөрлөг гм энд орно/

6. Төслөөс хүрээлэн буй орчинд үзүүлж буй өөрчлөлтөөс экосистемийн үйлчилгээ буурах, доройтох, уур амьсгалын өөрчлөлт хурдсах нь иргэдийн ажлын ачаалал/амьдралын чанарт үзүүлж буй болон үзүүлж болзошгүй нөлөөлөл

- Байгалийн нөөц, баялгийн (бэлчээр, эмийн болон шимт ургамал, ус рашаан, ой, ойн дагалдах баялаг, ан амьтан) төрөл, чанар, тоо хэмжээг БОННҮ-ний тайлангууд бусад эх сурвалжаас тооцож гаргах, ингэхдээ нутгийн малчдын мэдлэгт түлхүү суурилах
- Тухайн нутгийн иргэд байгалийн нөөцөө хэрхэн ашиглаж ирсэн ёс уламжлал, заншил, туршлага, бусад эх сурвалжид үндэслэн одоогийн нөхцөл байдлыг зураглах,
- Дээрх хоёр зураглалд үндэслэн Хүрээлэн буй орчинд түүний дотор газар/хөрсний эвдрэл, ургамлын бүрхэвч, чанарын хомсдол, усны нөөц хүртээмж болон бохирдол, тоосжилтоос ургамлын бүрхэвчид, талбай хаших, шуудуу татах, бэлчээрээр хүнд даацын машин явах зэрэг олон салаа замын өөрчлөлтөөс үүдэлтэй байгалийн биомасс өгөөж буурах, үржил шимт талбайн хэмжээ хумигдах, усны хомсдолоос иргэдийн өрхийн бизнест, амьдралын чанарт үзүүлэх нөлөөлөл,

- ачаалал, эдийн засагт гарч буй бодит өөрчлөлт иргэдийн амьдралд хэрхэн тусч байгаа болон нөлөөлж болзошгүй нөлөөлөл
- Бэлчээрийн даац: бэлчээрийн ургамлын төрөл зүйл, хэмжээ, чанарын хомсдол, огт алга болсноор малчдаас гарах зардлын төрөл хэмжээ нэмэгдэх эрсдлийг урьдчилан судлах үнэлэх, иргэдэд мэдлэг, мэдээлэл, урьдчилан сануулах, сэтгэл зүйн бэлтгэл хангах хугацааны өмнө мэдэгдэх, нөлөөллийг эрсдэл багатай даван туулах, дасан зохицох мэдлэг ур чадвар олгох арга хэмжээг “ННҮ-ний Менежментийн төлөвлөгөө”-д оруулж хэрэгжүүлэх арга замыг тусгах;
 - Хүнсний чанар, хүрэлцээ, аюулгүй байдал: Тоосжилт, нөөцийн хомсдол, боломжоо түр болон бүр алдах, аюултай баталгаагүй хүнс хэрэглэх зэрэгт орлуулах арга хэмжээ авах, тэр нь хэр хэмжээний мэдлэг, ур чадвар, нөөц шаардах, ямар технологи эзэмших шаардлага гарч болохыг тогтоож үнэлэх, төсөл хэрэгжүүлэгчээс ямар нөөц хүчин чармайлт шаардах, нутгийн захиргаанаас ямар дэмжлэг, оролцоо шаардахыг “ННҮ-ний Менежментийн төлөвлөгөө”-д оруулж хэрэгжүүлэх арга замыг тусгах;
 - Дуу чимээ, тоос шороо, химийн бодис, хог хаягдлын үнэр: Төслийн олборлолт, үйлдвэрлэл, тээвэр, хөдөлгөөний тоо хэмжээг ТЭЗҮ-д үндэслэн тодорхойлох ба эрсдлийн зэргийг тогтоож түүнээс нутгийн хүн ам, нийгэмд үзүүлэх нөлөөллийг тодорхойлно.

7. Эрүүл мэнд, сайн сайхан байдалд гарч буй өөрчлөлт, нөлөөлөл

- Нийгмийн амгалан тайван байдал
- Орон нутгийн иргэдийн биеийн болон сэтгэцийн эрүүл мэнд
- Хүн ам, мал, амьтны аюулгүй байдал
- Мал, амьтны эрүүл мэнд
- Хүн амын дундах халдварт болон халдварт бус өвчлөл
- Хүмүүс хоорондын итгэлцэл, харилцаа, эв нэгдэл, хамтын хөдөлмөр
- Орлогын ялгаа, нийгэм дэх тэгш бус байдлын үзүүлэлт

8. Хүсэл тэмүүлэл, ирээдүйдээ итгэх итгэлд гарч буй өөрчлөлт, нөлөөлөл

- Хувь хүн, өрх гэр бүл, нийгмийн аюулгүй, амгалан тайван байдал
- Ирээдүй, үр хүүхдийн ирээдүйн талаарх хүсэл тэмүүлэл, найдвар
- Төрсөн нутаг, малын бэлчээргүй болох нь гэсэн айдас түгшүүр
- Өрх гэр бүл, хувь хүний амжиргааны эх үүсвэр, орлоготой холбоотой төсөөлөл, эрсдэл, айдас;
- Ажил эрхлэлттэй холбоотой тодорхойгүй байдал
- Ирээдүйн хүсэл, тэмүүлэл, амьдралын төлөвлөгөө;
- Төслийн шууд нөлөөллөөс үүдэлтэй айдас, түгшүүр, дарамт


9. Бусад

- Тухайн төслийн үйл ажиллагаанаас үүдэн гарсан хүний эрхийн зөрчил
- Бусад эерэг, сөрөг өөрчлөлт, нөлөөлөл

Нийгмийн Нөлөөллийн үнэлгээ хийхдээ дээр дурьдсан хүчин зүйлсэд гарсан/ гарч болзошгүй өөрчлөлт, нөлөөллийг хувь хүн, өрх гэр, нийгмийн түвшинд авч үзэж, тодорхойлно

2.3. Нийгмийн нөлөөллийн үнэлгээний үе шат

Нийгмийн нөлөөллийн үнэлгээг байгаль орчны нөлөөллийг үнэлэх бүхий л үе шатанд хамтатган, зэрэгцэн дараах бүтцийн дагуу гүйцэтгэнэ.




Зураг 1. Нийгмийн нөлөөллийн үнэлгээ байгаль орчны нөлөөллийн үнэлгээтэй уялдах байдал

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын асуудал хариуцсан болон байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагууд энэхүү аргачлалд зааснаар дараах арга хэмжээг авна. Үүнд:


- **Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОНННУ)-нд** Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн ерөнхий үнэлгээ (БОННЕУ)-ээр тогтоогдсон гарч болох нийгмийн эерэг нөлөөллийн үр нөлөө, болзошгүй сөрөг нөлөөлөл ба эрсдэл, мөн нөлөөллийн бүсийн хүн амын хүний эрх, эрхэм чанарыг дордуулахгүй байх тоон болон чанарын мэдээлэл, судалгааг нарийвчлан тусгасан эсэхийг нягтлах;
- **Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн менежментийн төлөвлөгөөнд (БОННМТ)-д** Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОНННУ)-ээр тогтоогдсон нийгмийн эерэг нөлөөллийн үр нөлөөг нэмэгдүүлэх, сөрөг нөлөөллийг арилгах, урьдчилан сэргийлэх ба зайлсхийх, хүний эрхийг дордуулахгүй байх бүхий л арга хэмжээ, зардлыг тусгасан менежментийн төлөвлөгөөг жил бүр боловсруулж батлуулах ажлыг тусгасан эсэхийг нягталж, төлөвлөгөөний хэрэгжилтийг салбарын төрийн захиргааны төв болон бусад байгууллага, орон нутгийн засаг захиргаа, нутгийн иргэд хяналт тавьж ажиллана.

Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг боловсруулах хугацааг БОННЕУ-д ерөнхий шинжээчийн дүгнэлт гарснаас хойш 90 хоногт багтаан гүйцэтгэнэ.

ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН ТӨСӨЛ, ТҮҮНИЙГ ДАГАСАН ДЭД БҮТЦИЙН ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЕРӨНХИЙ ПРОЦЕСС



Зураг 2. Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний процесс



Зураг 3. Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний гүйцэтгэлийн бүдүүвч

ГУРАВ. НИЙГМИЙН НӨЛӨӨЛЛИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

Нийгмийн нөлөөллийн төлөв байдлын үнэлгээ нь үнэлгээний ажлын эхний үе шат байх бөгөөд аливаа төслийг хэрэгжүүлэхээс өмнөх үеийн нутаг дэвсгэрийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлыг судалж баримтжуулан, цаашид экосистемийн үйлчлэлд гарах нөлөөллөөс нөлөөллийн бүс, нутаг дэвсгэрийн хүн ам, хүн амын бүлгүүд, өрх гэр бүл тэдний иргэний болон улс төрийн, нийгэм, эдийн засаг, соёлын эрхэд гарах өөрчлөлт, бүс орон нутгийн хөгжлийн төлөв, хандлагын онцлогийг урьдчилан тодорхойлохыг хэлнэ.

Нийгмийн нөлөөллийн төлөв байдлын үнэлгээг байгаль орчны төлөв байдлын үнэлгээний хамт, нийгмийн нөлөөллийн үнэлгээний журамд заасан дагуу эрх бүхий мэргэжлийн байгууллага болон судалгаа, шинжилгээний байгууллагын оролцоотойгоор хийж, шаардлагатай тохиолдолд холбогдох асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хандан чиглэл гаргуулж болно.

Нийгмийн нөлөөллийн төлөв байдлын үнэлгээний үйл ажиллагаа нь дараах үе шатаар хийгдэнэ:

1. Нийгмийн нөлөөллийн үнэлгээний гол зорилго, үндэслэл, цар хүрээг тодорхойлох;
2. Бусад судалгааны мэдээ, мэдээллийг цуглуулах, боловсруулах, нийгмийн нөлөөллийн төлөв байдлыг тодорхойлоход шаардлагатай нэмэлт судалгаа хийх;
3. Судалгааны мэдээллийг эмхэтгэн Нийгмийн нөлөөллийн төлөв байдлын үнэлгээний тайлан боловсруулах.

3.1. Нийгмийн нөлөөллийн төлөв байдлын үнэлгээний гол зорилго, үндэслэл, цар хүрээг тодорхойлох

Нийгмийн нөлөөллийн төлөв байдлын үнэлгээний зорилго, үндэслэл, цар хүрээг дараах байдлаар тодорхойлно. Үүнд:

- Байгаль орчны төлөв байдлын үнэлгээтэй нийцүүлэн тухайн төслийн үйл ажиллагаа, чиглэл, цар хүрээ зэргээс хамаарч нөлөөлөлд шууд болон шууд бусаар өртөж болзошгүй нутаг дэвсгэрийн хил хязгаар, нөлөөллийн бүсийг тодорхойлох,
- Тодорхойлсон нөлөөллийн бүс, газар нутаг, засаг захиргааны нэгжийн нийгэм, эдийн засгийн мэдээлэл, тухайн төслөөс үзүүлэх нийгмийн нөлөөлөл, үр дагаврыг тодорхойлох үзүүлэлтүүдийг аргачлалд зааснаар тодорхойлсон байна.
- Тухайн төслийн үйл ажиллагааны онцлог болон нөлөөллийн бүсийн иргэдийн тодорхойлсон асуудлыг харгалзан нийгмийн эерэг нөлөөллийг нэмэгдүүлэх, болзошгүй сөрөг нөлөөллийг арилгах, урьдчилан сэргийлэх, зайлсхийх зэргийн аль нь болохыг төлөвлөх, зохих нарийвчлалыг тогтоох шаардлагатай.
- Төсөл хэрэгжих газар нутгийн хүн амын газрын эрх, засаг захиргааны нэгжийн газрын ерөнхий төлөвлөгөө, зохион байгуулалтын төлөвлөгөө, түүний хэрэгжилт хөгжлийн хандлагыг судалж тусгана.
- Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн хүн ам, хүн амын бүлгүүд, өрх гэр бүл тэдний иргэний болон улс төрийн, нийгэм, эдийн засаг, соёлын эрхийн төлөв байдлыг тодорхойлно.

Энэ шатанд төсөл хэрэгжүүлэгч нь Нийгмийн нөлөөллийн үнэлгээг гүйцэтгэх эрх бүхий этгээдийн хамт нөлөөллийн бүсийн иргэд, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд, иргэдэд зориулсан төслийн товч танилцуулгыг урьдчилан бэлтгэж хүргүүлсэн байна.

3.2. Нийгмийн нөлөөллийн төлөв байдлыг тодорхойлоход шаардлагатай нэмэлт судалгаа хийх

Судалгааны ажлын нарийвчилсан төлөвлөгөөг энэ шатанд боловсруулж, төлөвлөгөөний дагуу тодорхойлсон нөлөөллийн бүсийн нийгмийн нөлөөлөл, үр дагаврыг тодорхойлох үзүүлэлтүүдээр суурь мэдээллийг төрийн байгууллага, мэдээллийн бусад эх сурвалжаас цуглуулна. Цаашлаад суурь мэдээллийн орхигдсон хэсгийг гүйцээх ажлыг зохион байгуулна.

Нийгмийн нөлөөллийн төлөв байдлын тайлан боловсруулахад дутагдаж байгаа буюу орхигдсон мэдээллийг гаргахдаа дараах шаардлагыг баримтлана.

- Холбогдох хууль тогтоомж, Нийгмийн нөлөөллийн үнэлгээний журамд заасан шаардлагыг хангахад ямар мэдээлэл дутагдаж байгаа;
- Үйл ажиллагааны онцлогт уялдуулан нөлөөлөлд өртөж болзошгүй нөлөөллийн бүс, нутаг дэвсгэрийг бүрэн тодорхойлоход дутагдаж байгаа мэдээлэл;
- Тухайн салбарын шинжлэх ухааны судалгааны хамгийн сүүлийн үеийн арга зүйг баримтлан, үнэн зөв мэдээлэлд тулгуурлан гүйцэтгэх боломж бүрдсэн эсэх;
- Олон улсын байгууллагын стандарт, шаардлагуудыг хангахуйц мэдээлэл байгаа эсэх

Нийгмийн нөлөөллийн төлөв байдлын үнэлгээ нь төсөл хэрэгжиж эхлэхээс өмнөх, тухайн нөлөөллийн бүс нутгийн нийгмийн нөхцөл, байдлыг иж бүрэн илтгэнэ.

3.3. Судалгааны мэдээллийг эмхэтгэн нийгмийн нөлөөллийн төлөв байдлын үнэлгээний тайлан боловсруулах

Нийгмийн нөлөөллийн төлөв байдлын суурь мэдээллийн дүнг нэгтгэн боловсруулахдаа төсөл хэрэгжсэнээр тухайн нутаг дэвсгэрийн экосистемийн үйлчлэлд нөлөөлснөөр нутаг дэвсгэрийн нийгэм, эдийн засаг, хүний эрүүл мэнд, хүний эрхийн өнөөгийн төлөв байдал, хэтийн төлөвт гарах буюу гарч болзошгүй нөлөөллийн талаар цогц мэдээллийг багтаасан тайлан боловсруулна.

Нийгмийн нөлөөллийн төлөв байдлын тайлан боловсруулах мэргэжлийн байгууллага нь баримт бичгийн болон төсөл хэрэгжих газар нутаг, бүсэд очиж орчны/нөхцөл байдлын судалгаа хийсэн байна. Энэхүү судалгаанд үндэслэн нөлөөллийн бүсийг тогтоосон аргачлал, ашигласан судалгааны аргачлалыг агуулсан байна.

Нийгмийн нөлөөллийн төлөв байдлын үнэлгээний тайлан нь дараах бүтэцтэй байна. Үүнд:

- Төслийн товч танилцуулга
- Төсөл хэрэгжих газар нутаг ба төслийн улмаас нөлөөлөлд өртөх нөлөөллийн бүсийн хамрах хүрээ, үндэслэл
- Төсөл хэрэгжих, нөлөөлөлд өртөх засаг захиргааны нэгжийн хөгжлийн бодлогууд, газрын төлөвлөгөө хөтөлбөрүүд, байгаль орчны төлөв байдал биомассын хүртээмж ашиглалт, нутгийн хүн амын амжиргааны хамаарал
- Нийгмийн нөлөөллийн төлөв байдлыг эрхэд суурилсан хандлагаар:

- Төсөл хэрэгжих, нөлөөлөлд өртөх газар нутгийн нийгэм, эдийн засгийн суурь үзүүлэлт,
- Төсөл хэрэгжих, нөлөөлөлд өртөх газар нутгийн хүн амын иргэний, улс төрийн, нийгэм, эдийн засгийн, соёлын эрхийн хэрэгжилт тус бүрийн төлөв байдал
- Төсөл хэрэгжих, нөлөөлөлд өртөх газар нутагт хэрэгжиж буй эрдэс баялгийн салбарын ижил төстэй төслүүдийн нийгмийн нөлөөллийн одоогийн тойм
- Бусад
- Гарч болзошгүй нөлөөлөл
 - Төслөөс гарах эерэг нөлөөлөл
 - Төслөөс үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, эрсдэл
- Дүгнэлт:
 - Төслийн нийгмийн нөлөөллийн төлөв байдлын үнэлгээний дүгнэлт
 - Хавсралт материал: зураглал, дүрсжүүлэлт, фото болон бусад хэлбэрийн баримт нотолгоо бусад баримтжуулалт.
- Ашигласан мэдээлэл, эх сурвалж
- Төлөв байдлын үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллагын дэлгэрэнгүй танилцуулга, мэргэжилтнүүдийн танилцуулга, Мэргэжлийн байгууллагын Нийгмийн нөлөөллийн төлөв байдлын үнэлгээ хийсэн ажлын жагсаалт

Нийгмийн нөлөөллийн төлөв байдлын үнэлгээ хийж, тайлан боловсруулсан эрх бүхий мэргэжлийн байгууллага нь боловсруулсан Нийгмийн нөлөөллийн төлөв байдлын тайланг /ННТБ/ хүн амын хөгжил, нийгмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх үнэлгээний асуудал эрхэлсэн мэргэжлийн зөвлөлд хүргүүлж хянуулна.

Дөрөв. НИЙГМИЙН НӨЛӨӨЛЛИЙН ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ

Нийгмийн нөлөөллийн ерөнхий үнэлгээ /НННУ/ нь төслийн Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн төлөв байдлын үнэлгээний дүгнэлтэд үндэслэн хийгдэнэ. Нийгмийн нөлөөллийн ерөнхий үнэлгээ /НННУ/ нь Байгаль орчны ерөнхий үнэлгээтэй хамт хийгдэж нэг тайлан гарна. НННУ-г төлөвлөлтийн эхний үе шатанд хууль тогтоомж, судалгааны материал, техник технологи, стандарт, норм норматив, анхдагч мэдээ, тоо баримтад тулгуурлан хийгдэх бөгөөд тухайн төслийн нийгэмд учруулах сөрөг нөлөөллийг урьдчилсан байдлаар тогтоож, цаашид нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд нарийвчлан судлах шаардлагыг тодорхойлох үйл ажиллагаа юм.

4.1. Нийгмийн нөлөөллийн ерөнхий үнэлгээг хариуцан гүйцэтгэгч

Нийгмийн нөлөөллийн үнэлгээний ерөнхий шинжээчийг үнэлгээ хийх мэргэжлийн чадвар, ажлын дадлага туршлагыг харгалзан Хүн амын хөгжил, нийгмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр томилно.

/НННУ/ Нийгмийн нөлөөллийн Ерөнхий үнэлгээг Хүн амын хөгжил, нийгмийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас томилогдсон ерөнхий шинжээч гүйцэтгэх бөгөөд байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын ерөнхий шинжээчийн дүгнэлт, төслийн ТЭЗҮ-д үндэслэн гүйцэтгэнэ.

4.2. Төсөлд Нийгмийн нөлөөллийн ерөнхий үнэлгээ /ННЭҮ/ хийлгэх хүсэлт гаргах

Төсөл хэрэгжүүлэгч нь холбогдох эрх бүхий байгууллагаар баталгаажсан техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчин, нийгмийн өнөөгийн төлөв байдлын тодорхойлолт, тухайн сум, дүүргийн Засаг даргын санал болон холбогдох бусад баримт бичгийг бүрдүүлэн Хүн амын хөгжил, нийгмийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хандаж Нийгмийн нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлгэнэ. Хүсэлтэд:

- Төсөл хэрэгжүүлэгчийн ерөнхий үнэлгээ хийлгэх тухай хүсэлт /албан бичиг/;
- Төслийн танилцуулга тодорхойлолт;
- Газар зүйн мэдээллийн системийн зөвлөмжийн дагуу бүс нутаг, сав газар, нутаг дэвсгэрийн орон зайн зураглалд үндэслэн төсөл хэрэгжих талбайд хамаарах нутаг дэвсгэрийн өвөлжөө, хаваржаа, отрын болон хадлангийн нутаг, хүн, малын ундны ус усны эх үүсвэр, рашаан, худаг, тахилгат уул, овоо, түүхт соёлын дурсгалт зүйлсийн байршлыг харуулж, газар нутгийн албан ёсны болон нутгийн иргэдийн нэрлэж заншсан албан бус нэрийг аль алиныг бичиж харуулсан зураглал /Зураглал/;
- Холбогдох эрх бүхий байгууллагаар баталгаажсан техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөл. Техник эдийн засгийн үндэслэлд нийгмийн нөлөөллийн төлөв байдлын үнэлгээнд тусгагдсан нийгмийн сөрөг нөлөөллийг арилгах арга хэмжээ, төсөв, төлөвлөгөөг тусгасан байна;
- Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн нийгмийн нөлөөллийн төлөв байдлын тодорхойлолт, нийгмийн нөлөөллийн төлөв байдлын үнэлгээний тайлан, дүгнэлт
- Тухайн сум, дүүргийн Засаг даргын тодорхойлолт;
- Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар;
- Тусгай зөвшөөрөл, кадастрын зураг;
- Газрын зөвшөөрөл, кадастрын зураг;
- XV лицензтэй бол хайгуулын ажлын батлагдсан тайлан, нөөц баталсан шийдвэр;
- MV лицензтэй бол эрх бүхий байгууллагаар батлагдсан ТЭЗҮ, нөөц баталсан шийдвэр
- Орон нутгийн захиргаатай байгуулах гэрээнд тусгаж шийдвэрлэх боломжтой нийгмийн сөрөг нөлөөлөл, эрсдэлийн удирдлагын танилцуулга;

4.3. Нийгмийн нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийхэд тавигдах шаардлага

Нийгмийн Нөлөөллийн ерөнхий үнэлгээг хийх явцад шинжээч дараах асуудлыг анхааран үзэх шаардлагатай. Үүнд:

1. Төлөв байдлын үнэлгээний хүрээнд тодорхойлсон нөлөөллийн бүс нутгийн зураглал албан ёсны бусад эх сурвалжтай нийцэж байгаа эсэх;
2. Зураглалаар тухайн төсөл нь Монгол Улсын хууль, бусад хууль тогтоомжийн шаардлагад нийцэж байгаа эсэх;
3. Зураглалаар тухайн төсөл нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн хүн, малын ундны ус, худаг, булаг шанд, өвөлжөө, хаваржаа болон хадлан отрын газар, тахилгат уул, овоог хөндөхөөр бол байдал хэрхэн өөрчлөгдөхийг хүн амын иргэний, улс төрийн, нийгэм, эдийн засаг, соёлын эрхийг хангах эсвэл саад болох талаарх үндэслэл;
4. Зураглалаар тухайн төсөл нь хүн, малын ундны ус, гол мөрөн, худаг, булаг шанд, малын бэлчээр, отрын газар, тахилгат уул, овоо болон түүх соёлын дурсгалт зүйлсийг хөндөхөөр бол үр дагаврыг арилгах, зөрчигдсэн эрхийг сэргээх техник-эдийн засгийн үндэслэлд тусгагдсан төлөвлөгөө, төсөв, арга хэмжээний хэрэгжихүйц байдал, хугацаа, нөхцөл нь

холбогдох хууль тогтоомж, эрх зүйн шаардлага, нутгийн иргэдийн хүлээлтэд нийцсэн эсэх;

5. Төсөл хэрэгжүүлэх аж ахуйн нэгж, байгууллагын баримт бичиг нь хүчин төгөлдөр мөрдөж буй хууль, эрх зүйн шаардлагад нийцэж байгаа эсэх;
6. Төсөл хэрэгжих газар бүс нутгийн шинжтэй хуримтлагдах нөлөөлөл үүссэн эсэхийг тодруулах, хэрэв хоёр ба түүнээс дээш төсөл Зураглалд багтсан газрыг дайрч байгаа бол хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийлгэнэ.
7. Төслийн онцлогоос хамааран бусад шаардлагатай мэдээлэл, баримт.
8. Нийгмийн нөлөөллийн үнэлгээнд баримтлах суурь зарчим хангасан тайлбар
9. Нийгмийн нөлөөллийн үнэлгээний явцад баримтлах үйл ажиллагааны зарчим хангасан тайлбар танилцуулга

Нийгмийн нөлөөллийн Ерөнхий үнэлгээг гүйцэтгэсэн ерөнхий шинжээч дээрх асуудлуудыг харгалзан үзэж, “Нийгмийн нөлөөллийн ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудас”-ын дагуу үнэлгээний ажлын үр дүнг нэгтгэн дүгнэлт гарна. Нийгмийн нөлөөллийн ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудсыг Мэргэжлийн зөвлөл батална.

1-р хавсралт. Нийгмийн нөлөөллийн ерөнхий үнэлгээний хүсэлт, баримт бичиг хүлээн авах маягт

Төсөл хэрэгжүүлэгч:

Төсөл хэрэгжих байршил, хамрагдах баг:

Төслийн үе шат: (хайгуул, ашиглалт, барилга г.м)

Холбоо барих утас, цахим шуудан.....

Төсөл хэрэгжүүлэгчийн бүртгэлтэй хаяг:.....

Баримт бичиг	Шаардлагатай эсэх	Шаардлага хангасан эсэх	Тайлбар
Төсөл хэрэгжүүлэгчийн ерөнхий үнэлгээ хийлгэх тухай хүсэлт /албан бичиг/			
Төслийн товч тодорхойлолт			
Газар зүйн мэдээллийн системийн зөвлөмжийн дагуу бүс нутаг, сав газар, нутаг дэвсгэрийн орон зайн зураглалыг хийхээс гадна төсөл хэрэгжих нутаг дэвсгэрт хамаарах бэлчээр, хүн, малын ундны ус, худаг, тахилгат уул, овоо, түүхт соёлын дурсгалт зүйлсийн байршлыг харуулж, газар нутгийн албан ёсны болон нутгийн иргэдийн нэрлэж заншсан албан бус нэрийг аль алиныг бичиж харуулсан зураглал			
Холбогдох эрх бүхий байгууллагаар баталгаажсан техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөл			
Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн нийгмийн нөлөөллийн төлөв байдлын тодорхойлолт			
Орон нутагт байгуулах гэрээнд тусгаж шийдвэрлэх нийгмийн сөрөг нөлөөлөл, эрсдэлийн удирдлагын танилцуулга			
Засаг даргын тодорхойлолт			

Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар			
Тусгай зөвшөөрлийн хуулбар, кадастрын зураг			
XV лицензтэй бол хайгуулын ажлын батлагдсан тайлан, нөөц баталсан шийдвэр			
MV лицензтэй бол эрх бүхий байгууллагаар батлагдсан ТЭЗҮ, нөөц баталсан шийдвэр			
Газрын зөвшөөрөл, кадастрын зураг			

Хүлээн авсан материалын хуудасны тоо.....

Хүлээн авсан:

Овог, нэр:

Алба тушаал:

Гарын үсэг:

Огноо:

Хүлээлгэн

өгсөн:

Овог, нэр:

Алба тушаал:

Гарын үсэг:

2-р хавсралт. Нийгмийн нөлөөллийн ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудас

Төсөл хэрэгжүүлэгч:
 Төсөл хэрэгжих байршил, хамрагдах баг:
 Төслийн үе шат: (хайгуул, ашиглалт, барилга г.м)
 Холбоо барих утас, цахим шуудан.....
 Төсөл хэрэгжүүлэгчийн бүртгэлтэй хаяг:.....

Шалгуур		Нийцсэн	Нийцээгүй	Нарийвчилсан үнэлгээ хийх шаардлагатай	Тайлбар
Хүний суурь эрхийг хангах хууль тогтоомжийн нийцэл	Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа олон улсын гэрээ, конвенц, Үндсэн хуулийн холбогдох заалт				
Төрийн бодлого, шийдвэрийн нийцэл	Төрөөс баримтлах бодлогын баримт бичиг, Стратегийн үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийн холбогдох заалт				
Төслийн байршил, түүнтэй холбогдох шалгуурууд	2 ба түүнээс дээш ижил төрлийн төсөл тухайн багт хэрэгждэг, хуримтлагдсан нөлөөллийн үнэлгээ хийсэн эсэх				
	Тухайн төсөл хэрэгжсэнээр хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийх эсэх				
Нийгмийн нөлөөллийн үнэлгээнд баримтлах суурь зарчим хангасан тайлбар бодитой эсэх					
Нийгмийн нөлөөллийн үнэлгээний явцад баримтлах үйл ажиллагааны зарчим хангасан тайлбар танилцуулга хангалттай эсэх					
Нийгмийн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ: төслийн нөлөөлөлд өртөх хүн амын иргэний, улс төрийн, нийгэм, эдийн засаг, соёлын	Амьдралын хэв маягт гарах өөрчлөлт, нөлөөлөл				
	Амьжиргаагаа залгуулж буй хэлбэр өөрчлөгдөх				
	Орлогын эх үүсвэр өөрчлөгдөх				
	Амьдралын өртөг, зардал нэмэгдэх				
	Гэр бүлийн хөдөлмөрийн хуваарь өөрчлөгдөх				
	Албадан нүүлгэн шилжүүлэлт хийгдэх				
	Хүний эрхийн зөрчил нэмэгдэх				
	Орон нутагт ажиллах хүчний нөөцийн хомсдол үүсэх				
	Хувийн болон гэр бүлийн өмчийн эрхэд гарах өөрчлөлт, нөлөөлөл				
Газар ашиглах эрхэд гарсан					

эрхэд хэрхэн нөлөөлөх	өөрчлөлт					
	Өрхийн хэмжээнд малын тоо толгой өөрчлөгдөх					
	Малын жин, чанар, эрүүл мэнд өөрчлөгдөх					
	Усны чанар, хүртээмж					
	Орон нутгийн шийдвэр гаргалтад оролцох боломжид гарах өөрчлөлт, нөлөөлөл					
	Орон нутгийн иргэд өөрсдийн амьдралд нөлөөтэй шийдвэр гаргалтад оролцох боломж өөрчлөгдөх					
	Үнэт зүйлс, соёл болон итгэл үнэмшил, гарах өөрчлөлт, нөлөөлөл					
	Орон нутгийн иргэдийн хэл, харилцаа өөрчлөгдөх					
	Баяр, тэмдэглэлт өдрүүд өөрчлөгдөх					
	Хувцаслалт өөрчлөгдөх					
	Ёс заншил, уламжлал өөрчлөгдөх					
	Шашин шүтлэг өөрчлөгдөх					
	Иргэд хоорондын харилцаа, төрийн үйлчилгээний чанар хүртээмжид гарах өөрчлөлт, нөлөөлөл					
	Хүмүүс хоорондын харилцаа, итгэлцэл, эв нэгдэл өөрчлөгдөх					
	Эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний чанар, хүртээмж өөрчлөгдөх					
	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж өөрчлөгдөх					
	Гэмт хэргийн төрөл, давтамжид гарах өөрчлөлт					
	Малчид, орон нутгийн удирдлага хоорондын үл ойлголцол, маргаан ихсэх					
Хүрээлэн буй орчинд гарах өөрчлөлт, нөлөөлөл						
Хүнсний чанар, хүрэлцээ өөрчлөгдөх						
Хүн ам, мал, амьтны аюулгүй байдал өөрчлөгдөх						
Байгалийн нөөц, баялаг (бэлчээр, ус, ой, ойн дагалдах баялаг, ан амьтан, загас)-ийн хүртээмж, баялгийг ашиглах арга хэлбэр өөрчлөгдөх						
Орчны дуу чимээ, тоосжилт нэмэгдэх						
Эрүүл мэнд, иргэдийн амгалан тайван байдалд гарах өөрчлөлт, нөлөөлөл						

Хүн амын дундах халдварт болон халдварт бус өвчлөл				
Сэтгэцийн эрүүл мэнд өөрчлөгдөх				
Химийн бодис болон орчны бохирдлоос үүдэлтэй өвчлөл нэмэгдэх				
Хөдөлмөрийн аюулгүй байдлын (ХАБ) дүрэм журам зөрчигдсөний улмаас осол гэмтэл гарах, иргэд амь нас, эрүүл мэндээрээ хохирох				
Хүсэл тэмүүлэл, ирээдүйдээ итгэх итгэлд гарах өөрчлөлт, нөлөөлөл				
Хүмүүсийн өөрсдийн аюулгүй байдал, ирээдүй, үр хүүхдийнхээ ирээдүйн талаарх хүсэл тэмүүлэл ба тодорхойгүй байдлаас үүдэлтэй айдас хүйдэс нэмэгдэх				
Ажил эрхлэлт, ажлын байраа алдах айдас нэмэгдэх				
Төсөлд ажиллах гадаад улсын иргэдээс үүдэлтэй зөрчил, үл итгэлцэл				
Бусад				
Шүүхээр гомдол шийдвэрлэхэд гарах өөрчлөлт				
Нэгдсэн дүгнэлт:				
Онцгойлон анхаарах зүйлс:				
Ерөнхий үнэлгээ хийсэн Овог, нэр: Алба тушаал: Гарын үсэг: Огноо:	Ерөнхий үнэлгээний үр дүнг зөвшөөрсөн: Овог, нэр: Алба тушаал: Гарын үсэг: Огноо:			

Тав. НИЙГМИЙН НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭ

Нийгмийн нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлтээр Нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ /НННҮ/ хийлгэх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд хийгдэнэ. Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас томилсон ерөнхий шинжээч нь Нийгмийн нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлтэд нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын зорилт, чиглэл, хамрах хүрээ, хугацааг тодорхой заана.

Нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ нь Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэг бүрэлдэхүүн хэсэг бөгөөд үнэлгээг хамтад нь гүйцэтгэж БОНННҮ-/Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ/-ний нэгдсэн нэг тайлан боловсруулна.

Эрдэс баялгийн салбарын төсөл болон холбогдох дэд бүтцийн төсөлд хийгдэх “Нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ”-г нийгмийн салбарын мэргэшсэн судлаачид болон нутгийн иргэдийн төлөөллөөс бүрдсэн холимог баг хамтран гүйцэтгэнэ. Ингэхдээ байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, ерөнхий үнэлгээний шинжээчийн дүгнэлтэд үндэслэн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийж буй мэргэжлийн байгууллагатай нягт хамтран ажиллана.

Нөлөөллийн бүсийн иргэдийн оролцоог бодитой хангах, нутгийн захиргаатай харилцах, зөвлөлдөх, бүх төрлийн уулзалт хэлэлцүүлэг, судалгааны ажилд Нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний болон байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийж буй байгууллагууд хамтдаа мэдээлэл өгөх, санал авах ажиллагааг зохион байгуулна. Олон нийтийг тэр дундаа нөлөөллийн бүсийн иргэдэд мэдээлэл өгөхдөө төсөл хэрэгжсэнээр нутгийн хүн амын эрүүл, аюулгүй амьдрах орчин, экосистемд үзүүлэх нөлөөлөл нь нийгмийн ямар нөлөөллүүд үүсгэж болох түүнээс урьдчилан сэргийлэх, зайлсхийх, экосистемд үзүүлэх нөлөөллийг мөн арилгах арга хэмжээг маш тодорхой танилцуулна. Экосистемийн үйлчлэлийг алдагдуулах, өөрчлөх, орлуулах, зөөх, хаших зэрэг газрын эрхэд халдах аливаа тохиолдолд нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө гаргах эсэх, нөхөх олговрын ямар бодлого арга хэмжээ хэрэгжүүлэхийг мэдэгдэх, мэдээллээр хангах шаардлагатай.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх мэргэжлийн байгууллага нь дангаараа нийгмийн салбарын нөлөөллийн үнэлгээ хийх боломжгүй. Хүн амын хөгжил нийгмийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас тавигдсан мэргэжлийн тусгай шаардлага, ААН-ийн тусгай зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэн эрх авсан, хүний нөөц бүхий мэргэжлийн байгууллага Нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг гүйцэтгэнэ.

Нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ Төслийн болзошгүй эерэг, сөрөг нөлөөлөл, хариу арга хэмжээг хувь хүн, өрх гэр, нийгмийн түвшинд тус тус тодорхойлно.

Нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх бүхий л үйл явцад 1-р бүлэгт заасан Нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийхэд баримтлах зарчмуудыг бүрэн, хатуу мөрдөхийг шаардана.

4.1. Нарийвчилсан үнэлгээг гүйцэтгэх үе шат. Эдгээр үе шат бүрийг алгасах, нэгтгэхийг хориглоно.

Нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг гүйцэтгэхдээ дараах үе шатыг баримтална. Үүнд:

- I үе шат: Бэлтгэл хангах, хамтарсан баг бүрдүүлэх;
- II үе шат: Суурь мэдээлэл бүрдүүлэх;
- III үе шат: Мэдээлэлд боловсруулалт хийх;
- IV үе шат: Нөлөөллийн бүсийн иргэд иргэд, оршин суугчдаас албан ёсоор санал авч, хэлэлцүүлэг зохион байгуулна¹
- V үе шат: Эерэг ба сөрөг нөлөөллийг үнэлэх;
- VI үе шат: Нийгмийн нөлөөллийн менежментийн төлөвлөгөө боловсруулах;

¹ - БОНБҮТ хуулийн 18.4.Төслийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийж байгаа хуулийн этгээд тайлан боловсруулах явцдаа төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэд, оршин суугчдаас албан ёсоор санал авч, хэлэлцүүлэг зохион байгуулна.

- VII үе шат: Нөлөөллийн бүсийн иргэдийг мэдлэг мэдээллээр хангах, оролцоог хангах;²
VIII үе шат: Үнэлгээний тайлан бэлтгэх;
IX үе шат: Сонсох ажиллагаа явуулах болон Багийн ИНХ-ын хуралдаанаар БО,НННҮ-ний тайлангийн төслийг хэлэлцүүлэх, санал авах;
X үе шат: Батлагдсан БО, НННҮ тайлан, Менежментийн төлөвлөгөө, Хяналт шинжилгээний хөтөлбөрийг ил тод нээлттэй болгох;

I үе шат: Бэлтгэл хангах, хамтарсан баг бүрдүүлэх

Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний бэлтгэл үе шатыг нийгмийн нөлөөллийн ерөнхий үнэлгээний үр дүнд үндэслэн гүйцэтгэнэ. Энэ үе шатыг дараах байдлаар төлөвлөнө. Үүнд:

1. Үнэлгээний ажлын зорилго, зорилтоо тодорхойлох, ерөнхий төлөвлөгөө, хуваарь гаргах
2. Үнэлгээний ажлын удирдамж боловсруулах, үнэлгээг гүйцэтгэх судлаачдын баг болон хамтарсан баг бүрдүүлэх
3. Үнэлгээнд шаардлагатай тоног төхөөрөмжийг бэлтгэх, оролцогч талуудыг тодорхойлох
4. Үнэлгээний хамрах хүрээг тодорхойлох, нөлөөллийн бүсийн орон нутгийн иргэд, эмзэг бүлэг, орон нутгийн шийдвэр гаргагч оролцогч талуудыг тодорхойлох
5. Ажлын нарийвчилсан төлөвлөгөө гаргах, ашиглагдах арга зүй, аргачлалын тойм төлөвлөх, шалгуур үзүүлэлт, судалгааны асуулга зэргийг боловсруулах.

Төслийн үйл ажиллагаа ирээдүйд тэлж өргөжих магадлалтай байдаг тул нөлөөллийг өргөн хүрээнд авч үзнэ. Нөлөөлөл тодорхойлох үнэлгээний багт орж ажиллах нутгийн иргэд, удирдлагын төлөөллийг нөлөөллийн сумын нийт иргэдийн дунд санал асуулга явуулж тодруулна. Нөлөөллийн үнэлгээний багт ажиллах нутгийн иргэд нь орон нутгийн бүх иргэдийн бүлгийн төлөөллийг хангахуйц /үүнд: өндөр настан, эмэгтэйчүүд, өрх толгойлсон өрх, нийгмийн онцлогт хөгжил, малчин, албан хаагч, бизнес эрхлэгч г.м./, орон нутагтаа тодорхой хугацаанд тогтмол амьдарсан иргэд байна. Нөлөөллийн бүсийн иргэд зөвшилцөж, нийгмийн нөлөөллийн үнэлгээний багт хөндлөнгийн, хүний эрх, эдийн засаг ба нийгмийн тэгш хүртээмжийг хангах зэрэг чиглэлээр тасралтгүй, идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг ажиллуулж болох бөгөөд энэ эрхийг нутгийн иргэд сонгоно.

II үе шат: Суурь мэдээлэл бүрдүүлэх


Энэ үе шатны зорилго нь нийгмийн нөлөөллийн төлөв байдлын үнэлгээнд урьдчилсан байдлаар тодорхойлсон нөлөөллийн бүсийн газар нутгийн цар хүрээ нь тухайн төслийн нөлөөллийн бүс мөн эсэх, хүрээлэн буй орчинд болон нутгийн иргэд, өрх айл, хамт олонд үзүүлэх нийгмийн нөлөөллийг тодорхойлоход бүрэн хамрагдсан эсэхийг нягталж, төслийн зэрэг, сөрөг нөлөөлөлд шууд болон шууд бус байдлаар өртөх, өртөж болзошгүй орон нутгийн иргэд, бусад оролцогч тал, үүсэж болзошгүй хүний эрхийн болон нийгмийн асуудлыг бүрэн тодорхойлоход шаардлагатай суурь мэдээлэл бүрдүүлэх ажиллагаа юм. Уг ажлыг дараах байдлаар хийж гүйцэтгэнэ. Үүнд:

² - БОНБҮТ хуулийн 18.5.Олон нийтийн оролцооны асуудлыг журмаар зохицуулах бөгөөд уг журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд батална дагуу БОНХАЖЯ ны сайдын 2014 оны А05 тушаал

1. Суурь мэдээллийг цуглуулах, орхигдсон мэдээллийг илрүүлэх;
2. Урьдчилсан байдлаар тодорхойлсон төслийн *нийгмийн нөлөөллийн* бүсийг баталгаажуулах, шаардлагатай үнэдслэлтэйгээр тэлэх, багасгах;
3. Төсөл хэрэгжих орчны нийгмийн суурь нөхцөл байдал, онцлогийг тодорхойлсныг тодотгох, шинэчлэх;
4. Төслийн эерэг, сөрөг нөлөөлөлд шууд болон шууд бус байдлаар өртөх магадлалтай орон нутгийн иргэд, бусад оролцогч талыг тодорхойлох;
5. Төслийн эерэг, сөрөг нөлөөлөлд шууд болон шууд бус байдлаар өртөх магадлалтай бүс нутгийн зураглалыг гаргах;
6. Нөлөөлөлд өртөх бүсэд хэрэгжих бусад төслийг ерөнхий байдлаар тодорхойлох, шаардлагатай бол хуримтлагдах нөлөөллийн таамаглал боловсруулах.

Зураглал (жишээ)

XV-010000 тусгай зөвшөөрөлтэй талбайн тэмдэг, тэмдэглэгээ (жишээ загвар)



XV-01000000

III үе шат: Мэдээлэлд боловсруулалт хийх

Энэ шатны зорилго нь бүрдүүлсэн суурь мэдээлэлд дүн шинжилгээ хийх, мэдээллийг бататгах, шаардлагатай бусад нэмэлт мэдээлэл бүрдүүлэхэд чиглэнэ. Уг ажлыг дараах байдлаар хийж гүйцэтгэнэ. Үүнд:

1. Төслийн танилцуулга, үйл ажиллагаанаас экосистемд үзүүлэх нөлөөллийг Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний судалгаанд үндэслэн холбогдох мэдээллийг нутгийн удирдлагууд, нөлөөллийн бүсийн иргэд, бусад оролцогч талуудад хүргэж, судалгааны мэдээллийг баталгаажуулах, орхигдсон мэдээллийг олж тогтоох
2. Төслийн экосистемд үзүүлэх өөрчлөлтийн улмаас үүсэж болзошгүй хүний эрхийн болон нийгмийн асуудлуудыг нарийвчлан энэ аргачлалд санал болгож буй 8 төрөл тус бүрээр тодорхойлох
3. Төслөөс нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөлөл, болзошгүй өртөлт, үр дагаврыг тооцоолох
4. Эерэг нөлөөллийг нутгийн хөгжилд хэрхэн ашиглах боломжтой, түүнийг баталгаажуулах хуульчлагдсан механизмуудыг харуулах

Мэдээлэлд боловсруулалт хийх нь судалгааны чухал хэсэг бөгөөд энэ шатанд хүснэгт 1-т заасан дараах аргачлалыг ашиглаж болно.

Энэ үе шатанд Нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн эхний төсөл баримт бичиг нь Нийгмийн нөлөөллийн менежментийн төлөвлөгөөний анхны төсөл гарсан байна. Эдгээр нь Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний хүрээнд баримт бичгийн болон хээрийн судалгаатай зэрэгцээ хийгдэнэ.

Хүснэгт 1. Мэдээлэл боловсруулах жишиг аргачлал

№	Нийгмийн нөлөөлөл	Индикатор, хэмжих давтамж	Ашиглах арга зүй	Ашиглах мэдээлэл
Амьдралын хэв маягт гарч буй өөрчлөлт, нөлөөлөл				
1	Амьжиргаагаа залгуулж буй хэлбэр өөрчлөгдөх	Мал маллахаа больсон иргэдийн тоо, жил бүр	Ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлага Статистик анализ	Сум, аймаг, улсын статистик мэдээлэл Малчид, орон нутгийн удирдлагатай хийсэн ярилцлага, мэдээлэл
		Сум, аймаг, хот руу шилжсэн иргэний тоо, жил бүр		
		Уурхай, гэрээт компанид ажилд орсон иргэний тоо, жил бүр		
2	Орлогын эх үүсвэр өөрчлөгдөх	Өрхийн нийт орлогод гарсан өөрчлөлт, жил бүр	Статистик анализ Ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлага Нөхцөл байдлын таамаглалын арга	Сум, аймаг, улсын статистик мэдээлэл Оролцогч талуудтай хийсэн ярилцлага, мэдээлэл
		Төсөл болон холбогдох байгууллагуудад бүтэн, хагас цагийн болон ээлжийн ажилд орсон өрхийн гишүүний тоо, жил бүр		
		Өрхийн малын тоонд гарсан өөрчлөлт, жил бүр		
3	Амьдралын өртөг, зардал нэмэгдэх	Амьдралын дундаж өртөг, зардалд гарсан өөрчлөлт, жил бүр	Статистик анализ	Сум, аймаг, улсын статистик мэдээлэл

		Хүнсний бүтээгдэхүүний үнэд гарсан өөрчлөлт, жил бүр	Ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлага Нөхцөл байдлын таамаглалын арга	Оролцогч талуудтай хийсэн ярилцлага, мэдээлэл
		Байр, орон сууц, газар, автомашины үнэд гарсан өөрчлөлт, жил бүр		
		Хувцас, өргөн хэрэглээний барааны үнэд гарсан өөрчлөлт, жил бүр		
		Эрүүл мэндийн үйлчилгээ, эм тарианы үнэд гарсан өөрчлөлт, жил бүр		
		Боловсролын үйлчилгээ, үнэд гарсан өөрчлөлт, жил бүр		
4	Гэр бүлийн хөдөлмөрийн хуваарь өөрчлөгдөх	Өрхийн хүүхдүүдийн хөдөлмөрийн хуваарьт орсон өөрчлөлт, 3 жил тутам	Статистик анализ	Сум, аймаг, улсын статистик мэдээлэл
		Өрхийн эрэгтэй, эмэгтэй гишүүдийн хөдөлмөрийн хуваарьт орсон өөрчлөлт, 3 жил тутам	Ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлага	Оролцогч талуудтай хийсэн ярилцлага, мэдээлэл
5	Албадан нүүлгэн шилжүүлэлт хийгдэх	Бэлчээр, усны боломжоос шалтгаалан хийх нүүдлийн тоо, жил бүр	Статистик анализ	Сум, аймаг, улсын статистик мэдээлэл
		Ширгэсэн, ус нь багассан худгийн тоо, 3 жил тутам	Ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлага	Малчид, орон нутгийн удирдлагатай хийсэн ярилцлага, мэдээлэл
		Өвөлжөө, хаваржааны газраа алдсан өрхийн тоо, жил бүр	Нөхцөл байдлын таамаглалын арга	
		Өмнө ашиглаж байсан худаг, бэлчээрээ ашиглах боломжгүй болсон өрхийн тоо, жил бүр	Нөлөөллийн загварчлалын арга	
		Уурхайн тоосжилт, дуу чимээ зэрэг нөлөөллийн улмаас нүүсэн өрхийн тоо, жил бүр		
6	Хүний эрхийн зөрчил нэмэгдэх	Хүний эрхийн үндэсний комиссын аймаг дахь албан хаагчид ирсэн гомдлын тоо, жил бүр	Статистик анализ	Сум, аймаг, улсын статистик мэдээлэл
		Орон нутгийн цагдаагийн албан хаагчид ирсэн гэмт хэрэг зөрчилтэй холбоотой гомдлын тоо, жил бүр	Ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага Хоёрдогч эх сурвалжийн анализ	Хүний эрхийн үндэсний комиссын тайлан, мэдээлэл
7	Орон нутагт ажиллах хүчний нөөцийн хомсдол үүсэх	Орон нутгийн иргэдийн эзэмших мэргэжилд гарах өөрчлөлт, 3 жил тутам	Статистик анализ	Сум, аймаг, улсын статистик мэдээлэл
		Орон нутгийн иргэдийн ажил эрхлэлтэд гарах өөрчлөлт, жил бүр	Ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага Хоёрдогч эх	Ажил эрхлэлт, мэргэжил сонголттой холбоотой тайлан

			сурвалжийн анализ	мэдээлэл
Хувийн болон гэр бүлийн өмчийн эрхэд гарч буй өөрчлөлт, нөлөөлөл				
8	Газар ашиглах эрхэд гарсан өөрчлөлт	Өвөлжөө, хаваржааны газаргүй болсон/болох айл өрхийн тоо, жил бүр	Статистик анализ Ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага Хоёрдогч эх сурвалжийн анализ Нөхцөл байдлын таамаглалын арга Нөлөөллийн загварчлалын арга	Газар ашиглалт, бэлчээр, худагтай холбоотой сум, аймаг, улсын статистик мэдээлэл Оролцогч талуудтай хийсэн ярилцлага, мэдээлэл Холбогдох бусад тайлан, өгүүлэл
		Баг, сум, аймаг дахь газар ашиглагчдын тоо, 3 жил тутам		
		Баг, сум, аймаг дахь газар ашиглалтын хэлбэр, 3 жил тутам		
		Бэлчээр ашиглалтын хэмжээ, 5 жил тутам		
		Бэлчээрийн хүртээмжтэй байдал, 5 жил тутам		
		Нүүлгэн шилжүүлсэн өрхийн тоо, 3 жил тутам		
		Нөхөн олговрын хөтөлбөрт хамрагдсан өрхийн тоо, 3 жил тутам		
		Уламжлалт байдлаар газар эзэмшиж буй (гэрчилгээгүйгээр) өрхийн тоо, жил тутам		
9	Өрхийн хэмжээнд малын тоо толгой өөрчлөгдөх	Малын тоо, жил бүр	Статистик анализ Ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага Хоёрдогч эх сурвалжийн анализ	Малын тоо толгой, жин, чанар, эрүүл мэндтэй холбоотой сум, аймаг, улсын статистик мэдээлэл Оролцогч талуудтай хийсэн ярилцлага, мэдээлэл
11	Усны чанар, хүртээмж	Ширгэсэн болон ширгээгүй худгийн тоо, 3 жил тутам	Ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага Хоёрдогч эх сурвалжийн анализ	Тоон болон чанарын судалгааны мэдээлэл
		Усны чанар, хэмжээ, жил бүр		
Орон нутгийн шийдвэр гаргалтад оролцох боломжид гарсан өөрчлөлт, нөлөөлөл				

12	Орон нутгийн иргэд өөрсдийн амьдралд нөлөөтэй шийдвэр гаргалтанд оролцох боломж өөрчлөгдөх	Баг, сум, хорооны хурал, нийтийн сонсох үйл ажиллагаа явагдах давтамж, жил бүр	Ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага	Оролцогч талуудтай хийсэн ярилцлага, мэдээлэл
		Орон нутгийн удирдлагад бичгээр болон амаар ирсэн, шийдвэрлэсэн санал, гомдлын тоо, жил бүр		
		Орон нутагт байгуулагдсан, үйл ажиллагаа идэвхитэй явуулдаг иргэний нийгмийн байгууллагын тоо, 3 жил тутам		

Үнэт зүйлс, соёл болон итгэл үнэмшилд гарсан өөрчлөлт, нөлөөлөл

13	Орон нутгийн иргэдийн хэл, харилцаа өөрчлөгдөх	Хэл ярианд гарсан өөрчлөлт, шинэ үг хэллэг, 3 жил тутам	Ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага	Оролцогч талуудтай хийсэн ярилцлага, мэдээлэл
14	Баяр, тэмдэглэлт өдрүүд өөрчлөгдөх	Шинээр тэмдэглэх болсон баяр, тэмдэглэлт өдрүүдийн тоо, 5 жил тутам	Хоёрдогч эх сурвалжийн анализ	Холбогдох бусад тайлан, судалгааны өгүүлэл
15	Хувцаслалт өөрчлөгдөх	Орон нутгийн иргэдийн хувцаслалтад гарсан өөрчлөлт, 5 жил тутам	Нөхцөл байдлын таамаглалын арга	Хээр хийсэн чанарын судалгааны мэдээлэл
16	Ёс заншил, уламжлал өөрчлөгдөх	Морь уях, сойх заншилд орж буй өөрчлөлт, 5 жил тутам	Нөлөөллийн загварчлалын арга	
		Хурим найр хийх, үс авах ёслолд гарч буй өөрчлөлт, 5 жил тутам		
17	Шашин шүтлэг өөрчлөгдөх	Орон нутгийн иргэдийн шашин шүтлэгт гарч буй өөрчлөлт, 5 жил тутам		

Иргэд хоорондын харилцаа, төрийн үйлчилгээний чанар хүртээмжид гарсан өөрчлөлт, нөлөөлөл

18	Хүмүүс хоорондын харилцаа, итгэлцэл, эв нэгдэл өөрчлөгдөх	Асуулгын аргаар тодруулах	Ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага	Эдгээртэй холбоотой сум, аймаг, улсын статистик мэдээлэл
19	Эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний чанар, хүртээмж өөрчлөгдөх	Орон нутгийн хүүхдүүдийн ЭЕШ-ын үзүүлэлт, жил бүр	Хоёрдогч эх сурвалжийн анализ	Оролцогч талуудтай хийсэн ярилцлага, мэдээлэл
		Боловсрол, эмнэлгийн үйлчилгээтэй холбоотой гаргасан иргэдийн гомдол, сайшаал, саналын тоо, жил бүр	Нөхцөл байдлын таамаглалын арга	Холбогдох бусад тайлан, судалгааны өгүүлэл
		Орон нутаг дахь эмнэлгийн хүний нөөц, багшлах боловсон хүчний тоо, мэргэшсэн байдал, 3 жил тутам	Нөлөөллийн загварчлалын арга	Хээр хийсэн

		Орон нутгийн иргэдийн мэргэжил, боловсролын түвшинд гарсан өөрчлөлт, 3 жил тутам		чанарын судалгааны мэдээлэл
20	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж өөрчлөгдөх	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжтэй холбоотой гаргасан иргэдийн гомдол, сайшаал, саналын тоо, жил бүр		
21	Гэмт хэргийн төрөл, давтамжид гарах өөрчлөлт	Гэмт хэрэг, зөрчил бүртгэгдсэн тоо, шийдэгдсэн байдал, жил бүр		
22	Малчид, орон нутгийн удирдлага хоорондын үл ойлголцол, маргаан ихсэх	Малчид, удирдлагын хооронд маргаан гарсан тоо, бүртгэгдсэн байдал, шалтгаан, жил бүр		

Хүрээлэн буй орчинд гарч буй өөрчлөлтөөс үүдэлтэй өөрчлөлт, нөлөөлөл

23	Хүнсний чанар, хүрэлцээ өөрчлөгдөх	Орон нутгийн иргэдийн өдөр тутам хэрэглэх хоол хүнсний төрөл, 3 жил тутам	Ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага	Эдгээртэй холбоотой сум, аймаг, улсын статистик мэдээлэл
		Хоол хүнсний чанартай холбоотой үүссэн өвчлөлийн тоо, 3 жил тутам	Хоёрдогч эх сурвалжийн анализ	
24	Хүн ам, мал, амьтны аюулгүй байдал өөрчлөгдөх	Малын эрүүл мэндэд гарах өөрчлөлт, өвчлөлийн хэлбэр, тоо, 2 жил тутам	Нөхцөл байдлын таамаглалын арга	Оролцогч талуудтай хийсэн ярилцлага, мэдээлэл
		Хүний эрүүл мэндэд гарах өөрчлөлт, өвчлөлийн хэлбэр, тоо, 2 жил тутам	Нөлөөллийн загварчлалын арга	
25	Байгалийн нөөц, баялаг (бэлчээр, ус, ой, ойн дагалдах баялаг, ан амьтан, загас)-ийн хүртээмж, баялгийг ашиглах арга хэлбэр өөрчлөгдөх	Бэлчээр, ой ашиглалттай холбоотой гомдлын тоо, жил бүр	Нийтийн сонсголын арга	Хээр хийсэн чанарын судалгааны мэдээлэл
		Бэлчээр, ой ашиглалттай холбоотой үүссэн гэмт хэрэг зөрчлийн тоо, жил бүр	Жендэрийн нөлөөллийн үнэлгээний арга	
		Бэлчээр, ой ашиглагчид, ашиглах хэлбэр, жил бүр		
26	Орчны дуу чимээ, тоосжилт нэмэгдэх	Орчны дуу чимээ, тоосжилтын улмаас өвчилсөн, эмчлүүлсэн, гомдол гаргасан иргэдийн тоо, жил бүр		

Эрүүл мэнд, иргэдийн амгалан тайван байдалд гарч буй өөрчлөлт, нөлөөлөл

27	Хүн амын дундах халдварт болон халдварт бус өвчлөл	Өвчлөлийн тоо, жил бүр	Ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага	Эдгээртэй холбоотой сум, аймаг, улсын статистик мэдээлэл
		Орон нутгийн иргэдийн эрүүл мэндэд гарсан өөрчлөлт, төсөл хэрэгжүүлэгчийн хэрэгжүүлсэн эрүүл	Хоёрдогч эх	

		мэндийн хөтөлбөрийн тоо, хамрагдсан хүмүүсийн тоо, жил бүр	сурвалжийн анализ	Оролцогч талуудтай хийсэн ярилцлага, мэдээлэл
28	Сэтгэцийн эрүүл мэнд өөрчлөгдөх	Сэтгэл заслын эмчилгээ авсан иргэдийн тоо, жил бүр	Нөхцөл байдлын таамаглалын арга	Холбогдох бусад тайлан, судалгааны өгүүлэл
		Төслийн тэсэлгээний дуу чимээ, үүний улмаас бие болон сэтгэцийн эрүүл мэндийн өвчлөлтэй болсон хүний тоо, 2 жил тутам	Нөлөөллийн загварчлалын арга	
29	Химийн бодис болон орчны бохирдлоос үүдэлтэй өвчлөл нэмэгдэх	Өвчлөлийн тоо, жил бүр	Нийтийн сонсголын арга	Хээр хийсэн чанарын судалгааны мэдээлэл
30	Хөдөлмөрийн аюулгүй байдлын (ХАБ) дүрэм журам зөрчигдсөний улмаас осол гэмтэл гарах, иргэд амь нас, эрүүл мэндээрээ хохирох	Төслийн машин техникт дайруулах, ухсан нүхэнд унах гэх мэтээр бэртэж гэмтсэн, нас барсан хүний тоо, жил бүр		
		Төслийн машин техникт дайруулах, ухсан нүхэнд унах гэх мэтээр хорогдсон мал амьтны тоо, жил бүр		

Хүсэл тэмүүлэл, ирээдүйдээ итгэх итгэлд гарч буй өөрчлөлт, нөлөөлөл

31	Хүмүүсийн өөрсдийн аюулгүй байдал, ирээдүй, үр хүүхдийнхээ ирээдүйн талаарх хүсэл тэмүүлэл ба тодорхойгүй байдлаас үүдэлтэй айдас хүйдэс нэмэгдэх	Төслийн үйл ажиллагаа орон нутгийн хөгжилд урт хугацаанд хувь нэмрээ оруулна гэж үзэж буй орон нутгийн иргэдийн хувь, жил бүр	Ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага	Эдгээртэй холбоотой сум, аймаг, улсын статистик мэдээлэл
			Хоёрдогч эх сурвалжийн анализ	Оролцогч талуудтай хийсэн ярилцлага, мэдээлэл
32	Ажил эрхлэлт, ажлын байраа алдах айдас нэмэгдэх	Төслийн үйл ажиллагаатай холбоогүйгээр хүүхдээ ирээдүйд малчин болгохгүй гэж үзэж буй эцэг, эхийн тоо, 3 жил тутам	Нөхцөл байдлын таамаглалын арга	Холбогдох бусад тайлан, судалгааны өгүүлэл
		Төслийн үйл ажиллагаатай холбоотойгоор хүүхдээ ирээдүйд малчин болгохгүй гэж үзэж буй эцэг, эхийн тоо, 3 жил тутам	Нийтийн сонсголын арга	
33	Төсөлд ажиллах гадаад улсын иргэдээс үүдэлтэй зөрчил, үл итгэлцэл	Төсөлд байнга болон түр хугацаагаар ажиллаж буй гадаад иргэдийн тоо, жил бүр		Хээр хийсэн чанарын судалгааны мэдээлэл
		Төслийн ажилчдын оролцсон гэмт хэрэг зөрчлийн тоо, жил бүр		

Бусад

34	Гомдол	Шүүхэд гаргасан гомдлын тоо, шүүхийн шийдвэр шат бүрээр, хэрэгсэхгүй болсон гомдлын тоо, жил бүр	Харьцуулсан судалгааны арга	Сум, аймаг, улсын статистик мэдээлэл Оролцогч талуудтай хийсэн ярилцлага, мэдээлэл
		Шүүхээс бусад байгууллагад гаргасан гомдол, мэдээллийн тоо, утга агуулга, шийдвэрлэлт, жил бүр		

IV үе шат: Нөлөөллийн бүсийн иргэд иргэд, оршин суугчдаас албан ёсоор санал авч, хэлэлцүүлэг зохион байгуулах

Энэ ажлын зорилго нь төслийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийж байгаа хуулийн этгээд хамтарсан багийн гишүүдийг байлцуулан төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэд, оршин суугчдаас албан ёсоор санал авч, хэлэлцүүлэг зохион байгуулж талуудын саналыг Нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх явцад тодорхойлсон суурь мэдээллүүд, тэдгээрт хийсэн мэдээллийн боловсруулалт, дүн шинжилгээнд санал авах, хэлэлцүүлэг өрнүүлж орхигдсон нэмэлт мэдээллийг илрүүлэх, нийгмийн бүлгүүдийн олон янз хэрэгцээг тодруулах, ялгаатай нийгмийн бүлгүүдийн оролцоог хүртээмжтэй хангах зорилготой.

Энэ нь БОНБҮТ хуулийн 18-р зүйлийн 18.4 дэх хэсэгт заасан Төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийж байгаа хуулийн этгээд тайлан боловсруулах явцдаа төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэд, оршин суугчдаас албан ёсоор санал авч, хэлэлцүүлэг зохион байгуулах арга хэмжээтэй хамтдаа зохион байгуулагдана.

Энэ ажлыг Багийн ИНХын хуралдаанаас тусдаа бие даасан уулзалт, хэлэлцүүлэг хэлбэрээр зохион байгуулна.

Энэ шатанд нөлөөллийн бүсийн иргэд, нутгийн захиргаатай зөвлөлдөхдөө дараах байдлаар хэрэгжүүлнэ.

1. Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ түүнийг боловсруулах хугацаанд цуглуулсан/гаргасан мэдээллүүд түүнээс байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөлөл түүний дотор болзошгүй сөрөг нөлөөллийг энгийн ойлгомжтой бичвэр, хэллэгээр тайлбарлан тинилцуулна. Эдгээрийг Нийгмийн нөлөөллийн үндсэн 8 төрлөөр /хүснэгт 1/ нэг бүрчлэн танилцуулна.
2. Нутгийн захиргааны байгууллага, багийн ИНХ-ын тэргүүлэгчид, иргэдийн зохион байгуулалттай хоршоо, бүлэг байгаа бол тэдгээрийн ахлагчдын оролцоотой өргөтгөсөн хэлбэрээр нэг, мөн нөлөөллийн бүсийн иргэдийн оролцоотой нэг үндсэн 2 хэсэгт зохион байгуулж тэмдэглэл хөтлөх бөгөөд тэмдэглэл тус бүрийг Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд хавсралтаар оруулна. Тэмдэглэл тус бүрийн нэг хувийг нутгийн захиргааны байгууллагад үлдээж түүнийг олон нийтэд нээлттэй байлгана.
3. Шаардлагатай бол талуудад эрдэс баялгийн салбарын хууль тогтоомж, байгаль орчин нийгмийн нөлөөллийн үнэлгээ, иргэдийн оролцооны хууль тогтоомжийн талаар сургалт, сурталчилгаа явуулж болох бөгөөд зардлыг төсөл хэрэгжүүлэгч хариуцна.

Уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулахад нутгийн захиргаа зар түгээх, орон байр танхимаар хангахад дэмжлэг үзүүлж болно.

V үе шат: Эерэг ба сөрөг нөлөөллийг тодорхойлж, үнэлэх

Эрдэс баялгийн салбарын төсөл болон холбогдох дэд бүтцийн төсөл нь хүрээлэн буй орчин, байгаль орчинд өөрчлөлт, доройтол үүсгэж явагддаг онцлогтой. Энэ онцлог нь төсөл хэрэгжих тухайн нутгийн хүрээлэн буй орчинд нөлөөлөл бий болохтой зэрэгцээд бүс нутгийн иргэдийн орлого, амьжиргаа, байгалийн нөөц ашиглалт ба түүнд түшиглэсэн бусад салбаруудад /мал аж ахуй, газар тариалан, аялал жуулчлал г.м./ сөрөг нөлөөлөл үзүүлдэг. Ялангуяа уламжлалт нүүдлийн мал аж ахуй эрхлэлт болон нүүдэлчин соёл, уламжлал, түүний хөгжилд шууд сөрөг нөлөөлөл үзүүлэх магадлал өндөр юм. Иймд хүрээлэн буй орчин, эко системд өөрчлөлт оруулж, байгалиас хүртэх биомассын өгөөжийг доройтуулсанаар төсөл хэрэгжих нутаг

дэвсгэрийн болон нөлөөллийн бүсийн хувь хүн, өрх гэр бүл, нутгийн хүн амд хүний эрхийн наад захын эрх, эрх чөлөө, нийгэмд үзүүлэх нөлөөллийг уялдаатайгаар үнэлж түүний дотор сөрөг нөлөөллийг хүний эрхийн хандлагаар, жендэрийн мэдрэмжтэйгээр тодорхойлно.

Иймд энэ шатанд байгаль орчны болон нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийж байгаа мэргэжилтнүүд нягт уялдаатай, хамтран ажиллахыг шаардана. Өөрөөр хэлбэл нийгмийн нөлөөллийн үнэлгээг байгаль орчны мэргэжилтэн хамтдаа тодорхойлж, хүлээн зөвшөөрч гэмээ нь Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн менежментийн төлөвлөгөө, Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр чанартай, хэрэгжихүйц боловсрогдож төсөл амжилттай хэрэгжих боломжийг бүрдүүлнэ.

Нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний хүрээнд дараах ажил хийгдэнэ. Үүнд:

1. Төслийн улмаас үүсэж болзошгүй шууд болон шууд бус нийгмийн нөлөөллийг тодорхойлох;
2. Төслийн байгаль орчин, нийгмийн сөрөг нөлөөлөл нийгмийн ялгаатай бүлэгт хэрхэн ялгаатай нөлөөлөхийг тодорхойлох.
3. Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үргэлжлэх хугацаа, эрчим, түүний үлдэх үр дагавар нь нөлөөллийн бүсийн хүн амын тогтвортой хөгжил, ирээдүйд үзүүлэх нөлөөллийг уурхай хаах, хаагдсаны дараах үеийн нөлөөллийг тодорхойлох, түүнд хийх хяналт мониторинг, хэмжих шалгуур үзүүлэлтийг тодорхойлох

Төслийн шууд болон шууд бус Нийгмийн нөлөөллийг тодорхойлох нь эерэг нөлөөллийг нэмэгдүүлэх, үүсэж болох эрсдэл, сөрөг нөлөөллөөс зайлсхийх, арилгах ач холбогдолтой. Нөлөөллийн бүс дэх иргэдийн нийгмийн нөлөөллийг тодорхойлсны дараа эрэмбэлж, хамгийн ноцтой нөлөөллөөс зайлсхийх арга хэмжээ авах эсвэл төслийг зогсоох/хэрэгжүүлэх эсэх шийдвэр гаргахыг тогтооно.

Нийгмийн шууд, болон шууд бус нөлөөлөл нь үнэлгээний шалгуур үзүүлэлттэй хамааралтай бөгөөд нөлөөллийн ангиллыг хүснэгт 2-т үзүүлсний дагуу тодорхойлно. Төслийн онцлог, үйл ажиллагаанаас хамаарч уг ангилал өөрчлөгдөх боломжтой бөгөөд хэрэв өөрчлөгдсөн бол тайлбар хийнэ.

Хүснэгт 1. Нөлөөллийн ангилал

Нөлөөллийн ангилал	Хамрах хүрээ
Шууд нөлөөлөл	1. Амьдралын хэв маягт гарч буй өөрчлөлт, нөлөөлөл 2. Хувийн болон гэр бүлийн өмчийн эрхийн байдалд гарч буй өөрчлөлт, нөлөөлөл 7. Эрүүл мэнд, сайн сайхан байдалд гарч буй өөрчлөлт, нөлөөлөл 6. Хүрээлэн буй орчинд гарч буй өөрчлөлтөөс үүдэлтэй нөлөөлөл
Шууд бус нөлөөлөл	3. Орон нутгийн шийдвэр гаргалтад оролцох боломжид гарсан өөрчлөлт, нөлөөлөл, 5. Иргэд хоорондын харилцаа, төрийн үйлчилгээний чанар хүртээмжид гарсан өөрчлөлт, нөлөөлөл 4. Итгэл үнэмшил, үнэт зүйл, соёлд гарсан өөрчлөлт, нөлөөлөл, 8. Хүсэл тэмүүлэл, ирээдүйдээ итгэх итгэлд гарч буй өөрчлөлт, нөлөөлөл

Энэ шатанд төслийн үйл ажиллагааны улмаас тухайн орон нутагт бий болох магадлалтай нийгмийн нөлөөллийг судлаачид судалж, нөлөөлөлд өртөх иргэдийн саналд үндэслэн шаардлагатай гэж үзвэл нөлөөллийн нийт хамрах хүрээг эсхүл тодорхой хэсгийг авч шууд, болон

шууд бус нөлөөллийн ангилалд багтааж эсхүл нэг ба хэд хэдэн ангилалд багтааж болно. Нийгмийн эерэг, сөрөг нөлөөллийг тодорхойлох, үнэлэхэд энэхүү аргачлалын хавсралтад 1-т санал болгосон “Арга зүй”-г түлхүү ашиглана. Өөр аргазүй ашигласан тохиолдолд энд санал болгосон аргачлыг дордуулахгүй аргачлал ашиглах үүрэгтэй.

Тодорхойлсон нөлөөллийг хүснэгт 3-т заасан үнэлгээний матрицын аргыг ашиглан эрэмбэлнэ. Нөлөөллийг эрэмбэлэхийн өмнө нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийж байгаа компани болон оролцогч талууд нь тохиолдох магадлал болон үр дагаврын түвшин тус бүрийн дэлгэрэнгүй тодорхойлолтыг хамтран, зөвшилцөн гаргах шаардлагатайг анхаарна уу.

Хүснэгт 2. Нөлөөллийн магадлал болон үр дагаврын матриц (жишээ)

МАГАДЛАЛ		ҮР ДАГАВАР				Хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдал болон хүний үндсэн эрх зөрчигдөхөөр бол тухайн нөлөөллийг СӨРӨГ, АЮУЛТАЙД тооцно.
		1	2-3	4	5	
		Бага	Дунд	Өндөр	Аюултай	Эерэг ба сөрөг ҮР ДАГАВАР (жишээ)
5	Байнга: тохиолдох (жишээлбэл долоо хоногт нэг удаа гэх мэт)	6	7-8	9	10	Хүний амь насанд хохирол учруулах аюултай бол давтамжаас үл хамаарч хамгийн өндөр нөлөөлөл, эрсдэлтэйд тооцно. Харин эерэг үр дагаврыг хүний эрүүл мэндийг хамгаалах, эрхийг хангах нөхцөл сайжрах зэрэг ач холбогдлоор эрэмбэлж тодорхойлно.
4	Түгээмэл: зарим тохиолдолд тохиолддог (жишээлбэл сард нэг удаа тохиолдох магадлалтай)	5	6-7	8	9	Нэг болон түүнээс олон өрхийн гишүүдийн амь нас, эрүүл мэндэд сөрөг үр дагавар, гэмтэл, өвчлөл эсвэл ажиллах чадвараа алдах өөрчлөлт орох зэрэг сөрөг, ажлын байр бий болгох, орлого нэмэгдэх зэрэг тодорхой түвшинд хүртэл өөрчлөлт гарахаар бол эерэг г.м
2-3	Заримдаа: (жилд нэг удаа тохиолдох магадлалтай)	3-4	4-6	6-7	7-8	Осол, гэмтэл гарах магадлалтай, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгохоос өөр зохицуулах боломжгүй нөхцөл үүсэх бол тухайн нөхцөлийг үнэлэх. Нийгмийн үйлчилгээг сайжруулах зэрэг нь эерэг нөлөөлд тооцогдох боломжтой.
1	Маш ховор: (жишээлбэл 9-өөс дээш жилд нэг удаа тохиолдож болно)	2	3-4	5	6	Төсөл хэрэгжсэнээр нутгийн иргэд, өрх гэр бүл, ААН-д нөлөөлөл төдийлөн гарахааргүй, гарсан ч үүсэх үр дагавар нь төдийлөн мэдрэгдэхээргүй бол

Тайлбар:

Бага	Дунд	Өндөр	Аюултай
------	------	-------	---------

Анхаарах: ННУ боловсруулахад байгуулагдсан хамтарсан баг нь үнэлгээний өмнө дараах зүйлийг зөвшилцөн тодорхой болгож, үнэлгээний стандартаа боловсруулж гарган, түүний дагуу үнэлгээг хийнэ.

1. Нийгмийн нөлөөллийн хүлцэх ба үл хүлцэх түвшин
2. Бий болгох, нэмэгдүүлэх мөн бий болохоос урьдчилан сэргийлэх, зайлсхийх, сэргээх г.м. шаардлага
3. Төсөл зогсоох эсхүл үргэлжлүүлэх нөлөөллийн үндэслэл

Нийгмийн нөлөөллийг нарийвчлан тодорхойлох шатанд дараагийн ажил нь Нөлөөллийн магадлал болон үр дагаврын үнэлгээний хүснэгт 4-т заасны дагуу төслийн улмаас үүсэж болзошгүй шууд бус болон хуримтлагдах нөлөөллийг тодорхойлж гаргах юм. Уг ажлыг хийхэд ашиглах хамгийн үр дүнтэй арга нь ижил төстэй бусад газар, бусад төслүүдийн туршлагыг судлах байж болох юм. Үүнээс гадна оролцогч талууд хамтдаа болзошгүй нөлөөллийн зураглал хийх, нөхцөл байдлын таамаглал гаргах аргуудыг хослуулан ашиглана.

Аливаа төслийн улмаас үүсэх нийгмийн нөлөөлөл нь эрэгтэй, эмэгтэй, хүүхэд, ахмад настан, орлогын түвшингийн бүх ангиллын өрх зэргээр нийгмийн бүлэг тус бүрд харилцан адилгүй, өөр эрчим, давтамжтайгаар илэрнэ. Иймд төслийн нөлөөллийг тодорхойлох, үнэлэх шатанд нийт тодорхойлсон нөлөөлөл нь нийгмийн ялгаатай бүлэгт төслийн мөчлөг бүрд хэрхэн мэдрэгдэх, нөлөөлөх магадлалтай, ямар үр дагавар үлдээхийг заавал үнэлж, тодорхойлно. Жендэрийн нөлөөллийн үнэлгээ болон бусад арга зүйг ашиглана уу.

Нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний хэрэгжилтэд 3 жил тутамд Байгаль орчны аудитын хамт аудит хийж дүгнэлтийг олон нийтэд нээлттэй байлгана.

Төсөл хэрэгжүүлэгч:
 Төсөл хэрэгжих байршил, хамрагдах баг:
 Төслийн үе шат: (хайгуул, ашиглалт, барилга г.м)

Хүснэгт 3. Нөлөөллийн магадлал болон үр дагаврын үнэлгээний хүснэгт

№	Хамрах хүрээ	Нөлөөлөл											
		Хувь хүн				Өрх гэр				Нийгэм			
		Бага	Дунд	Өндөр	Аюултай/ маш Өндөр	Бага	Дунд	Өндөр	Аюултай/ Өндөр	Бага	Дунд	Өндөр	Аюултай/ маш Өндөр
1	Амьдралын хэв маягт гарч буй өөрчлөлт, нөлөөлөл												
1.1	Орлогын эх үүсвэрийн төрөл, хэлбэр												
1.2	Гэр бүлийн гишүүдийн хөдөлмөр эрхлэлт												
1.3	Уламжлалт байдлаар мал маллах хэлбэр, хэв маяг												
1.4	Уламжлалт, дасан зохицсон амьдралын хэв маяг												
1.5	Амьжиргааны өртөг												
1.6	Гэр бүл төлөвлөлт												
1.7	Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт												
1.8	Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, өдөр тутмын гэр ахуйн ажлын ачаалал, нэгж хөдөлмөрт зарцуулах цагийн өөрчлөлт												
Ерөнхий дүн	АМЬДРАЛЫН ХЭВ МАЯГТ ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТ, НӨЛӨӨЛӨЛ												

Жич: Хүснэгтийн дагуу нийгмийн нөлөөллийн хамрах хүрээнд заасан 8 чиглэлийн хүрээнд тус тусад нь, нэг бүрчлэн үнэлнэ.

VI үе шат: Нийгмийн нөлөөлийн менежментийн төлөвлөгөө боловсруулах

Энэхүү үе шатны зорилго нь төслийн үйл ажиллагааны нийгэм, эдийн засаг, хүний эрх зэрэгт үзүүлэх эерэг нөлөөллийг нэмэгдүүлэх, үүсэж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, зайлсхийх, үр дагаврыг арилгах, нөлөөллийн бүсийн иргэдийг нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох зэрэг арга замуудыг талуудын оролцоотой тодорхойлох “Нийгмийн нөлөөллийн менежментийн төлөвлөгөө”-г боловсруулах юм.

Нөлөөллөөс зайлсхийх, үр дагаврыг арилгах төлөвлөгөө боловсруулахад хэрэглэгддэг арга зүй нь төслийн мөчлөг бүрд ялгаатай байх ба нийгмийн бүлэг бүрд одоо үзүүлэх болон цаашид ул мөр үлдээх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, зайлсхийх, үр дагаврыг арилгах буюу эрхийг сэргээх мөн эерэг нөлөөллийг нэмэгдүүлэх арга хэмжээг хүснэгт 5-т заасны дагуу матрицаар үнэлэн төлөвлөвөл зохино.

Нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний менежментийн төлөвлөгөө нь төслийн үргэлжлэх хугацаанд төрийн байгууллага, төсөл хэрэгжүүлэгч, орон нутгийн иргэд болон бусад оролцогч талуудын хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлох, төслийн барилгажилт, олборлолт, хаалтын явцад бий болж болзошгүй сөрөг нөлөөлөл болон төслөөс бий болох эерэг үр дүн, боломжуудыг зохицуулахад чиглэгдэнэ. Төлөвлөгөөг боловсруулахад төсөл хэрэгжих орон нутгийн засаг захиргаа, холбогдох мэргэжилтнүүд үнэлгээ хийсэн багийнханд шаардагдах мэдээллээр хангаж дэмжлэг үзүүлж ажиллах шаардлагатай.

Менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх хяналт-шинжилгээний хөтөлбөрийн дагуу хэрэгжилтийг хянаж ажиллах ба үүнд сөрөг нөлөөллөөс сэргийлэх, зайлсхийх, үлдэх үр дагаварыг арилгах мөн эерэг нөлөөллийг нэмэгдүүлэхэд хэрэгжүүлэх ажлын хугацаа, төсөв, хөрөнгө нөөц, нөлөөллийг дахин хянах мөчлөгийг тодорхойлж, хариуцах албан тушаалтныг томилсон цогц төлөвлөгөө боловсруулна.

Нийгмийн нөлөөллийн менежментийн төлөвлөгөө нь Байгаль орчны менежментийн төлөвлөгөөтэй нягт уялдаатай, салшгүй бүрэлдэхүүн хэсэг нь байна. Харин байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулж болдог бол Нийгмийн сөрөг нөлөөллийг бууруулах тухай ойлголт Нийгмийн нөлөөллийн менежментийн төлөвлөгөөнд байх ёсгүй. Учир нь төсөл хэрэгжсэнээр хүмүүсийн амьдрал, ёс зан заншил, үнэт зүйл, итгэл үнэмшил, ирээдүйн амьдрах нөхцөл аажмаар алдагдахыг болон нийгмийн нөлөөллийг бууруулснаар хүний амжиргаа урт хугацаандаа байгалиас авах үр шим боломжоо бүрэн алдах, ёс зан заншил, үнэт зүйл, итгэл үнэмшлээ хэзээ нэг цагт бүрэн алдах эрсдлийг баталгаажуулж, хүчээр хүлээн зөвшөөрүүлдэг тул өнөөдрийн нийгмийн нөлөөллийг бууруулах тухай ойлголт хэрхэвч байж болохгүй юм.

Төсөл хэрэгжүүлэгч:

Төсөл хэрэгжих байршил, хамрагдах баг:

Төслийн үе шат: (хайгуул, ашиглалт, барилга г.м)

Хүснэгт 4. Хариу арга хэмжээг тодорхойлох хувилбар

Нөлөөллийн түвшин	Хүлцэх хэмжээ		Нөлөөллийг арилгах/нэмэгдүүлэх арга хэмжээ
	Сөрөг	Эерэг	
Маш их	Хүлээн зөвшөөрөхгүй/ Бий болгохгүй	Нөлөөллийг хадгалах/ Нэмэгдүүлэх	Төслийг хэрэгжүүлэх эсэх асуудал гарна. Сөрөг нөлөөллийг бий болгохгүй байх хариуцлага хүлээнэ. Үүнд дэлгэрэнгүй судалгаа, төлөвлөлт шаардлагатай байж болох бөгөөд эрсдэл үүсгэж буй нөхцөл байдалд хэсэгчилсэн эсхүл бүхэлд нь тогтмол хяналт шаардлагатай учраас хянах үүрэг хариуцлагыг тодорхой болгоно. Хяналтыг алдсан нөхцөлд хариуцлага хүлээх зарчмыг мөн тодорхойлсон байна.

			Эерэг нөлөөллийг хадгалах, нэмэгдүүлэх үечилсэн төлөвлөгөө гаргаж болно.
Их	Хүлээн зөвшөөрөхгүй/ Урьдчилан сэргийлэх/ Зайлсхийх	Нөлөөллийг хадгалах/ Нэмэгдүүлэх	Уг сөрөг нөлөөллийг “бий болсны дараа бууруулах” арга хэмжээ авахгүйгээр сөрөг нөлөөллийг анхнаас нь бий болгохгүй, урьдчилан сэргийлэх, зайлсхийх нэн даруй шаардлагатай арга хэмжээ авна. Нөлөөллийг шийдвэр гаргах түвшинд танилцуулж, хянах ба нарийвчилсан судалгаа, төлөвлөлт шаардлагатай, үүрэг даалгаврыг зогсоож нэмэлт судалгаа хийх шаардлагатай эсэхийг тодорхойлох. Эерэг нөлөөллийг хадгалах, нэмэгдүүлэх үечилсэн төлөвлөгөөг заавал гаргана.
Дунд	Арилгах/ Зайлсхийх	Нөлөөллийг нэмэгдүүлэх	Гүйцэтгэх удирдлага болон менежерүүдийг үүрэг хариуцлага тодорхойлогдсон, урьдчилан сэргийлэх болон залруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулагдсан, нөлөөллийг харьяа алба хэлтсүүд дахин үнэлж, арилгах арга хэмжээ авах, тодорхой түвшинд удирдаж арилгах, зайлсхийх арга хэмжээ авч удирдлагад тайлагнах. Гүйцэтгэх удирдлагын түвшинд хэлэлцэгдэх, урьдчилан сэргийлэх болон залруулах, тогтмол хянах, идэвхтэй удирдах тодорхой давтамжаар хянах арга хэмжээ авах шаардлагатай. Эерэг нөлөөллийг нэмэгдүүлэх үечилсэн төлөвлөгөөг заавал гаргана.
Бага	Арилгах	Нөлөөллийг нэмэгдүүлэх	Тогтмол хяналт шаардлагагүй боловч арилгах арга хэмжээ авах ба дахин үүсгэхгүй байх нөхцөлийг бүрдүүлнэ. Журмын дагуу эрсдэлийг хянаж ажиллах, тогтсон журмын дагуу удирдах. Эерэг нөлөөллийг нэмэгдүүлэх үечилсэн төлөвлөгөөг заавал гаргана.

Байгаль орчин, Нийгмийн нөлөөллийн менежментийн төлөвлөгөөний “Хяналт-шинжилгээний хөтөлбөр”-ийн шалгуур үзүүлэлтүүдийг үнэлгээ хийсэн мэргэжилтнүүд, орон нутгийн иргэд, нөлөөллийн бүсийн иргэд, нутгийн захиргаа хамтран гаргана. Хяналт-шинжилгээний хөтөлбөрт нөлөөллийн бүсийн иргэдээс гадна төслийн улмаас шилжин ирсэн ажилчид, замын дагуу амьдардаг иргэд гэх мэт төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй бүлгийг тодорхойлж, гарах өөрчлөлтийг хянах шалгуурыг заавал тусгана. Түүнчлэн хяналт-шинжилгээний хөтөлбөр боловсруулахдаа урьдчилан тааварлаагүй нөлөөллийг хэрхэн хянах, хэмжих талаар анхаарах ёстой. Төслийн хяналт-шинжилгээний хөтөлбөрөөр шууд нөлөөллөөс гадна шууд бус, хуримтлагдах нөлөөллийг хянана. Нөлөөллийг хянах үзүүлэлтүүд тодорхой, хэмжигдэхүйц, төслийн үйл ажиллагаатай уялдсан байх шаардлагатай.

Нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийсний дараа нэгдсэн бүртгэлийг Хүснэгт 6. Нөлөөллийн хяналтын нэгдсэн бүртгэлийн дагуу хариу арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг тогтмол хянаж, дүгнэх ба хяналтыг нөлөөлөлд өртөх иргэдэд нээлттэй байлгана. Төсөл бүр харилцан адилгүй нөлөөлөл мөн хяналтын хөтөлбөр байж болох тул энэхүү аргачлалд дурьдсан жишиг хүснэгтийг тухайн төслийн онцлогт тохирсон байдлаар өөрчлөн боловсруулна.

Төслийн нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнд суурилсан хариу арга хэмжээний төлөвлөгөө болох менежментийн төлөвлөгөө нь дараах бүтэцтэй байна. Үүнд:

- Нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний хураангуй
- Эерэг нөлөөллийг нэмэгдүүлэх төлөвлөгөө, зардал
- Сөрөг нөлөөллөөс зайлсхийх төлөвлөгөө, зардал
- Сөрөг нөлөөллийг арилгах арга хэмжээ, зардал
- Хяналт, шинжилгээний хөтөлбөр, гарах зардал
- Оролцогч талуудтай хамтран ажиллах төлөвлөгөө
- Санал, гомдол хянан шийдвэрлэх, хяналт, хариуцлага

Хяналт шинжилгээний хөтөлбөр боловсруулахад орон нутгийн иргэд, нөлөөллийн бүсийн иргэд эрх зүйн болон мэргэжил арга зүйн туслалцаа авах, шаардлагатай бол сургалтад хамрагдах эрхийг төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээний компани хүндэтгэх, шаардагдах зардлыг төсөл хэрэгжүүлэгч гаргах үүрэг хүлээнэ. Энэ талаар 1-р шатанд гарах төлөвлөгөөнд тусгана.

Хүснэгт 5. Нийгмийн нөлөөллийн хяналт-шинжилгээний жишиг индикаторууд

№	Нийгмийн нөлөөлөл	Индикатор, хэмжих давтамж	Ашиглах арга зүй	Ашиглах мэдээлэл
Амьдралын хэв маягт гарч буй өөрчлөлт, нөлөөлөл				
1	Амьжиргаагаа залгуулж буй хэлбэр өөрчлөгдөх	Мал маллахаа больсон, мал нь хэт цөөрсөн өрх, хүний тоо, жил бүр	Ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлага	Сум, аймаг, улсын статистик мэдээлэл
		Сум, аймаг, хот руу шилжсэн хүний тоо, жил бүр	Статистик анализ	Малчид, орон нутгийн удирдлагатай хийсэн ярилцлага, мэдээлэл
		Уурхай, гэрээт компанид ажилд орсон хүний тоо, жил бүр		
2	Орлогын эх үүсвэр өөрчлөгдөх	Өрхийн нийт орлогод гарсан өөрчлөлт, жил бүр	Статистик анализ	Сум, аймаг, улсын статистик мэдээлэл
		Төсөлд болон холбогдох байгууллагуудад бүтэн, хагас цагийн болон ээлжийн ажилд орсон өрхийн гишүүний тоо, жил бүр	Ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлага	Оролцогч талуудтай хийсэн ярилцлага, мэдээлэл
		Өрхийн малын тоонд гарсан өөрчлөлт, жил бүр	Нөхцөл байдлын таамаглалын арга	
3	Амьдралын өртөг, зардал нэмэгдэх	Амьдралын дундаж өртөг, зардалд гарсан өөрчлөлт, жил бүр	Статистик анализ	Сум, аймаг, улсын статистик мэдээлэл
		Хүнсний бүтээгдэхүүний үнэд гарсан өөрчлөлт, жил бүр	Ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлага	Оролцогч талуудтай хийсэн ярилцлага, мэдээлэл
		Байр, орон сууц, газар, автомашины үнэд гарсан өөрчлөлт, жил бүр		

		Хувцас, өргөн хэрэглээний барааны үнэд гарсан өөрчлөлт, жил бүр	Нөхцөл байдлын таамаглалын арга	
		Эрүүл мэндийн үйлчилгээ, эм тарианы үнэд гарсан өөрчлөлт, жил бүр		
		Боловсролын үйлчилгээ, үнэд гарсан өөрчлөлт, жил бүр		
4	Гэр бүлийн хөдөлмөрийн хуваарь өөрчлөгдөх	Өрхийн хүүхдүүдийн хөдөлмөрийн хуваарьт орсон өөрчлөлт, 3 жил тутам	Статистик анализ	Сум, аймаг, улсын статистик мэдээлэл
		Өрхийн эрэгтэй, эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн хуваарьт орсон өөрчлөлт, 3 жил тутам	Ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлага	Оролцогч талуудтай хийсэн ярилцлага, мэдээлэл
5	Албадан нүүлгэн шилжүүлэлт хийгдэх	Бэлчээр, усны боломжоос шалтгаалан хийх нүүдлийн тоо, жил бүр	Статистик анализ	Сум, аймаг, улсын статистик мэдээлэл
		Ширгэсэн, ус нь багассан худгийн тоо, 3 жил тутам	Ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлага	Малчид, орон нутгийн удирдлагатай хийсэн ярилцлага, мэдээлэл
		Өвөлжөө, хаваржааны газраа алдсан өрхийн тоо, жил бүр	Нөхцөл байдлын таамаглалын арга	
		Өмнө ашиглаж байсан худаг, бэлчээрээ ашиглах боломжгүй болсон өрхийн тоо, жил бүр	Нөлөөллийн загварчлалын арга	
		Уурхайн тоосжилт, дуу чимээ зэрэг нөлөөллийн улмаас нүүсэн өрхийн тоо, жил бүр		
6	Хүний эрхийн зөрчил нэмэгдэх	Хүний эрхийн үндэсний комиссын аймаг дахь ажилтанд ирсэн гомдлын тоо, жил бүр	Статистик анализ	Сум, аймаг, улсын статистик мэдээлэл
		Орон нутгийн цагдаагийн ажилтанд ирсэн гэмт хэрэг зөрчилтэй холбоотой гомдлын тоо, жил бүр	Ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага Хоёрдогч эх сурвалжийн анализ	Хүний эрхийн үндэсний комиссын тайлан, мэдээлэл
7	Орон нутаг ажиллах хүчний нөөцийн хомсдол үүсэх	Орон нутгийн иргэдийн эзэмших мэргэжилд гарах өөрчлөлт, 3 жил тутам	Статистик анализ	Сум, аймаг, улсын статистик мэдээлэл
		Орон нутгийн иргэдийн ажил эрхлэлтэд гарах өөрчлөлт, жил бүр	Ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага Хоёрдогч эх сурвалжийн анализ	Ажил эрхлэлт, мэргэжил сонголттой холбоотой тайлан мэдээлэл

Хувийн болон гэр бүлийн өмчийн эрхийн байдалд гарч буй өөрчлөлт, нөлөөлөл

8	Газар ашиглах эрхэд гарсан өөрчлөлт	Өвөлжөө, хаваржааны газаргүй болсон/болох айл өрхийн тоо, жил бүр	Статистик анализ	Газар ашиглалт, бэлчээр, худагтай холбоотой сум, аймаг, улсын статистик мэдээлэл Оролцогч талуудтай хийсэн ярилцлага, мэдээлэл Холбогдох бусад тайлан, өгүүлэл
		Баг, сум, аймаг дахь газар ашиглагчдын тоо, 3 жил тутам	Ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага	
		Баг, сум, аймаг дахь газар ашиглалтын хэлбэр, 3 жил тутам	Хоёрдогч эх сурвалжийн анализ	
		Бэлчээр ашиглалтын хэмжээ, 5 жил тутам	Нөхцөл байдлын таамаглалын арга	
		Бэлчээрийн хүртээмжтэй байдал, 5 жил тутам	Нөлөөллийн загварчлалын арга	
		Нүүлгэн шилжүүлсэн өрхийн тоо, 3 жил тутам		
		Нөхөн олговрын хөтөлбөрт хамрагдсан өрхийн тоо, 3 жил тутам		
		Уламжлалт байдлаар газар эзэмшиж буй (гэрчилгээгүйгээр) өрхийн тоо		
9	Өрхийн хэмжээнд малын тоо толгой өөрчлөгдөх	Малын тоо, жил бүр	Статистик анализ Ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага Хоёрдогч эх сурвалжийн анализ	Малын тоо толгой, жин, чанар, эрүүл мэндтэй холбоотой сум, аймаг, улсын статистик мэдээлэл Оролцогч талуудтай хийсэн ярилцлага, мэдээлэл Чанарын судалгааны мэдээлэл
10	Малын жин, чанар, эрүүл мэнд өөрчлөгдөх	Малын жин, чанар, эрүүл мэнд, 2 жил тутам		
11	Усны чанар, хүртээмж	Ширгэсэн болон ширгээгүй худгийн тоо, 3 жил тутам	Ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага	Тоон болон чанарын судалгааны мэдээлэл
		Усны чанар, хэмжээ, жил бүр	Хоёрдогч эх сурвалжийн анализ	
Орон нутгийн шийдвэр гаргалтад оролцох боломжид гарсан өөрчлөлт, нөлөөлөл				
12	Орон нутгийн иргэд өөрсдийн амьдралд	Баг, сум, хорооны хурал, нийтийн сонсох үйл ажиллагаа явагдах давтамж, жил бүр	Ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага	Оролцогч талуудтай хийсэн ярилцлага,

	нөлөөтэй шийдвэр гаргалтанд оролцох боломж өөрчлөгдөх	Орон нутгийн удирдлагад бичгээр болон амаар ирсэн, шийдвэрлэсэн санал, гомдлын тоо, жил бүр		мэдээлэл Холбогдох бусад тайлан Хүний эрх, засаглалын чиглэлээр ажилладаг байгууллагуудын тайлан
		Орон нутагт байгуулагдсан, үйл ажиллагаа идэвхитэй явуулдаг иргэний нийгмийн байгууллагын тоо, 3 жил тутам		
Итгэл үнэмшил, үнэт зүйлс, соёлд гарсан өөрчлөлт, нөлөөлөл				
13	Орон нутгийн иргэдийн хэл, харилцаа өөрчлөгдөх	Хэл ярианд гарсан өөрчлөлт, шинэ үг хэллэг, 3 жил тутам	Ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага	Оролцогч талуудтай хийсэн ярилцлага, мэдээлэл
14	Баяр, тэмдэглэлт өдрүүд өөрчлөгдөх	Шинээр тэмдэглэх болсон баяр, тэмдэглэлт өдрүүдийн тоо, 5 жил тутам	Хоёрдогч эх сурвалжийн анализ	Холбогдох бусад тайлан, судалгааны өгүүлэл
15	Хувцаслалт өөрчлөгдөх	Орон нутгийн иргэдийн хувцаслалтад гарсан өөрчлөлт, 5 жил тутам	Нөхцөл байдлын таамаглалын арга	Хээр хийсэн чанарын судалгааны мэдээлэл
16	Ёс заншил, уламжлал өөрчлөгдөх	Морь уях, сойх заншилд орж буй өөрчлөлт, 5 жил тутам	Нөлөөллийн загварчлалын арга	
		Хурим найр хийх, үс авах ёслолд гарч буй өөрчлөлт, 5 жил тутам		
17	Шашин шүтлэг өөрчлөгдөх	Орон нутгийн иргэдийн шашин шүтлэгт гарч буй өөрчлөлт, 5 жил тутам		
Иргэд хоорондын харилцаа, төрийн үйлчилгээний чанар хүртээмжид гарсан өөрчлөлт, нөлөөлөл				
18	Хүмүүс хоорондын харилцаа, итгэлцэл, эв нэгдэл өөрчлөгдөх	Асуулгын аргаар тодруулах	Ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага	Эдгээртэй холбоотой сум, аймаг, улсын статистик мэдээлэл
19	Эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний чанар, хүртээмж өөрчлөгдөх	Орон нутгийн хүүхдүүдийн ЭЕШ-ын үзүүлэлт, жил бүр	Хоёрдогч эх сурвалжийн анализ	Оролцогч талуудтай хийсэн ярилцлага, мэдээлэл
		Боловсрол, эмнэлэгийн үйлчилгээтэй холбоотой гаргасан иргэдийн гомдол, сайшаал, саналын тоо, жил бүр	Нөхцөл байдлын таамаглалын арга	Холбогдох бусад тайлан, судалгааны өгүүлэл
		Орон нутаг дахь эмнэлэгийн боловсон хүчин, багшлах боловсон хүчний тоо, мэргэшсэн байдал, 3 жил тутам	Нөлөөллийн загварчлалын арга	Хээр хийсэн

		Орон нутгийн иргэдийн мэргэжил, боловсролын түвшинд гарсан өөрчлөлт, 3 жил тутам		чанарын судалгааны мэдээлэл
20	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж өөрчлөгдөх	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжтэй холбоотой гаргасан иргэдийн гомдол, сайшаал, саналын тоо, жил бүр		
21	Гэмт хэргийн төрөл, давтамжид гарах өөрчлөлт	Гэмт хэрэг, зөрчил бүртгэгдсэн тоо, шийдэгдсэн байдал, жил бүр		
22	Малчид, орон нутгийн удирдлага хоорондын үл ойлголцол, маргаан ихсэх	Малчид, удирдлагын хооронд маргаан гарсан тоо, бүртгэгдсэн байдал, шалтгаан, жил бүр		

Хүрээлэн буй орчинд гарч буй өөрчлөлтөөс үүдэлтэй өөрчлөлт, нөлөөлөл

23	Хүнсний чанар, хүрэлцээ өөрчлөгдөх	Орон нутгийн иргэдийн өдөр тутам хэрэглэх хоол хүнсний төрөл, 3 жил тутам	Ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага	Эдгээртэй холбоотой сум, аймаг, улсын статистик мэдээлэл
		Хоол хүнсний чанартай холбоотой үүссэн өвчлөлийн тоо, 3 жил тутам	Хоёрдогч эх сурвалжийн анализ	
24	Хүн ам, мал, амьтны аюулгүй байдал өөрчлөгдөх	Малын эрүүл мэндэд гарах өөрчлөлт, өвчлөлийн хэлбэр, тоо, 2 жил тутам	Нөхцөл байдлын таамаглалын арга	Оролцогч талуудтай хийсэн ярилцлага, мэдээлэл
		Хүний эрүүл мэндэд гарах өөрчлөлт, өвчлөлийн хэлбэр, тоо, 2 жил тутам	Нөлөөллийн загварчлалын арга	Холбогдох бусад тайлан, судалгааны өгүүлэл
25	Байгалийн нөөц, баялгийн (бэлчээр, ус, ой, ойн дагалдах баялаг, ан амьтан, загас) хүртээмж, баялгийг ашиглах арга хэлбэр өөрчлөгдөх	Бэлчээр, ой ашиглалттай холбоотой гомдлын тоо, жил бүр	Нийтийн сонсголын арга	Хээр хийсэн чанарын судалгааны мэдээлэл
		Бэлчээр, ой ашиглалттай холбоотой үүссэн гэмт хэрэг зөрчлийн тоо, жил бүр	Жендэрийн нөлөөллийн үнэлгээний арга	
		Бэлчээр, ой ашиглагчид, ашиглах хэлбэр, жил бүр		
26	Орчны дуу чимээ, тоосжилт нэмэгдэх	Орчны дуу чимээ, тоосжилтын улмаас өвчилсөн, эмчлүүлсэн, гомдол гаргасан иргэдийн тоо, жил бүр		

Эрүүл мэнд, сайн сайхан байдалд гарч буй өөрчлөлт, нөлөөлөл

27	Хүн амын дундах халдварт болон халдварт бус өвчлөл	Өвчлөлийн тоо, жил бүр	Ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага	Эдгээртэй холбоотой сум, аймаг, улсын статистик мэдээлэл
		Орон нутгийн иргэдийн эрүүл мэндэд гарсан өөрчлөлт, төсөл хэрэгжүүлэгчийн хэрэгжүүлсэн эрүүл мэндийн хөтөлбөрийн тоо,	Хоёрдогч эх сурвалжийн	

		хамрагдсан хүмүүсийн тоо, жил бүр	анализ	Оролцогч талуудтай хийсэн ярилцлага, мэдээлэл
28	Сэтгэцийн эрүүл мэнд өөрчлөгдөх	Сэтгэл заслын эмчилгээ авсан иргэдийн тоо, жил бүр	Нөхцөл байдлын таамаглалын арга	Холбогдох бусад тайлан, судалгааны өгүүлэл
		Төслийн тэсэлгээний дуу чимээ, үүний улмаас бие болон сэтгэцийн эрүүл мэндийн өвчлөлтэй болсон хүний тоо, 2 жил тутам	Нөлөөллийн загварчлалын арга	
29	Химийн бодис болон орчны бохирдлоос үүдэлтэй өвчлөл нэмэгдэх	Өвчлөлийн тоо, жил бүр	Нийтийн сонсголын арга	Хээр хийсэн чанарын судалгааны мэдээлэл
30	ХАБ дүрэм журам зөрчигдсөний улмаас осол гэмтэл гарах, иргэд амь нас, эрүүл мэндээрээ хохирох	Төслийн машин техникт дайруулах, ухсан нүхэнд унах гэх мэтээр бэртэж гэмтсэн, нас барсан хүний тоо, жил бүр		
		Төслийн машин техникт дайруулах, ухсан нүхэнд унах гэх мэтээр хорогдсон малын тоо, жил бүр		
Хүсэл тэмүүлэл, ирээдүйдээ итгэх итгэлд гарч буй өөрчлөлт, нөлөөлөл				
31	Хүмүүсийн өөрсдийн аюулгүй байдал, ирээдүй, үр хүүхдийнхээ ирээдүйн талаарх хүсэл тэмүүлэл ба тодорхойгүй байдлаас үүдэлтэй айдас хүйдэс нэмэгдэх	Төслийн үйл ажиллагаа орон нутгийн хөгжилд урт хугацаандаа хувь нэмрээ оруулна гэж үзэж буй орон нутгийн иргэдийн хувь, жил бүр	Ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага Хоёрдогч эх сурвалжийн анализ Нөхцөл байдлын таамаглалын арга	Эдгээртэй холбоотой сум, аймаг, улсын статистик мэдээлэл Оролцогч талуудтай хийсэн ярилцлага, мэдээлэл
32	Ажил эрхлэлттэй холбоотой айдас нэмэгдэх	Төслийн үйл ажиллагаатай холбоогүйгээр хүүхдээ ирээдүйд малчин болгохгүй гэж үзэж буй эцэг, эхийн тоо, 3 жил тутам	Нөлөөллийн загварчлалын арга	Холбогдох бусад тайлан, судалгааны өгүүлэл
		Төслийн үйл ажиллагаатай холбоотойгоор хүүхдээ ирээдүйд малчин болгохгүй гэж үзэж буй эцэг, эхийн тоо, 3 жил тутам		
33	Төсөлд ажиллах гадаад иргэдээс үүдэлтэй зөрчил, үл итгэлцэл үүсэх	Төсөлд байнга болон түр хугацаагаар ажиллаж буй гадаад иргэдийн тоо, жил бүр		
		Төслийн ажилчдын оролцсон гэмт хэрэг зөрчлийн тоо, жил бүр		
Бусад				
34				

Эрдэс баялгийн төсөл болон түүнийг дагасан дэд бүтцийн төслийн хэрэгжилтийн улмаас үүсэх нийгмийн нөлөөлөлд мониторинг хийхдээ дор дурьдсан индикаторуудыг ашиглаж болно. Эдгээр нь төсөл бүрт харилцан адилгүй байж болох тул жишиг болгон оруулав, Мониторингийн багийнхан тухайн төслийн онцлогт тохирсон байдлаар шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулан гаргана.

Нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийсний дараа нэгдсэн бүртгэлийг Хүснэгт 6. Нөлөөллийн хяналтын нэгдсэн бүртгэл- ийн дагуу хариу арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг тогтмол хянаж, дүгнэх ба хяналтыг нөлөөлөлд өртөх иргэд, бусад талуудад нээлттэй байлгана.

Хүснэгт 6. Нөлөөллийн хяналтын нэгдсэн бүртгэл (загвар)

Компанийн нэр:				Магадлал	Үр Дагавар	ТӨСЛИЙН НӨЛӨӨЛЛИЙН БҮРТГЭЛ						ЭРСДЭЛИЙН ХАРЬЦУУЛАЛТ					
Төслийн үе шат:						#	Хамрагдах хүрээ	НӨЛӨӨЛӨЛ агуулсан нөхцөл, үйл ажиллагаа	Эерэг / Сөрөг	Хүлцэх хэмжээ	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв	Хариуцах ажилтан	Хянах ажилтан	Баталгаажуулах албан тушаалтан	Эрсдэлийн эхний үнэлгээний тайлбар	Эрсдэлийн шинэчилсэн үнэлгээ
Байршил, хамрагдах аймаг, сум, баг:																	
Бүртгэлийн огноо:																	
Бүртгэлийг шинэчлэх огноо:																	
1																	
2																	
3																	
4																	
5																	

VII үе шат: Төслийн нөлөөллийн бүсийн иргэдийг мэдээллээр хангаж, оролцоог баталгаажуулах

Энэ шатны зорилго нь 1-рт Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ болон Нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний дүгнэлтийн уялдааг хангах, Менежментийн төлөвлөгөө, Хяналт шинжилгээний хөтөлбөрийн уялдааг хангах бодитой хэрэгжихуйц төлөвлөгөө болгох, орон нутгийн иргэд, түүний дотор нөлөөллийн бүсийн иргэдэд хангалттай ойлголт өгөх, тэднийг өөрийн өрхийн аж ахуй, бэлчээрийн ашиглалт, газрын эрхээ хамгаалах, мөн төслийн үйл ажиллагаанд мэдлэгтэйгээр хяналт тавих, ирээдүй үедээ үнэн зөв мэдээлэл үлдээх улмаар үе дамжсан мэдлэгт суурилсан хяналт оролцоо бий болгох суурийг бэлтгэх зорилготой.

БОНБҮТ хуулийн 18-р зүйлийн 18.5 дахь заалт дагуу БОАЖНХ-ийн сайдын 2014 оны А-03 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах” журмын дагуу зохион байгуулахад Нийгмийн нөлөөллийн үнэлгээний тайлангийн төсөл, Менежментийн төлөвлөгөөний төсөл, Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төсөлд иргэдтэй уулзалт хийх, оролцооны аргаар үнэлэх аргачлалыг ашиглан иргэдийн саналыг бүрэн авах, нөлөөллийн үнэлгээний үе шатанд олон нийтийн оролцоог зөвлөлгөөн, хэлэлцүүлэг, санал асуулга явуулах замаар төслийн шууд болон шууд бус нөлөөллийг үнэлж, иргэдийн амьжиргаа, нийгмийн асуудлыг тусгахад анхаарах, менежментийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтийг боловсруулах явцад олон нийтийн оролцоог хангах арга хэмжээг төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй иргэдийн саналын дагуу тусгаж, тэдний оролцоог хэрхэн хангах арга замыг тодорхой болгосон байна.

Энэ шатны ажлыг дараах байдлаар гүйцэтгэж баримтжуулан, баримтыг баталгаажуулан БО, НННҮ-ний тайланд хавсаргана.

1. Боловсруулсан Нийгмийн нөлөөллийн үнэлгээний тайлангийн төсөл
2. Нийгмийн нөлөөллийн менежментийн төлөвлөгөөний төсөл
3. Нийгмийн нөлөөллийн менежментийн хяналт шинжилгээний хөтөлбөрийн төсөл
4. 4-р шатанд гаргасан иргэдийн саналыг хэрхэн тусгасан дэлгэрэнгүй мэдээлэл, тайлбарыг ажлын 10 өдрийн өмнө нөлөөллийн бүсийн иргэдэд хэвлэж өгсөн байх, олон нийтэд нээлттэй болгосон байна.
5. Нөлөөллийн бүсийн иргэд дээрх 3 баримт бичгүүдтэй танилцаж ойлгох, эрх зүйн болон мэргэжлийн зөвлөгөө авах хангалттай хугацаа өгсөн байна.
6. Нөлөөллийн бүсийн иргэд, олон нийт БОНННҮ-ний тайлан холбогдох баримт бичигт тусгах санал, шүүмжээ бичгээр үнэлгээний компани, нутгийн захиргааны байгууллага болон Багийн ИНХ-д тайлангийн төслийн баримт бичгүүдийг гар дээр хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор хүргүүлнэ.

VIII үе шат: Үнэлгээний тайлан бэлтгэх

Энэ шатны зорилго нь үнэлгээний явцад бүрдүүлсэн мэдээллийг нэгтгэн боловсруулж тайлангийн хэлбэрт оруулах, төрийн эрх бүхий байгууллагын зохицуулалт, шаардлагыг хангасан тайлангийн бүтэц, хэлбэрт оруулсан “Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан”-ийн төслийг төсөл хэрэгжүүлэгчид танилцуулах, нийгмийн эерэг ба сөрөг нөлөөлөл, түүнд өртөгчдийн асуудлыг ойлгуулах, авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал болон өгч буй зөвлөмжийг хэрэгжүүлэхийг баталгаажуулна. Нөлөөллийн бүсийн иргэдээс гаргасан санал, шүүмжийг албан ёсоор тусад нь тэмдэглэн төсөл хэрэгжүүлэгчид хүлээлгэн өгч, БОНННҮ-ний тайланд хавсаргана.

Тайланг дараах байдлаар боловсруулна. Үүнд:

1. Боловсруулсан мэдээллийг нэгтгэн тайлангийн бүтэц, хэлбэрт оруулах;
2. Төсөл хэрэгжүүлэгчид тайланг танилцуулах;
3. Төрийн эрх бүхий байгууллагад тайланг хүргүүлэх;
4. Шаардлагатай тохиолдолд төрийн эрх бүхий байгууллагаас ирүүлсэн саналыг судлан тусгаж, тайланг төсөл хэрэгжүүлэгчид хүргүүлэх.

Нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан нь “Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан”-ийн бүрэлдэхүүн хэсэг хэдий ч бие даасан дараах бүтэцтэй байна. Үүнд:

Нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн бүтэц:

1. Тайлангийн техникийн бус хураангуй;
2. Оршил;
3. Эрх зүйн хамрах хүрээ;
4. Төслийн тодорхойлолт;
5. Төслийн хамтарсан баг;
6. Төсөл хэрэгжих засаг захиргааны нэгж бүрийн нийгэм, эдийн засгийн төлөв байдал;
7. Төслийн нийгэмд үзүүлж болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл, тэдгээрийн эрчим, тархалт, үр дагаврыг тогтоосон тооцоо, судалгааны үр дүн;
8. Төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, зайлсхийх, арилгах арилгах арга хэмжээний зөвлөмж;
9. Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн ерөнхий үнэлгээнд эрсдэлийн үнэлгээ хийхээр заасан бол төслийн үйл ажиллагаанаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн эрсдэлийн үнэлгээ;
10. Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн менежментийн төлөвлөгөөний зорилт, хамрах хүрээ, шалгуур үзүүлэлтүүд;
11. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэдийн нийтийн хурлын санал, тэмдэглэл; ирцийн бүртгэл
12. Ашигласан материал, арга зүй ;
13. Хавсралт.
14. Үнэлгээний компаний ажлын жагсаалт, багийн бүрэлдэхүүний танилцуулга.

IX үе шат: Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг Багийн ИНХ- ын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэр гаргуулах.

Энэ үе шатны зорилго нь тухайн төсөл хэрэгжих засаг захиргааны анхан шатны нэгжийн хуралдаанаар хэлэлцүүлж дэмжих эсэх шийдвэр гаргуулж БОНННҮ-ний тайлангийн эцэслэсэн хувилбарыг хэлэлцүүлэн шийдвэр гаргуулах, цаашид талуудад үүсэх аливаа эрсдлээс хамгаалах, урт хугацааны харилцан хяналт, хариуцлагатай түншлэлийг хөгжүүлэх, харилцан тогтвортой хөгжлийг бий болгох ач холбогдолтой ажил юм.

Энэ шатны ажлыг дараах байдлаар гүйцэтгэж баримтжуулан, баримтыг баталгаажуулан БО, НННҮ-ний тайланд хавсаргана.

1. Нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ гүйцэтгэсэн компани төсөл хэрэгжих багийн ИНХ-д БО,НННҮ-ний тайлангийн төсөл хэлэлцүүлэх хүсэлтээ хүргүүлнэ. Тухайн төсөл 2-оос дээш багийн нутаг дэвсгэр хамарч байгаа бол баг бүрийн багийн ИНХ-д хүсэлтээ хүргүүлнэ.
2. Багийн ИНХ-ын хуралдаанд төсөл хэрэгжүүлэгч ААНБ-ыг байлцуулан БО,НННҮ-ний тайлангийн төслийг танилцуулж хэлэлцүүлнэ.
3. БО, НННҮ-ний тайланд багийн ИНХ-ын хуралдааны ирц, тэмдэглэл, шийдвэрийг хавсаргана. Багийн ИНХ-ын хуралдаанд танилцуулж хэлэлцүүлсэн нь зөвхөн иргэдийн оролцоог хангаж буй хэрэг бөгөөд төслийг хэрэгжүүлэх эрхийг олгосон, зөвшөөрсөн ойлголт биш юм.

Х үе шат: Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг олон нийтэд нээлттэй болгох

Энэ үе шатны ажлын зорилго нь батлагдсан Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг олон нийт танилцах, мэдээлэлтэйгээр хяналт тавих, хариуцлага шаардах боломжийг бүрдүүлэх, талуудын үүрэг хариуцлага, оролцоог бодитой дүгнэх боломжийг олон нийтэд олгох зорилготой.

Энэ шатны ажлыг дараах байдлаар гүйцэтгэнэ.

1. Батлагдсан Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг 5 хувь үйлдэж төсөл хэрэгжүүлэгч, төсөл хэрэгжих нутгийн захиргааны байгууллага, Хүн амын хөгжил, нийгмийн хамгаалал болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тус бүрт, төсөл хэрэгжих нутгийн захиргааны байгууллагад хүргүүлж, үнэлгээ хийсэн компани өөртөө нэг хувийг хадгална. Засаг захиргааны нэгжийн хувьд 2-оос дээш сум, дүүрэг хамарсан төсөл бол Нутгийн захиргааны байгууллагын тоогоор хувилж хүргүүлнэ.
2. Үнэлгээ хийсэн компани БО, Нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг батлагдсан даруйд Байгаль орчны мэдээллийн нэгдсэн цахим системд бүрэн эхээр оруулах үүрэгтэй.
3. Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг олон нийтэд нээлттэй байлгах үүргийг төсөл хэрэгжүүлэгч болон сум дүүргийн Засаг дарга, баг, хорооны Иргэдийн нийтийн хурал мөн аймаг нийслэлийн байгаль орчны газар хариуцна.
4. Төсөл хэрэгжүүлэгч нь батлагдсан Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, Менежментийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх явцад олон нийтийн оролцоог хангаж, хэрэгжилтийг жил бүрийн 11 сарын 20 дотор багтаан тухайн төсөл хэрэгжиж буй нутгийн иргэд, олон нийтэд танилцуулж, санал авч сайжруулж байна.

ЗУРГАА. САНАЛ, ГОМДОЛ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ МЕХАНИЗМ

Нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх ажлын хүрээнд үнэлгээний баг төслийн үйл ажиллагаа, төлөвлөлтийн талаар оролцогч талууд санал хүсэлтээ илэрхийлэх,

шаардлагатай үед гомдол гаргах, шийдвэрлүүлэх боломжтой амар хялбар, хүртээмжтэй механизмыг бий болгосон байх ба уг механизмыг тогтмол ажиллуулдаг, тайлагнадаг байх санал зөвлөмжийг төсөл хэрэгжүүлэгчид үүрэгжүүлэх шаардлагатай. Шаардлагатай бол шүүхийн замаар эрх, эрх чөлөөгөө хамгаалах эрхийг хүндэтгэх үүрэгтэй.

Санал, гомдол хянан шийдвэрлэх механизмыг бий болгохдоо нийгмийн нөлөөллийн үнэлгээ боловсруулахад байгуулсан хамтарсан багийн бүтцийг идэвхжүүлэн, цааш үргэлжлүүлэн ажиллуулах эсхүл шинээр компани, иргэд, төрийн байгууллагын хамтарсан бүтцээр, сонирхлын зөрчилгүй этгээдийг бүтэц, бүрэлдэхүүнд багтаан байгуулсан байна. Ямар ч тохиолдолд нөлөөлөлд өртөх иргэдийн оролцоогүй, компани дангаараа шийдвэр гаргах механизм байх боломжгүй гэдгийг анхаарна уу. Санал, гомдол шийдвэрлэх багт багтсан гишүүн бүр иргэд, хуулийн этгээдээс ирүүлсэн санал, гомдол, хүсэлт, мэдээллийн ерөнхий мэдээлэл ба дэлгэрэнгүйг авч, судлах боломжтой байна. Санал гомдлыг шийдвэрлэхдээ тухайн бүтцэд урьдчилан мэдээлэл хүргэн, мэдээллийн дагуу холбогдох баримтыг хүргэж, хуралдуулах, холбогдох шийдвэр гаргахад оролцуулах зэрэг зохион байгуулалтын ажил, зардлыг төсөл хэрэгжүүлэгч хариуцан, үйл ажиллагааг журамлан зохицуулсан байна. СГХШМ-ын үйл ажиллагаатай холбоотой бүхий л мэдээлэл олон нийтэд ил тод байх шаардлагыг заавал хангана.

Санал гомдол хянан шийдвэрлэх механизм нь дараах хэлбэртэй байж болох ч тухайн газар нутаг, иргэдийн тархалт, технологийн боломж зэргийг урьдчилан тодорхойлж, аль болох боломжит хувилбар эсхүл хэд хэдэн хувилбаруудыг зэрэг сонгож болно. Үүнд:

- **Пейж хуудас.** Уг пейж хуудсыг ажиллуулахдаа нөлөөлөлд өртөх иргэдэд шаардлагатай мэдээллийг хүргэх, санал асуулга, хэлэлцүүлэг хийх болон гомдол, санал хүргүүлэх сувгийг бий болгосон, тэдгээрийг шийдвэрлэхэд шаардлагатай үлдэгдэл хугацаа, хариуцсан албан тушаалтан, шийдвэрлэгдсэн эсэх нь харагдах байдлаар хийнэ.
- **Утсаар гомдол, санал хүлээн авах суваг.** Хэрэв уг системээр мэдээлэл авах бол гомдол, саналыг хүлээн авсан бүртгэлийн дугаарыг хариу мессежээр хүргэж, тэдгээрийг шийдвэрлэхэд шаардлагатай үлдэгдэл хугацаа, хариуцсан албан тушаалтныг мэдэгдэнэ.
- **Цахим хуудас.** Хэрэв байгууллагын цахим хуудсаар иргэдийн гомдол, санал, мэдээлэл хүлээн авах бол дээрх пейж хуудас болон утсаар санал гомдол хүлээж авах сувгийг заавал давхар бий болгосон байна. Цахим хуудаст гомдол, саналыг хүлээн авах, иргэдэд ойлгомжтой, олоход хялбар, энгийн бүтэцтэй цэс бий болгож, цахим шуудангийн хаяг эсхүл фейсбүүк хаягтай нь мэдээллийг холбох, гомдол саналын бүртгэлийн дугаарыг хариу мэдээлэх, тэдгээрийг шийдвэрлэхэд шаардлагатай үлдэгдэл хугацаа, хариуцсан албан тушаалтныг мэдэгдэнэ.
- **Бичгээр гомдол хүлээж авах.** Энэ нь тодорхой цэг, албан хаагч байхыг шаардах бөгөөд ач холбогдол нь гаргасан гомдол санал түүний хариу шийдвэрлэлт баримт болж үлддэг ач холбогдолтой. Цаашид шүүхийн замаар асуудал шийдэх хүртэл явах тохирлдолд цаасан баримт бичиг нь нотлох баримт болдог ач холбогдолтой.
- **Бусад.** Гомдол санал хүлээн авах, хянан шийдвэрлэх бусад аль тохирох хувилбарыг төсөл хэрэгжүүлэгч бий болгож болох хувилбарыг НННҮ боловсруулах хамтарсан санал болгож болно. Ямар ч тохиолдолд дээрх пейж хуудас болон утсаар санал гомдол хүлээж авах сувгийг давхар үүсгэсэн байна.

Санал, гомдол бүр бүртгэлийн дугаартай, архивлагдсан байна. Шийдвэрлэгдэх хугацаа нь хуанлийн 30 хоногоос хэтрэхгүй бөгөөд шаардлагатай арга хэмжээг авахад

төрийн захиргааны болон орон нутгийн удирдлагын байгууллагад хүсэлт гаргах, оролцоог нэмэгдүүлэх, удирдамж ба зөвлөмж гаргуулах зэрэг ажлыг нийт гишүүдийн оролцоотой шийдвэрлэж, зохион байгуулж болно. Нийгмийн сөрөг нөлөөллийг арилгах, хүний үндсэн эрхийн зөрчлийг таслан зогсооход хугацаа сунгаж шийдвэрлэх үндэслэлгүй бөгөөд хэрэв төрийн байгууллагаас тухайн асуудалтай холбоотой зөвшөөрөл, баталгаа зэрэг шаардлагатай бол уг зөрчигдсөн эрхтэй холбоотой үйл ажиллагааг зогсоосон байх шаардлагатай.

- о О о -

Нийгмийн нөлөөллийн үнэлгээний арга зүй

Нийгмийн нөлөөллийн үнэлгээнд олон тооны арга зүй хэрэглэх боломжтой. Тухайн төслийн цар хүрээ, төрөл, хэрэгжих хугацаа, оролцогч талуудын сонирхол, эрсдлээс сэргийлэх арга хэмжээ, үнэлгээний багийн нөөц, ур чадвар, бусад хүчин зүйлсээс шалтгаалан үнэлгээний багийнхан аль ч арга зүйг дангаар нь мөн хэд хэдийг зэрэг сонгон ашиглах боломжтой. Нийгмийн шууд болон шууд бус нөлөөлөл, эерэг болон сөрөг нөлөөллийг тодорхойлох зорилгоор сонголтыг хийнэ.

Нэг арга зүйг дангаар нь ашиглахгүйгээр хэд хэдэн арга зүйг цогцоор нь ашиглах нь шаардлагатай мэдээллийг гаргаж өгөх ач холбогдолтой. Мөн нэг арга зүйн аргаар тодорхойлж чадаагүй нөлөөллийг өөр арга зүйгээр тодорхойлж гаргах магадлалтай тул арга зүйг аль болох зэрэгцүүлж ашиглавал зохино.

Санал болгох арга зүй:

1. Нийгмийн зураглал хийх арга зүй
2. Санал асуулгын арга зүй
3. Хоёрдогч эх сурвалжийн мэдээлэл ашиглах арга зүй
4. Нийгмийн нөлөөллийн орчны эрхзүй, стратегийн шинжилгээ хийх арга зүй
5. Нийгмийн суурь үзүүлэлтүүдийн судалгааны арга зүй
6. Нөлөөлөл үүсгэх арга замыг тодорхойлох арга зүй
7. Нөхцөл байдлын таамаглалын арга зүй
8. Жендэрийн нөлөөллийн үнэлгээний арга зүй
9. Нийтийн сонсголын арга зүй
10. Нөлөөллийн загварчлалын арга зүй

Арга зүйн дэлгэрэнгүй санал болгож буй хэлбэртэй доорх хүснэгтээс танилцана уу.

Хүснэгт 7. Арга зүйн тайлбар

№	Тодорхойлолт	Санал болгох арга зүй
1	Нийгмийн зураглал хийх арга зүй	Энэхүү арга зүй нь төслийн нөлөөллийн бүст хамаарах оролцогч талуудын сонирхол, нөлөөллийг тодорхойлох, өрхийн нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүд (боловсролын түвшин, ур чадвар, эд хөрөнгө болон эрхийн эзэмшил, өрхийн орлого гэх мэт)-ийг тодорхойлоход ашиглагддаг арга зүй юм. Уг арга зүйгээр ямар өрх тухайн төслийн үр шимийг хэрхэн хүртэх эсхүл хүртэхгүй байхыг тодорхойлох боломжтой ба ашиглахдаа дор дурдсан асуудлуудад анхаарна. Үүнд: - Бэлтгэлийн шатанд үнэлгээний зорилгыг тодорхойлж, оролцогч талуудыг эхний байдлаар тодорхойлсоны дараа төслийн боломжит бүх оролцогч талуудын жагсаалтыг гаргаж, тэдгээрээс анхдагч болон хоёрдогч оролцогч талуудыг тодорхойлж, бусад оролцогч талуудыг эрэмбэлнэ. Анхдагч оролцогч тал гэдэг нь төслийг үр шимийг шууд хүртэх (ажлын байраар хангагдах гэх мэт), эсвэл төслийн сөрөг

		<p>нөлөөлөлд шууд өртөх (нүүлгэн шилжүүлэлтэнд өртөх гэх мэт) хүмүүсийг хэлэх бол хоёрдогч оролцогч тал гэдэгт төслийн шууд бус дундын оролцогчдыг (төслийн ханган нийлүүлэгчид, төслийн гэрээт ажилчид, шинэ суурьшлын бүсийн оршин суугчид гэх мэт) нэрлэнэ.</p> <ul style="list-style-type: none"> - Тухайн төслийн нөлөөллийн бүсийн бүх өрхийг судалгаанд хамруулсан байх - Өрх бүр өөрсдийн аж байдлыг өөрсдөө үнэлэх боломжийг бүрдүүлэх. Үүний өмнө өрхийн гишүүдээс хэн нь асуулгад оролцохыг тодорхойлж, зөвшөөрөл авсан байх ба асуулгын зорилго, ач холбогдол зэргийг сайтар тайлбарлана. Нутгийн иргэд шаардлагатай гэж үзсэн бол сургалтад хамруулж чадавч олгох, хэд хэдэн удаагийн дадлага хийх, хүний эрхийн мэргэжилтнүүд, ТББ-аас зөвлөгөө өгөх шаардлагатай. - Асуулт бүрийн хариулт нөлөөллийн эрчим өөр өөр ялгаатай өнгөтэй байх ба тухайн үнэлгээнээс шаардлагатай үзүүлэлтийг сонгоно. Жишээ нь улаан өнгөөр “Хүүхдүүдийн сургуульд суралцах байдал”-ыг, шар өнгөөр “Боловсролын хүртээмж”-ийг илэрхийлсэн гэх мэт. Өнгө бүр өөрийн дугаартай, өнгө дотроо ангилалтай байж болох ба ингэснээрээ тухайн өрхийн амьжиргаанд цаг хугацааны явцад гарч буй өөрчлөлтийг харуулах зорилготой байна. <p>Тухайн зураглал нь тухайн өрх бүрийн аж амьдралын нөхцөлийг, амьдралын чанарын өөрчлөлтийг жил бүрээр харуулах ба төсөл хэрэгжсэнээр хэрхэн өөрчлөгдөхийг дүгнэх юм. Түүнчлэн, төсөл хэрэгжсэнээр хэд хэдэн үзүүлэлтэд өөрчлөлт хэрхэн орж байгааг бэлтгэсэн асуултын хүрээнд тодорхойлох боломжийг бүрдүүлнэ.</p>
2	Санал асуулгын арга зүй	<p>Санал асуулга нь тоон болон чанарын мэдээллийг цуглуулах, боловсруулах, шинжилгээ хийх арга зүй юм. Энэхүү арга зүйгээр тухайн төслийн нөлөөллийн бүсийн айл өрхүүдийг бүгдийг хамруулахыг эрмэлзвэл зохино. Энэхүү аргыг богино хугацаанд олон тооны мэдээлэл цуглуулах шаардлага үүссэн тохиолдолд түлхүү хэрэглэдэг.</p> <p>Санал асуулгын арга зүйг ашиглахдаа судалгаа, ярилцлагын зорилт, хэрэгцээ, шаардлагад тохируулан тухай бүрд нь тохирох дизайн, арга зүйг сонгож, санал асуулгыг урьдчилан боловсруулсан (асуулт, асуулт ба хариулт, асуулт ба сонголт гэх мэт) хувилбартай мэдээллийг тусгасан хэвлэмэл хуудсаар эсхүл нээлттэй асуултаар авч баримтжуулна.</p> <ul style="list-style-type: none"> - <i>Стандарт ярилцлага:</i> Тодорхой зорилгын хүрээнд боловсруулсан асуултад судалгаанд хамрагдагч бодож байж хариулт өгдөг арга юм. - <i>Хагас стандарт ярилцлага:</i> Судалгаагаар хатуу тогтоосон хүрээн дэх шаардлагатай мэдээллийг авахдаа (хагас нээлттэй асуулгын хуудас) тухайн сэдэвтэй холбоотой судалгаанд хамрагдагчийн санал бодлыг орхигдуулдаггүй ач холбогдолтой арга юм. - <i>Чөлөөт ярилцлага:</i> Судлаач судалгааны хатуу тогтоосон хүрээнд баригдахгүйгээр асуултуудыг өөрийнхөөрөө асууж мэдээлэл авч, хариултыг бүрэн тэмдэглэж (дуу хураагуурт бүрэн буулгах) авдаг уян хатан арга. Судалгааны зорилгоос хамаарч судлаач ерөнхий хүрээндээ аль эсвэл судалгааны зорилтуудаасаа хальсан асуудлуудыг олж харж, зохих өөрчлөлтүүд оруулах боломжтой байдаг давуу талтай арга юм. - <i>Утсаар санал авах арга:</i> Судалгаанд хамрагдагчаас мэдээлэл авахдаа утсаар ярилцаж, хямд өртгөөр шуурхай хариулт авдаг арга юм. Энэхүү арга нь богино хугацаанд, олон хүнээс мэдээлэл авах сайн талтай хэдий ч санал асуулгад оролцохоос янз бүрийн шалтгаанаар татгалзах, мөн хөдөө орон нутаг дахь утасны хүрэлцээ, сүлжээний чанар зэргээс шалтгаалан судалгааны түүврийн төлөөлөх чадварыг

		<p>бүрэн хянаж чаддаггүй сул талтай. Иймд олон хүнээс, хаалттай асуултаар, цөөн тооны, тодорхой мэдээлэл авах зорилгоор ашиглахад тохиромжтой.</p> <ul style="list-style-type: none"> - <i>Ганцаарчилсан ярилцлага:</i> Судлаач судалгаанд оролцогчтой ганцаарчилан нүүр тулсан уулзалт хийх замаар шууд харилцаж, судалгааны мэдээллийг олж авах арга юм. Энэ тохиолдолд судалгаанд хамрагдагчийн санал бодлыг асуулгын хуудсыг агуулгаас хамаарахгүйгээр (аль эсвэл асуулгын хуудас огт хэрэглэхгүйгээр) тухайн хүнийхээ нөлөөллийн асуудлын талаарх байр суурь, хандлага, сэдэл, сэтгэл зүйг гүнзгийрүүлэн нээн илрүүлэхийг чармайдаг. Судалж буй зүйлийн талаар судалгаанд хамрагдагчид бүрдсэн зан авир, хандлага, түүнийг тодорхойлж буй хүчин зүйлсийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авах боломжийг энэхүү арга олгодог. - <i>Судалгаанд хамрагдагчийн</i> ярилцах явцдаа илэрхийлж буй сэтгэл хөдлөлийг анзаарч, түүний санаа бодол хэрхэн илэрч буйг хянуур мэдрэх чадвар бүхий мэргэжлийн судлаач ганцаарчилсан ярилцлагыг хийдэг. Энэхүү ярилцлагыг тодорхой асуумж болон тодорхой сэдвээр чөлөөтэй ярилцах байдлаар хийж болдог. - <i>Фокус бүлгийн ярилцлага:</i> Фокус бүлгийн ярилцлагыг 6-10 хүний бүрэлдэхүүнтэйгээр хийдэг бөгөөд чиглүүлэгчийн удирдлага доор бүлгийн анхаарлыг ярилцаж буй сэдэв, түүний хүрээнд төвлөрүүлсэн хэлэлцүүлэг хэлбэрээр явуулдаг. <p>Ашиг сонирхол нэгтэй хүмүүсийг нэг фокус бүлэг болгон (жишээ нь: малчид, төрийн захиргааны байгууллагын ажилтнууд, хувиараа бизнес эрхлэгчид гэх мэт ялгаатай бүлгүүдийг тус бүр бүлэг болгох) ярилцлагыг хийнэ. Судалгааны судлах зүйлийн хүрээнд сонгосон бүлгийн тухайн асуудлаарх төсөөлөл, ойлголт, хандлагыг урьдчилан бэлтгэсэн асуулга дагуу судална. Судалгааг хийхдээ тусгайлан бэлдсэн өрөө тасалгаанд, тодорхой багаж хэрэгсэл ашиглан явуулахаас гадна судалгааны шинжилгээ хийхэд зориулсан дэлгэрэнгүй тэмдэглэл, мөн видео болон аудио бичлэг хийж баримтжуулдаг.</p>
3	Хоёрдогч эх сурвалжийн мэдээлэл ашиглах арга зүй	<p>Нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх эхний шат буюу төслийн тухай суурь мэдээлэл бүрдүүлэх, төслийн оролцогч талуудыг тодорхойлох зэрэгт хоёрдогч эх сурвалжийн мэдээлэл ашиглах арга зүйг хэрэглэнэ.</p> <p>Хоёрдогч эх сурвалжийн мэдээлэл нь ихэнх тохиолдолд олон нийтэд нээлттэй байдаг. Үндэсний статистикийн газрын www.1212.mn, захиргааны байгууллагуудын мэдээлэл, холбогдох судалгааны тайлан, ном, товхимол, бусад эх үүсвэрийн тоон ба чанарын мэдээлэл зэрэг нь хоёрдогч өгөгдлийн багцуудын тод жишээ юм. Хоёрдогч өгөгдөл ашиглах хөрөнгө, цаг хугацаа хэмнэх, өгөгдөлд дүн шинжилгээ хийхэд зарцуулах цаг, боломжийг нэмэгдүүлэхээс гадна, мэргэжлийн түвшинд боловсрогдсон судалгааг ашиглах боломж олгодог давуу талтай. Үүнд төрийн бүх шатны байгууллагуудын албан ёсны мэдээллээс гадна судалгаа шинжилгээний болон судалгааны байгууллагууд, төслүүдийн судлагаа, тайланд тусгагдсан мэдээллүүд мөн хамаарна. Хоёрдогч эх үүсвэрийн мэдээлэлд боловсруулалт хийж, тайланд тусгах шаардлагатай.</p>
4	Нийгмийн нөлөөллийн орчны эрхзүйн	<p>Нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх компани нь тухайн төсөлд эрхзүйн шинжилгээ хийж зохих дүгнэлтийг гаргахад энхүү аргачлалыг ашиглана.</p> <ul style="list-style-type: none"> - Эхний шатанд төсөлд хамаарах хүний эрх, нийгэм, бизнесийн зарчимтай холбоотой дотоодын хууль, эрхзүйн орчны шинжилгээ

	шинжилгээ хийх арга зүй	<p>хийнэ. Үүнд: Үндсэн хууль, салбарын хууль тогтоомж, дүрэм, журам, аргачлал, үндэсний болон тухайн бүс нутаг, орон нутгийн хөгжлийн хөтөлбөр бодлого мөн төслийг хэрэгжүүлэх засаг захиргааны (нийслэл/аймаг, сум/дүүрэг, баг/хороо) түвшин, холбогдох төрийн байгууллагуудын (Засгийн газар, яам, агентлаг г.м.) шийдвэр багтана.</p> <ul style="list-style-type: none"> - Хүний эрх, нийгэм, бизнесийн зарчимтай холбоотой Монгол Улсын нэгдэн орсон олон улсын конвенци, гэрээ хэлэлцээрүүдийг олж тогтооно. - Төсөл, хэрэгжүүлэгч компани олон улсын банк, санхүүгийн байгууллагаас санхүүжилт авдаг эсэхийг тодорхойлж улмаар тэдгээр байгууллагуудын хүний эрх, нийгэм, бизнесийн зарчимтай холбоотой тавьдаг нийтлэг шаардлагууд, хүлээсэн үүрэгтэй дотоодын хууль, тогтомжууд хэрхэн нийцэж байгааг тодорхойлж, дүгнэлт өгнө. Хэрэв дотоодын хууль, дүрэм, журам болон олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн үүргүүд санхүүжүүлэгчдийн шаардлагатай зөрчигдөхөөр бол хуульд хэрхэн нийцүүлэх, зөрчил, хийдлийг арилгах зөвлөмжийг төсөл хэрэгжүүлэгчтэй зөвшилцсөн боловсруулна.
5	Нийгмийн суурь үзүүлэлтүүдийн судалгааны арга зүй	<p>Үнэлгээний баг төслийн хамрах хүрээнд нийгмийн суурь үзүүлэлтүүдийг тодорхойлохдоо орон нутгийн иргэд, төрийн захиргааны байгууллагын ажилтнуудын тусламжтайгаар орон нутгийн статистик, өгөгдөл зэргийг цуглуулна. Энэхүү үзүүлэлтүүд нь тухайн төсөл хэрэгжиж буй орон нутгийн иргэдийн нийгэм, эдийн засаг, соёлын байдлын талаар ерөнхий дүр зургийг тодорхойлоход чухал үүрэгтэй. Нийгмийн шалгуур үзүүлэлтийн судалгаанд дараах зүйлүүдийг багтаана.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - <i>Хүн ам зүйн суурь үзүүлэлтүүд гэдэгт</i> хүн амын тоо, нягтаршил, оршин суух газар, нас, хүйс зэргийг авч үзнэ. - <i>Хүн амын өсөлт, өөрчлөлт</i> гэдэгт төслийн үйл ажиллагаанаас үүсэх хүн амын шилжилт хөдөлгөөний нөлөөллийг авч үзнэ. - <i>Нийгэм, соёлын орчин</i> гэдэгт соёл, ёс заншил, биет болон биет бус соёлын өвүүд, соёлын төв, барилга байгууламж, тэдгээрийн хүртээмж зэргийг авч үзнэ. - <i>Нийгэм-эдийн засгийн орчинд</i> дэд бүтэц, хүмүүсийн орлого, бүтээмжид нөлөөлөх хүчин зүйлс, газар, бэлчээрийн түрээс, ашиглалт, өмчлөл, ашигтай зах зээлд нэвтрэх боломж, мөн бараа, бүтээгдэхүүний хүртээмж, гэр бүл, айл саахалтын бүтэц, хөдөлмөр эрхлэх боломж, боловсрол, тухайн нутаг орондоо үнэлэгддэг, хэрэгцээтэй ур чадвар, орон нутгийн бизнес, худалдаа үйлчилгээний тогтолцоо, эдийн засгийн суурь болох дэд бүтэц, тухайн орон нутагт зориулагдсан хөгжлийн бодлого, жижиг дунд үйлдвэрлэлийн хөтөлбөр зэргийг авч үзнэ. - <i>Нийгмийн зохион байгуулалтад</i> нөлөөлөлд өртсөн иргэдийн нутгийн удирдлага, төлөөллийн байгууллагуудын шийдвэр гаргах үйл явцад оролцох, мэдээлэл авах, үйлчилгээ авах боломж, бололцоо, чадавх зэргийг авч үзнэ.
6	Нөлөөлөл үүсгэх арга замыг тодорхойлох арга зүй	<p>Эрдэс баялгийн салбарын төсөл нь зайлшгүй хүрээлэн буй орчин/байгаль орчинд өөрчлөлт, доройтол үүсгэдэг салбарын онцлогтой. Нэгэнт төсөл нь тухайн нутгийн хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөлөл үүсгэдэг тул тухайн бүс нутгийн байгалийн нөөцөд түшиглэсэн бусад салбаруудад /мал аж ахуй, газар тариалан, аялал жуулчлал г.м./ эерэг болон нийгмийн сөрөг нөлөөлөл үзүүлдэг. Ялангуяа уламжлалт нүүдлийн МАА-н салбарын хөгжилд шууд нөлөөлөл үзүүлнэ. Энэ арга зүйг аливаа төслийн улмаас тухайн орон нутгийн иргэдэд үзүүлэх нийгмийн нөлөөллийг тодорхойлоход ашиглаж болно.</p> <p>Нөлөөлөл үүсэх нөхцөл, тохиолдлуудыг гаргахдаа нөлөөлөл үүсгэж болзошгүй хүчин зүйлсийг ерөнхий зургаар нь тодорхойлж, үүний дараа</p>

		<p>тэдгээрийг нарийвчлан ангилна. Тухайлбал, уул уурхайн төсөл нь мөчлөг бүрт ялгаатай нөлөөлөл үзүүлэх бөгөөд олборлолт ашиглалт түүхий эдийн тээвэрлэлтийн үйл ажиллагааны улмаас орон нутгийн иргэдийн зан заншилд өөрчлөлт гарна гэсэн нөлөөлөл тодорхойлогдож болно. Тэгвэл, ашиглалтын үйл ажиллагаанд багтах үйл ажиллагааг дэлгэрэнгүй задалж, үйл ажиллагаа тус бүрийн үүсгэх магадлалтай нөлөөллийг хамрах хүрээний аль хэсэгт хэрхэн нөлөөлөхийг тус бүрт нь үнэлж, тодорхойлно. Ингэж тодорхойлох нь төслийн аль шатанд нөлөөлөл хэрхэн өөрчлөгдөхийг харуулах магадлалтай.</p> <p>Нөлөөллийг ангилахдаа одоогийн нөхцөл байдал ба ирээдүйд төсөл хэрэгжсэнээр хэрхэн өөрчлөгдөх магадлалыг гаргана. Уг арга зүйг ашиглан нөлөөллийг тодорхойлоход төслийн бүх оролцогч талууд оролцож, ирээдүйд үүсч болзошгүй хүний эрх, нийгмийн нөлөөлөл үүсгэх гадаад ба дотоод хүчин зүйлс, тэдгээрийн улмаас үүсэх нийгмийн нөлөөллүүдийг нарийвчлан тодорхойлоход ач холбогдолтой.</p>
7	Нөхцөл байдлын таамаглалын арга зүй	<p>Энэхүү арга зүй нь ирээдүйд үүсч болзошгүй нөхцөл байдлыг таамаглахад ашиглагддаг ба төслийн үйл ажиллагаанд нөлөөллийн үнэлгээ хийхэд илүү тохиромжтой. Уг аргаар эхний ээлжид судлаачид өмнөх практик болон ижил төстэй үйл ажиллагааны улмаар үүсч буй мөн үүсэх нөлөөллийг судлан, хэрэгжих төсөлд таамаглал дэвшүүлдэг учраас эрдэс баялгийн, дэд бүтцийн төслийн нийгмийн нөлөөллийг тодорхойлоход ашиглах бүрэн боломжтой гэж үздэг. Гол зорилго нь аливаа асуудал, нөлөөллийн өөрчлөлтийг урт хугацаанд (5-10 жил) өргөн хүрээнд таамаглан гаргахыг эрмэлздэг.</p> <p>Энэхүү арга зүйг ашиглахдаа нөхцөл байдлыг дунджаар 3 янзаар авч үзэхийг санал болгодог ба, үүнд нэгд, одоогийн нөхцөл байдал өөрчлөлт багатай буюу хэвээр үргэлжлэх, хоёрт, гэнэтийн сөрөг өөрчлөлт гарах, гуравт, өөдрөг хувилбар зэрэг байж болно. Гэхдээ өмнөх жишгийг сайтар харгалзаж, гарсан эерэг ба сөрөг нөлөөллийн аль алиныг судалж үзнэ. Ашиглахдаа анхаарах зүйл нь нэг хувилбарт хэт их анхаарал хандуулалгүй, бүх боломжит хувилбаруудыг ижил түвшинд авч үзэн, бодитой дүн шинжилгээ, дүгнэлт хийхийг эрмэлзэх явдал юм.</p>
8	Жендэрийн нөлөөллийн үнэлгээний арга зүй	<p>Уул уурхай болон дэд бүтцийн төслүүд нь эмэгтэй, эрэгтэй хүн, хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд харилцан адилгүй байж болно. Иймээс төслийн жендэрийн нөлөөлөл, ялангуяа орлого багатай эмэгтэйчүүд, хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх нөлөөллийг зайлшгүй үнэлэх шаардлагатай. Жендэрийн нөлөөллийн үнэлгээг хийхдээ дор дурдсан асуудлуудыг авч үзэх шаардлагатай. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Жендэр ба бүс нутаг, үндэсний бодлого төлөвлөлт - Жендэр ба хүний эрхийн асуудал - Орон нутаг, гэр бүлийн ба хөдөлмөрийн хуваарилалтын жендэрийн нөхцөл байдал, өөрчлөлт - Хөгжлийн төлөвлөлтөд жендэрт суурилсан бодлого, оролцоо - Нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор зэргийн жендэрийн нөлөөлөл - Усжуулалт, цахилгаанжуулалт, зам зэрэг бүтээн байгуулалт, төслийн үр шимийг хүртэх боломж ба жендэрийн асуудал - Мэдээлэл хүртэх боломж, хүртээмж дахь жендэрийн асуудал - Хөгжлийн төсөл, хөтөлбөрийн нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэд, бүлгүүдийг төлөөлөх институцуудын жендэрийн байдал болон бусад асуудал. <p>Жендэр ба хүний эрхтэй холбоотой нөлөөллийг үнэлэхдээ гэр бүл, тухайн орон нутаг, бүс нутаг, үндэсний хэмжээнд авч үзэх ба тухайн өрх гэрийн төдийгүй хувийн өмчтэй холбоотой эрх, мэдээлэл авах боломж, хүртээмж, нөөцийг ашиглах, зарцуулах эрх, шийдвэр гаргалт, хөдөлмөр</p>

		<p>эрхлэх боломж, тохирсон цалин хөлс авах зэрэг хүний эрхийн суурь асуудлуудад жендэрийн дүн шинжилгээ хийх байдлаар хандана.</p> <p>Жендэрийн нөлөөллийн үнэлгээг дараах алхмуудын дагуу хийнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Холбогдох суурь мэдээллийг цуглуулах - Тухайн орон нутгийн онцлог, гэр бүл, хот айл, орон нутагт эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн гүйцэтгэх үүрэг, ялгаа зэргийг тодруулах нөхцөл байдлыг таних судалгаа хийх - Уул уурхай, түүний дэд бүтцийн төслүүдийн улмаас эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үүсч болзошгүй асуудлуудыг тодорхойлох - Тухайн орон нутгийн эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох - Жендэрийн холбоотой стратеги боловсруулж, менежментийн төлөвлөгөөнд тусгах, - Тогтмол мониторинг үнэлгээ хийх <p>Жендэрийн үнэлгээ хийхдээ холбогдох хууль тогтоомж³, үндэсний бодлого, хөтөлбөрүүдэд⁴ тусгагдсан үйл ажиллагаа, төлөвлөлт, тэдгээрийн үр дүн, тайлан, зөвлөмж зэргийг харгалзан үзвэл зохино.</p>
9	Нийтийн сонсголын арга	<p>Нийтийн сонсголын тухай хууль болон Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах журмын хэрэгжилтийг хангах нь энэ арга зүйн онцлог байна. Уг аргыг хамтарсан баг байгуулах шатнаас тайланг хэлэцэн, төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх хүртэлх бүхий л шатанд хангаж ажиллах нь зүйтэй. Нийгмийн нөлөөллийн үнэлгээ боловсруулж эхлэхдээ гаргах төлөвлөгөөнд нөлөөлөлд өртөх магадлалтай иргэд, өрх, аж ахуйн нэгж байгууллага, төрийн захиргааны байгууллага зэргийн оролцоог хэрхэн хангах талаар сайтар төлөвлөж, орон нутгийн иргэдийн санал, зөвлөмжийг авах, иргэдийг мэдээллээр хангах, шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцоог нэмэгдүүлэн чадавхжуулах, төрийн шийдвэрийг иргэдэд хүртээмжтэй, нээлттэй, ил тод, шударга, эрх тэгш гаргахад үзүүлэх хамгийн том дэмжлэг болох юм. Улмаар уг процессыг хууль тогтоомжийн дагуу хангаж ажиллах нь нийгмийн зөвшөөрөл авах шалгуур болох ёстой. Нийтийн сонсгол нь нөлөөлөлд өртөж болзошгүй болон төслийн талаар сонирхсон бүх иргэд, талуудад нээлттэй байна. Төрийн захиргааны байгууллага нь нийтийг хамарсан асуудлаар шийдвэр гаргахаасаа өмнө Захиргааны ерөнхий хуулийн сонсох ажиллагааг зохион байгуулах үүрэгтэй тул уг үүргийг хэрэгжүүлэх ажлыг хамтран зохион байгуулах боломжтой.</p> <p>Нийтийн сонсгол хийх байр, газар, цаг хугацааг сонгохдоо төсөлд өртөгч орон нутгийн иргэд, ялангуяа эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өндөр настнуудад хүртээмжтэй оролцоог нь хангаж болохуйц байдлаар нэг эсхүл хэд хэдэн газар, нөхцөлөөр зохион байгуулна. Төслийн улмаас орон нутгийн иргэдэд үүсэх нийгмийн нөлөөллийг бодитой, үнэн зөв гаргахын тулд нөлөөллийн үнэлгээний баг нийтийн сонсголын үеэр тоон ба чанарын арга зүй ашиглан мэдээлэл цуглуулна. Энэ үеэр мөн асуулга, ярилцлага, санал гомдол авах механизмыг хэрхэн шийдвэрлэх зэрэг бусад ажлыг зохион байгуулж болно. Нийтийн сонсгол явуулахдаа холбогдох хууль⁵, журам⁶-д заасан нийтлэг зарчим, арга зүйг дагаж мөрдвөл зохино.</p>

³ Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, 2011

⁴ Жендэрийн эрх тэгш байдлыг хангах Үндэсний хөтөлбөр, Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт жендэрийн талаар баримтлах бодлого, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө (2019-2026) гэх мэт

⁵ Захиргааны ерөнхий хууль 2015, Нийтийн сонсголын тухай хууль 2015

⁶ Нийтийн сонсгол зохион байгуулах журам, УИХ-ын 2017 оны 12 дугаар тогтоол

10	Нөлөөллийн загварчлалын арга	<p>Эрдэс баялгийн салбарын төсөл, түүнийг дагасан дэд бүтцийн төсөл хэрэгжсэнээр орон нутагт бий болох нийгмийн нөлөөллийг тодорхойлохдоо төрөл бүрийн загварчлалын арга зүй ашиглаж болно. Загварчлал хийх нь нөлөөлөл үүсгэх олон хүчин зүйлийг орхигдуулдахгүй авч үзэх, түүнчлэн тооцооллыг богино хугацаанд боловсруулах ач холбогдолтой. Гэхдээ ашигласан өгөгдлийн чанараас шалтгаалж нарийвчлал нь харилцан адилгүй байх магадлалтай. Нийгмийн нөлөөлөлд “Загварчлалын арга зүй” ашиглахдаа тухайн орон нутгийн иргэд, мэргэжилтнүүдийн саналыг тусгах нь нийгмийн нөлөөллийг бодитой үнэлэхэд дөхөм болно. Нөхцөл байдлын таамаглалын арга зүйг энэ аргатай хавсарган гүйцэтгэх боломжтой. Загварчлалын арга зүйг ашиглан нийгмийн нөлөөлөл тодорхойлох ажил дараах үе шаттай хийгдэнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Загварчлалын хамрах хүрээг тодорхойлох - Эрдэс баялгийн салбарын төсөл, дэд бүтцийн төслийн нийгмийн нөлөөллийн талаар ажилладаг мэргэжилтнүүд, нөлөөлөлд өртөж байсан орон нутгийн иргэд, бусад оролцогч талуудтай уулзалт хийх, санал авах - Загварчлалд ашиглах дата, мэдээллүүдийг цуглуулах - Загварчлал ажиллах схемийг боловсруулах - Загварчлалыг турших, сайжруулах, эцэслэх зэрэг байж болно.
----	------------------------------	--

Нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийхэд анхаарах зөвлөмжүүд

1. Нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх 1-р үе шатны бэлтгэл ажил хийхэд анхаарах зөвлөмж

Зөвлөмж:

Төслийн НННҮ-ний нөлөөллийн бүсэд хамрагдах анхдагч, хоёрдогч, оролцогч талууд тус бүрийн талаар тоон болон чанарын мэдээллийг гарган авах нь дүн шинжилгээний гол зорилт тул тэдэнтэй хэрхэн ажиллаж мэдээлэл цуглуулах тохиромжтой арга хэлбэрийг эхлээд сонгох нь чухал. Ингэхдээ, зарим чухал мэдээллүүдийн жагсаалтыг урьдчилан гаргаж, ярилцлагын асуулгад оруулсан байх хэрэгтэй. Талууд тус бүртэй нэг арга хэлбэр, нэг асуумжаар ярилцах боломжгүй. Тухайлбал:

- *Оролцогч талуудын байр суурь, ажил эрхлэлт, нөлөөллийн ангилалын тухай товч мэдээлэл*
- *Төслийн тухай болон зорилтот үр дүн, хүлээлтийн талаарх тэдний мэдлэг, төсөл хэрэгжүүлэгчийн түгээсэн мэдээллийн үр дүн*
- *Төслийн нөлөөллийн бүсэд хамрагдах магадлалтай гэж тогтоосон талууд төслийг мөн холбогдох үйл ажиллагаануудыг эсэргүүцдэг, дэмждэг, эсвэл төвийг сахисан байр сууринаас хандагийн алин болохыг тодорхойлох?*
- *Талуудын төслийн талаарх байр суурь, итгэл үнэмшил, үр шим хүртэх хүлээлт, айдас болгоомжлол төрүүлж буй байр суурь*
- *Нөөц: Оролцогч талууд тус бүрийн нөөц (хүн хүч, хөрөнгө санхүү, технологи, мэдлэг ур чадвар)-ийг тодорхойлох*
- *Улс төрийн байдал, хандлага*
- *Талуудаас авах ярилцлагын асуулга, удирдамж боловсруулсны дараа нөлөөллийн үнэлгээнд ашиглахын өмнө заавал туршиж үзэн сайжруулсан байх.*
- *Орон нутгийн хөгжлийн бодлого, хөтөлбөрүүд тэдгээрийг судалж дэмжих болон сөрөг нөлөөлөх асуудлыг тодорхойлох*

- Нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх 2-р үе шатны суурь мэдээлэл бүрдүүлэхэд анхаарах зөвлөмж

Зөвлөмж:

Суурь мэдээллийг төрийн нээлттэй эх сурвалж, холбогдох судалгаа, тайлан, шинжилгээ орон нутгийн засаг захиргааны байгууллагуудаас авна. Суурь мэдээллийг баг, сум, аймгийн (аль тохирох) иргэдийн хурал, нийтийн сонсгол, уулзалт, хэлэлцүүлгээр а) баталгаажуулах, б) орхигдсон мэдээллийг тодорхойлох ажил хийгдэнэ. Төрийн байгууллага, нээлттэй эх сурвалжаас мэдээллийг цуглуулах ба хэрэв мэдээллийн олдоц хангалтгүй бол судалгааны мэдээллийг эх сурвалжтай нь ашиглах, өөрсдийн дүгнэлтийг ижил төрлийн цар хүрээтэй бусад төслийн жишгийг харгалзан ашиглаж болно.

Төсөл хэрэгжүүлэгч хуулийн этгээд болон Нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг гүйцэтгэх эрх бүхий компани нь уурхайн товч түүх, төслийн хайгуул, олборлолт, технологи, тоног төхөөрөмж, ашиглах химийн бодис, хог хаягдал түүний менежмент, тээвэр, ажилчдын тоо, төлөвлөлт, нөөц гэх мэт үндсэн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг багтаасан төслийн үйл ажиллагааны танилцуулгыг энэ шатанд боловсруулж гаргана.

Төслийн нийгмийн нөлөөллийн бүсийг урьдчилсан байдлаар тогтоохдоо төслийн нийгмийн нөлөөлөлд өртөх ба өртөж болзошгүй талууд, сонирхлын бүлгүүд, эрх бүхий этгээдүүд зэрэг


оролцогч талуудыг тогтоож, нийгмийн нөлөөллийн бүсийг урьдчилсан байдлаар тодорхойлно. Бэлчээрийн газар, оторлох, хадлан авах, сэлгэн суурьших зэрэг нь мал аж ахуйгаас хамааралтай малчдын амьжиргаанд шууд хамааралтай асуудал учраас газрын эрх, хүн малын ундны усны хэрэгцээ, хангамж, хүртээмжийн асуудлыг онцгойлон авч үзнэ. Газар, ундны устай холбоотой мэдээллийг төрийн эрх бүхий байгууллагаас заавал гаргуулж авсан байх ба түүний дээр бусад эх сурвалжийг ашиглаж болно.

Төслийн эерэг, сөрөг нөлөөлөлд шууд болон шууд бус байдлаар өртөх магадлалтай орон нутгийн иргэд, бусад оролцогч талуудыг тодорхойлохдоо нийгмийн нөлөөллийн бүсийг урьдчилсан байдлаар тогтоосон зураглалд үндэслэн нөлөөлөлд өртөж болзошгүй боломжит бүх оролцогч талуудын жагсаалтыг гаргаж, тэдгээр нь анхдагч, хоёрдогч эсвэл оролцогчийн аль нь болохыг тодорхойлно. Төслийн ННҮ-ний нөлөөллийн бүсэд хамрагдах боломжит бүх оролцогч талуудыг жагсааж, тэдгээр нь а/анхдагч; б/хоёрдогч; в/оролцогч талын аль нь болохыг тодорхойлно. Уулзалт, ярилцлага хийх дарааллыг тогтоож, оролцогч талуудыг эрэмбэлнэ. Уулзалт, ярилцлагын дараа а/анхдагч; б/хоёрдогч; в/оролцогч талын байр солигдож болох бол үүний дараа хамгийн их сөрөг нөлөөлөлд өртөгчид, өндөр эрсдэлтэй талуудыг нягталж, тэдэнд үзүүлэх сөрөг нөлөөлөл, хуримтлагдах нөлөөллийн таамаг боловсруулна. Мөн оролцогчдоос хасагдах эсхүл шинээр нэмэгдэх боломжтойг анхаарна уу.

Газар зүйн мэдээллийн системийн зөвлөмжийн дагуу бус нутаг, сав газар, нутаг дэвсгэрийн орон зайн зураглалыг хийхээс гадна Масштаб 1:174150-иар доорх лицензтэй талбайн зургийг томруулж, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрт хамаарах бэлчээр, хүн, малын ундны ус, гол мөрөн, худаг, тахилгат уул, овоо, оршуулгын газрын байршлыг харуулж, газар нутгийн албан ёсны болон нутгийн иргэдийн нэрлэж заншсан албан бус нэрийг аль алиныг бичиж харуулсан байвал зохино. Зураглалыг А4 хэмжээтэй, гаргацтай, бүрэн тайлбартай байдлаар өнгөтөөр хэвлэн нөлөөллийн бүсийн иргэдэд тарааж, мөн тайланд хавсаргана.

Зураглал (жишээ)

XV-010000 түсгэй зөвшөөрөлтэй талбайн тэмдэг, тэмдэглэгээ (жишээ загвар)



Нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх 3-р үе шатны Нөлөөллийн бүсийн иргэд, оршин суугчдаас албан ёсоор санал авч хэлэлцүүлэг зохион байгуулахад анхаарах зөвлөмж

Зөвлөмж:

Төслийн мэдээллийг нутгийн иргэд, удирдлагууд, нөлөөллийн бүсийн иргэд, бусад оролцогч талуудад хүргэхдээ ННҮ-хийх компани нь захиалагч буюу төсөл хэрэгжүүлэгч хуулийн этгээдээс төслийн ННҮ- хийхтэй холбоотой мэдээллийг бүрэн авч, төслийн нөлөөлөлд өртөх иргэд болон төслийн бусад оролцогч талуудыг тодорхойлсоны дараа төслийн мэдээлэл, үүсч болзошгүй нөлөөллүүдийг хэлэлцэх уулзалтуудыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулж, оролцогч талуудад холбогдох бүх мэдээллийг хүргэнэ. Олж авсан мэдээллийг баталгаажуулах, орхигдсон мэдээллийг олж тогтоох зорилгоор хэлэлцүүлэг, ярилцлага өрнүүлэн, тэмдэглэл хөтөлнө.

Хэрэв насанд хүрээгүй иргэдээс ярилцлага, мэдээлэл авах шаардлагатай бол эцэг, эх, асран хамгаалагчаас зөвшөөрөл заавал авсан байна.

Төслийн улмаас үүсч болзошгүй хүний эрхийн болон нийгмийн асуудлуудыг тодорхойлохдоо ННҮ-хийх компани тухайн төсөл хэрэгжсэнээр хүний эрх, нийгмийн болзошгүй нөлөөллийн төрлүүдийг ерөнхий байдлаар тодорхойлж, жагсаалт гаргаж, нөлөөллийн хүрээг тогтооно.

ННҮ-ний нөлөөллийн бүсэд хамрагдах магадлал бүхий талуудтай ярилцлага хийх болон тэмдэглэл хөтлөхдөө энгийн, ойлгомжтой байдлаар, өвөрмөц үг хэллэггүй, товчлолгүй хөтөлнө. Ярилцлага, сурвалжлага хийсний дараа оролцогч талын мэдээллийг урьдчилан бэлтгэсэн хүснэгтэд үнэн зөв, бодитой тодорхойлж, нэгтгэнэ. Үүнд: оролцогч талуудын байр суурь (дэмжигч, төвийг сахигч, эсэргүүцэгч), ярилцлагын үеэр оролцогч талуудаас шууд авсан мэдээлэл, бусад оролцогч талуудаас авсан мэдээлэл буюу хоёрдогч эх сурвалжаас авсан шууд бус мэдээлэл (бусдын бодол) г.м. Ингэхдээ шинжээч/ мэргэжилтэн нь субъектив байр сууринаас хандахгүй байх судлаачийн ёс зүйг хатуу чанд баримтлана.

Тэмдэглэлийг нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд хавсаргах ба судлаач/ шинжээч судалгааны явцад олж авсан мэдээллээ хувь хүний нэр хүндтэй холбоотой мэдээллийг нууцлах үүрэгтэйгээ анхнаасаа ярилцагчдад ойлгуулж, чанд мөрдөхийг анхаарна уу. Ярилцах иргэдийг кодлосон байж болно.

Суурь мэдээлэл, боловсруулсан мэдээлэлд зэрэгт үндэслэн мэдээллийг боловсруулахдаа:

- Нөлөөлөлд өртөгч тал (анхдагч, хоёрдогч, оролцогч)-уудыг нарийвчилан, үнэн зөв тодорхойлно.
- Нөлөөллийн загварчлал (матрицаар эерэг ба сөрөг нөлөөллийн тохиолдох магадлал, үүсэх үр дагаварын тооцоолол) гаргана.
- Гол сөрөг нөлөөллийг тодорхойлсон байна.
- Нөхцөл байдал үүссэнээс үүдэх нийгмийн өөрчлөлтийн таамаг дэвшүүлнэ.
- Суурь мэдээлэл, боловсруулсан мэдээлэлд зэрэгт үндэслэн гол сөрөг нөлөөллийг арилгах, эерэг нөлөөллийг дэмжих, хүний эрхийг дордуулахгүй байхад авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулсан байна.

Нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх 8-р үе шатны Үнэлгээний нэгтгэл тайлан боловсруулахад анхаарах зөвлөмж

Зөвлөмж:

Нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн агуулга, хэлбэр

1. **Тайлангийн техникийн бус хураангуй:** Энэ хэсэгт төсөл хэрэгжих нутгийн нийгмийн өнөөгийн төлөв байдлын товч мэдээллийг оруулах ба хураангуй нь төсөл, түүний хэрэгжих газар нутгийн хамрах хүрээ, төслийн шууд ба шууд бус нөлөөлөл, гол сөрөг нөлөөлөл, түүнийг арилгах арга хэмжээний талаар бүрэн гүйцэд ойлголт өгч чадахуйц хэмжээнд боловсруулагдана. Хураангуйд бусад аргачлалаар заасан хууль, эрх зүйн болон техникийн төслийн шаардлагыг хангасан байхаас гадна тодорхой бус асуудлууд, тэдгээрийн нийгэм, эдийн засагт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг онцлон тусгана. Төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах зохих зөвшөөрлийн талаар зайлшгүй дурдах ба энгийн, ойлгомжтой хэлбэрээр бичигдсэн байна.
2. **Оршил:** Тухайн төслийн нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний гол зорилго, нарийвчилсан үнэлгээний хүрээнд хийсэн ажил, үнэлгээний судалгааны ажлын гол үр дүн, цаашид төсөл хэрэгжүүлэгч, орон нутаг болон шийдвэр гаргах түвшинд анхаарах асуудлуудыг товч тодорхой тусгасан байна.
3. **Эрх зүйн хамрах хүрээ:** Өнөөгийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төслийн үйл ажиллагаатай холбогдох хууль, эрх зүйн орчин, төслийг хэрэгжүүлэх явцад зайлшгүй мөрдөж ажиллах хуулийн хориглосон, хязгаарласан зохицуулалт, төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм, журам, стандарт, Монгол Улсын нэгдэн орсон конвенциудын холбогдох шаардлагуудыг тодорхой тусгана.
4. **Төслийн тодорхойлолт:** Төслийн техник, эдийн засгийн үндэслэл (Feasibility Study Report), зураг төсөл (Design parameters and Layouts), төсөл хамрах газар нутгийн тайлбар Зураглал (Project Affecting Area) бусад холбогдох баримт бичгүүдээс тухайн төслийн гол зорилт, цар хүрээ, хэмжээ, төсөл хэрэгжих үе шат, түүхий эд, байгалийн баялгийн ашиглалт, эрчим хүч, ус, дулааны хэрэгцээ, техник, технологийн сонголт, үйлдвэрлэлийн хүчин чадал, үйлдвэрлэлийн эцсийн болон завсрын бүтээгдэхүүн, гарах хаягдал, ялгарал, түүнийг эргүүлэн ашиглах, зайлуулах арга зам, тухайн төслийн нийгэм, эдийн засагт үзүүл эерэг ба сөрөг нөлөөлөл, бий болгох ажлын байр, түүнээс орон нутгийн иргэдээс ажиллуулах ажлын байрны тоо, орон нутгаас худалдан авалт хийх наад захын (жил бүр зайлшгүй) тоон мэдээлэл, нийгмийн асуудлыг шийдэх гаргалгаа зэргийг тодруулна.
5. **Төслийн хамтарсан баг:** Төслийн нөлөөллийн үнэлгээг боловсруулах хамтарсан багийг бүрдүүлэх үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл багтах ба төлөвлөгөө, түүний дагуу хэрэгжүүлсэн арга хэмжээ, хууль тогтоомж, олон нийтийн оролцоог хангах зохицуулалтыг хэрхэн хангаж ажилласан талаар болон нөлөөллийн бүсийг тодорхойлох, тухайн тодорхойлогдсон нөлөөллийн бүсийн хамтарсан багийг сонгох, шаардлагыг хангасан эсэхийг хянаж, нягтлах, зөвшилцөх, баталгаажуулах ажиллагаа ба ашигласан мэдээлэл, баримт зэргийг дурдаж, гишүүдийн мэдээлэл, хурал, хэлэлцүүлэг, зөвшилцөх ажиллагааны тайлан, дүгнэлтийг баримтжуулан тусгана. Энэ хэсгийн үйл ажиллагааны баримтыг тайлангийн төгсгөлд заавал хавсаргасан байна.
6. **Төслийн гол эерэг нөлөөлөл ба болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ:** Төслийн гол болон болзошгүй эерэг ба сөрөг нөлөөллүүд, түүнд өртөх хүний эрх, нийгэм, эдийн засгийн асуудал, түүх, соёлын дурсгал, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн иргэдийн нийгмийн байдал, эрүүл мэндэд үзүүлэх эерэг ба сөрөг нөлөөллийн үнэлгээний хамрах хүрээгээр, чиглэл бүрээр гаргаж тусгана. Мөн тэдгээр гол болон болзошгүй нөлөөллийн эрчмийг матрицын аргаар тодорхойлж, тархалт, хэмжээг ижил төрлийн цар хүрээтэй бусад төслийн жишгийг харгалзан, орон нутгийн иргэдийн ярилцлага, уулзалт болон тэдний өмнөх туршлагыг харгалзан харьцуулалт хийх байдлаар тогтооно. Энэ хэсэгт төслийн улмаас үүсэх, үүсэж болзошгүй үл хүлцэх сөрөг нөлөөллийг заавал дурдаж, хэрэв байгаа бол түүнээс зайлсхийж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрхэн зөвшилцөж тодорхойлсон болон тухайн эрсдэлийг хянах арга хэмжээ, хөрөнгө, нөөц зэргийг тусад нь заана. Энэхүү аргачлалд тавигдсан шаардлагуудын дагуу системтэй хандаж, тогтоосон төслийн гол болон болзошгүй эерэг ба сөрөг нөлөөлөлд анализ хийж, эерэг нөлөөллийг нэмэгдүүлэх боломжит хувилбарууд, сөрөг нөлөөлөл ба дам ба хоёрдогч байдлаар үүсэж болзошгүй сөрөг

нөлөөллүүдийг тодорхойлон тусгаж, нэгдсэн дүгнэлт гаргаж тусгасан байх шаардлагатай. Төслийг хэрэгжүүлэх явцад түүний дээр тодорхойлогдсон гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд, нөлөөлөлд өртөх түүх, соёлын дурсгал, хүн, малын үндны ус, түүн рүү хэрх орц гарц, зам, барилга, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн иргэдийн нийгмийн байдал, эдийн засаг, эрүүл мэндийн чиглэл бүрээр арилгах арга хэмжээг тодорхойлж, түүнд зарцуулах зардал, хүн хүч, техник, технологи, удирдлага зохион байгуулалт, хугацаа, үе шат зэргийг нарийвчлан тодорхойлж хэрэгжүүлэх зөвлөмжийн хамт тусгана. Хүний үндсэн эрхийг ноцтой зөрчих, үндсэн эрхийн хэрэгжилт хангагдахгүй нөхцөлд дүйцүүлэн хамгаалахыг хориглох ба хүний үндсэн эрхийг хэдийд ч дордуулахгүй байх арга хэмжээг заавал авч хэрэгжүүлэх шаардлагатай. Үнэлгээний судалгаа, гол болон болзошгүй нөлөөллийг тогтоох, түүнд үнэлгээ өгөхөд ашигласан арга, загварчлал, тооцооллын дүнг түүнийг сонгосон үндэслэлийн талаар дэлгэрэнгүй тайлбарлаж тусгасан байна. Үнэлгээний судалгааны явцад цуглуулсан мэдээ, мэдээлэл, хээрийн судалгааны явцад хийсэн хэмжилтийн эх сурвалжийг тодорхой бичихээс гадна, эх хувиар нь тайланд хавсаргаж, фото зураг, бичлэгээр баталгаажуулсан байвал зохино.

7. **Хяналт-шинжилгээ ба менежментийн төлөвлөгөө:** Нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний гол үр дүн буюу тухайн төслийг хэрэгжүүлэх явцад төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, нутгийн иргэд, оршин суугчид, дамжин өнгөрөгчид үүсэх магадлалтай нийгмийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл, эрх, ашиг сонирхлын зөрчил, тэдгээрээс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг арилгах, үр дагаврыг арилгах, нөхөн сэргээх чиглэлээр авч хэрэгжүүлэх гол арга хэмжээ, эерэг нөлөөллүүд, тэдгээрийг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, төслийн хаалтын үеийн зорилтууд, нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор олгох, хяналт шинжилгээ хийх гол субъектүүд, түүнийг илтгэх үзүүлэлтүүдийг нэгтгэн (Төслийн хяналт шинжилгээний хөтөлбөр), Төслийн нийгмийн нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, зайлсхийх, хасах үр дагаврыг арилгах менежментийн төлөвлөгөөг зөвлөмжийн хамт энэ хэсэгт тусгана. Төслийг хэрэгжүүлэх явцад бий болох эерэг нөлөөллийг нэмэгдүүлэх арга хэмжээнд зарцуулах хөрөнгө нөөцийн удирдлага ба үр дүнг хянах арга хэмжээ мөн учирч болзошгүй аюул, гамшиг, үйлдвэрлэлийн осол болон бусад эрсдэл, нийгмийн сөрөг нөлөөллийг хянах төлөвлөгөө, үнэлгээг холбогдох эрх бүхий байгууллагаас батлан мөрдүүлж байгаа аргачлалын дагуу хийж, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тодорхойлон энэ хэсэгт тусгана. Үлдэгдэл эрсдэлийг хэрхэн, хэн, яаж хянах талаарх төлөвлөгөөг хамтарсан багаар зөвшилцөн баталгаажуулсан байх шаардлагатай ба уг шаардлагыг хэрхэн хангасан талаарх мэдээлэл энэ хэсэгт багтана. Төсөл хэрэгжүүлэгчийн зөвшилцөлд оролцсон байдлын талаарх мэдээллийг мөн тусгасан байна.
8. **Ашигласан материал:** Энэ хэсэгт судалгааны явцад цуглуулсан, ашигласан бүхий л мэдээ, материал, тэдгээрийн эх сурвалжийг дурдана.
9. **Хавсралт:** Тайланг дагалдах уулзалт, ярилцлагын мэдээлэл, огноо, хугацаа, тайлангийн аль хэсэгт ашигласан талаар тэмдэглэгээ хийгдсэн байвал зохино. Уг тэмдэглэгээ нь тайлангийн тодорхой хэсэгт дурдагдсан байна.

Нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг боловсруулж эхлэхдээ анхан шатны багийн иргэдийг оролцуулж, тэдний санал, зовнил, асуудлыг тодорхойлох бөгөөд боловсруулж дууссаны дараа төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэх, мөн төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн засаг захиргаа, эсвэл ИТХ-ын саналыг авч, тайланд багийн иргэдийн тэмдэглэл ба хурлын тэмдэглэлийн аль алиныг хавсаргана. Тайланг боловсруулан төсөл хэрэгжүүлэгчид танилцуулж, нийгмийн эерэг ба сөрөг нөлөөлөл, түүнд өртөгчдийн асуудал, эрсдэлийг ойлгуулах, хүний үндсэн эрхийг дордуулахгүй байх хууль тогтоомжид заасан үүрэг, хариуцлагыг ойлгуулах, авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг баталгаажуулан өөрөөр хэлбэл төсөл хэрэгжүүлэгч тайланг батлагдсаны дараа хэрэгжүүлэх үүргээ ухамсарласан байх нөхцөлийг бүрдүүлсэн байвал зохино.

Зөвлөмж: Санал гомдол хянан шийдвэрлэх механизм (СГХШМ)

Санал, гомдол шийдвэрлэх албан ёсны механизм нь үүрэг хүлээгч талуудад учирсан хохирлыг арилгах нэмэлт, нөөц арга замыг бий болгож өгдөг. Төсөлтэй холбоотой хүний эрхийн асуудлаар дохио өгөхөөс гадна санал гомдол хянан шийдвэрлэх зохистой механизмыг хэрэгжүүлэх амлалт нь итгэлцлийг бий болгох, үйл ажиллагаа явуулах нийгмийн зөвшөөрөл авахад дэмжлэг үзүүлэх, орон нутагт учирах хохирол болон бизнесийн хохирлыг бууруулахад хувь нэмрээ оруулна.

Төслийн үйл ажиллагаа нээлттэй, хандах боломжтой байх хэрэгтэй. Төслийн орон нутагтай харилцах мэргэжилтэн төслийн нөлөөлөлд өртсөн иргэдтэй сайн харилцаатай, хүмүүс асуудлаа илэрхийлэхэд хялбар байх ёстой. Тухайн мэргэжилтэн хичнээн нээлттэй байж, сайн ажиллаа ч гэсэн орон нутгийн иргэдийн дунд төсөл рүү хандахад бэрхшээлтэй байна, асуудлыг нь хангалттай нухацтай авч үзэхгүй байна гэж үзэх хүмүүс заавал гарч ирдэг. Ийм учраас санал гомдол шийдвэрлэх албан ёсны механизмийг хэд хэдэн төрлөөр, төслийн эхний үе шатанд бий болгох нь чухал юм. Төрөл бүрийн механизм нь төслийн ажилчид, төслийн нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэд зэрэг янз бүрийн оролцогч талуудад хэрэгцээтэй байж болно.

Санал бодол, гомдлыг ялгаж ойлгох шаардлагатай. Санал бодол гэдэгт асуулт, мэдээлэл авах хүсэлт, тодорхой үйл явдал, нөлөөлөлтэй холбоотой болон холбоогүй ерөнхий үзэл бодол зэрэг багтана. Хүмүүсийн илэрхийлсэн иймэрхүү санал бодлыг анхаарч авч үзэхгүй бол энэ нь гомдол болж хувирч мэдэх бөгөөд нийгмийн зөвшөөрлөө алдахад ч хүргэж мэднэ. Санал бодол бүрийг албан ёсны гомдол гэж бүртгэх шаардлагагүй боловч хүмүүсийн хандлагыг анхаарч, өсөн нэмэгдэхээс нь өмнө орон нутгийн иргэдийн оролцоотойгоор тодорхойлох, арга хэмжээ авах, зохистой менежментийн системд бүртгэх хэрэгтэй.

СГХШМ нь ихэвчлэн дараах **үе шатуудын** дагуу явагддаг. Үүнд:

1. Хүлээн авах: - ойлгомжтой энгийн байх, хэн нэгний нэр дурдагдсан бол тухайн мэдээлэл гаргасан хүний мэдээллийн нууцлалыг хадгалах, энэ талаар гомдол гаргагчид мэдэгдэх.
2. Баталгаажуулах - баталгаажуулалт нь бодитой, дуусах хугацаагаа баримтлах ёстой.
3. Үнэлэх болон томилох - цар хүрээг үнэлэх, хурдавчилсан үнэлгээ хийх, хяналт шалгалт хийх мэргэжилтнүүдийг томилох.
4. Хянан шалгах - үйл явцыг тодорхой болгох, явцын дунд итгэлцлийг бий болгох, үйл явдал, нотолгоо болон баримт бичгүүдийг бүрдүүлэх, үйл явцын туршид харилцаа холбоог найдвартай хадгалах.
5. Хариу өгөх - хариу өгөх хүнийг тодорхойлох, хууль тогтоомж, дүрэм журамд нийцсэн байдлаар шийдвэрлэж, хариу өгөх, шийдэл болон бичиг баримт дээр яриа хэлэлцээр хийх. Энэ шатанд Хамгаалах болон сэргээх (Protect and Remedy) үйл ажиллагаа хамаарах бөгөөд төслийн үйл ажиллагааны улмаас эрх ашиг нь хохирсон (мал нь дайруулж үхсэн, уурхайн болон бусад гэрээлэгч компаниудын ажилчид, удирдлагын зүгээс бэлгийн дарамт зэрэг зүй бус зан авир гаргасан, иргэдийн зүй ёсны хүсэлт, саналыг хүлээн аваагүйгээс сэтгэл санаа болон эд хөрөнгийн хохирол учирсан гэх мэт) болох нь тогтоогдвол, энэхүү зөрчлийг шүүхийн бус замаар шийдвэрлэх боломжтой гэж үзвэл, хохирлын хэмжээнд нь тохируулан дараах арга хэмжээнүүдээс сонгож, хохирлыг барагдуулах, эрхийг сэргээх арга хэмжээ авна. Үүнд, уучлалт гуйх, алдсан эд хөрөнгийг ижил төрлийн зүйлээр нөхөн төлөх, мөнгөн хэлбэрээр нөхөн төлөх, нөхөн сэргээх болон ижил төрлийн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах зэрэг багтана.
6. Сонголт хийх, эсвэл давж заалдах - нөхцөл байдалдаа тохирсон сонголтүүдийг бий болгох, өмнөх шатанд гаргасан сэргээх арга хэмжээг хангалтгүй гэж үзвэл өөр арга хэмжээ авч өгөх хүсэлт гаргах, эсвэл гарсан зөрчил, маргааныг шүүхээр шийдвэрлүүлэх шаардлагатай гэж үзвэл холбогдох хуульд заасан процедурыг дагаж мөрдөх боломжтой.
7. Эргэн хянах ба хаах - үр дүн болон сэтгэл ханамжийн түвшинг баримтжуулах, авсан арга хэмжээ, тэдгээрийн үр дүн, гомдол гаргагчид хэр сэтгэл ханамжтай байгааг тодорхойлж, тухайн хэргийг хаана.

8. Хэрэв шийдвэрлэлтэд иргэн, ААН гомдолтой хэвээр байвал асуудлыг эхнээс нь нягталж, тайлбарыг заавал бичгээр гаргах ба маргаан таслах зуучлагч томилж шийдвэрлүүлэх эсхүл шүүхээр шийдвэрлүүлэх арга хэмжээ авч болно.
9. СГХШМ, түүний процесс, гомдол гаргах нөхцөл, заавал шийдэх асуудлууд, хариуцлагыг тодорхойлсон бодлогын баримт бичигтэй байхыг шаардаж, төсөл хэрэгжүүлэхээс өмнө тус баримт бичгийг баталгаажуулсан байхаас гадна баримт бичгээ олон нийтэд ил тод байршуулж, нөлөөлөлд өртөх иргэдэд таниулж, мэдээлсэн байна.

2-Р ХЭСЭГ

НИЙГМИЙН НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН, ЗӨВЛӨМЖ

Агуулга

ТАНИЛЦУУЛГА	70
НЭГ. ЕРӨНХИЙ ҮНДЭСЛЭЛ	70
Салбарын хамрах хүрээ	71
Суурь зарчим	72
Хамрах хүрээ	72
ХОЁР. ТӨРИЙН БОДЛОГО	73
2.1. Урт хугацааны хөгжлийн бодлого	74
2.2. Дунд хугацааны зорилтот хөтөлбөр	77
2.3. Хууль тогтоомж, үндэсний хөтөлбөр, журмын зохицуулалт	77
2.3.1. Холбогдох хууль тогтоомж	77
2.3.2. Нөлөөллийн үнэлгээний хэрэгцээ шаардлагыг зохицуулсан байдал	80
2.3.3. Орон нутгийн гэрээнд нийгмийн нөлөөллийг үнэлэх талаар тусгасан байдал	83
2.3.4. Шийдвэр гаргах үе шатанд олон нийтийн оролцоо, мэдэх эрхийг хангах талаар	84
ГУРАВ. МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛ БА НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ КОМПАНИД ТАВИГДАХ ШААРДЛАГА	86
3.1. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээг батлах мэргэжлийн зөвлөл	86
3.2. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл	87
3.3. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ боловсруулах мэргэжлийн компани	87
ДӨРӨВ. ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭХ, ХЯНАН МАГАДЛАГАА	88
ТАВ. МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ӨМНӨ ХҮЛЭЭСЭН ҮҮРЭГ, ОЛОН УЛСЫН СТАНДАРТ, ПРАКТИКААС ЗАЙЛШГҮЙ АВЧ СУУЛГАХ ҮНДСЭН КОНЦЕПЦИ	90
5.1. Нийгмийн нөлөөллийг тооцоолоход чиглэгдсэн олон улсын суурь бодлого, зарчим	92
5.2. Нийгмийн нөлөөллийг үнэлэхтэй холбогдох олон улсын стандарт	93
ЗУРГАА. ЗӨВЛӨХ БАГИЙН САНАЛ, ЗӨВЛӨМЖ	95
Хавсралт 1. Процессын зураглал: Уул уурхай, дэд бүтцийн төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааны үе шатад нөлөөллийн үнэлгээний талаар тусгагдсан байдал	101
Хавсралт 2. Саналын товъёог	120
Хавсралт 3. Олон улсын хүний эрх, байгаль орчин, нийгмийн стандарт, зарчмын задаргаа	144
Эх сурвалж:	166

Хүснэгт

<i>Хүснэгт 1. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан нийгмийн нөлөөллийн үнэлгээг боловсруулахтай холбоотой зорилго, зорилтууд</i>	<i>74</i>
<i>Хүснэгт 2. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө 2016-2020-д тусгагдсан нийгмийн нөлөөллийн үнэлгээг боловсруулахтай холбоотой зорилго, зорилтууд</i>	<i>77</i>
<i>Хүснэгт 3. Олон улсын хүний эрх, байгаль орчин, нийгмийн стандарт, зарчмын жагсаалт (олборлох салбар)</i>	<i>93</i>
<i>Хүснэгт 4. Зөвлөх багийн дэвшүүлж буй 17 санал зөвлөмж</i>	<i>95</i>

НИЙГМИЙН НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

ТАНИЛЦУУЛГА

Энэхүү тайланг Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар (ЗГХЭГ)-ын Тэргүүн дэд даргын 2020 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 28 дугаар тушаалаар батлагдсан уул уурхай, газрын тосны үйл ажиллагаанаас хүн ам, хот суурин газрын хэвийн амьдрал, ахуйд нөлөөлж буй нөлөөллийн бүсийг тогтоох, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгохтой холбогдсон асуудлыг судалж, санал боловсруулах шаардлагын хүрээнд, Нийгмийн нөлөөллийн үнэлгээний аргачлал боловсруулах Ажлын хэсэг (“Ажлын хэсэг”)-ийн хэрэгцээнд зориулан боловсруулав.

Уг тайлан нь дараах зорилготой. Үүнд:

1. Монгол Улсад мөрдөгдөж байгаа хүчин төгөлдөр хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг тодорхойлох, үнэлэлт дүгнэлт өгөх,
2. Нийгмийн нөлөөллийн үнэлгээний аргачлалыг боловсруулахад анхаарч, авч үзэх олон улсын стандартын шаардлагуудыг тодорхойлох,
3. Нийгмийн нөлөөллийн үнэлгээний аргачлалыг боловсруулж, батлахад хууль, эрх зүйн хүрээнд тулгамдах асуудлыг судалж, санал зөвлөмж хүргүүлэх,
4. Нийгмийн нөлөөллийн үнэлгээний аргачлалыг практик дээр хэрэгжүүлэхэд хууль тогтоомж, дүрэм журамд оруулах шаардлагатай нэмэлт, өөрчлөлт, шинээр бий болгох эсхүл хүчингүй болгох зохицуулалтын санал зөвлөмж хүргүүлэх,
5. Нийгмийн нөлөөллийн үнэлгээг үр дүнтэй хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай бодлогын баримт бичгүүдийн уялдаа холбоог хангах санал зөвлөмжийг хүргүүлэх зэрэг болно.

Ажлын хэсэг нь ЗГХЭГ-ын Стратеги удирдлага, зохицуулалтын газрын даргаар ахлуулан 6 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулагдсан ба төрийн бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлж ажиллах юм.

Тайланг Оксфордын их сургуулийн бодлого, арга зүйн дэмжлэгтэйгээр “Говийн санаачлага” төслийн Зөвлөх баг (“Зөвлөх баг”) боловсруулав.

НЭГ. ЕРӨНХИЙ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Үндсэн хуулиар хүний үндсэн эрхийг тодорхойлж, баталгаатай эдлүүлэхээр заасны дотор Арван зургадугаар зүйлд **Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй**; Арванесдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт **“Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна”** хэмээн тунхаглан заажээ. Монгол Улсын Үндсэн хуулийн⁷ Зургадугаар зүйлд Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна гэж заасан бөгөөд “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч”, “Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг ... тэгш, шударга хүртээхэд чиглэнэ”, “Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй” гэж заасан. Түүнчлэн,

⁷ <https://www.legalinfo.mn/law/details/367?lawid=367>

тус зүйлийн дөрөвт “...газрыг хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашиглавал хураан авч болно” гэсэн байдаг.

Монгол Улсын нэгдэн орж, 1976 онд хүчин төгөлдөр болсон Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пактын нэгдүгээр зүйлийн 1.2 дахь хэсэгт “Бүх улс түмэн зорилгодоо хүрэхийн тулд харилцан ашигтай байх зарчим дээр тулгуурласан олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа болон олон улсын эрх зүйгээр хүлээсэн аливаа үүрэгт хохирол учруулахгүйгээр байгалийн баялаг нөөцөө чөлөөтэй эзэмшинэ. Аль ч ард түмнийг ямар ч тохиолдолд оршин тогтнох арга хэрэгслээс нь салгаж үл болно” гэж заажээ.

Ийнхүү иргэн хүн амьд явах, эрүүл мэндээ хамгаалуулах эрхээ зүй ёсоор эдлэхийн тулд эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах ёстой юм. Амьд явах эрх, эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг хангах үндсэн баталгаа нь эрүүл, аюулгүй орчин бөгөөд орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдах явдлаас төр иргэнээ хамгаалах үүрэг хүлээнэ. Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэхдээ Байгаль орчныг хамгаалах багц хуулиудыг баталж, хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм, эдийн засгийн хөгжлийг байгаль орчны тэнцэлтэй уялдуулан тогтвортой хөгжлийг хангах, баялгийг зохистой ашиглах, жам ёсны боломжтойг нь нөхөн сэргээхтэй холбогдож төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулах эрх зүйн үндэс тавигдсан юм.

Гэвч байгаль орчны багц хуулийн хэрэгжилт нь нийгэм, эрүүл мэнд, эдийн засаг, боловсролын салбарын бусад хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, төрийн шийдвэр, үйл ажиллагаа, ил тод байдал, хариуцлага зэрэгтэй шууд холбоотой, харилцан нөлөөлөл үзүүлдэг байна. Тиймээс, олон улсын сайн жишиг, цаашдын чиг хандлагын хүрээнд тэдгээрийн харилцан хамаарал, нөлөөллийг тодорхойлох, үнэлэх, асуудлыг цогцоор нь шийдвэрлэх нь үр дүнтэй гэдгийг хөгжлийн байгууллагуудын зөвлөмж анхааруулсаар байна. Тиймд нийгмийн нөлөөллийн үнэлгээг уул уурхайн салбарт хэрэгжих бүхий л төсөлд хамааруулж хэрэгжүүлэх шаардлагатай юм.

Салбарын хамрах хүрээ

Нэр томъёоны тодорхойлолтод Ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д заасан эрдсийн хуримтлалаас гадна Газрын тосны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-4.1.5 дахь хэсэгт заасан газрын тос, Цөмийн энергийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т заасан цацраг идэвхт ашигт малтмал болон Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д заасан түгээмэл тархацтай ашигт малтмал бүгдийг багтах шаардлагатай. Түүнчлэн ашигт малтмал, газрын тос, уламжлалт бус газрын тос, цацраг идэвхт ашигт малтмал, түгээмэл тархацтай ашигт малтмалыг эрэх, хайх, ашиглах, боловсруулах, баяжуулах үйлдвэрлэл эрхлэх болон бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаатай холбоотой цогц үйл ажиллагааг хамааруулах нөхцөлд нийгмийн нөлөөллийн үнэлгээг уул уурхайн салбарын төсөлд бус харин эрдэс баялгийн салбарт хийгдэх байдлаар тодорхойлох нь зүйтэй байна.

Сүүлийн жилүүдэд эрдэс баялгийн салбарын үйлдвэрлэл эрчимжиж, түүнийг дагаад дэд бүтцийн томоохон төсөл, хөтөлбөрүүд хэрэгжих болсонтой холбоотойгоор иргэдийн амьдрал, эрүүл мэнд, байгаль орчин, нийгэм, эдийн засагт асар их эерэг болон сөрөг нөлөө үзүүлэх болсон ба байгаль орчин, хүний эрүүл мэндэд учруулсан сөрөг нөлөөлөл, ялангуяа орон нутгийн иргэдийн үндсэн эрх зөрчигдсөн гомдол олширч, ихээхэн эсэргүйцэл гарах болсон. Монгол Улс хүний эрх, эрх чөлөөг хангах хууль зүйн баталгааг тодорхой хэмжээнд бүрдүүлсэн ч тус салбарын үйл ажиллагаанд ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэн нийгэмд үүсээд буй хэрэгцээ шаардлагыг зайлшгүй тооцох, нийгмийн нөлөөллийн хамрах хүрээ, нөлөөллийн үр дагаврыг тодорхойлон эрсдэлийг үр дүнтэй бууруулах, арилгах, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь юуны өмнө манай Засгийн газрын олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүрэг, хариуцлага юм.

Эрдэс баялгийн салбарын төсөл, түүнийг дагасан дэд бүтцийн төслийн хэрэгжилтэд хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүний эрх, нийгэм, байгаль орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөлөл, эрсдэлийг арилгах, зайсхийх зорилгоор нийгмийн нөлөөллийн үнэлгээг боловсруулж хэвших, хүний эрхийн зарчмыг хангах шаардлагатай юм. Түүнчлэн хүний эрхийн зөрчил бий болгохгүйн үүднээс сөрөг нөлөөллийг “бууруулах” тухай ойлголт байж болохгүй, зөвхөн бүрэн арилгах, зайлсхийх, урьдчилан сэргийлэх асуудал ярих ёстой ажээ.

Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенци, санаачлагуудад заасан хүний эрхийн наад захын суурь зарчмыг багцалж үзэхэд:

Суурь зарчим

- **Эрх тэгш байдлыг хангах.** Нас, хүйс, хэл, яс үндэс, ажил, мэргэжил, шашин шүтлэг, хөрөнгө чинээ, нийгмийн байдал, хөгжлийн бэрхшээл гэх мэт ялгаатай байдлыг үл харгалзан хүний эрх, хүний эрхэм чанарыг хүндэтгэн үзэх, эрх тэгш, ялгаварлалгүй байх;
- **Хүний эрхийг хангах.** Хүн бүр аюулгүй, хөгжих боломж бүхий эрүүл орчинд амьдрах эрхээ эдлэх боломжтой байх, хөдөлмөрлөх, ажлын байраа сонгох, төрөөс нийгмийн хамгаалал хүртэх, мэдээллийн эрх чөлөөтэй, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, аливаа дарамт шахалт, сүрдүүлэг, хүч хэрэглэх явдал, төөрөгдүүлсэн худал мэдээллээс ангид байх, өмчлөх эрх, оюуны өмчөө баталгаажуулах эрхийг хангах, **бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх**, өөрсдийн амьдрал ахуйд нөлөө үзүүлэх аливаа шийдвэр гаргалтад бодитойгоор оролцох боломжтой байх;
- **Хүний эрхийг хангах нөхцөлийг бүрдүүлэх.** Хувь хүний амьд явах, эрүүл мэндээ хамгаалуулах, аюулгүй орчинд амьдрах, халдашгүй данхан байх, хувийн нууц, эд хөрөнгө халдашгүй байх, эрх зүйн туслалцаа авах, сурч боловсрох, чөлөөтэй зорчих, шашин шүтэх эс шүтэх, эвлэлдэн нэгдэх, тусгай хэрэгцээ, онцлог эрхийг хангах нөхцөлийг бүрдүүлэх.

Нийгмийн нөлөөллийн үнэлгээ гэдэг нь эрдэс баялгийн салбарын төсөл, тэдгээрийг дагасан дэд бүтцийн төслийн улмаас тухайн орчинд амьдарч буй нутгийн иргэд, удирдлага, бусад талуудад үүсэх эерэг болон сөрөг нөлөөллийг судлах, үүсч болзошгүй сөрөг нөлөөллийг арилгах, зайлсхийх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тодорхойлох үндсэн баримт бичиг юм. Тиймд төслийн улмаас гарч болзошгүй өөрчлөлт, үүсч болзошгүй нөлөөллийг дараах хүрээнд тодорхойлно хэмээн олон улсын нийгмийн нөлөөллийн үнэлгээний аргачлал, зөвлөмжид⁸ заасан байдаг.

Хамрах хүрээ

1. Иргэдийн амьдралын хэв маяг
2. Итгэл үнэмшил, үнэт зүйл, соёл
3. Иргэд хоорондын харилцаа, төрийн үйлчилгээний чанар, хүртээмж
4. Орон нутгийн шийдвэр гаргалтанд оролцох боломж
5. Хүрээлэн буй орчин
6. Эрүүл мэнд, сайн сайхан байдал
7. Хувийн болон өмчийн эрх
8. Хүсэл тэмүүлэл, айдас түгшүүр

Монгол Улсад хэрэгжүүлэх нийгмийн нөлөөллийн үнэлгээ, түүний боловсруулах аргачлал нь олон улсын дээрх стандарт, хамрах хүрээнд хийгдэх нь зүйтэй байна.

⁸ Хавсралт 1. Нийгмийн хариуцлагыг тооцох, нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх олон улсын аргачлалын жагсаалт

ХОЁР. ТӨРИЙН БОДЛОГО

Монгол Улсад хүний эрхийг хангах чиглэлээр үндэсний механизм байгуулахаар заасан бөгөөд чадавхи бэхжүүлэх, хүний эрхийг сахин биелүүлэх, бэхжүүлэх, хамгаалах, хангах үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх арга зам, үүрэг хариуцлагыг доорх байдлаар тодорхойлсон байна⁹. Үүнд:

Монгол Улсын Их Хурал нь хүний эрхийг хангах бодлогыг тодорхойлж, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, Засгийн газраас хүний эрхийн хүрээнд явуулж байгаа үйл ажиллагааг хянан шалгах, шүүх эрх мэдлийн хүрээний бодлогыг хууль тогтоох замаар тодорхойлох, энэ бүхэнд иргэд, тэдний олон төрлийн байгууллагын санал, оролцоог өргөтгөх замаар хүний эрхийг хангахад чиглүүлэгч, шийдвэрлэгч үүрэг гүйцэтгэнэ.

Засгийн газар нь төрийн гүйцэтгэх эрх мэдлийн дээд байгууллагын хувьд хүний эрх, эрх чөлөөний талаархи хууль тогтоомж, олон улсын гэрээ, энэхүү хөтөлбөрийн биелэлтийг зохион байгуулж хангах ажлыг Улсын Их Хурлын өмнө шууд хариуцан хууль, гэрээний биелэлт, үр дүнг Улсын Их Хуралд, улмаар олон улсын гэрээний биелэлтийг НҮБ-д тогтмол тайлагнана. Засгийн газар хүний эрхийн талаархи хууль тогтоомжийн болон олон улсын гэрээний биелэлтийг хангахын тулд төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагаас явуулж буй үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэсэн шинэтгэл хийнэ.

Хүний эрхийн төрөлжсөн байгууллагууд нь бие даасан хараат бус байдлыг бэхжүүлж, шударга, хүртээмжтэй, бүтээлч байдлыг хангаж, үйл ажиллагааг нь идэвхжүүлэн өргөтгөж, үр нөлөөг дээшлүүлэн, хүний эрхийн асуудлаар мэргэшүүлэх, боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх, тэдгээрийн үйл ажиллагааны хүнд суртал, чирэгдлийг арилгах, хүний эрх хамгаалах, зөрчигдсөн эрхийг нь сэргээн хангах гол механизм болгоно.

Төрийн бус байгууллагууд нь засаг төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж, удирдах, шийдвэр гаргахад оролцох иргэний оролцоог өргөтгөн идэвхжүүлдгээрээ хүний эрхийг хангах механизмын нэн чухал хэсэг болно. Хүний эрх, хүний хөгжил, хүрээлэн буй орчинтой холбоотой хөтөлбөрүүдийг боловсруулах, биелүүлэх, хянан зохицуулах, үнэлэн дүгнэхтэй холбогдсон судалгаа, яриа хэлэлцүүлэг хийх, шийдвэр гаргах ажиллагаанд засаг төрийн бүх шатны байгууллага нь төрийн бус байгууллагууд, орон нутгийн үүсгэл санаачлагын бүлэглэлүүдийн хоорондын үр бүтээлч түншлэлийг хөгжүүлэх үүрэгтэй болохыг эрхэм зорилго болгоно.

Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагууд хүний эрх, эрх чөлөөг хангах баталгааг өргөтгөн бэхжүүлэх, тэдгээрийн эрхээ эдэлж, үүргээ биелүүлэх таатай орчин бүрдүүлэх үйлсэд дорвитой үүрэг гүйцэтгэнэ. Хүний эрх, мөн олон улсын хамтын нийгэмлэгээр хүлээн зөвшөөрөгдсөн ёс зүйн хэм хэмжээ, зарчмуудыг хувийн хэвшил нэгэн адил сахин биелүүлэх ёстойг иш үндэс болгож, тэдгээрт хууль ёсны шаардлага тавина.

Үндэсний аудитын газраас 2018 онд “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн тайлан”-д Монгол Улсад хүчин төгөлдөр хэрэгжиж байсан бодлогын баримт бичгүүдэд үнэлгээ хууль тогтоомжид нийцэхгүй байна гэж үзсэн баримт бичгүүдийг хүчингүйд тооцсон. Монгол Улсын Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай (2020) хуулийн¹⁰ 6 дугаар зүйлийн 6.2-т 30 хүртэл жилийн хугацаанд хэрэгжүүлэх “Алсын хараа” нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг байна гэжээ. Цаашлаад хуулийн 6.4-т “Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн болон хотын ерөнхий төлөвлөгөөг Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт үндэслэнэ” гэсэн байна.

⁹ Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр, УИХ-ын 2003 оны 41 дүгээр тогтоолын хавсралт

¹⁰ <https://www.legalinfo.mn/law/details/15403?lawid=15403>

Шат дарааллын хувьд авч үзвэл Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа дараах бодлогын баримт бичгийн хүрээнд¹¹ цаашдын чиг хандлагыг уялдуулах нь зүйтэй.

1. Урт хугацааны хөгжлийн бодлого
2. Дунд хугацааны зорилтот хөтөлбөр
3. Богино хугацааны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг

2.1. Урт хугацааны хөгжлийн бодлого

“Алсын хараа -2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан, 3 үе шаттайгаар хэрэгжүүлэх, нийт 9 зорилго, 50 зорилттой, 5 жил тутамд хяналт шинжилгээ хийгдэж, дүгнэгдэх бодлогын баримт бичгийг баталсан байдаг. Уг баримт бичгийг батлах тогтоолын 6-д “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын үр дүнг илэрхийлэх үзүүлэлтүүд, Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилтууд нь агуулгаараа ““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад тусгагдсан тул “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 19 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай хэмээн заасан.

“Монгол Улсын цаашдын ирээдүйн макро-эдийн засгийн бодлого нь урт хугацаанд тогтвортой, мөчлөг сөрсөн, өрийн дарамт болон зардлын өсөлтийн нарийвчлан тооцсон аргачлалаар дунд хугацаанд эдийн засгийг тогтворжуулж, улмаар урт хугацаанд тогтвортой хөгжлийг хангасан өөрөө өөрийгөө тэтгэсэн, гадаад зах зээлийн сөрөг өөрчлөлтөөс дархлагдсан байх шаардлагатай бөгөөд эдийн засгийн өсөлт хүний хөгжил, дундаж орлоготой иргэдийг тэтгэх цогц бодлого уруу илүүтэй чиглэх бодит шаардлагыг бий болгож байна гэж үзээд эл утгаар өнгөрсөн 30 жилийг бүхэлд нь дүгнэж, ирэх 30 жилийг урт хугацаагаар төсөөлөх урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулсан” хэмээн Үзэл баримтлалдаа хэлжээ.

Тиймээс Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, хүний эрхийг хангах, эдийн засаг, байгаль орчин, эрүүл мэнд, нийгмийн аюулгүй байдлыг хангах зорилго, зорилт энэхүү баримт бичгийн хүрээнд тодорхойлогдох бөгөөд уул уурхай, газрын тосны үйл ажиллагаанаас хүн ам, хот суурин газрын хэвийн амьдрал, ахуйд нөлөөлж буй нөлөөллийг тодорхойлоход чиглэгдсэн зорилго, зорилтууд тусгагджээ (*Хүснэгт 1. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан нийгмийн нөлөөллийн үнэлгээг боловсруулахтай холбоотой зорилго, зорилтууд*). Мөн УИХ-ын 2014 оны 18 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого” нь хувийн хэвшилд түшиглэсэн, ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, ойрын болон дунд хугацаанд эдийн засгийн тэнцвэртэй олон тулгуурт бүтцийг бий болгож, үндэсний язгуур эрх ашгийг хангахад чиглэгдсэн, эрдэс баялгийн салбарт төрийн урт хугацаанд баримтлах бодлогыг тодорхойлсон баримт бичгийн ерөнхий чиглэл, зорилгыг харгалзаж үзэх нь зүйтэй.

Хүснэгт 8. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан нийгмийн нөлөөллийн үнэлгээг боловсруулахтай холбоотой зорилго, зорилтууд

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого	
Зорилго/Зорилт	Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн

¹¹ <https://www.legalinfo.mn/law/details/15403?lawid=15403>

ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖИЛ	
Зорилго 2. Чанартай амьдралын баталгаа бүхий нийгмийн хамгаалалтай, аз жаргалтай амьдралын ээлтэй орчинд, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болсон чанартай боловсролыг хүн бүр эзэмших боломжийг бүрдүүлэн нийгмийн идэвхтэй, эрүүл монгол хүнийг хөгжүүлнэ.	
<u>Хүний эрхийг дээдэлсэн нийгэм.</u>	I үе шат (2021-2030): Хүний эрхийг хангах үндэсний тогтолцоог бэхжүүлэх, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хүний эрхийг хангахад чиглэсэн олон талт түншлэлийг хөгжүүлэх үе. 1.Хүний эрхийг хангасан бодлого, хууль тогтоомж боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих үндэсний тогтолцоо бэхжиж, үр нөлөө дээшилнэ. 2.Төр, иргэний нийгэм, хувийн хэвшил хүний эрхийг хамгаалахад хамтарч ажиллах тогтолцоо төлөвшинө.
Зорилт 5.5. Иргэний нийгэм-хувийн хэвшил-төрийн түншлэлийг бэхжүүлэх замаар үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилтэд хамаарал бүхий талуудын оролцоог хангасан зохистой тогтолцоог бүрдүүлнэ.	
ЗУРГАА. НОГООН ХӨГЖИЛ	
Зорилго 6. Байгаль орчинд ээлтэй ногоон хөгжлийг эрхэмлэн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, байгаль орчны тогтвортой байдлыг ханган үр өгөөжийг нь өнөө болон ирээдүй хойч үе хүртэх нөхцөлийг бүрдүүлж, хүний амьдралын чанарыг сайжруулна.	
<u>Эх байгаль анхдагч экосистем.</u>	I үе шат (2021-2030): Монгол орны унаган байгаль, экосистемийн үйлчилгээний үнэ цэн, даацыг тогтоож, үнэлэмжийг нэмэгдүүлж эдийн засгийн үр өгөөжийг үнэлэх үе. 1.Байгалийн баялгийн нөөц, экосистемийн үйлчилгээний үнэ цэн, даацыг тогтоож, үнэлгээг шинэчилнэ. 2.Цэнгэг усны нөөц, гол, мөрний урсац бүрэлдэх эх зэрэг онцлог экосистемийг тусгай хамгаалалтад авч, унаган байгалийг хамгаална.
Зорилт 6.1. Байгалийн үнэ цэн, өгөөжийг үнэлэн хамгаалж, анхдагч экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална.	
<u>Байгалийн баялгийн үр өгөөж.</u>	I үе шат (2021-2030): Байгаль орчныг хамгаалах, нөөцийг зохистой ашиглах, шинжлэх ухааны үндэслэлтэй бодлого хэрэгжүүлж, доройтсон орчныг нөхөн сэргээж нөөцийн хомсдолыг бууруулах, ашиглалтын нөөц бий болгох үе. 1.Биологийн олон янз байдлыг хамгаалах, тархац нутаг, амьдрах орчныг нь тэтгэж хомсдолоос сэргийлэх, ашигт зүйлийг үржүүлэх, тарималжуулах, ойн агропарк байгуулах замаар ашиглалтын нөөц бүрдүүлнэ. 2.Хөрсний үржил шим, чийгийг хамгаалж, газрын доройтол, цөлжилтөөс сэргийлэн, эвдрэлд орсон, доройтсон газрыг нөхөн сэргээж, аж ахуйн эргэлтэд оруулна. 3.Байгаль орчны хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлан таниулж, стандарт, хэм хэмжээг мөрдүүлэн, байгаль хамгаалалд иргэдийн оролцоог хангана. 4.Байгаль орчны хяналт-шинжилгээний сүлжээ, кадастр, мэдээллийн санг өргөжүүлж, шинэ үеийн техник, технологийн шинэчлэл хийнэ.
Зорилт 6.2. Байгалийн нөөц баялгийг нөхөн сэргээж хомсдолыг бууруулан, ашиглалтын нөөц бий болгож, байгалийн үр өгөөжийг ирээдүй хойч үедээ өвлүүлнэ.	
ДОЛОО. АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ	
Зорилго 7. Улсын батлан хамгаалах чадавхыг бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, нийгмийн дэг журам, иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангах, гамшгийн эрсдэлийг бууруулах замаар хүн, нийгмийн аюулгүй байдлыг хангана.	

<p><u>Хүн, нийгмийн амар тайван байдал.</u></p> <p>Зорилт 7.3. Уламжлалт бус аюулын эрсдэлийг бууруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадавхыг бэхжүүлж, хүн-нийгмийн амар тайван орчныг бүрдүүлнэ.</p>	<p>I үе шат (2021-2030): Уламжлалт бус аюулын хүчин зүйлсийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадавхыг бэхжүүлж, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх үе.</p> <p>1. Хууль сахиулах болон тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын зохион байгуулалт, үүрэг гүйцэтгэх чадавхыг хүн амын бүлгүүдийн ялгаатай хэрэгцээ, нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн хөгжүүлнэ.</p> <p>2. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, иргэдийг гэмт хэрэгт өртөх, хохирохоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, түүнтэй тэмцэх тогтолцоонд инновацад суурилсан техник, технологийн дэвшлийг нэвтрүүлж, нөлөөллийн арга хэмжээг цогцоор хэрэгжүүлж, урьдчилан сэргийлэх чадавхыг дээшлүүлж, гэмт хэргийн илрүүлэлтийг нэмэгдүүлнэ.</p> <p>3. Орон нутгийн гамшгаас хамгаалах чадавхыг нэмэгдүүлэн, тогтолцоог бэхжүүлж, улсын хэмжээний гамшгийн эрсдэлийн түвшнийг бүрэн тодорхойлно.</p>
<p>ЕС.УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ</p>	
<p>Зорилго 9. Амьдрахад таатай, байгаль орчинд ээлтэй, хүн төвтэй ухаалаг хот болгон хөгжүүлнэ.</p>	
<p><u>Орчин төвтэй шийдэл.</u></p> <p>Зорилт 9.2. Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж, экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан, хүлэмжийн хийн ялгарал багатай ногоон технологи бүхий амьдралын таатай орчинтой хот болно.</p>	<p>I үе шат (2021-2030): Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангаж, нөхөн сэргээх, хариуцлагатай, хэмнэлттэй хэрэглээг бий болгох үе.</p> <p>1. Экосистемийн үнэ цэн экологийн даацыг тогтоож, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон байгалийн нөөцийн тогтвортой менежментийг хэрэгжүүлнэ.</p> <p>2. Байгальд ээлтэй, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэн бохирдол үүсгэгчийг багасгаж, агаар, хөрс болон орчны бохирдлыг бууруулсан байна.</p> <p>3. Усны нөөц, ундны усны баталгаат эх үүсвэрээр хангаж, гадаргын усыг хуримтлуулан, дахин ашиглаж, усны үнэ цэнийг нэмэгдүүлнэ.</p> <p>4. Хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх үйлчилгээнд технологийн шинэчлэл хийж бохирдол бага ялгаруулах, хог хаягдалгүй хэрэглээг дэмжих тогтолцоотой болсон байна.</p> <p>5. Хотын ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэнгийн талбайг боломжит бүх байршилд нэмэгдүүлж, хот доторх оршуулгын газрыг дахин зохион байгуулна.</p> <p>6. Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг даван туулах, гамшгийг эрт илрүүлэх, тэсвэрлэн гарах чадавхыг бэхжүүлнэ.</p> <p>7. Хүнсний аюулгүй байдлыг хангах, хөдөө орон нутгаас нийлүүлдэг органик хүнсний сүлжээ бий болгоно.</p> <p>8. Агаар, орчны чанарын хяналт-шинжилгээний чадавхыг олон улсын түвшинд хүргэнэ.</p> <p>9. Ногоон барилгын стандартыг нэвтрүүлж, хэрэгжүүлнэ.</p>
<p>Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого</p>	
<p><u>Бодлогын 1.1</u></p>	<p>“Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого нь хувийн хэвшилд түшиглэсэн, ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж...”, 2.1.3-д “эрдэс баялгийн салбарыг хөгжүүлэхэд төрийн байгууллага, аж ахуйн нэгж нээлттэй, ил тод, хариуцлагатай байх” зарчмыг тунхаглаж, 3.1.7-т “ил тод байдлын болон хариуцлагатай уул уурхай, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийн үнэлгээ зэрэг олон улсын санаачилгыг дэмжин хөгжүүлэх” гэж бодлогын чиглэлээ тодорхойлсон байна.</p>

2.2. Дунд хугацааны зорилтот хөтөлбөр

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө 2016-2020¹²

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 121 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд Засгийн газрын 2016-2020 онд хэрэгжүүлэх ажлын үүргийг тодорхойлсон бөгөөд тус Ажлын хэсгийн үйл ажиллагааг дараах үйл ажиллагааны хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэхээр байна. Үүнд:

Хүснэгт 9. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө 2016-2020-д тусгагдсан нийгмийн нөлөөллийн үнэлгээг боловсруулахтай холбоотой зорилго, зорилтууд

Дөрөв. Байгаль орчин, ногоон хөгжлийн бодлого	
Тэргүүлэх зорилт № 4.1. “Байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, хойч үедээ өвлүүлэн үлдээх, байгалийн нөөц баялгийг хамгаалах, хомсдлоос сэргийлэх, зохистой ашиглах, нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэн, байгаль орчинд нийцтэй, хүртээмжтэй эдийн засгийн өсөлт, нийгмийн тогтвортой хөгжлийн үндэс болгоно. Аялал жуулчлалын өрсөлдөх чадварыг бүс нутгийн хэмжээнд дээшлүүлж, эрх зүйн таатай орчинг бүрдүүлж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.	4.1.3.Байгаль орчны багц хуулийг хэрэгжүүлэх цогц арга хэмжээ авч, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй үйлдвэрлэл, үйлчилгээ болон байгалийн нөөцийн хууль бус ашиглалтад тавих хяналтыг сайжруулна, 4.2.6.Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах бодлого хэрэгжүүлж, уул уурхайн хайгуул, олборлолтод өртөж, эвдрэлд орсон газар нутгийг нөхөн сэргээнэ 4.3.1.Байгаль хамгаалах, байгалийн нөөц баялгийг арвижуулах, нөхөн сэргээх ажил эрхэлж байгаа иргэн, нутгийн иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг дэмжих эрх зүй, эдийн засгийн орчинг бүрдүүлж, орон нутагт ажлын байр, орлогын нэмэлт эх үүсвэр бий болгох ажлыг зохион байгуулна.
Тав. Засаглалын бодлого	
Тэргүүлэх зорилт № 5.1. Тогтвортой, хариуцлагатай улс төрийн соёлыг төлөвшүүлж, хүчтэй, чадамжтай, хууль дээдэлсэн төрт ёсыг бэхжүүлэх зарчмыг баримтална.	5.1.18. Хөдөөгийн иргэдийн аюулгүй орчинд амьдрах, малчдыг мэдээллээр хангах хөтөлбөр хэрэгжүүлж, сум, багийнхаа үйл ажиллагаанд орон зайн тэгш бус байдлаас үл хамааран жигд оролцох боломжоор хангана.
Тэргүүлэх зорилт № 5.3. Хууль заавал хэрэгждэг, хүн бүрд эрх тэгш, алагчлалгүй, шударга үйлчилдэг, итгэл хүлээсэн хүний эрхийн мэдрэмжтэй, шударга ёсны засаглалыг бэхжүүлэх зарчмыг баримтална.	5.3.11. Хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоог сайжруулж, хүний эрхийн стандартыг нэвтрүүлнэ.

Монгол Улсын хөгжлийн урт болон дунд хугацааны бодлого, хөтөлбөрийн зорилго, чиглэл, үндсэн зарчимд олон улсын хүний эрхийн зарчмууд сууж өгсөн бөгөөд нийгмийн нөлөөллийн үнэлгээ боловсруулахад бүтцэд зайлшгүй тусгах шаардлагатай олон улсын зарчмуудыг энэхүү тайлангийн Гурав-т тусгайлан жагсаалт байдлаар харуулав.

2.3. Хууль тогтоомж, үндэсний хөтөлбөр, журмын зохицуулалт

2.3.1. Холбогдох хууль тогтоомж

¹² Энэхүү тайланг Зөвлөх багаас боловсруулж эцэслэх үед 2020-2024 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлагдаагүй байв.

Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа дараахь хууль тогтоомжид нийгмийн нөлөөллийн зарим асуудлыг тусгасан байгаад сэдэвчилэн дүн шинжилгээ хийлээ. Дүн шинжилгээнд дараах хууль тогтоомжийг хамруулсан. Үүнд:

Шууд хамааралтай хууль тогтоомж:

1. **Ашигт малтмалын тухай хууль**¹³-ийг анх 1997 онд баталж, 2006.07.08нд шинэчлэн найруулсан ба түүнээс хойш 34 удаа нэмэлт өөрчлөлт орсон. Хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт ашигт малтмал эрэх, хайх, ашиглах болон хайгуулын талбай, уурхайн эдэлбэрийн орчныг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршдог.
2. **Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль** -ийг анх 1998 онд батлаж, 2012 онд шинэчлэн найруулсан. Уг хуулийн зорилт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 2 дахь заалтыг хэрэгжүүлэх, байгаль орчныг хамгаалах, хүний үйл ажиллагааны улмаас байгаль орчны тэнцвэрт байдал алдагдахаас сэргийлэх, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатайгаар байгалийн нөөц ашиглалт явуулах, бүс нутаг, салбарын хэмжээнд баримтлах бодлого, хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө болон аливаа төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлэх, хэрэгжүүлэх эсэх талаар дүгнэлт, шийдвэр гаргах, оролцогч талуудын харилцааг зохицуулахад оршдог.
3. **Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль**¹⁴-ийг 2014 онд баталсан. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах тусгай зөвшөөрөл авах, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг хариуцлага болон хайгуулын талбай, уурхайн эдэлбэрийн орчныг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршдог.
4. **Цөмийн энергийн тухай хууль**¹⁵-ийг 2009.07.16нд баталсан. Энэ хуулиар Монгол Улсын нутаг дэвсгэрт цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийг энхийн зорилгоор ашиглах, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангах, хүн ам, нийгэм, байгаль орчныг ионжуулагч цацрагийн сөрөг нөлөөллөөс хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулдаг.
5. **Газрын тухай хууль**¹⁶-ийг 2002 онд баталсан. Энэ хуулиар газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулах болон түүнтэй холбогдсон бусад харилцааг зохицуулдаг.
6. **Захиргааны ерөнхий хууль**¹⁷ 2015 онд батлагдсан. Нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн захирамжилсан шийдвэр гаргадагийн хувьд төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв орон нутгийн бүх байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага болон шийдвэр, үйл ажиллагаанд нь захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргахаар хуульд тусгайлан заасан байгууллагуудын шийдвэр нь иргэдийн эрх ашигт нийцсэн байх, иргэд эрх ашиг нь зөрчигдсөн гэж үзвэл захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргах харилцааг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар (2016¹⁸) зохицуулсан.
7. **Нийтийн сонсголын тухай хууль**¹⁹ 2015 онд батлагдсан. Хуульд заасан нийтийн эрх ашгийг хөндсөн асуудлаар шийдвэр гаргахын өмнө сонсгол зохион байгуулах, хэлэлцэхээр зохицуулсан бөгөөд орон нутагт ашигт малтмал олборлох ашиглахтай холбоотой шийдвэр нь үүнд хамаарна.

Бусад холбогдох хууль

1. Барилгын тухай хууль²⁰, 1998
2. Эрчим хүчний тухай хууль²¹, 1995

¹³ <https://www.legalinfo.mn/law/details/63?lawid=63>

¹⁴ <https://www.legalinfo.mn/law/details/9750?lawid=9750>

¹⁵ <https://www.legalinfo.mn/law/details/97?lawid=97>

¹⁶ <https://www.legalinfo.mn/law/details/216?lawid=216>

¹⁷ <https://www.legalinfo.mn/law/details/11259>

¹⁸ <https://www.legalinfo.mn/law/details/11703>

¹⁹ <https://www.legalinfo.mn/law/details/11225>

²⁰ <https://www.legalinfo.mn/law/details/11705?lawid=11705>

²¹ <https://www.legalinfo.mn/law/details/60?lawid=60>

3. Автозамын тухай хууль²², 2017
4. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль²³, 2016
5. Газрын тосны тухай хууль²⁴, 2014
6. Газрын хэвлийн тухай хууль²⁵, 1988
7. Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль²⁶, 2005
8. Соёлын өвийг хамгаалах тухай хууль²⁷, 2014
9. Боловсролын тухай хууль²⁸, 2002
10. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай²⁹, 2008
11. Хог хаягдлын тухай³⁰, 2017
12. Химийн хорт болон аюултай бодисын тухай³¹, 2006
13. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай³², 2012
14. Байгаль орчныг хамгаалах тухай³³, 1995

Үндэсний хөтөлбөр

- Монгол улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр, 2003

Төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагаас баталсан журам

1. “Байгаль орчны стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний журам”, Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт,
2. “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”, Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт,
3. “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журам”, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 01 дугаар сарын 06-ны өдрийн А-03 тоот тушаал,
4. “Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн ТЭЗҮ-д тавих үндсэн шаардлагууд, ТЭЗҮ хүлээж авах журам”, Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын 2012 оны 74 дүгээр тушаал,
5. “Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журам”, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/181, А/458 дугаар хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралт,
6. “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал”, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны А-138 дугаар тушаалын хавсралт,
7. “Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт жөндөрийн талаар баримтлах бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2019-2026)”, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны 5 сарын 6-ны А/114 дүгээр тушаал³⁴

²² <https://www.legalinfo.mn/law/details/12656?lawid=12656>

²³ <https://www.legalinfo.mn/law/details/11711?lawid=11711>

²⁴ <https://www.legalinfo.mn/law/details/10484?lawid=10484>

²⁵ <https://www.legalinfo.mn/law/details/218?lawid=218>

²⁶ <https://www.legalinfo.mn/law/details/214?lawid=214>

²⁷ <https://www.legalinfo.mn/law/details/10439?lawid=10439>

²⁸ <https://www.legalinfo.mn/law/details/9020?lawid=9020>

²⁹ <https://www.legalinfo.mn/law/details/564?lawid=564>

³⁰ <https://www.legalinfo.mn/law/details/12652?lawid=12652>

³¹ <https://www.legalinfo.mn/law/details/526?lawid=526>

³² <https://www.legalinfo.mn/law/details/8663?lawid=8663>

³³ <https://www.legalinfo.mn/law/details/8935?lawid=8935>

³⁴ <https://mrpam.gov.mn/public/pages/45/bodlogo%20scan.pdf>

Аргачлал³⁵

1. “Байгаль орчны стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014.04.10 өдрийн А-117 тоот тушаалын 1 дүгээр хавсралт³⁶,
2. “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014.04.10 өдрийн А-117 тоот тушаалын 2 дугаар хавсралт.³⁷

2.3.2. Нөлөөллийн үнэлгээний хэрэгцээ шаардлагыг зохицуулсан байдал

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд байгалийн нөөцийг ашиглах, газрын тос болон ашигт малтмал хайх, ашиглах, аж ахуйн зориулалтаар газар эзэмших, ашиглах эрх авах болон төсөл хэрэгжүүлэхээс өмнө байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийхээр заасан. Монгол Улсад бүх төрлийн ашигт малтмал олборлолтын үйл ажиллагаа болон хүнд үйлдвэрийн төсөл буюу ашигт малтмал баяжуулах, боловсруулах, химийн үйлдвэр, кокс-химийн үйлдвэр болон бусад бүх төрлийн ашигт малтмалын хүнд үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, дэд бүтцийн бүхий л төсөл нь БОНБҮТХ-ийн Хавсралтад зааснаар байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийх төслийн ангилалд багтсан³⁸.

Хуулийн 4.1-д байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ гэдэгт: байгаль орчны стратегийн үнэлгээ, ³⁹байгаль орчны төлөв байдлын үнэлгээ⁴⁰, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ⁴¹/цаашид “нөлөөллийн үнэлгээ” гэх/, хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ⁴² хамаарна гээд мөн хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д “Нөлөөллийн үнэлгээний журам, аргачлалыг Засгийн газар батлах бөгөөд уг журам, аргачлалд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээтэй холбоотой асуудал, үнэлгээний шинжилгээ, хянан магадлагаа болон мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагаа, нийгэм, эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний талаарх зохицуулалтыг тусгана” гэж заасан.

Байгаль орчны нөлөөлөх байдлын дээрх 4 төрлийн үнэлгээний тодорхойлолтоос үзэхэд стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээгээр нийгэм, хүний эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэл, сөрөг нөлөөлөлийг тодорхойлохоор байна. Харин Засгийн газраас батлах Байгаль орчны нөлөөллийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээний журам, аргачлалд нийгэм, эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний талаар тусгахаар зохицуулжээ.

Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.10-т Төрийн захиргааны байгууллага уул уурхайн үйлдвэрлэлээс улс орны эдийн засаг, нийгмийн салбарт үзүүлж байгаа нөлөөллийг үнэлэх, дүгнэлт гаргах **чиг үүргийг заан** хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагааны явцад худаг, өвөлжөө, хувийн болон нийтийн зориулалттай орон байр бусад барилга байгууламж болон түүх, соёлын дурсгалт зүйлсэд гэм хор учруулсан бол хохирлыг нь өмчлөгч, эзэмшигчид бүрэн

³⁵ Хүчингүй болсон. Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт, **Байгаль орчны стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний журмаар зохицуулж байна.**

³⁶ <http://www.mne.mn/wp-content/uploads/2017/07/2014.7.pdf>

³⁷ <http://www.mne.mn/wp-content/uploads/2017/07/2014.7.pdf>

³⁸ *Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Хавсралт, Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийх төслийн жагсаалт*

³⁹ 3.1.3. **“байгаль орчны стратегийн үнэлгээ”** гэж улсын болон бүс нутаг, салбарын хэмжээнд баримтлах бодлого, хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах явцад түүний хэрэгжилттээс **байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд** учирч болзошгүй эрсдэл, сөрөг нөлөөлөл, үр дагаврыг уур амьсгалын өөрчлөлтийн чиг хандлага, гамшиг, аюулт үзэгдэл, осол, аюултай уялдуулан тодорхойлохыг;

⁴⁰ 3.1.4. **“байгаль орчны төлөв байдлын үнэлгээ”** гэж аливаа төслийн техник, эдийн засгийн төлөвлөлтийн баримт бичиг, зураг төсөл, улсын болон бүс нутаг, салбарын хэмжээнд хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах явцад тэдгээрийг хэрэгжүүлэх нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлыг судлан тогтоож цаашид төсөл, хөтөлбөр, төлөвлөгөө, бодлого боловсруулахад анхаарах байгалийн нөхцөл, орчны онцлогийг тодорхойлохыг;

⁴¹ 3.1.6. **“байгаль орчны нөлөөллийн үнэлгээ”** гэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас тодорхой төслийг хэрэгжүүлэх явцад **байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл, үр дагаврыг урьдчилан тодорхойлж, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээ тогтоохыг;**

⁴² 3.1.5. **“хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ”** гэж тодорхой бүс нутаг, сав газарт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас хэрэгжүүлж байгаа төслүүдээс **хүн амын эрүүл мэндэд үзүүлж байгаа хам болон давхардмал сөрөг нөлөөллийг тодорхойлж, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээ тогтоохыг;**

хэмжээгээр нөхөн төлөх бөгөөд шаардлагатай тохиолдолд тэдгээрийг шилжүүлэн байрлуулахтай холбогдсон зардлыг хариуцна.”, мөн хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-д “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь зохих хууль тогтоомжийн дагуу уурхайд ажиллагсдын хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн нөхцөл болон тухайн сум, дүүргийн иргэдийн аюулгүй байдлыг хангах талаар тодорхой үйл ажиллагаа явуулна” гэсэн байна.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 31 дүгээр зүйлийн 31.1д дээр дурдсан Ашигт малтмалын тухай хуулийн 41, 44 дүгээр зүйлүүдийг ишлэн зохицуулсан харин Цөмийн энергийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д “...тусгай зөвшөөрөл хүсэгч ... аюулгүй ажиллагааны шаардлагыг бүрэн хангасан байх; хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг бүрэн хангасан байх;бүс нутгийн хөгжил, эрүүл мэнд, боловсрол зэрэг нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд санаачлагатай оролцдог байх; ... нийгмийн хариуцлага, ... талаархи дэлхий нийтэд хүлээн зөвшөөрсөн стандартыг хэвшүүлсэн байх;” 17.2-д “... тусгай зөвшөөрөл хүсэгч нь ... дараахь нөхцөлийг хангасан байна:...17.2.4.уул уурхайн үйлдвэрлэлийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны олон улсын стандарт, шаардлагыг хангаж ажилладаг байх.”, мөн хуулийн 30 дугаар зүйлийн 30.1-д ...тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн хөрөнгө оруулагч өөрөө хүсэлт гаргавал ... түүнтэй хөрөнгө оруулалтын гэрээг 10 хүртэл жилийн хугацаатай байгуулж болох бөгөөд түүнд дараах зүйлийг тусгана: 30.1.5.ашигт малтмалыг хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд хохирол багатай олборлох; 30.1.8.бүс нутгийг хөгжүүлэх, ажлын байр шинээр бий болгох; 30.1.9.учирсан хохирлыг нөхөн төлөх” гэж заажээ.

Бусад хууль, журамд тусгагдсан байдал

Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т “Гэрээлэгч дараах үүрэг хүлээнэ: 11.2.17....орон нутгийн хөгжилд сайн дурын үндсэн дээр дэмжлэг үзүүлэх асуудлыг тусгасан гэрээг тухайн тусгай зөвшөөрлийн талбай орших сум, дүүргийн Засаг даргатай байгуулж ажиллах;” мөн хуулийн 40 дүгээр зүйлийн “40.1.Гэрээлэгч нь хайгуул, ашиглалтын явцад худаг, өвөлжөө, намаржаа, хаваржаа, хувийн болон нийтийн зориулалттай орон байр, бусад барилга байгууламж, түүх, соёлын дурсгалт зүйл зэрэг бусдын өмчлөл, эзэмшлийн эд хөрөнгөд хохирол учруулсан бол хохирлыг нь бүрэн хэмжээгээр нөхөн төлнө. 40.2.Гэрээлэгч энэ хуулийн 40.1-д заасан барилга байгууламж, эд хөрөнгийг шилжүүлэн байрлуулахтай холбоотой зардлыг бүрэн хариуцна” гэж заасан байна.

Барилгын тухай хуулийн 7 дугаар зүйлийн “7.1.Эрх бүхий байгууллага барилгын ажлын зөвшөөрөл олгохдоо доор дурдсан асуудлыг харгалзан үзнэ: 7.1.1.барилгын үйл ажиллагаанаас шалтгаалан үүсэх иргэн, хуулийн этгээдийн өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаа газар, үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой эрх, ашиг сонирхол; 7.1.2.иргэн, хуулийн этгээдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, ажиллахтай холбогдон үүсэх эрх, ашиг сонирхол;” гэсэн байна.

Эрчим хүчний тухай хуулийн 25 дугаар зүйлийн “25.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараахь үүрэг хүлээнэ: 25.1.2.хууль тогтоомж, эрчим хүчний техникийн ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрэм, журам, тусгай зөвшөөрөлд заасан нөхцөл, шаардлага, тусгай зөвшөөрөл олгогчийн шийдвэрийг дагаж мөрдөх; 25.1.11.үйл ажиллагаагаа эхлэхээс өмнө байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг эрх бүхий байгууллагаар хийлгэх, байгаль хамгаалах, нөхөн сэргээх жил бүрийн төлөвлөгөө боловсруулж, холбогдох байгууллагаар батлуулж мөрдөх;” гэж заажээ.

Соёлын өвийн тухай хуулийн 27.8.Хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, газар тариалан эрхлэх, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгохоос өмнө палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, дүгнэлт гаргуулна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 8.4.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудад хүртээмжтэй дэд бүтцийг сайжруулах, түүнд мэдээлэл харилцааны технологийг

ашиглах боломжийг нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэлтийг дэмжих, эрүүл ахуйн шаардлага хангасан хоол хүнс, хувцас, орон байр, ахуйн хэрэгслээр хангах арга хэмжээг авч, зардлыг барилга, зам, нийтийн тээвэр, мэдээлэл, харилцаа холбоо, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн төсөвт тусган шийдвэрлэнэ, 9.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй буюу түүний хэрэгцээ, шаардлагад нийцсэн нийгмийн дэд бүтэц, орон сууц, олон нийтийн барилга байгууламжийн орчны болон дотоод зохион байгуулалтын заавал дагаж мөрдөх үндэсний стандартыг барилгын болон хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн стандартчиллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

Автозамын тухай хуулийн 5.1.3.авто зам барих, эзэмших, ашиглах, арчлах, хамгаалах, засварлах үеийн үйл ажиллагаа нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх; 19.2.Авто зам, замын байгууламжийн зураг төсөлд тавигдах шаардлагад зорчигчдын эрүүл ахуй, хөдөлгөөний аюулгүй байдал, байгаль орчин, түүх, соёлын дурсгалд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх нөхцөлийг хангах, авто зам, замын байгууламжийг зэрлэг амьтдын амьдрах орчин, нүүдэл, шилжилт хөдөлгөөнийг хязгаарлахгүй байх нөхцөлийг хангасан гүүрэн, нүхэн гарц, гарамтай байхаар тусгах гэсэн байна.

Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 8.4.3-т үйлдвэрийн хаягдлыг хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд хор нөлөө үзүүлэхээргүй орчинд хадгалах, зайлуулах, устгах нөхцөлийг бүрдүүлэх гэсэн ба Газрын хэвлийн тухай хуулийн 6.Хүн амын эрүүл мэнд, мал, ан амьтан, байгаль орчинд онцгой нөлөө бүхий хортой бодисыг хамгаалан булахад зориулан газрын хэвлийг ашиглуулах тухай асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ гээд 3/газрын хэвлийг ашиглахад үүсч болзошгүй хортой нөлөөнөөс хий мандлын агаар, газар, ой, ус, рашаан, мал ан амьтан, байгаль орчны бусад объект, барилга байгууламжийг найдвартай хамгаалах, түүнчлэн тусгай хамгаалалттай газар, байгалийн болон түүх, соёлын дурсгалт зүйлийн хадгалалт, хамгаалалтыг хангах; 1.Газрын хэвлийн ашиглалт, хамгаалалтад тавих төрийн хяналтын зорилт нь тус улсын яам, тусгай газар, аж ахуйн нэгж, байгууллага, иргэн, түүнчлэн гадаад улсын хуулийн этгээд, иргэн, харьяалалгүй хүн хэвлийг ашиглах, хамгаалах талаар тогтоосон журмыг сахиж, түүнийг ашиглахад аюулгүй ажиллагааг хангах, болзошгүй аюул, хортой нөлөөнөөс хүн ам болон мал, ан амьтан, байгаль орчин, барилга байгууламжийг хамгаалах, сэргийлэх, уг аюул, хортой нөлөөг арилгах үүргийн биелэлтийг хангах, ашигт малтмалын нөөц, ордын болон газрын хэвлийн улсын тоо бүртгэлийн журам, түүнчлэн газрын хэвлийн тухай хууль тогтоомжийн бусад заалтыг хэрэгжүүлэх явдлыг хангахад оршино хэмээн зохицуулжээ.

Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын 2014 оны А/11 тоот тушаалаар Байгаль орчны стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал, Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний аргачлал баталсан боловч Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны А/80 дугаар тушаалаар хүчингүй болгосон байдаг. Уг асуудлыг Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт, **Байгаль орчны стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний журмаар зохицуулж байгаа ч байгаль орчны стратеги, хуримтлагдсан нөлөөллийн үнэлгээний нарийвчилсан аргачлал байхгүй, доорх ерөнхий зохицуулалтаар хязгаарлагдсан:**

- 1) байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэл, сөрөг нөлөөллөөс зайлсхийх боломжит хувилбар болон хэрэгжүүлэхээс татгалзах хувилбарыг тодорхойлох;
- 2) байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэл, сөрөг нөлөөлөл, түүний үр дагавар, хуримтлагдах сөрөг нөлөөлөл
- 3) сөрөг нөлөөллөөс зайлсхийх, бууруулах боломжит хувилбар болон хэрэгжүүлэхээс татгалзах хувилбар, тэдгээрийн байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөллийн харьцуулалт;

- 4) сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээг бүрэн гүйцэд хэрэгжүүлсэн тохиолдолд байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд үзүүлэх эерэг нөлөөлөл;
- 5) тухайн бүс нутгийн байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд үзүүлсэн болон үзүүлж байгаа гол сөрөг нөлөөллүүд, тэдгээрийн үр дагаврын тодорхойлолт;
- 6) хуримтлагдсан сөрөг нөлөөллөөс үүдэн бий болсон байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндийн хохирлын үнэлгээ хийх

Түүнчлэн Эрүүл мэндийн сайдын 2014 оны 413 тоот тушаалаар Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ хийх аргачлалыг мөн БОНБҮТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.7-д заасныг үндэслэн тусад нь баталжээ. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан нийгмийн нөлөөллийн үнэлгээ одоогоор байхгүй боловч ХНХЯ-ны дэргэдэх Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институци нь онцгой нөхцөлийн болон халамжийн зарим хөтөлбөр, ЗГ-ын шийдвэрт нөлөөллийн үнэлгээ хийдэг. Уг нөлөөллийн үнэлгээ нь нийгэм, эдийн засгийн үр өгөөжийг тооцоолох, эрсдэлийг тодорхойлох зорилгоор хийгддэг, тогтсон стандартгүй, судлаачдын арга зүй, удирдлагын бодлого шийдвэртэй уялдаж боловсруулагддаг байна.

2.3.3. Орон нутгийн гэрээнд нийгмийн нөлөөллийг үнэлэх талаар тусгасан байдал

Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн “42.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана” гэж заасан. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон нутгийн захиргааны байгууллагын хооронд байгуулах “Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай гэрээ”-ний загварыг Засгийн газрын 2016 оны 179 дүгээр тогтоолоор баталсан.⁴³

Уг гэрээний загварын 1.2-т “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн тусгай зөвшөөрөл бүхий талбай орших аймаг (нийслэл), сум (дүүрэг)-ын байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд сайн дурын үндсэн дээр дэмжлэг үзүүлнэ”, мөн “3.1. Энэхүү гэрээний хүрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ: 3.1.2. орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тэднийг сургалтад хамруулах талаар орон нутгийн хөдөлмөрийн байгууллагатай хамтарч ажиллан, шаардлагатай ажлын байр болон түүнд тавих шаардлагыг ил тод, нээлттэй хэлбэрээр нийтэд зарлах; 3.1.3. хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд шаардлагатай ажлын байрны сургалтын хөтөлбөр боловсруулж, тухайн орон нутгийн иргэдийг хамруулах ажлыг зохион байгуулах; 3.1.4. нийт ажлын байрны ... доошгүй хувьд тухайн орон нутгийн иргэдийг зохих түвшний сургалтад хамруулсны үндсэн дээр ажиллуулах;” зэрэг тухайн орон нутгийн иргэдэд сайн дурын үндсэн дээр дэмжлэг үзүүлэх үүрэг хүлээхээр тусгажээ.

Эрдэс баялгийн салбарын төсөл, хөтөлбөр, түүнийг дагасан дэд бүтцийн төсөл хэрэгжүүлэх нь төрөөс төсөл хэрэгжүүлэх хайгуулын талбайн солбицлыг тогтоон, батлахаас эхлэн уурхайн хаалт, нөхөн сэргээлт хийж төслийг дуусгах хүртэл хэд хэдэн үе шат дамждаг. Нийгмийн нөлөөллийн үнэлгээг төсөл эхлэхээс өмнө хийх шаардлагатай ба үнэлгээний хэрэгжилтийг хангах, хяналт тавихад төслийн үе шат тус бүрт хийгдэх нөлөөллийн үнэлгээтэй холбогдох процессын зураглалыг хянавал зохино.

Хавсралт 3. Процессын зураглалыг харна уу

⁴³ <https://www.legalinfo.mn/annex/details/7245?lawid=11852>

2.3.4. Шийдвэр гаргах үе шатанд олон нийтийн оролцоо, мэдэх эрхийг хангах талаар

БОНБУТХ-ийн 7.7-д “Нөлөөллийн үнэлгээний журам, аргачлалыг Засгийн газар батлах бөгөөд уг журам, аргачлалд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээтэй холбоотой асуудал, үнэлгээний шинжилгээ, хянан магадлагаа болон мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагаа, нийгэм, эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний талаарх зохицуулалтыг тусгана” гэж заасан. Харин Ашигт малтмалын тухай хуулийн 11.1.10-т ашигт малтмалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага (АМГТГ)-ын чиг үүрэгт уул уурхайн үйлдвэрлэлээс улс орны эдийн засаг, нийгмийн салбарт үзүүлж байгаа нөлөөллийг үнэлэх, дүгнэлт гаргахаар заасан.

Захиргааны акт гэж захиргааны байгууллагаас тодорхой нэг тохиолдлыг зохицуулахаар нийтийн эрх зүйн хүрээнд гадагш чиглэсэн, эрх зүйн шууд үр дагавар бий болгосон амаар, бичгээр гаргасан захирамжилсан шийдвэр болон үйл ажиллагааг ойлгоно⁴⁴. Түүнчлэн төрийн захиргааны байгууллагын байгуулах гэрээ нь захиргааны гэрээнд тооцогдохоор байна.

Төрөөс тодорхой нэг төслийг хэрэгжүүлэх ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчид холбогдуулж захиргааны акт болон захиргааны гэрээ байгуулах шийдвэрийг төрийн захиргааны байгууллага, орон нутгийн засаг захиргааны удирдлагаас дараах тохиолдолд гаргаж байна:

1. Тусгай зөвшөөрөл олгох захирамж
2. Газар, ус ашиглах бусад гэрээ байгуулах
3. Орон нутгийн гэрээ байгуулах

Захиргааны шийдвэр гаргах ажиллагааны улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй этгээдийг түүний хүсэлтээр, эсхүл захиргааны байгууллага өөрийн санаачилгаар, оролцогчийн зөвшөөрснөөр шийдвэр гаргах ажиллагаанд татан оролцуулахаар заасан⁴⁵. Мөн хуулийн 24.4.Тухайн захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд хамааралтай тохиолдол бүрийн үндэслэлийг захиргааны байгууллага нарийвчлан шинжлэн судлах үүрэгтэй бөгөөд оролцогчийн хувьд ач холбогдол бүхий нөхцөл байдлыг тогтооно гээд Захиргааны акт, захиргааны гэрээг батлан гаргахын өмнө эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй этгээдэд захиргааны шийдвэр гаргахад ач холбогдол бүхий нөхцөл байдлын талаар тайлбар, санал гаргах боломж олгох ба тус ажиллагааг .сонсох ажиллагаа гэнэ гэж зааснаар дээрх захиргааны акт гаргахдаа сонсох ажиллагааг заавал зохион байгуулахаар заасан.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журам⁴⁶-д заасан аргачлалд нийгмийн нөлөөллийн хэрхэн үнэлж дүгнэх нь тодорхойгүй, 2.2.3. хуримтлагдах нөлөөллөөс байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд үзүүлсэн болон үзүүлж буй гол сөрөг нөлөөлөл, түүний үр дагаврын тухай; төслүүдийн хуримтлагдсан нөлөөллийн эрчим, цар хүрээ (цаг хугацаа, орон зай), тархалтыг тогтоох; 2.5.4.нөлөөллийн үнэлгээний үе шатанд олон нийтийн оролцоог зөвлөлгөөн, хэлэлцүүлэг, санал асуулга явуулах замаар төслийн шууд болон шууд бус нөлөөллийг үнэлж, иргэдийн амьжиргаа, нийгмийн асуудлыг тусгахад анхаарах гэсэн 2 зохицуулалттай.

Хууль тогтоомжийн тухай хууль

Нөлөөллийн үнэлгээ хийх эрх зүйн баримт бичигт 2015 онд батлагдсан Хууль тогтоомжийн тухай хууль багтана. Тус хуулийн дагуу Монгол Улсад хууль тогтоомжийн төсөл боловсруулахад хуулийн 6.2-т зааснаар хууль тогтоомж хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг тандан судлахдаа дор дурдсан суурь асуултуудыг ашиглахаар заасан ба Хүснэгт 1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө, Хүснэгт 2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө, Хүснэгт 3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө, Хүснэгт 4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг үнэлж, тайлбарыг гаргадаг.

*Хууль тогтоомжийн тухай хуульд зааснаар хууль тогтоомж гэдэгт хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг санаачлах, боловсруулах ажиллагааны үндэслэл, чанарыг сайжруулах, түүнд олон нийтийн оролцоог хангах, хууль тогтоомжийн төсөлд тавих шаардлагыг тодорхойлох, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлнэ. Үнэлгээг хууль тогтоомжийн **хэрэгцээ**,*

⁴⁴ Захиргааны ерөнхий хууль, 37.1

⁴⁵ Захиргааны ерөнхий хууль, 13.326.1.

⁴⁶ Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 01 дугаар сарын 06-ны өдрийн А-03 тоот тушаалын хавсралт

шаардлагыг урьдчилан тандан судлахдаа зохицуулалтын хувилбаруудын үр нөлөөг тандан судлах хэсэгт хийнэ. Төрийн захиргааны төв байгууллагаас батлах захиргааны журмыг боловсруулах үе шатанд ижил үнэлгээ хийхээр заасан. Гэхдээ эрх зүйн баримт бичгийг зөвхөн батлуулах зорилгоор дээрх үнэлгээг бөглөхдөө судалгаанд үндэслэхгүй, зөвхөн баримт бичиг боловсруулсан багийн үнэлэмжээр гүйцэтгэдэг.

Тиймээс хэрэв төрийн захиргааны байгууллага үйл ажиллагааны процессыг журамлан зохицуулах шаардлагатай бол хүний эрх, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг загвар хүснэгтэд заасан асуултанд хариулж үнэлсэн байхаар байна.

ГУРАВ. МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛ БА НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ КОМПАНИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

3.1. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээг батлах мэргэжлийн зөвлөл

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2, 4.3-т байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний асуудлыг зохицуулах, энэ хуулийн 4.1.1, 4.1.4, 7.1.2-т заасан үнэлгээний үр дүн, тайланд дүгнэлт өгөх, үүрэг бүхий байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэргэжлийн зөвлөл /цаашид “мэргэжлийн зөвлөл” гэх/ томилогдон ажиллана гэжээ. Стратегийн үнэлгээний тайланг мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцэж, дүгнэлт гаргах бөгөөд уг дүгнэлтийг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Засгийн газарт танилцуулна.

Хуулийн 6.6-д 6.6.Эрх бүхий мэргэжлийн байгууллага нь боловсруулсан байгаль орчны төлөв байдлын үнэлгээ болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний тайланг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх үнэлгээний асуудал эрхэлсэн мэргэжлийн зөвлөлд хүргүүлж хянуулахаар, мөн хуулийн 7.7-д 7.7.Нөлөөллийн үнэлгээний журам, аргачлалыг Засгийн газар батлах бөгөөд уг журам, аргачлалд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээтэй холбоотой асуудал, үнэлгээний шинжилгээ, хянан магадлагаа болон мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагаа, нийгэм, эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний талаарх зохицуулалтыг тусгана гэсэн байна.

Гэвч Аргачлал батлах тухай /Байгаль орчны стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал, Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний аргачлал/ Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014.04.10 өдрийн А-117 тоот тушаалын 1 дүгээр хавсралт, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014.04.10 өдрийн А-117 тоот тушаалын 2 дугаар хавсралт⁴⁷ нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны А/80 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Байгаль орчны, байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын хүчингүй болсонд тооцох тушаалууд дотор орсон тул хүчингүй болж, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А-117 дугаар тушаалаар зохицуулж байна. Мэргэжлийн зөвлөлийн гишүүдийг сонгох, томилох, чөлөөлөх, тэдгээрийн шалгуур заасан, мэргэжлийн зөвлөлийн ажиллах үйл ажиллагааны журмын зохицуулалт байхгүй байна. Түүнчлэн шаардлагатай тохиолдолд байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ хуулийн 6.3-т заасан хуримтлагдсан нөлөөллийн үнэлгээ хийхэд мэргэжлийн баг томилж болно. Тиймд нийгмийн болон бусад нөлөөллийг тооцох чадавхи тус зөвлөлд байхгүй юм.

Мөн Байгаль орчны аудитын орон тооны бус мэргэжлийн зөвлөлийг байгуулсан байдаг ба Мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг 3 жилийн хугацаагаар томилохоор заасан байна⁴⁸. Мэргэжлийн зөвлөл нь байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын 4, байгаль орчны аудитын төрийн бус байгууллага болон байгаль орчны аудиторын 3 төлөөллөөс бүрдсэн нийт 7 гишүүнтэй байна. Байгаль орчны аудит хийх эрхийг холбогдох хууль, энэ журамд заасан шаардлага, нөхцөлийг хангасан Монгол Улсын хуулийн этгээдэд Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгох ба зөвхөн байгаль орчны аудитын үйл ажиллагаа эрхэлнэ. Орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн гишүүдийн шалгуур журамд зөвлөлийн гишүүдэд тавигдах шаардлагыг заагаагүй учраас байгаль орчны чиглэлээр аудит хийх эрх бүхий гишүүдээс бүрдэнэ. Мөн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг хүлээн авсан шинжээч ажлын 18 өдөрт багтаан үнэлгээний шинжилгээ хийж дүгнэлт гаргах бөгөөд шаардлагатай тохиолдолд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ерөнхий шинжээч уг тайланд үнэлгээний шинжилгээ хийх шинжээчдийн баг томилох ба тус баг нь байгаль орчны чиглэлээр

⁴⁷ <http://www.mne.mn/wp-content/uploads/2017/07/2014.7.pdf>

⁴⁸ <http://www.mne.mn/wp-content/uploads/2019/02/Baigali-ornii-auditiin-juram2019.pdf>

мэргэжсэн байхаар заасан. Тиймд нийгмийн болон бусад нөлөөллийг тооцох чадавхи зөвлөлд байхгүй юм.

Практикт мэргэжлийн зөвлөлд дүгнэлт гаргаж хүргүүлэх БОАЖЯ-ны нэг мэргэжилтэнд батлуулахаар ирүүлсэн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан хуримтлагддаг, ачаалал өндөр учраас үнэлгээг нарийвчилан хянах боломж хязгаарлагдмал байна. Тиймээс өнөөгийн хяналт хариуцлагын асуудлууд үргэлжилсээр байгаа ч иргэдээс ирсэн гомдол шийдвэрлэх ажиллагаа сул, механизмыг ч тус зөвлөлөөс бүрдээгүй байдалтай байна. Мөн нийгмийн нөлөөллийн үнэлгээг хянах, дүгнэх чиглэлээр огт мэргэшээгүй тул одоогийн байдлаар шууд дүгнэлт гаргах чадамжгүй байна.

3.2. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл

Тус зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүн, үйл ажиллагааны аргачлалыг⁴⁹ Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2016 оны 23 тоот тушаалаар баталсан байдаг. Ашгт малтмалын тухай хуулийн 10 лугаар зүйлийн 10.1.9, 48 дугаар зүйлийн 48.4, Газрын тосны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6, 9 дүгээр зүйлийн 9.1.5 болон 9.1.11, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4, Цөмийн энергийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4.5 дах заалтыг тус тус үндсэлж мэргэжлийн дүгнэлт гаргах, зөвлөмж хүргүүлэх үүрэг бүхий Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл байхаар байна. Тиймд ашигт малтмалын баялгийн үнэлгээ, ТЭЗҮ, хайгуулын ажлын үр дүнгийн тайлан болон газрын тосны үйл ажиллагааны төлөвлөгөөг тус зөвлөл батална.

Зөвлөл нь шинжээч томилох эрхтэй ба шинжээч нь геологийн үнэлгээ хийх чадавхи бүхий этгээд байх, гишүүд нь геологи, газрын тос, уул уурхайн болон эдгээр салбарын эдийн засгийн чиглэлийн мэргэжлийн туршлага бүхий зөвлөх ба мэргэшсэн мэргэжилтэн, улс төрийн бус албан тушаалтан байхаар журамд заасан. Мөн зөвлөлийн бүрэлдэхүүнийг уул уурхай, газрын тосны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн буюу сайд батлахаар заасан ба гишүүдийг ирцийн байдлыг харгалзан 30 хүртэлх хувийг жил бүр солихоор зохицуулжээ. Тиймд тус зөвлөл болон шинжээч нь нийгмийн болон бусад нөлөөллийг тооцох чадавхигүй юм.

Мөн тус зөвлөлөөр батлагддаг ТЭЗҮ нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг БОАЖЯ батлахаас өмнө батлагддаг ба тус үнэлгээнд тусгасан нийгэм, эрүүл мэнд, байгаль орчны нөлөөллийн үнэлгээг харгалзан үзэх боломжгүй, Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уухайн төслийн Техник, эдийн засгийн үндэслэл хүлээн авах журмын 6.1.12. Хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн асуудал, аюулгүй ажиллагаа, эрсдэлийн менежмент хэсэгт зөвхөн орон нутагтай хамтран ажиллах зөрдлын төсөвийг тусгаж өгдөг байна.

3.3. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ боловсруулах мэргэжлийн компани

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг энэ заасны дагуу эрх авсан дотоодын аж ахуйн нэгж гүйцэтгэнэ гэж заасан ба хуулийн 12 дугаар зүйлд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.6.6-д заасан тусгай зөвшөөрлийг Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 5-д заасан шаардлагыг хангасан Монгол Улсын аж ахуйн нэгжид байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно гэжээ. Тухайн аж ахуйн нэгж нь байгаль орчны талаарх хууль тогтоомжийн мэдээллийн сантай, материаллаг бааз, боловсон хүчний хангамж болон байгаль орчны үнэлгээ хийх мэргэжлийн чадавхитай байхаар хуулийн 12 дугаар зүйлд заасан байна. Аж ахуйн нэгжид байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эрхийг мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр гурван жилийн хугацаатай олгоно. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эрх бүхий

⁴⁹ <http://www.mmhi.gov.mn/uploads/file/3d694e66524d40319ee9c3dba528c9d5972da627.pdf>

аж ахуйн нэгж нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийхэд үндсэн үйл ажиллагаагаа чиглүүлнэ.

Ашигт малтмалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-т төсөл хэрэгжүүлэгч нь холбогдох эрх бүхий байгууллагаар баталгаажсан техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны өнөөгийн төлөв байдлын тодорхойлолт, тухайн сум, дүүргийн Засаг даргын санал болон холбогдох бусад баримт бичгийг бүрдүүлэн энэ хуулийн хавсралтад заасан ангиллын дагуу байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл байгаль орчны албанд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлгэхээр заасан. Хуулийн 6 дугаар зүйлийн 6.6-д эрх бүхий мэргэжлийн байгууллага нь боловсруулсан байгаль орчны төлөв байдлын үнэлгээ болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний тайланг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх үнэлгээний асуудал эрхэлсэн мэргэжлийн зөвлөлд хүргүүлж хянуулна гэжээ.

Мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн аж ахуйн нэгжийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эрхийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр гурван жилээр сунгана. Тиймд Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эрх бүхий аж ахуйн нэгж нь өөрсдийн боловсон хүчний чадавхиа харуулахын тулд зарим нэг нийгмийн болон эрүүл мэндийн мэргэжилтнийг багтаа оруулдаг боловч нийгмийн нөлөөллийг тооцох аргачлал байхгүйгээс нөлөөллийг бүрэн үнэлдэггүй байна.

Мөн мэргэшсэн байгууллагын эрх нь зөвхөн байгаль орчны чиглэлээрх үнэлгээг гүйцэтгэхэд чиглэгдсэн, нийгмийн нөлөөллийн үнэлгээг хийх чадавхи, мэдлэг, дадлага туршлагагүй учраас хүний нөөцийн мэргэшсэн байдал нь нийгмийн нөлөөллийн үнэлгээ боловсруулах хэмжээнд хүрч чадахгүй байна.

ДӨРӨВ. ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭХ, ХЯНАН МАГАДЛАГАА

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль⁵⁰ 1995 онд батлагдсан байдаг. Хуулийн зорилт нь иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж өргөдөл, гомдол гаргах, түүнийг байгууллага, албан тушаалтнаас шийдвэрлэх үйл ажиллагааг зохицуулахаар заасан. Уг хуулийн 11 дүгээр зүйлийн 2-т зааснаар иргэн, хуулийн этгээд, байгууллага төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэртэй холбоотой гомдлыг түүнд холбогдож байгаа байгууллага, албан тушаалтныг харьяалсан дээд шатны байгууллага, албан тушаалтанд, харьяалсан дээд шатны байгууллага, албан тушаалтан байхгүй бол тухайн захиргааны актыг гаргасан байгууллагад гаргах ба эсхүл шүүхэд гаргаж шаардлагатай.

Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон орон нутгийн төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд 2019 оны гуравдугаар улиралд (зөвхөн) иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээг Засгийн газрын хуралдаанд танилцуулсаныг харахад төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд нийт 569,209 иргэн хандаж санал, хүсэлт, гомдол, шүүмжлэл гаргаснаас 557,698 иргэний өргөдлийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж хариу өгсөн нь 98 хувийн үзүүлэлттэй байна. Мөн 8590 өргөдлийг шийдвэрлүүлэхээр холбогдох байгууллага албан тушаалтанд шилжүүлж, 3080 өргөдлийг хугацаа хэтрүүлэн шийдвэрлэжээ. Өргөдлийн дийлэнх буюу 64 хувь нь орон нутгаас ирүүлсэн нийгмийн халамж, цалин хөлс, газрын харилцаа, орон сууц, санхүүгийн дэмжлэг хүссэн асуудлаар гаргасан өргөдөл гомдол байна гэжээ. Харин Засгийн газрын гишүүд болон яам, агентлагийн удирдлагад нийт 333,686 өргөдөл, гомдол иргэдээс ирүүлсэн бөгөөд мөн орон нутгийн иргэдийн гомдол зонхилсон байна. Төрийн байгууллагад гаргах гомдол, мэдээллийг биечлэн, бичгээр, цахим хаягаар,

⁵⁰ <https://www.legalinfo.mn/law/details/294?lawid=294>

факсаар, утсаар авах боломжтой ба өргөдөл, гомдлыг хуанлийн 30 хоногийн хугацаанд, шаардлагатай бол дахин 30 хоног сунгаж хариу мэдэгдэх үүрэгтэй. Саналын шинжтэй өргөдлийн хариуг 90 хоногийн хугацаанд шийдвэрлэхээр Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасан.

2005 оны Засгийн газрын 67 тоот⁵¹ захирамжаар төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагад иргэдээс ирүүлсэн болон шийдвэрлүүлж хариу өгүүлэхээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас шилжүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд дүн шинжилгээ хийж, мэдээлэл, танилцуулга бэлтгэн улирал, хагас жилийнхийг 4, 7, 10 дугаар сарын 10-ны дотор, жилийн эцсийнхийг дараа оны 1 дүгээр сарын 10-ны дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлэхээр заасан.

Хувийн хэвшлийн эрдэс баялгийн салбарын төсөл, дэд бүтцийн төсөл хэрэгжүүлэгч компанийн үйл ажиллагаатай холбоотой гомдлыг асуудлаас хамаарч төрийн холбогдох захиргааны байгууллагад гаргаж шийдвэрлүүлэхээр байна. Хэдийгээр зарим томоохонд тооцогдох компаниуд гомдол мэдээлэх, шүгэл үлээх дотоод сувгийг бий болгосон ч бүх аж ахуйн нэгж гомдол хүлээн авах суваггүй, улсын бүртгэлийн нээлттэй мэдээллийн сангийн⁵² бүртгэлтэй хаяг дээр байхгүй, холбоо барих боломжгүй байх тохиолдол орон нутагт элбэг гарч байна.

Төрийн зохицуулагч байгууллагууд аж ахуйн нэгжээс гомдол мэдээлэл хүлээн авах суваг бий болгож, орон нутгийн иргэд, байгууллага, хуулийн этгээдийн гомдол, хүсэлт, мэдээллийг хүлээн авах, шийдвэрлэх, мэдээллийг ил тод болгох шаардлага хууль тогтоомжиор ногдуулаагүй харин хуулийн этгээдийн төрийн байгууллагад гаргах гомдлын асуудлыг хуульчилсан байна. Жишээ нь:

- 1) Ашигт малтмалын тухай хууль 37.2.Байгаль орчны албанаас зөвшөөрөл авалгүйгээр ашигт малтмал эрэх, хайх, энэ хуулийн 35.4-т заасан комиссын шийдвэргүйгээр ашигт малтмал ашиглах үйл ажиллагаа эхлэхийг хориглох бөгөөд тухайн асуудлаар маргаан гарвал мэргэжлийн хяналтын байгууллагад гомдол гаргаж болно, 56.5.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 56.4-т заасны дагуу тусгай зөвшөөрлийг цуцалсан шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргах эрхтэй, 62.7.Маргаанд оролцогч тал төрийн захиргааны байгууллагын шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргаж болно хэмээн зааснаар хязгаарлагдаж байна.
- 2) Газрын тосны тухай хууль, 43.1-т Газрын тостой холбогдсон үйл ажиллагааны явцад үүсэх эд хөрөнгийн болон бусад маргааныг төрийн захиргааны байгууллага, гэрээлэгч хэлэлцээрийн журмаар шийдвэрлэж чадаагүй тохиолдолд гомдлоо арбитрын хэлэлцээртэй бол арбитрын журмаар, бусад тохиолдолд шүүхэд гаргаж болно.
- 3) Авто замын тухай хууль, 29.2.2.авто замын арчлалт, засвар, хөдөлгөөний аюулгүй байдлын талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах, шаардлага тавих;
- 4) Хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай хууль, **44 дүгээр зүйлийн 44.1.**Хөгжлийн бэрхшээлтэй хүн хуульд заасан эрх нь зөрчигдсөн гэж үзвэл иргэн, хуулийн этгээдээс зөрчлийг арилгуулахыг шаардах, холбогдох хуульд заасны дагуу гомдол, нэхэмжлэл гаргах эрхтэй, 44.2.Иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллага хуульд заасан эрхийг хязгаарласан, ялгаварлан гадуурхах үйл ажиллагааг явуулсан гэж үзвэл хөндөгдсөн эрхээ хамгаалуулахаар гомдол гаргах эрхээ шууд болон төлөөллөөрөө дамжуулан хэрэгжүүлнэ.
- 5) Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай 29.5.Ажил олгогч энэ зүйлийн 29.1, 29.2-т заасан үүргээ биелүүлээгүй, эсхүл үйлдвэрлэлийн осол гарсан, хурц хордлогод өртсөн дүгнэлтийг иргэн, ажилтан зөвшөөрөхгүй бол гомдлоо хөдөлмөрийн мэргэжлийн хяналтын байгууллага болон шүүхэд гаргаж холбогдох хуулийн дагуу шийдвэрлүүлнэ. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаанаас болж өртсөн иргэн, хуулийн этгээдийн асуудлыг зохицуулаагүй.

⁵¹ <https://www.legalinfo.mn/law/details/3022>

⁵² www.opengovernment.mn

- 6) Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 27 дугаар зүйлийн 11/ байгаль орчны тухай хууль тогтоомжийг зөрчсөн шийдвэр гаргасан байгууллага, албан тушаалтны шийдвэрийг хүчингүй болгохыг шаардах, эсхүл дээд шатны байгууллагад гомдол гаргаж, шийдвэрлүүлэх. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн **41 дүгээр зүйлд заасан мэдээллийн санг хэрэглэгчийн эрх, үүрэгт 2/мэдээллийн сангийн үйл ажиллагаа болон өгөгдөл, мэдээллийн талаар гомдол гаргахаар хязгаарлагдсан байна.**

Гэвч бодит байдал дээр иргэдээс гомдлыг тухайн зөрчил гаргагч аж ахуйн нэгжид шууд гаргаж, шийдвэрлүүлэх⁵³, тухайн гомдлын шийдвэрлэлтийг төрөөс хянах механизмыг бүрдүүлэх сонирхол давамгайлж байна.

ТАВ. МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ӨМНӨ ХҮЛЭЭСЭН ҮҮРЭГ, ОЛОН УЛСЫН СТАНДАРТ, ПРАКТИКААС ЗАЙЛШГҮЙ АВЧ СУУЛГАХ ҮНДСЭН КОНЦЕПЦИ

Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн хоёрт “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ” гэж заасан. Олон улсын эрх зүйн болон үндэсний эрх зүйн харилцан хамаарлын асуудлыг олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчлэх ба гэрээнээс үүсэх үүргийг ёсчлон биелүүлэх талаар Үндсэн хуулийн 10 дугаар зүйлд заажээ.

Манай улс 100 гаруй олон улсын олон талт гэрээ, хэлэлцээрт нэгдэн орж, соёрхон баталсан байдаг ба тэдгээрт хүний эрхийг хангах асуудлыг нэг тэргүүнд чухалчилсан байдаг. Түүнчлэн, одоогоор хүчин төгөлдөр үйлчилж буй хуулиудын 300 гаруй нь “Монгол улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө” гэх заалт агуулах бөгөөд энэ нь Монгол улс олон улсын эрх зүйн давуу хүчинтэй байх буюу монист хандлага баримталдагийг нотлож байгаа юм⁵⁴. Бид дэлхийн нийгэмлэгийн гишүүн улсын хувьд НҮБ зэрэг хэд хэдэн олон улсын байгууллагын өмнө хариуцлага хүлээж, соёрхон баталсан гэрээ конвенцийн хэрэгжилтийг хангах, хөгжлийн байгууллагуудын өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх үүрэгтэй юм,

Монгол Улсын Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт, хэлэлцүүлэг (UPR), НҮБ 2020 он

2020 оны 5 дугаар сард зохион байгуулагдсан НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн 36-р хуралдаанаар Монгол Улсын Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт, хэлэлцүүлэг (UPR)⁵⁵-г хийсэн. Уг тайлангийн үеэр НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газрын тайлангийн IV. Олон улсын хүмүүнлэг болон хүний эрхийн зарчмыг хэрэгжүүлэх үүргийн биелэлт бүлгийн Хөгжил, байгаль орчин, бизнес ба хүний эрх хэсгийн 16-р зүйлд “Эдийн засаг, нийгэм ба соёлын эрхийн хороо нь уул уурхайн төслүүдийн үйл ажиллагаанаас болж малчдын эдийн засаг, нийгэм, соёлын эрхэд мөрөг нөлөөлөл бий болж байгаад сэтгэл зовниж байгаагаа илэрхийлсэн. Түүнчлэн, өв залгамжлан авч үлдсэн малчдын нутаг уул уурхайн эрчимтэй явагдсанаас шалтгаалж нүүдэлчин уламжлалтай малчдын бэлчээр, талбай, цэвэр усны нөөц хорогдож, хомсдон, иргэдээс урьдчилан мэдэгдэх, зөвшөөрөл авах ажиллагааг лиценз олгохоосоо өмнө аваагүйгээр нутаг дэвсгэрийг компаниудад олгосон, мөн уул уурхайн компаниудаас малчдад нөхөн олговор олгох тохиолдол хангалтгүй байгааг тус хороо эмзэглэж байгаагаа илэрхийлсэн. Тиймээс тус хорооноос хүний эрх ба байгаль орчны нөлөөллийн үнэлгээг уул уурхайн тусгай зөвшөөрөл олгохоосоо өмнө гүйцэтгэдэг болох, мөн тухайн

⁵³ 2020.07.05-06 хооронд Дорноговь аймгийн Айраг, Даланжаргалан сумын иргэд, малчидтай хийсэн ярилцлага.

⁵⁴ Сүүлийн жилүүдэд олон улсын шинжтэй эрх зүйн маргаанд олон улсын эрх зүйн уламжлалт субъект болох улсаас гадна Засгийн газар, төрийн өмчит болон бусад хуулийн этгээд, хувь хүн, төрийн бус байгууллага зэрэг төрөл бүрийн субъект татагдан орох асуудал нь онолын хүрээнээс хальж эрх зүйн практикт олонтоо тохиолдох болсон. Олон улсад үүссэн маргаанаас харахад уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулах хуулийн этгээд, үйл ажиллагаатай холбоотой маргаан зонхилж байна.

⁵⁵ <https://documents-dds-ny.un.org/doc/UNDOC/GEN/G20/061/32/PDF/G2006132.pdf?OpenElement>

төслийн үйл ажиллагааны нөлөөлөлд өртөж болзошгүй бүх талын хамаарал бүхий этгээдийг тухайн үнэлгээнд идэвхитэй оролцох нөхцөлийг бүрдүүлэх шаардлагыг Монгол Улсад тавьж байна.”⁵⁶ гэсэн нь нийгмийн нөлөөллийн үнэлгээг хийх шаардлага, түүгээр үл барам тухайн нийгмийн нөлөөллийн үнэлгээг олон улсын зарчмын дагуу байгаль орчны нөлөөллийн үнэлгээтэй хамтатган хийж гүйцэтгэх хэрэгцээ нэгэнт тулгарсныг илтгэх, анхаарал татахуйц дүгнэлт гаргасан байна.

Цаашлаад дээрх тайлангийн Цөөнх ба уугуул иргэд хэсэгт “Арьс өнгөөр ялгаварлан гадуурхахтай тэмцэх хорооноос Монгол Улс Ашигт малтмалын тухай хууль, Тусгай зөвшөөрлийн тухай хууль болон Захиргааны ерөнхий хуульдаа өөрчлөлт оруулж, иргэдийн урт удаан хугацаанд аж төрж, уламжлалаар өвлөн авсан газар нутаг дээр нь уул уурхайн тусгай зөвшөөрөл, ашиглалтын эрхийг олгохоос өмнө ялангуяа цаа буга маллах малчид болон бусад үндэсний цөөнхийн сонсох эрхийг хангах, зөвшилцөх, хэлэлцүүлэгт оролцуулах зэргээр эрхийг хангаж, хамгаалах шаардлагатай”⁵⁷ гэж анхааруулсан.

Европын комиссын Монгол Улсын Тогтвортой хөгжил, сайн засаглалын чиглэлээрх олон улсын конвенцийн хэрэгжилтийн дүгнэлт тайлан, 2020 он

2020 оны 2 дугаар сарын 10-нд Европын парламент ба Европын зөвлөлийн хамтран гаргасан Монгол Улсын 2018-2019 оны Тогтвортой хөгжил, сайн засаглалын чиглэлээрх олон улсын конвенцийн хэрэгжилтийн дүгнэлт⁵⁸-д “Байгаль орчин. 2017 онд НҮБ-ын Хүний эрх ба байгаль орчны тусгай илтгэгч байгаль орчны стандарт, байгаль орчныг хамгаалах чиглэлээр нэмэлт арга хэмжээ авах шаардлагатай, томоохон алтны төслүүдийн нарийвчилсан үнэлгээг хийх, Байгаль орчны Омбудсман томилох шаардлагатай байгааг онцлон тэмдэглэсэн...” гэжээ.

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын хэрэгжилт хэсэг (International Covenant on Economic, Social and Cultural Rights (CESCR))-т “2015 оны сүүлийн дүгнэлтийг харахад Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын хороо уул уурхайгаас малчдын эдийн засаг, нийгэм, соёлын эрхэд үзүүлж буй сөрөг нөлөөлөл нь сэтгэл зовнихоор байна. Түүнчлэн бэлгийн чиг хандлага, жендэр, хөгжлийн бэрхшээлээр ялгаварлан гадуурхахын эсрэг хууль тогтоомж бий болгох шаардлагатай. Тиймд Монгол Улс эрх зүйн зохицуулалтаа пактын шаардлагад нийцүүлэх”⁵⁹, Байгаль орчныг хамгаалах, Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын конвенциудын хэрэгжилт хэсэгт “Уул уурхайн салбарт ил тод байдлыг хангах нь хангалтгүй... уурхайд ажилладаг “нинжа” нарын үйл ажиллагаа байгаль орчинд сөргөөр нөлөөлж, хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийг хөхиүлэн дэмжиж байна. 2017 онд НҮБ-ын Хүний эрх ба байгаль орчны тусгай илтгэгч анх удаа Монгол Улсад ажилласан байдаг. Тэрбээр Монгол Улс байгаль орчныг хамгаалах ажиллагаандаа ахиц гаргах шаардлагатай бөгөөд уул уурхай болон нүүрс хэрэглээнээс үүдэх сөрөг үр дагавар, нөлөөллийг бууруулах шаардлагатай...томоохон алтны уурхайд үнэлгээ хийж үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах хэрэгтэй гэдгийг анхааруулж байна. Одоогийн хүчин төгөлдөр хууль тогтоомжоор Байгаль орчны Омбудсман томилж, байгаль орчны мэдээллийн ил тод байдлыг хангах болон

⁵⁶ Report of the Office of the United Nations High Commissioner for Human Rights, 2020, pg 3, 16. The Committee on Economic, Social and Cultural Rights expressed concern at the adverse impact of mining projects on herders’ economic, social and cultural rights. It also expressed concern that nomadic herders’ rights to their pasture, hay land and water resources were continuously infringed owing to mining activities on their traditional lands; free, prior and informed consent of herders was not obtained when licences for mining in their traditional territory were granted; and compensation to herders affected by mining projects was not adequate. The Committee urged Mongolia to carry out human rights and environmental impact assessment processes before the mining licences were granted and to ensure that all stakeholders affected by such projects effectively participated in the assessment processes.

⁵⁷ Report of the Office of the United Nations High Commissioner for Human Rights, 2020, pg 10, 72. The Committee on the Elimination of Racial Discrimination also recommended that Mongolia amend the Minerals Law, the Law on Licensing and the General Administrative Law to ensure that the rights of ethnic minorities, in particular those practising reindeer herding, to meaningful consultation, prior to the issuance of mining licences or exploration permits on lands that they traditionally used or occupied, were guaranteed.

⁵⁸ <https://ec.europa.eu/transparency/regdoc/rep/10102/2020/EN/SWD-2020-23-F1-EN-MAIN-PART-1.PDF>

⁵⁹ The EU Special Incentive Arrangement for Sustainable Development and Good Governance (“GSP+”) assessment of Mongolia covering the period 2018 – 2019, Brussels, Feb 10 2020: <https://ec.europa.eu/transparency/regdoc/rep/10102/2020/EN/SWD-2020-23-F1-EN-MAIN-PART-1.PDF>

гомдол шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай” гэсэн байна. НҮБ-ын Хүний эрх ба байгаль орчны тусгай илтгэгчийн 2018 онд гаргасан тайланд агаарын бохирдол, эрдэс баялаг ба уул уурхайн салбар, байгаль орчныг хамгаалах, мэдээллийн ил тод байдлыг хангах болон олон нийтийн оролцоог шийдвэр гаргах ажиллагаанд хангах, шийдвэрлэх арга хэмжээг бий болгох зэрэг нарийвчилсан зөвлөмж тусгагджээ.

Монгол Улсад нийгмийн хариуцлага гэсэн ойлголт хууль эрх зүйн баримт бичигт сууж өгөөгүйгээс нийгмийн нөлөөллийг үнэлэх аргачлалгүй явж ирсэн байдаг. Нийгмийн хариуцлагыг MNS ISO 26000:2012 стандартыг удирдамж болгон ажиллах хэмээн ойлгодог боловч, уг стандартыг шууд авч ашиглах аргачлал одоогоор алга. Монгол Улсын аж ахуйн нэгж, байгууллагууд төрийн байгууллагад зориулан тайлан боловсруулдаг жишигтэй. Тиймээс төрөөс хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд тодорхойлсон тайлагналтаар хязгаарлагддаг.

Харин Сингапур, Хонг Конг, Индонез, Канад, Австрали (цөөн хэдээс бусад) зэрэг улсын жишээг харахад Нийгмийн нөлөөллийн үнэлгээг батлахад төрөөс аливаа шаардлага тавьдаггүй, компаниуд өөрсдийн дотоод зохицуулалтаар баталж байна. Энэ нь олборлох салбарт үйл ажиллагаа явуулах нь санхүүжилт ихээхэн шаардагдах ба мэргэшсэн санхүүжүүлэгчид нийгэм, байгаль орчинд ээлтэй, эрсдэл бага, эрсдэлийг бууруулж, арилгах чадавхитай төсөлд санхүүжилтээ олгох зорилготой, төсөл хэрэгжүүлэгчид тавьдаг шаардлага байна. Өөрөөр хэлбэл, төрийн байгууллагаас шаарддаг, баталдаг талаарх мэдээлэл дээрх 5 улсын төрийн байгууллагуудын нээлттэй эх сурвалжид байхгүй байна. Улмаар компаниуд өөрийн хийсэн ажлын чанар, нэр хүндээрээ зах зээлд өрсөлддөг ба нөлөөллийн үнэлгээг хараат бус шинжээчид судлан дүгнэлт гаргахыг мөн санхүүжүүлэгчээс шаарддаг. Нийгмийн нөлөөллийн үнэлгээний нэгэн адил техник эдийн засгийн үндэслэлийг төрийн зохицуулагч байгууллагаас тавьсан шаардлагын дагуу гэхээсээ харин санхүүжүүлэгчийн шаардлагын дагуу боловсруулж, нийгмийн хариуцлагаараа өрсөлдөж санхүүжилт босгох хандлага төлөвшсөн гэдгээрээ манай улсаас ялгаатай.

5.1. Нийгмийн нөлөөллийг тооцоолоход чиглэгдсэн олон улсын суурь бодлого, зарчим

Эрдэс баялгийн салбарт төсөл хэрэгжүүлэхэд зардал ихээхэн гардаг бөгөөд тухайн төсөл хэрэгжих орон нутгийн уугуул иргэд, тэдний амьжиргаа, орлого, өв соёл, ахуй амьдралд шууд нөлөөлөхөөс гадна эрүүл мэнд, боловсрол, аюулгүй байдал зэрэгт шууд болоод дам байдлаар нөлөөлөх магадлалтай. Эдийн засгийн үйл ажиллагааг нийгмийн хариуцлагатай уялдуулах, нийгмийн нөлөөллийг үнэлэх, тооцоолох, хариуцлагатай үйл ажиллагаа эрхлэхийг дэмжих хэд хэдэн баримт бичиг, санаачилга, аргачлалыг олон улсын хөгжлийн байгууллагууд баталж, хэрэгжүүлэх зөвлөмж, гарын авлага гаргасан байдаг.

Олон улсын практикаас зайлшгүй авч хэрэгжүүлэх үндсэн зарчмууд дараах нийтлэг зорилго, ач холбогдолтой. Үүнд:

1. Хүний эрхийг хангах, хамгаалах,
2. Нийгмийн хариуцлага, тогтвортой хөгжлийг дэмжих,
3. Ирээдүйд байгаль орчин, нийгэм, эдийн засаг, эрүүл мэндэд учирч болох эрсдэлийг тооцоолох, тэдгээрийг бууруулах, арилгах,
4. Шинэ, дэвшилтэт техник, технологи ашиглаж байгалийн нөөцийг зохистой ашиглах, хэмнэх,
5. Хүний хөдөлмөрийг бодитой, шударга үнэлэх,
6. Төр, иргэн, аж ахуйн нэгжийн харилцан ойлголцолыг бий болгох, бэхжүүлэх,
7. Оролцогч талуудын оролцоог хангах, тэдний санал бодолд түшиглэн үйл ажиллагаагаа төлөвлөх, шийдвэр гаргах,
8. Өрсөлдөх давуу талыг нэмэгдүүлж, зардал бууруулж, урт хугацааны тогтвортой орлогыг бий болгох,

9. Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийг татах үнэлэмж нэмэгдүүлэх, томоохон санхүүжилт шаардлагатай төслүүдийг санхүүжүүлэх, хөрөнгө босгох,
10. Компанийн эрсдэлийг зөв тооцож, зардлыг бууруулах,
11. Ажилтнуудын бүтээмжийг нэмэгдүүлэх, ёс зүйн дэмжлэг бий болгох,
12. Нэр хүндийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх

Тэдгээрийн хамрах хүрээ, агуулгуудыг харьцуулж дотоодын санаачилгыг сайжруулах боломжтой. Тиймээс, уул уурхайн тогтвортой хөгжил, хариуцлагатай уул уурхайтай холбоотой судалгаанууд, дэд бүтцийн томоохон төсөл, хөтөлбөрийн үнэлгээ⁶⁰ зэрэг баримт бичигт хамгийн олон удаа иш татагдсан олон улсын 23 стандарт заасан баримт бичиг, санаачилгууд (Хүснэгт 5)-д дүгнэлт хийн, нийгмийн нөлөөллийн үнэлгээ боловсруулах зохицуулалт бий болгох, түүний аргачлалыг боловсруулахад харгалзаж үзэх бодлого, хамрах хүрээг тодорхойлов.

5.2. Нийгмийн нөлөөллийг үнэлэхтэй холбогдох олон улсын стандарт

Хүснэгт 10. Олон улсын хүний эрх, байгаль орчин, нийгмийн стандарт, зарчмын жагсаалт (олборлох салбар)

№	Баримт бичиг/ Стандартын нэр
1	Хүний эрхийн түгээмэл тунхаглал, <i>Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей 1946</i> <i>(Universal Declaration of Human Rights, UN General Assembly, 1946)</i>
2	Байгаль орчны асуудлаар мэдээлэл авах, шийдвэр гаргахад оролцох, эрхээ хамгаалуулах талаарх ААРХУС-ын конвенц, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс 1998 <i>(Convention on Access to Information, Public Participation in Decision-making and Access to Justice in Environmental Matters, UNECE 1998)</i>
3	Уугуул болон омгийн хүмүүсийн тухай 169 конвенци, Олон улсын хөдөлмөрийн байгууллага 1989 <i>(Convention 169, ILO 1989)</i>
4	Байгаль орчин ба хөгжлийн тухай Риогийн тунхаг, НҮБ-ын Байгаль орчин ба хөгжлийн хурал 1992 <i>(Rio Declaration on Environment and Development, UN Conference on Environment and Development 1992)</i>
5	Тогтвортой амьжиргааны арга зүй /ТАА3/, Хөдөөгийн тогтвортой амьжиргааны Зөвлөх хороо 2000 <i>(Sustainable Livelihoods Guidance Sheets, Sustainable Rural Livelihoods Advisory Committee 2000)</i>
8	Даян дэлхийн гэрээ, НҮБ 2000 <i>(UN Global Compact, UN 2000)</i>
9	Даян дэлхийн тайлагналтын санаачилга, БО хариуцлагатай санаачлага, Tellus, НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр 2014 <i>(GRI Global Reporting Initiative, Ceres (formerly the Coalition for Environmentally Responsible Economies) and Tellus Institute, with the support of the United Nations Environment Programme (UNEP) 2014)</i>
10	Эквадорын зарчим, 94 санхүүгийн байгууллагууд 2003 <i>(The Equator Principles, 94 financial institutions 2003)</i>
11	ОУСК-ийн Байгаль орчин, Нийгмийн тогтвортой байдлын гүйцэтгэлийн стандарт, ОУСК 2012

⁶⁰ Монгол Улс ТТХТ төсвийн зардал ба эрсдэлийг удирдах нь тайлан, ОУВС Төрийн өмчийн концессын төслийн аудитын үнэлгээ 2018

	<i>(Performance Standards on Environmental and Social Sustainability, IFC 2012)</i>
12	Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний зааварчилгаа, Европын Сэргээн босголт, хөгжлийн банк (ЕСБХБ) 1998 <i>(Guidance on ESIA, EBRD 1998)</i>
13	ISO 26000 - Нийгмийн хариуцлагын стандарт, ОУСБ 2010 <i>(Corporate social responsibility standard, ISO 2010)</i>
14	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын стандарт 2019, ОУИТБС <i>(Extractive Industries Transparency Initiatives Standards 2019 (EITI))</i>
15	Хариуцлагатай уул уурхайн баталгаажилтын стандарт, Хариуцлагатай уул уурхайн баталгаажилтын санаачлага 2016 <i>(Standart for Responsible Mining IRMA-SDT-001 Draft v2.0, IRMA 2016)</i>
16	Хариуцлагатай уул уурхайн индекс, Хариуцлагатай уул уурхайн нийгэмлэг 2020 <i>(Responsible Mining Index Methodology, Responsible Mining Foundation 2020)</i>
17	10 зарчим, Уул уурхай ба металлын ОУ-ын зөвлөл 1998, 2003, 2020 <i>(10 principles, ICMM 1998, 2003, 2020)</i>
18	ОУ-ын Нийгмийн хариуцлага 8000, 2008 <i>(Social Accountability International (SAI) 8000, 2008)</i>
19	Үндэстэн дамнасан корпорациудын удирдамж, Эдийн засгийн хамтын ажиллагаа ба хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ) 1976 <i>(OECD Guidelines for Multinational Enterprises 1976)</i>
20	Аюулгүй байдал ба хүний эрхийн сайн дурын зарчим, АНУ, ИВУИНВУ, олборлох салбарын компаниуд ба ИНБ-ууд хамтарсан 2000 <i>(Voluntary Principles on Security and Human Rights, Voluntary Principles Initiative (VPI), the US and UK, a group of extractive companies and NGOs 2000)</i>
21	Хариуцлагатай уул уурхайн санаачилгын тунхаг бичиг, Уул уурхайн ассоиаци 2006 он
22	Бизнес ба хүний эрхийн зарчим, НҮБ 2005 <i>(UN Guiding Principles on Business and Human Rights, UN E/CN.4/RES/2005/69 2005)</i>
23	Уул уурхайн тогтвортой хөгжлийн замын зураг: Атлас, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр 2016 <i>(Mapping Mining to the Sustainable Development Goals: An Atlas, UNDP 2016)</i>

Олборлох салбар ба олон улсын хүний эрхийн стандарт, практикт суулгах зарчмуудыг Хавсралт 3-аас дэлгэрэнгүй харна уу.

ЗУРГАА. ЗӨВЛӨХ БАГИЙН САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Энэхүү сэдэвчилсэн санал, зөвлөмжийг Нийгмийн нөлөөллийн үнэлгээний аргачлалыг батлан, хэрэгжүүлэх шийдвэр гаргахад тус дөхөм болох зорилгоор боловсруулав.

Хүснэгт 11. Зөвлөх багийн дэвшүүлж буй 17 санал зөвлөмж

№	Ерөнхий нөхцөл	Санал
1. Туршилт (тест)		
	- Нийгмийн нөлөөллийн үнэлгээний Зөвлөх багийн боловсруулсан аргачлалын төслийг туршиж үзэх шаардлагатай.	- Хэлэлцүүлэгээс гарсан санал, зөвлөмжийн дагуу уг аргачлалыг дунд хэмжээний төслийн нийгмийн нөлөөллийн үнэлгээнд ашиглаж, орон нутагт туршилт хийх; - Туршилтыг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний эрх бүхий компани дангаараа (энэ удаа) гүйцэтгэх боломжгүй бөгөөд аргачлалыг сайжруулах зорилгоор нийгмийн нөлөөллийн үнэлгээний аргачлалыг боловсруулсан Зөвлөх багийн тусламжтай, хамтран гүйцэтгэх нь зүйтэй байна. - Хамтарсан баг нь туршилтын үнэлгээний бүхий л процессын тэмдэглэл хөтөлж, аргачлалын дагуу үнэлгээг боловсруулахад тулгамдаж буй бэрхлээлийг тогтоох, аргачлалын төслийг сайжруулах саналыг Ажлын хэсэгт уламжлах нь зүйтэй юм.
2. Олон нийтийн хэлэлцүүлэг хийх		
	- Захиргааны ерөнхий хууль, Хууль тогтоомжийн тухай хуулиар нийтэд хамаарах журмын зохицуулалтыг батлахдаа олон нийтээр хэлэлцүүлсэн байх шаардлагатай.	- Нийгмийн нөлөөллийн үнэлгээний аргачлалын төслийг туршилтын хугацаанд тус төслийн олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, талуудын саналыг нэмж авах нь сайн туршлагад тооцогдоно.
3. Журам батлах		
	- БОАЖЯ-наас БОНБУ-ний аргачлалыг боловсруулан батлуулахаар ХЗДХЯ-д илгээсэн байна.	- Журам батлах түргэвчилсэн арга. Уг аргачлалд нийгмийн нөлөөллийн үнэлгээний хэсгийг тусгаж, хамтад нь батлуулж болно. Ингэснээр БОНБУ-ний аргачлалын хамт нийгмийн нөлөөллийн үнэлгээний аргачлал батлагдах магадлалтай ч нийгмийн нөлөөллийн үнэлгээг хэрэгжүүлэх зохицуулалтгүй юм. Журам батлагдсан тохиолдолд төрийн эрх бүхий байгууллагаас журмын хэрэгжилтийг хянах, хариуцлага тооцох нөхцөл бүрдсэн байх учраас түргэвчилсэн журмаар журмыг батлах шаардлагатай эсэхийг Ажлын хэсэг шийдвэрлэх нь зүйтэй.
	- Журам батлах эрх хэмжээ нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 7 дугаар зүйлийн 7.7-д зааснаар ЗГ-т олгогдсон тул журмыг ЗГ батална.	- Түр журам. Журмыг “түр журам” хэлбэрээр батлах, турших, хэрэгжилтийг нэг жилийн туршилтын хугацаанд хянаж, зохицуулалтыг илүү боловсронгуй

<p>- Журмын зохицуулалт, аргачлалын хэрэгжилтэд тулгарч болох хүндрэл, бэрхшээлийг харгалзан хариуцлагыг шууд тооцох нь цаашдын хэрэгжилтэд сөрөг үр дагавар үзүүлэх магадлалтай.</p>	<p>болгон, сайжруулж үндсэн журмыг туршилтын хугацаа дууссаны дараа батлах нь зүйтэй.</p> <ul style="list-style-type: none"> - ЗГ нь тус үүргээ асуудлыг хамтарч хариуцах салбарууд болох УУХҮЯ, БОАЖ болон ХНХ-ын сайд нарт үүрэг болгох шаардлагатай. - Түр журмыг хөдөлмөр, нийгмийн хамгаалал, уул уурхай, байгаль орчны асуудал эрхэлсэн сайд нар хамтарсан тушаалаар батлах нь зүйтэй. Мөн түр журам баталж, хэрэгжилтийг туршилтын хугацаанд хянах үүрэг хариуцлагыг тодорхой заах нь зүйтэй. - Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 7 дугаар зүйлийн 7.7-д “Нөлөөллийн үнэлгээний журам, аргачлал” хэмээн тусгагдсан тул байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг хамтатгах тохиолдолд нэршлийг “Нөлөөллийн үнэлгээний журам, аргачлал” гэж өөрчлөх магадлалтайг анхаарах.
<p>- Журам батлахад Хууль тогтоомжийн тухай хууль, түүний аргачлалын дагуу дараах шаардлага тавьдагийг харгалзах. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Хууль тогтоомжид журмын нэрийг дурьдсан байх, ✓ Журмын төслийн нөлөөллийн шинжилгээ боловсруулах, ✓ Журмын төслийн танилцуулгыг боловсруулах 	<ul style="list-style-type: none"> - Журамд тавигдах ерөнхий шаардлага. Хууль тогтоомжид тавигдсан аргачлал, шаардлагын дагуу Нийгмийн нөлөөллийн үнэлгээний журмын төслийг боловсруулах зөвлөх багийг сонгож, гүйцэтгүүлэх нь зүйтэй байна. - Нийгмийн нөлөөллийн үнэлгээний аргачлал боловсруулахтай холбогдуулан боловсруулсан Эрх зүйн зохицуулалтын судалгаанд журмын Танилцуулга, холбогдох судалгаа, зөвлөмжийг удиртгал болгох нь тус дөхөмтэй. - Нийгмийн нөлөөллийн үнэлгээний бүхий л асуудлыг тусгах, байгаль орчны нөлөөллийн үнэлгээний үе шаттай уялдуулан баталгаажуулах шаардлагатай.
<p>4. Журмаар зохицуулах харилцаа, хамрах хүрээ</p>	
<ul style="list-style-type: none"> - Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн хавсралтын 1-т заасан уул уурхай, дэд бүтцийн төсөлд нөлөөллийн үнэлгээг боловсруулахаар заасан. Тиймд энэ дагуу нийгмийн нөлөөллийн үнэлгээг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний хамт боловсруулах нөхцөлийг бүрдүүлэх. - Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 3.1.1-т заасан шинээр байгуулах болон ажиллаж байгаа үйлдвэр, үйлчилгээ, уул уурхай, барилга байгууламж, тэдгээрийг шинэчлэх, өргөтгөх зэрэг аливаа үйл ажиллагааг эрхлэх “төсөл” хэрэгжүүлэх этгээд буюу тус хуулийн хавсралт байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийх төслийн ангилалд заасан үйл ажиллагаа явуулахад БОНЕУ хийлгэхээр заасан. Үүнд 11 ангиллын төслүүд үнэлгээг хийлгэхээр байна. Гэвч уул уурхайн хайгуулын үйл ажиллагаа явуулахад нийгмийн нөлөөллийг зайлшгүй тодорхойлох хэрэгцээ шаардлага байгаа нь судалгааны явцад тогтоогдсон тул хайгуулын үе шатанд нэгэнт боловсруулагддаг Менежментийн төлөвлөгөөнд нийгмийн нөлөөллийн төлөв 	<ul style="list-style-type: none"> - Уул уурхайн салбар гэсэн нэр томъёог ашиглахад баяжуулах, боловсруулах үйлдвэр, геологийн эрэл, хайгуул, газрын тосны салбар, бичил аргаар ашигт малтмал олборлох, нөхөн сэргээлт гэсэн үйл ажиллагааны чиглэлүүд орхигдохоор байгааг анхаарч үйл ажиллагааны чиглэл, хамрах хүрээ, зорилгын хүрээнд “Эрдэс баялгийн салбар”-ын төсөлд хамаарахаар зохицуулах нь зүйтэй байна. Тиймд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн хавсралтын 1-т заасан хавсралтыг шинэчлэн, зөвхөн уул уурхайн төсөл гэдгээрх хязгаарлалтыг энэ салбарт тавихгүй байх шаардлага, хэрэгцээ байна. - Шатлалын хувьд үнэлгээг боловсруулахад дараах саналыг анхаарч үзвэл зохино. Үүнд: <ul style="list-style-type: none"> ○ Байгаль орчны төлөв байдлын үнэлгээтэй хамт нийгмийн нөлөөллийн төлөв байдлын үнэлгээг, ○ Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээтэй хамт Нийгмийн нөлөөллийн ерөнхий үнэлгээг, ○ Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээтэй хамт Нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг,

байдлын үнэлгээнд тусгагдсан эрсдэлийг бууруулах ажлыг хийхээр, харин ашиглалтын үе шатанд БОНБУ тухай хуульд заасанаар нийгмийн нөлөөллийг тодорхойлж тусгахаар буюу олборлолтын төслийн аль алинд нөлөөллийг тогтоох шаардлагатай байна.

- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөтэй хамт нийгмийн нөлөөллийн менежментийн төлөвлөгөөг боловсруулах нь төсөл хэрэгжүүлэгчийн ачаалал, зардал болон цаг хугацааг хэмнэх, нэмэлт дарамт үүрүүлж буй мэт сэтгэгдлийг бууруулах магадлалтай байна.
- Нийгмийн нөлөөллийн үнэлгээний аргачлалын Суурь мэдээлэл бүрдүүлэх үе шат хэсгийг нийгмийн нөлөөллийн төлөв байдлын үнэлгээнд ашиглах, мөн холбогдох зааварчилгааг хамаарах этгээдэд өгөх нь зүйтэй байна.
- Хэдийгээр уул уурхай, дэд бүтэц, үйлдвэрлэл, үйлчилгээ, хот байгуулалт зэрэг бүхий л төсөлд ННҮ-г хийх хэрэгцээ шаардлага байгаа ч эхний ээлжинд зөвхөн эрдэс баялгийн салбарт хэрэгжүүлэх төсөл, түүнийг дагаад хэрэгжүүлэх дэд бүтцийн төслийг хамруулан цаашид Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн хавсралтын 1-т заасан бүх ангилалыг хамруулж ахиулах нь зүйтэй. Хэрэв эдгээр 11 ангиллын төслүүд бүгд ННҮ-г хийлгэхээр бол тодорхойгүй байдал үүсэх магадлалтай. Учир нь ННҮА-ыг боловсруулахдаа зөвхөн уул уурхайн хайгуул болон ашиглалт, түүнийг дагасан дэд бүтцийн төслийн хүрээнд нөлөөллийг тодорхойлохоор боловсруулсан. Тиймд бусад төслийн үр нөлөөг судлаагүй юм.
- Төслийн ангиллын 1-т заасан Уул уурхайн төсөл, Бүх төрлийн ашигт малтмалын олборлолт, тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд ашиг олох зорилгогүйгээр ашиглагдаж байгаа түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолтын төслийн хүрээнд судалгаа хийгдсэн гэдгийг анхаарах шаардлагатай.
- Уул уурхайн төсөл гэдэгт хайгуулын төслийг хамруулах эрх зүйн зохицуулалтын өөрчлөлтийг оруулах шаардлагатай. Уг өөрчлөлтийг түр журмын хэрэгжилтийн үед төрийн захиргааны төв байгууллагын сайдын эрх хэмжээгээр зохицуулан шийдвэрлэх боломжтой. Харин албан ёсны журам батлагдахад үүнийг хуулийн хавсралтад өөрчлөлт оруулан шийдвэрлэх нь зүйтэй. Цаашид ангилал бүрээр төслийг ахиулах нь зүйтэй.
- Түүнчлэн энэ зөвлөмжөөр түр журам батлахаар байгаа тул түр журмын хүрээнд хамааруулах төслийг үндсэн журам батлагдах үед нарийвчилан тодорхойлж, шат дараатай арга хэмжээ авах нь тохиромжтой.
- Нийгэм-эрүүл мэнд, нийгэм-байгаль орчны асуудлыг судлах, хамрах хүрээг өргөжүүлэх.
- Төлөв байдлын үнэлгээгээр тодорхойлсон байгаль орчин болон нийгмийн асуудлыг Ашигт малтмалын ордын урьдчилсан техник, эдийн засгийн үнэлгээ (Pre-Feasibility Study)-д тусгаж, зардлыг тодорхойлох, Менежментийн төлөвлөгөөнд жил бүр тусгаж, жил бүр хянах зэргээр тодорхой хугацаанд шийдвэрлэх боломжтой.
- Аргачлалын Суурь мэдээлэл бүрдүүлэх үе шат хэсгийг нийгмийн нөлөөллийн төлөв байдлын үнэлгээнд ашиглах боломжтой.

	<ul style="list-style-type: none"> - Цаашид уг нийгмийн нөлөөллийн үнэлгээг стратегийн нөлөөллийн үнэлгээ, хуримтлагдах нөлөөллийн үнэлгээнд хийж хэвших, хууль тогтоомжид өөрчлөлт оруулах, холбогдох журмуудыг сайжруулан боловсруулах шаардлагатай. -
<p>5. Үнэлгээг хянах, батлах байгууллагын бүтцэд өөрчлөлт оруулах, чадавхижуулах</p>	
<ul style="list-style-type: none"> - Нийгмийн нөлөөллийн үнэлгээг БОНБУ-ний тухай хуульд заасны дагуу БОНБУ-тэй хамтатган хийхээр төлөвлөсөн. Гэвч одоогийн нөхцөлд БОНБУ-г батлах эрх бүхий байгууллага нь БОАЖЯ-аар хязгаарлагдаж байна. - Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журамд Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ, Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг батлах Мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагаа, шалгуурыг тодорхойлсон. 9.1-т Мэргэжлийн зөвлөл нь байгаль орчин, нийгэм, эрүүл мэнд, эдийн засаг, хөгжлийн салбарын төлөөллийг оролцуулсан 10-аас доошгүй гишүүний бүрэлдэхүүнтэй байх ба гишүүд нь тухайн чиглэлээрээ 10-аас дээш жил ажилласан туршлагатай байна гэж заасан. Гэвч Мэргэжлийн зөвлөлд танилцуулагдах баримт бичгийг хянахад нийгмийн нөлөөллийг хянаж, баталгаажуулах эрх бүхий нийгмийн нөлөөллийн үнэлгээний мэргэжилтэн одоогоор байхгүй байна. Журмын 4.14-т Хэрэгжиж байгаа төслийн техник эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ), зураг төсөл шинэчлэгдэх, өргөтгөл хийх (техник, технологийг шинэчлэх, түүхий эд, байгалийн нөөц баялгийг ашиглах хэмжээ, хүчин чадал, газрын байрлал өөрчлөх болон байгаль орчны аудитын зөвлөмжөөр нэмэлт тодотгол хийлгэх шаардлагатай гэж үзсэн зэрэг) болон тухайн төсөлтэй холбогдох харилцааг зохицуулах эрх зүйн гол баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд нэмэлт тодотгол хийлгэхэд тухайн төсөлд хийлгэсэн байгаль орчны хуваарьт аудитын зөвлөмж, тайланг ирүүлнэ гэсэн байгаа тул нийгмийн нөлөөллийг үнэлэх аудитор гэж томилогдоогүй байгаа нь нийгмийн нөлөөллийн үнэлгээг хянан баталгаажуулах этгээдгүй байгааг харуулж байна. - БОНБУ тухай хуулийн 7.4.-т зааснаар шинээр байгуулах болон одоо ажиллаж байгаа үйлдвэр, үйлчилгээ, барилга байгууламж, тэдгээрийг шинэчлэх, өргөтгөх, байгалийн нөөц ашиглах төсөлд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг үнэлгээний шинжээч 	<ul style="list-style-type: none"> - Нийгмийн нөлөөллийн үнэлгээг БОНБУ-ний тухай хуульд заасны дагуу БОНБУ-тэй хамтатган хийхээр аргачлалыг боловсруулсан тул Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг цогцоор нь батлах Мэргэжлийн зөвлөлийн бүтцийг БОАЖЯ болон ХНХЯ нар хамтран батлах шаардлагатай. - Түүнчлэн Мэргэжлийн зөвлөлийн журамд өөрчлөлт оруулж, ННУ батлах эрх хэмжээг нэмж зохицуулах шаардлагатай бөгөөд эрх бүхий сайд нар хамтран журмыг баталвал зохино. - Уг зөвлөлд нийгмийн нөлөөллийн үнэлгээг хянан, баталгаажуулах эрх бүхий этгээдийг бий болгохгүйгээр ННУ-г зорилгын хүрээнд хэрэгжүүлэх боломжгүй. Мөн Мэргэжлийн зөвлөлд ч төслүүдийн нийгмийн нөлөөллийн үнэлгээг хянах, баталгаажуулах мэдлэг, туршлага, эрх бүхий гишүүний хэрэгцээ шаардлага байгаа тул уг бүтцийг сайжруулахгүйгээр нийгмийн нөлөөллийн хяналт, баталгаажуулалт орхигдохоор байна. Тиймд туршилтын хугацаанд ХНХЯ-аас шинжээч томилж нийгмийн нөлөөллийн үнэлгээний хэсгийг судалж, дүгнэлт гаргах цаашлаад албан ёсны журам батлагдахад Мэргэжлийн зөвлөлийн дэргэд уг асуудлыг хариуцсан байнгын албан тушаалтан байхаар зохицуулах шаардлагатай. Ер нь Мэргэжлийн зөвлөлийн үүрэг, хариуцлага өндөр, хариуцах асуудлын хүрээ өргөн зэргээс шалтгаалж Мэргэжлийн зөвлөлийн дэргэд байнгын ажиллагаатай түүний ажлын албыг байгуулах, мэргэшсэн боловсон хүчин, сургалт сурталчилгааг хариуцуулах нь илүү үр дүнтэй байна. - Шинжээч нь ажлын 14 хоногийн дотор тайланг хянаж, судлан дүгнэлт гаргах нь одоогийн нөхцөлд ч дан ганц байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хянахад ч хүндрэлтэй, богино хугацаа тул нийгмийн нөлөөллийн үнэлгээ нэмэгдэх нөхцөлд уг хугацааг зайлшгүй сунгах шаардлага тулгарч байна. Мөн хэн, хэзээ, ямар шалгуураар байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг хянах, дүгнэлт гаргах процессыг журамлаж өгөх шаардлагатай. Журамд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журмын хэрэгжилтийг хангах бие даасан шаардлага бий болгож, хэрэгжилтийг хянаж үздэг тусгайлсан шаардлага, механизмыг бий болгох шаардлага байна. - Байгаль орчны мэргэжлийн зөвлөлийн 2012 оноос хойших чадавхи, туршлагад үндэслэн Нийгмийн нөлөөллийг үнэлэх нь зүйтэй. Гэвч одоогийн байдлаар зөвхөн байгаль орчны аудитортой бөгөөд нийгмийн нөлөөллийг үнэлэх Мэргэжлийн зөвлөлийн бүтэц бүрдээгүй байна. Тиймд одоогийн Байгаль орчны

<p>ажлын 14 хоногт багтаан хийж дараах дүгнэлт гаргахаар байна. Гэвч энэ хугацаа нь цөөн мэргэжилтнүүдэд хүрэлцдэггүй, сард дунджаар 30-аас дээш үнэлгээг хянах боломжгүй учраас чанарын асуудал тогтмол хөндөгдсөөр байгаа юм.</p>	<p>мэргэжлийн зөвлөлийг өргөжүүлэн, нийгмийн нөлөөллийн үнэлгээг хамтатган батлах эрх хэмжээг олгох нь зүйтэй байна.</p> <ul style="list-style-type: none"> - Мэргэжлийн зөвлөлийн бүтцийг дараах байдлаар өөрчилж, нийгмийн нөлөөллийг үнэлэх чиглэлийн гишүүдийг бүтцэд бий болгох шаардлагатай. <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын 3 ба түүнээс дээш төлөөлөл, шинжээч, ✓ Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын 3 ба түүнээс дээш төлөөлөл, шинжээч, ✓ Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын 2 ба түүнээс дээш төлөөлөл, шинжээч, ✓ Жөндэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын төлөөлөл, шинжээч, ✓ Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын төлөөлөл, шинжээч ✓ Бусад <ul style="list-style-type: none"> - Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний журам шинээр боловсруулж батлуулахдаа Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д заасныг үндэслэн одоогийн хэрэгжиж буй ЗГ-ын 2013 оны 374 тогтоолын хавсралтаар батлагдсан Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журамд өөрчлөлт оруулахдаа нийгмийн нөлөөллийг үнэлэх хэсгийг нэмж, “Нөлөөллийн үнэлгээний журам” боловсруулж, батлуулах боломжтой. Тус журамд Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг батлах мэргэжлийн зөвлөл, түүний эрх хэмжээ, бүтэц, шаардлага зэргийг тодорхойлж, Мэргэжлийн зөвлөлд дүгнэлт гаргуулахаар хянах аудиторт тавигдах шаардлага, эрх хэмжээг тодорхойлж өгөх нь зүйтэй юм. - Мэргэжлийн зөвлөл (шинээр байгуулагдах)-ийн гишүүд, нийгмийн нөлөөллийн үнэлгээг хянах шинжээч, мэргэжилтэн, аудиторыг сургалтад хамруулж, олон улсын стандарт, нийгмийн нөлөөллийн үнэлгээ, чанар, үнэлгээ зэргээр чадавхижуулах шаардлагатай.
6. Үнэлгээг гүйцэтгэх хамтарсан баг томилох	
<ul style="list-style-type: none"> - Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар үнэлгээг төсөл хэрэгжүүлэгч нь эрх бүхий мэргэжлийн байгууллага болон судалгаа, шинжилгээний байгууллагын оролцоотойгоор хийлгэхээр заасан. Одоогийн практикаар Байгаль орчны нөлөөллийн үнэлгээг гүйцэтгэх эрхийг хуулийн этгээд нь БОАЖЯ-наас авч, үнэлгээг гүйцэтгэн, зөвшөөрлийг сунгаалдаг. ННҮ-г тухайн байгаль орчны нөлөөллийн үнэлгээ гүйцэтгэх эрх бүхий хуулийн этгээд дангаараа гүйцэтгэх нь: 	<ul style="list-style-type: none"> - Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т Шаардлагатай тохиолдолд байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ хуулийн 6.3-т заасан үнэлгээ хийхэд мэргэжлийн баг томилж болно хэмээн заасан байдаг. Нийгмийн нөлөөллийн үнэлгээний аргачлалаар судлаач болон орон нутгийн иргэдийн хамтарсан баг нийгмийн нөлөөллийн үнэлгээг гүйцэтгэхээр оруулах боломжтой. - БОННҮ-г гүйцэтгэхээсээ өмнө хуульд зааснаар БОАЖ-ын асуудал эрхэлсэн сайдаар хамтарсан баг томилуулах шийдвэрийг авах шаардлагатай.

<ol style="list-style-type: none"> 1. Төслийн нийгмийн нөлөөллийн бүсийг бүрэн тодорхойлохгүй, 2. Төслөөс үүдэх нийгмийн сөрөг нөлөөллийг бүрэн тодорхойлохгүй, 3. Тухайн орон нутгийн иргэдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх зохистой аргыг тодорхойлохгүй үлдэхээр байна. 	
7. Үнэлгээг гүйцэтгэх эрх бүхий байгууллага	
<ul style="list-style-type: none"> - Одоогийн байдлаар БОНБҮ боловсруулах эрх бүхий этгээд нь Нийгмийн нөлөөллийн үнэлгээ боловсруулах эрхгүй, чадавхи сул, туршлагагүй байна. 	<ul style="list-style-type: none"> - Мэргэжлийн зөвлөлийн зөвхөн сургалтанд хамрагдсан БОНБҮ боловсруулах эрх бүхий этгээдэд нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх эрх олгох нь зүйтэй байна. БОНБҮ-ий эрх аваагүй этгээдэд эрх олгосон нөхцөлд үнэлгээг уялдуулах чадавхи улам сулрах магадлалтайг анхаарах шаардлагатай. Эрх олгох, сунгах, баталгаажуулах, холбогдох төлбөр, бүртгэл, ил тод байдлын асуудлыг журмаар зохицуулна. - БОННҮ-г боловсруулах судлаачдад урьдчилан сургалт хийж, нийгмийн нөлөөллийн үнэлгээг тодорхойлох, боловсруулах аргачлалд сургасан байх.
8. Чадавхи бэхжүүлэх	
<ul style="list-style-type: none"> - Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг боловсруулах эрх бүхий хуулийн этгээд, дүгнэлт гаргах БОАЖЯ-ны мэргэжилтэн/ шинжээч болон үнэлгээг батлах эрх бүхий Мэргэжлийн зөвлөлийн гишүүдийн аль аль нь нийгмийн нөлөөллийн үнэлгээний талаарх мэдээлэл, мэдлэг хангалтгүй байна. 	<ul style="list-style-type: none"> - Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг батлах мэргэжлийн зөвлөлийн гишүүд, дүгнэлт гаргах шинжээчид, хянах аудиторыг бэлтгэх, сургалтанд хамруулах шаардлагатай. - Мэргэжлийн зөвлөлийн зөвхөн сургалтанд хамрагдсан гишүүд, шинжээчид, аудиторт нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх эрх олгож, эрхийг сунгах, баталгаажуулах, холбогдох төлбөр, бүртгэл, ил тод байдлын асуудлыг журмаар зохицуулах, - Олон нутгийн байгаль орчны мэргэжилтэн, экологийн цагдаа нарт сургалт, мэдээлэл өгөх, хяналт хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, - Орон нутгийн иргэд, болон үнэлгээний эрхтэй компанийн судлаачид хамтарч үнэлгээ боловсруулахаар аргачлалд тусгаж байгаа тул иргэдийг мөн нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх сургалтанд хамруулах шаардлагатай. - Уул уурхайн яамны холбогдох мэргэжлтнийг томилуулах, сургалтанд хамруулах, - Мэргэжлийн хяналтын байгууллагуудын байцаагчдыг сургалтанд хамруулж, хяналт хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх - Орон нутгийн иргэд орон нутгийн хөгжлийн гэрээ, байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөөгөөр дамжуулан жил бүр хяналт тавихад арга зүйн дэмжлэг үзүүлэх, сургах. - Сургалтын гарын авлага, сургалтын модулийг Зөвлөлийн гишүүд, дүгнэлт гаргах шинжээчид, орон нутгийн иргэд болон үнэлгээний компанийн мэргэшиж,

	итгэмжлэл авах мэргэжилтнүүдэд гэх мэт задалж боловсруулах шаардлагатай байна
9. Нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговрын асуудлыг бүрэн зохицуулах	
<ul style="list-style-type: none"> - Олон улсын практик, стандартаас харахад нөхөн олговор олгох хэлбэрээр иргэдийн зөрчигдсөн эрхийг сэргээх үйл ажиллагаа нь нүүлгэн шилжүүлэлтийн хөтөлбөрийн нэг хэсэг хэлбэрээр хэрэгжих нь түгээмэл бөгөөд Монгол Улсад энэ талын зохицуулалт хангалтгүй байгаа нь орон нутгийн иргэд, малчдын эрхийн зөрчлийн үндсэн шалтгаан болж байна. Ашигт малтмалын тухай хуулийн 41.1-т Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагааны явцад худаг, өвөлжөө, хувийн болон нийтийн зориулалттай орон байр бусад барилга байгууламж болон түүх, соёлын дурсгалт зүйлсэд гэм хор учруулсан бол хохирлыг нь өмчлөгч, эзэмшигчид бүрэн хэмжээгээр нөхөн төлөх бөгөөд шаардлагатай тохиолдолд тэдгээрийг шилжүүлэн байрлуулахтай холбогдсон зардлыг хариуцна гэж заасан. - Бодит байдал дээр хуулийн тус заалтын дагуу хохирлыг барагдуулах аргачлалгүй, ямар тохиолдлыг шаардлагатай тохиолдол гэж үзэн шилжүүлэн байршуулах, мөн нөхөн олговор олгох эрх, эд хөрөнгийг хэрхэн үнэлэхтэй холбоотой тодорхой зохицуулалт байхгүйгээс нөхөн олговрын үйл ажиллагаа нь тусгай зөвшөөрөл эзэмшигч компани, иргэд хоорондын тохиролцоо хэлбэрээр хэрэгжиж байгааг практикаас харж болно. Түүнчлэн, нүүлгэн шилжүүлэхтэй холбогдсон харилцааг хуульд тунхаг байдлаар оруулж, зохицуулалтыг хэрхэхийг шийдвэрлээгүй нь уул уурхайн нөлөөлөлд өртсөн иргэдэдийн хүндрэл, бэрхшээлийг тодорхой шийдэлд хүргэхгүй үлдээсэн. 	<ul style="list-style-type: none"> - Ашигт малтмалын тухай хуулийн 41.1-т өөрчлөлт оруулах, ингэхдээ 1. Нүүлгэн шилжүүлэлт 2.Нөхөн олговрыг зохицуулсан журмыг тус тус боловсруулах шаардлагатай. Үүнд нүүлгэн шилжүүлэлт хамгийн эцсийн арга хэмжээ болохыг анхаарч, олон улсын стандартад нийцүүлэх, орон нутгийн иргэдийн амьжиргааны чанарыг өмнөх байдлаас нь дордуулахгүй байхад анхаарлаа хандуулсан байх. - Сэтгэл санааны хохирлыг тооцоолох асуудлыг журамд зохицуулж өгөх нь зүйтэй байна. - Төслийн нийгмийн нөлөөллөөс зайлсхийх, түүнийг бууруулах, нөхөн сэргээх төлөвлөгөө боловсруулах үе шатны зорилго нь төслийн үйл ажиллагаанаас учирч болзошгүй сөрөг нөлөөллөөс зайлсхийх, зайлсхийх боломжгүй бол бууруулах, бууруулах боломжгүй бол орчин, нөхцөлийг нөхөн сэргээх, нөлөөллийн бүсийн иргэдийг нүүлгэн шилжүүлэх, мөнгөн ба мөнгөн бус хэлбэрээр нөхөн төлбөр олгох төлөвлөгөө боловсруулах, арга замуудыг гаргаж, тодорхойлох асуудлыг компани, иргэд ННУ-г боловсруулах үе шатанд зөвшилцөн шийдвэрлэх талаар арга хэмжээг БОННМТ-нд тусгах шаардлагатай. - Бүртгэгдээгүй эрхийг хүлээн зөвшөөрөх асуудлыг үнэлгээний явцад багийн хурал дээр ярилцан, нөхөн олговор олгоход хийгдэх ажлыг БОННМТ-д тусгах шийдвэрлэх.
10. Баримт бичгүүдийн уялдаа, холбоог хангах	
<ul style="list-style-type: none"> - Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, Ашигт малтмалын ордын урьдчилсан техник, эдийн засгийн үнэлгээ, Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ, Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ, Орон нутгийн хөгжлийн гэрээ зэрэг баримт бичгүүдэд нэгэнт хийгдэж буй нийгмийн нөлөөллийн үнэлгээний хэсгийг боловсронгуй болгож, хэрхэн боловсруулах талаарх аргачлалтыг бий болгох, ингэхдээ дээрх баримт бичгүүдийн харилцан уялдааг хангаж, хяналт, хариуцлагыг бий болгох шаардлагатай. БОНБУ-ний үе шаттай уялдуулан дараах 	<ul style="list-style-type: none"> - Техник, эдийн засгийн үндэслэл. Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уухайн төслийн Техник, эдийн засгийн үндэслэл хүлээн авах журмын Гурав. Ашигт малтмалын баялагт урьдчилсан үнэлгээг боловсруулахад тавигдах шаарлагын 3.1.6, Танилцуулга хэсэг, Тав. Ашигт малтмалын ордыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулахад тавигдах шаардлагын 5.1.6, Танилцуулга хэсэгт нийгмийн нөлөөллийн үнэлгээг боловсруулсан хамтарсан баг, нөлөөллийн бүсийн талаархи танилцуулга, мэдээлэл, мөн 3.1.12, 6.1.12. Хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн асуудал, аюулгүй ажиллагаа, эрсдэлийн менежмент-д нийгмийн нөлөөллийн төлөв

баримт бичгийг боловсруулахаар төлөвлөлт хийж, холбогдох судалгааг гаргасан. Үүнд:

- Байгаль орчны төлөв байдлын үнэлгээтэй хамт Нийгмийн нөлөөллийн үнэлгээг,
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээтэй хамт Нийгмийн нөлөөллийн ерөнхий үнэлгээг,
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээтэй хамт Нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг,
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөтэй хамт Нийгмийн нөлөөллийн менежментийн төлөвлөгөөг боловсруулахаар төлөвлөсөн.

-**Техник, эдийн засгийн үндэслэл.** ТЭЗҮ-д талбайн нөөц, нөөцийн тооцоолол, үнэлгээ, хэмжил зүйн асуудлууд багтахаас гадна нийгэм, байгаль орчин, түүний дотор цэвэр ус, байгалийн бусад баялаг, эдийн засгийн үнэлгээ багтдаг. ТЭЗҮ боловсруулах бүтцэд олборлолт, дэд бүтэц, баяжуулалт, боловсруулалт, хөдөлмөр эрүүл ахуй, нийгмийн асуудал, аюулгүй ажиллагаа, эрсдэлийн менежмент, байгаль орчин, төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө, эдийн засаг, санхүүгийн үнэлгээний шаардлагуудыг тавьдаг. Гэвч Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн ТЭЗҮ-д тавих үндсэн шаардлагууд, ТЭЗҮ хүлээж авах журмын 6.1.12-т Хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн асуудал, аюулгүй ажиллагаа, эрсдэлийн менежмент-д нийгмийн нөлөөллийн төлөв байдлын үнэлгээгээр тодорхойлогдсон нийгмийн сөрөг нөлөөлөл, тэдгээрээс хамгийн эрсдэлтэй гэж үнэлсэн нөлөөллийг тусгах шаардлагатай гээд, ААН-үүд зөвхөн зардлын тооцооллыг гаргаж өгдөг. ТЭЗҮ-д дүгнэлт гаргах ЭБМЗ-ийн хөндлөнгийн шинжээч нь геологич мэргэжилтэй байх шаардлагатай учраас зөвхөн геологийн нөөцийн үнэлгээг чухалчилж, нийгэм, байгаль орчин, эрүүл мэндийн нөлөөллийг тооцдоггүй. Мөн ТЭЗҮ-г БОНБУ-нээс өмнө баталдаг зохицуулалттай тул аливаа нөлөөллийн үнэлгээг тооцдоггүй байна.

- Дээрх журамд өөрчлөлт оруулах ажил одоогоор УУХҮЯ дээр олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр хийгдэж байна.

-**Орон нутгийн хөгжлийн гэрээ.** Ашигт малтмалын тухай хуулийн 42.1-т зааснаар хайгуулын болон ашигт малтмалын лиценз эзэмшигч нь “орон нутгийн захиргаатай хамтран ажиллаж байгаль орчныг хамгаалах, уурхай байгуулах, уурхай байгуулахтай холбоотой дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр гэрээ байгуулж ажиллана” гэж заасан. Мөн 2014 онд

байдлын үнэлгээгээр тодорхойлогдсон нийгмийн сөрөг нөлөөлөл, тэдгээрээс хамгийн эрсдэлтэй гэж үнэлсэн нөлөөллийг тусгах шаардлагатай байна. Нийгмийн нөлөөллийн үнэлгээгээр тодорхойлогдсон эрсдэлүүдийг тусгаж, эдийн засгийн хувьд төслийн үр өгөөжийг сайжруулахад авах арга хэмжээг нийгмийн эерэг нөлөөллийг нэмэгдүүлэх, сөрөг нөлөөлөл, эрсдэлийг бууруулах зорилгоор тус баримт бичигт зааж өгөх нь зүйтэй.

Бүтцэд нийгмийн нөлөөллөөс гарах зардал гэдгийг тусад нь тусгах шаардлагатай.

- **Орон нутгийн хөгжлийн гэрээ.** Нийгмийн нөлөөллийн үнэлгээнд хийгдэх ажлын байр, худалдан авалттай холбоотой тодорхойлогдсон эрсдэлийг бууруулах, нөхцөл байдлыг сайжруулах 2 асуудлыг тусгайлан авч Орон нутгийн гэрээний заалтад тусгах, жил бүр гэрээг сунгахдаа хянах шаардлагатай.

Цаашид УУХҮЯ болон Ашигт малтмал, газрын тосны газар (АМГТГ) нь хуулийн 42.1-р заалтыг үр дүнтэй, адил тэгш үйлчлэх зарчмаар хэрэгжүүлэх, талуудын хүлээлт, шаардлагатай улам бүр тулгарч байгаа мөн санхүүжилт ихээхэн шаардлагатай тус салбар нь гадны хөрөнгө оруулагчдын шаардлагыг хангахад Засгийн газрын 2016 оны 179 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан Загвар гэрээнд өөрчлөлт оруулж, холбогдох тусгай зөвшөөрлийн үйл явцтай ОНХГ-ний үйл явцыг уях шаардлагатай. Түүнчлэн тус ОНХГ-нд хариуцлагын механизмуудыг нэвтрүүлэх хэрэгцээ өндөр байна.

- **Уулын ажлын төлөвлөгөө.** Ашигт малтмал, газрын тосны газар илгээдэг уулын ажлын төлөвлөгөөнд орон нутгийн гэрээнд тусгагдсан ажлын байрыг компани биечлэн эсхүл туслан гүйцэтгэгчээр дамжуулан бий болгох, хэрэгжилтийг тусгаж өгөх шаардлагатай.

- **Менежментийн төлөвлөгөө.** Нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийгдсэнээр одоогийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө болно. Менежментийн төлөвлөгөөнд ажлын байр, худалдан авалттай холбоотой тодорхойлогдсон эрсдэлийг бууруулах, нөхцөл байдлыг сайжруулах 2 асуудлыг хэрхэн шийдвэрлэх нарийвчилсан төлөвлөгөөг тусгаж, жил бүр хянах шаардлагатай.

<p>батлагдсан Газрын тосны тухай хуулийн 11.2.17-д “ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, орон нутгийн хөгжилд сайн дурын үндсэн дээр дэмжлэг үзүүлэх асуудлыг тусгасан гэрээг тухайн тусгай зөвшөөрлийн талбай орших сум, дүүргийн Засаг даргатай байгуулж ажиллах” гэж заасан. Улмаар 2016 оны 5 сард Монгол Улсын Засгийн газар ...тогтоолоор “Байгаль хамгаалах, уурхайтай холбоотой дэд бүтцийг хөгжүүлэх, үйлдвэр байгуулах, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хийх гэрээний загвар” (цаашид, “Загвар гэрээ”)-ыг батлан гаргасан.</p> <p>- Уулын ажлын төлөвлөгөө. Ашигт малтмал, газрын тосны газар илгээдэг уулын ажлын төлөвлөгөөг тогтмол өгдөг боловч үйл ажиллагаа, хариуцлагын хэлбэрийг уялдуулдаггүй.</p> <p>- Байгаль орчны менежментийн төлөвлөгөө. Жил бүр батлагддаг уг төлөвлөгөө нь нийгмийн асуудлыг тусгаж, шийдвэрлэх улмаар шийдвэрлэлтийг жил бүр хянах шаардлагатай ч практик дээр хураалгадаг бичиг баримтын нэг төрөл болжээ.</p>	
<p>11. Орон нутгийн төлбөр, хандив, тусламжийг оновчтой хуваарилах</p>	
<p>- Зарим сумд⁶¹ ашигт малтмалын үйл ажиллагаанд бусад сумдаас илүү өртдөг, үүнийгээ дагаад тухайн сумаас төлөх нийт лицензийн төлбөрт харьцангуй их дүнгээр төлбөр төлөгддөг ба нийгмийн сөрөг нөлөөлөл нь хуримтлагддаг учраас бусад сумдтай харьцуулахад харьцангуй өндөр. Монгол Улсын Засгийн газар 2015 оны 5 сард Төсвийн тухай хуульд нөөц ашигласны төлбөрийн 30 хувийг орон нутагт, мөн хайгуулын ба ашиглалтын лицензийн төлбөрийн 50 хувийг орон нутагт шилжүүлэх өөрчлөлтийг хийсэн. 2016 оны 12 сард Засгийн газар 2017 оны төсвийг батлахдаа орон нутагт шилжүүлэх хувь хэмжээг 30-аас 10 болгон бууруулсан. Харин 2020 оноос ашигт малтмалын хайгуулын лицензийн төлбөрийн 100 хувийг, ашиглалтын лицензийн төлбөрийн 50 хувийг тухайн орон нутагт шилжүүлэхээр болсон. Төсвийн бодлого тогтворгүй байх нь урт хугацааны төлөвлөлт хийхэд хүндрэлтэй болгож байна. Түүнчлэн тухайн орон нутагт хуваарилалт хийнэ гэдэг нь тухайн аймагт хийгдэх хуваарилалт бөгөөд сумдад төлсөн татварын хэмжээгээр хуваарилалт хийгдэхгүй байна.</p>	<p>- Тухайн аймгаас төсвийн хуваарилалтыг тэгшитгэж хуваарилах байр суурь давамгайлж ирсэн нь орон нутагт бодитоор үүссэн сөрөг нөлөөллийг арилгах, бууруулахад тухайн төсөв нь хангалтгүй тул тухайн аймаг, сум, багийн хөгжлийн төлөвлөлтөд тус салбарын үр өгөөж төдийлөн хувь нэмэр үзүүлэхгүй байгааг залруулж, төлсөн татварын хэмжээнд хуваарилалт хийн, буцаан олгох бодлого барих нь зүйтэй байна. .</p> <p>- Хуулиар орон нутагт давуу тал үүсэхгүй тохиолдолд орон нутгийн захиргаа уул уурхайн компаниудаас шууд мөнгөн хандив тусламж авах сонирхол үргэлжлэхээр байгаа нь судалгаанаас харагдсан⁶². Уул уурхайн орлого ашгийг орон нутагт хуваарилах төрийн бодлого, зохицуулалтыг тогтвортой, тодорхой болгох нь орон нутагт тус салбараас орох өгөөж тогтвортой нэмэгдэх, дунд болон урт хугацааны төлөвлөлт хийх боломж бүрдэхээр байгааг анхаарах шаардлагатай.</p> <p>- Орлогын хуваарилалтад гарч буй өөрчлөлтөөс орон нутагт үзүүлэх нөлөөллийг бодит тоо баримтад үндэслэн сайтар судлах шаардлагатай байна.</p>

⁶¹ Дорноговь аймаг, Айраг сумын нийт нутаг дэвсгэрийн 80 гаруй хувьд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгогдсон, судалгааны хугацаанд 100 гаруй тусгай зөвшөөрлийг тус суманд компаниуд эзэмшиж байна.

⁶² Дорноговь аймаг, Айраг, Даланжаргалан сумдад Зөвлөх багийн хийсэн ярилцлага, 2020.07.05-06

<p>- Ашигт малтмалын хуулийн 42.1-р заалт болон Засгийн газраас баталсан Загвар гэрээний аль аль нь уул уурхайн компанийн зүгээс орон нутгийн захиргаанд санхүүгийн хувь нэмэр оруулах тухай дурдаагүй байдаг. Зарим орон нутгийн захиргаад уул уурхай бүхий орон нутгуудыг дэмжсэн орлогын хуваарилалтын тогтолцоо байхгүй учраас Орон нутгийн хөгжлийн сан нэрээр ТББ байгуулан, уул уурхайн тусгай зөвшөөрөл бүхий компаниуд тодорхой мөнгө хуримтлуулах хэлбэрийг удирдлагууд нь дэмжих хандлага байна. Учир нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай 2012 онд батлагдсан хуульд зааснаар орон нутгийн захиргаа нь тухайн орон нутагт үйл ажиллагаагаараа холбогдох компаниудаас хандив тусламж авахыг хязгаарласан. Улмаар Хөгжлийн сан нэрээр ТББ байгуулсан тохиолдолд хандив тусламж авах нь нээлттэй болж, уул уурхайн салбарын мөнгөн хандив, тусламж нь орон нутагт шингэцгүй, орон нутгийн удирдлага болон компаниуд хоорондын шийдсэн зүйлд хөрөнгө оруулалт хийгдэх байдлаар зохицуулалт, хуулийн хязгаарлалтаас гадуур, нийгмийн сөрөг нөлөөллийг бууруулахад хувь нэмэр үзүүлэхгүй харин ч авлига, ашиг сонирхлын зөрчлийг өдөөх хандлагатай байна⁶³.</p>	<p>- Хандив, тусламж, орон нутгийн хөгжилд оруулах хувь нэмрийг зөвхөн нийгмийн нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон нийгмийн асуудлыг шийдвэрлүүлэх, тэдгээр асуудлыг орон нутгийн хөгжлийн гэрээ, менежментийн төлөвлөгөөнд тусгаж, иргэд, төр болон компанийн хооронд зөвшилцөн шийдвэрлэгдэх нь оновчтой цаашид төрийн байгууллагууд анхаарах шаардлагатай байна. Хөгжлийн сангаар дамжиж хэрэгжих төсөл хөтөлбөр нь компаниудын нэгдлийн хамтран хэрэгжүүлэх, нийгмийн нөлөөллийн үнэлгээнд тусгагдсан эерэг нөлөөллийг нэмэгдүүлэх, бие даасан, сайн дурын, хандивын арга хэмжээ байх шаардлагатай. Түүнээс тус санд мөнгө хандивласан нь аливаа компанийн нийгэм, эрүүл мэнд, байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах ажилтай холбоогүй байх шаардлагатай байна.</p> <p>- Аймгийн ЗД-ын захирамжаар ЗДТГ болон сангийн хооронд гэрээ байгуулж зохицуулан, тухайн сангуудын хэрэгжүүлэх үйл ажиллагааг уул уурхайн компаниуд баг тус бүрийн иргэдтэй зөвшилцөн гэрээнд тусгаж шийдвэрлэх хэрэгтэй.</p> <p>- Түүнээс гадна орон нутгаас хураасан газар, ус, ашигласан байгалийн нөөцийн татвар, гадаад ажилтан, байгаль орчны нөхөн сэргээлт зэрэг төлбөр, хураамжийг тухайн орон нутагт ялангуяа сум, багт нь буцаан шилжүүлж, орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд хөрөнгө оруулалт хийхэд ач холбогдолтой байна.</p>
12. Компаниудын хариуцлагыг сайжруулах	
<p>- Компанийн нийгмийн хариуцлагыг хэрэгжиж буй хууль тогтоомжтой уялдуулах, хянах механизм хангалттай бүрдээгүй байна. Ялангуяа мэдээллийг ил тод болгох, орон нутгийн иргэдтэй шууд харилцах, тайлагнах болон төрийн эрх бүхий байгууллагын хяналт шалгалтыг хүндэтгэх, шаардлагыг хэрэгжүүлэх асуудал хүндрэлтэй хэвээр байна⁶⁴.</p>	<p>- Компанийн нийгмийн хариуцлагыг сайжруулан, иргэдэд шууд хандах, гомдол гаргах, мэдээллийг нээлттэй, ил тод өгөх сувгийг бий болгохыг БОННМТ-нд тусгаж шийдвэрлэх шаардлагатай.</p> <p>- Нийгмийн нөлөөллийг үнэлэхдээ багийн хурлыг зохион байгуулж, тухайн багийн иргэдээс санал асуулга явуулан хэрэгцээ шаардлагыг тодорхойлон шийдвэрлэх арга замыг БОННУ, БОНМТ болон орон нутгийн хөгжлийн гэрээнд тусгаж шийдвэрлэх,</p> <p>- Зарим тохиолдолд аймаг болон сумын ЗД болон компани нарын хооронд орон нутгийн хөгжлийн гэрээ байгуулагдаж байгаа нь гурван талын төлөөллийг бүрэн хамарч чадахгүйд хүрч байна. Тиймд орон нутгийн хөгжлийн гэрээг багийн ИТХ, аймгийн ЗД болон аж ахуйн нэгжийн гурвалсан гэрээ хэлбэрээр батлаж байх шаардлагатай.</p>

⁶³ Дорноговь аймаг, Айраг, Даланжаргалан сумдад Зөвлөх багийн хийсэн ярилцлага, 2020.07.05-06

⁶⁴ Зөвлөх багийн хийсэн ярилцлага, хэлэлцүүлгийн дүгнэлт

	<ul style="list-style-type: none"> - Мөн гэрээг батахдаа БОННУ-д тусгагдсан бий болгох ажлын байрны тоо болон орон нутгийн иргэдээс заавал худалдан авах бараа, бүтээгдэхүүний тоо хэмжээг нарийвчилан тусгах шаардлагатай. - Компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд дараах асуудлыг хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд жил бүр хянаж хэвших. Үүнд: <ul style="list-style-type: none"> ✓ Мэдээллийн ил тод байдал, ✓ Гомдол, мэдээлэл хүлээн авах суваг бий болгосон эсэх, гомдол мэдээллийн тоо, шийдвэрлэлтийн тайлан мэдээний ил тод байдал, ✓ Ажлын байр бий болгоход тухайн орон нутгийн иргэдэд үзүүлж буй дэмжлэг, ✓ Нөлөөлөлд өртсөн иргэдийг эмчийн үзлэгт хамруулсан тоон мэдээллийн ил тод байдал, ✓ Нөлөөлөлд өртсөн бүсийн малын эрүүл мэндийн үзлэгт хамруулсан байдал, ✓ Саарал ус ашигласан мэдээллийг нээлттэй болгох.
13. Ил тод байдал, иргэдийн мэдэх эрхийг хангах	
<p>- 2016 оны 7 сард батлагдсан Захиргааны ерөнхий хуулийн дагуу төрийн байгууллагууд нь олон нийтийн ашиг сонирхлыг хөндсөн аливаа захиргааны шийдвэр гаргах, гэрээ байгуулахдаа олон нийтийн сонсгол зохион байх үүрэгтэй. Захиргааны акт гэж захиргааны байгууллагаас тодорхой нэг тохиолдлыг зохицуулахаар нийтийн эрх зүйн хүрээнд гадагш чиглэсэн, эрх зүйн шууд үр дагавар бий болгосон амаар, бичгээр гаргасан захирамжилсан шийдвэр болон үйл ажиллагааг ойлгохоор байна⁶⁵. Харин орон нутгийн гэрээг захиргааны гэрээ мөн эсэхээр маргаантай хэвээр байгааг тодорхой болгон, албан ёсны тайлбар гаргах, Түүнчлэн төрийн захиргааны байгууллагын байгуулах гэрээ нь захиргааны гэрээнд тооцогдохоор байгаа ч төрийн захиргааны байгууллагууд үүн дээр маргаантай ханддагаас хуулийн хэрэгжилт хангагдаагүй. Захиргааны шийдвэр гаргах ажиллагааны улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй этгээдийг түүний хүсэлтээр, эсхүл захиргааны байгууллага өөрийн санаачилгаар, оролцогчийн зөвшөөрснөөр шийдвэр гаргах ажиллагаанд татан оролцуулахаар заасан⁶⁶. Мөн хуулийн 24.4.Тухайн захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд хамааралтай тохиолдол бүрийн үндэслэлийг захиргааны байгууллага</p>	<ul style="list-style-type: none"> - Захиргааны ерөнхий хууль, Нийтийн сонсголын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж Засгийн газраас уул уурхайн тусгай зөвшөөрөл олгох талбайн солбицолыг баталгаажуулах шийдвэрийг орон нутгийн Засаг дарга нараас авахдаа орон нутгийн иргэдтэй зөвшилцөн, сонсох ажиллагааг зохион байгуулж шийдвэрлэх шаардлагатай байна. - Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниудын нэгдлийн сангуудын орлого, зарцуулалт, үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй, ил тод болгох зохицуулалтыг хуульд тусгах, - Орон нутгийн хөгжлийн гэрээнд тусгагдах асуудлыг тухайн багийн иргэдтэй хэлэлцэн зөвшилцөж тусгадаг болох, тухайн асуудлын шийдвэрлэлтийг жил бүр хянаж, зөвшилцсөн иргэдэд мэдээллэх механизмыг бүрдүүлэх, - Уул уурхай, газрын тосны төслийн үйл ажиллагаанд Загвар гэрээний 5.1-д гэрээний ил тод байдлыг хангах зорилгоор “тухайн орон нутгийн иргэдэд гэрээ байгуулсан талаар мэдээлэх бөгөөд гэрээ, түүнтэй холбогдсон баримт бичгийг талуудын цахим хуудсанд ажлын 3 хоногийн дотор байршуулна. Гэрээний хувийг ажлын 5 хоногийн дотор аймаг (сум, дүүрэг)-ийн Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын дэд зөвлөлд хүргүүлнэ” гэсний хэрэгжилтийг ЗДТГ-аас албадан хангуулах, хугацаатай үүргээ биелүүлээгүй тохиолдолд хариуцлага тооцох шаардлагатай.

⁶⁵ Захиргааны ерөнхий хууль, 37.1

⁶⁶ Захиргааны ерөнхий хууль, 13.3, 26.1.

<p>нарийвчлан шинжлэн судлах үүрэгтэй бөгөөд оролцогчийн хувьд ач холбогдол бүхий нөхцөл байдлыг тогтооно гээд Захиргааны акт, захиргааны гэрээг батлан гаргахын өмнө эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй этгээдэд захиргааны шийдвэр гаргахад ач холбогдол бүхий нөхцөл байдлын талаар тайлбар, санал гаргах боломж олгох ба тус ажиллагааг .сонсох ажиллагаа гэнэ гэж зааснаар дээрх захиргааны акт гаргахдаа сонсох ажиллагааг заавал зохион байгуулахаар заасан.</p> <p>- Байгаль орчныг хамгаалах тухай хуульд баялгийг ашиглахтай холбоотой шийдвэр, тайлан зэргийг ил тод байдлагаар заасан боловч бодит байдал дээр байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайлан бүрэн эхээрээ ил тод байна гэсэн зохицуулалт байдаггүй нь шүүхийн маргаанд ихээхэн асуудал үүсгэж шударга байдлыг тогтооход хүндрэл учруулж байна.</p>	<p>- Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг олон нийтэд ил тод болгох зохицуулалтыг хийх шаардлагатай ба нутгийн иргэдэд сөрөг нөлөөллийг мэдээлэх, хяналт тавих хэлбэрийг тодорхой болгох, компаниас сөрөг нөлөөлөл ба тэдгээрийг бууруулахад авч хэрэгжүүлэх төлөвлөгөөг тарааж хянахад нь мэдээлэл (брошур) олгож хэвшүүлэх шаардлагатай байна.</p> <p>- Орон нутгийн иргэд ийг бэлтгэж, сурган ажилд авсан талаарх мэдээллийг орон нутгийн хөгжлийн гэрээ, байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөөгөөр дамжуулан жил бүр хянах нөхцөлийг бүрдүүлэх</p>
<p>14. Баримт, нотолгоог стандартын дагуу хангах</p>	
<p>- Орон нутагт багийн хурлын тэмдэглэлийг хуурамчаар үйлддэг, олон дахин хуралдуулж асуудлыг ашигтайгаар шийдвэрлүүлэх зэрэг БОНБУ-ний боловсруулах шатанд түгээмэл гарч, улмаар иргэдийн эрх зөрчигдсөөр байгааг таслан зогсоож чадаагүй байна.</p>	<p>- Дараах нотлох баримтыг ННУ-ий аргачлалын дагуу үнэлгээнд хавсаргаж, төрийн эрх бүхий байгууллагад хүргүүлэх шаардлагатай ба журамд зохицуулалтыг тусгана. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Хамтарсан баг бүрдүүлэн ажиллах төрийн эрх бүхий төв байгууллагын сайдын шийдвэр, ✓ Төсөл хэрэгжих сумын багийн иргэдийн хурал зарласан, хуралдсан мэдээлэл, багийн хурлын тэмдэглэлд хэдэн удаа хуралдсан, ямар асуудал хэлэлцсэн талаарх бүрэн мэдээлэл, зөвхөн багийн ИТХ-ын дарга биш харин ННУА боловсруулах хамтарсан баг буюу тухайн орон нутгийн нөлөөлөлд өртөх бүсийн иргэд, малчид болон судлаачид хамтран баталж, гарын үсгээр баталгаажуулсан байх шаардлагыг анхаарна. <p>- Үнэлгээгээр тодорхойлогдсон эрсдэл, давуу тал ба сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний талаарх мэдээлэл</p>
<p>15. Хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах</p>	
<p>- Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай хуулийн олон нийтэд ил тод мэдээлэх, тайлагнах болон стратегийн үнэлгээ хийхтэй холбоотой зохицуулалт, Ашигт малтмалын тухай хуулийн олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах, нөхөн олговор олгох талаарх зохицуулалт, Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уухайн төслийн Техник, эдийн засгийн үндэслэл хүлээн авах журам, Орон нутгийн хөгжлийн гэрээний загвар, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон</p>	<p>- Ашигт малтмалын тухай хуулийн 41.1-т өөрчлөлт оруулах, ингэхдээ 1. Нүүлгэн шилжүүлэлт 2. Нөхөн олговрыг зохицуулсан журмыг тус тус боловсруулах шаардлагатай. Үүнд нүүлгэн шилжүүлэлт хамгийн эцсийн арга хэмжээ болохыг анхаарч, олон улсын стандартад нийцүүлэх, орон нутгийн иргэдийн амьжиргааны чанарыг өмнөх байдлаас нь дордуулахгүй байхад анхаарлаа хандуулсан байх.</p> <p>- Одоогийн БОНБУ тухай хуульд зааснаар үнэлгээг ажлын 14 хоногт шинжээч дүгнэлт гаргахаар байгаа ч дан ганц байгаль орчны үнэлгээг хянаж, дүгнэлт гаргахад хугацаа хангалтгүй байдаг. Тиймд нийгмийн нөлөөллийн үнэлгээ</p>

<p>нийтийн оролцоог хангах тухай журам зэргийн хэрэгжилтэд үнэлгээ хийж холбогдох өөрчлөлтүүдийг тусгах хэрэгцээ шаардлага үүссэн.</p> <ul style="list-style-type: none"> - Одоогийн хууль тогтоомжийн зохицуулалтаар үнэлгээ хийгдээгүй, буруу, дутуу хийгдсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг зохицуулалт сул байна. Мөн хэрэгжилт дээр хяналт тавих асуудал нь менежментийн төлөвлөгөөг боловсруулсан эсэхээр хязгаарлагдаж, менежментийн төлөвлөгөөтэй уялдаж буй эсэхийг нягтлах, үнэлгээний дагуу үйл ажиллагаа явагдаж байгаа эсэхийг хянах ямар ч зохицуулалт, ажлын уялдаа байхгүй орхигдсон байна. - Байгаль орчныг хамгаалах тухай хуульд баялгийг ашиглахтай холбоотой шийдвэр, тайлан зэргийг ил тод байдлагаар заасан боловч бодит байдал дээр байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайлан бүрэн эхээрээ ил тод байна гэсэн зохицуулалт байдаггүй нь шүүхийн маргаанд ихээхэн асуудал үүсгэж шударга байдлыг тогтооход хүндрэл учруулж байна. - Мэргэжлийн хяналтын байгууллага нь батлагдсан удирдамжийн дагуу хяналт шалгалтаа хийдэг ба уурхайн кемп дээр өдөр тутамд гарч болзошгүй зөрчлүүдийг хянахаар тусгагдаагүй байна 	<p>хамтран хийгдэхэд хангалттай хугацааг судалгаа, туршилтат үндэслэн шинээр тогтоож өгөх хэрэгтэй.</p> <ul style="list-style-type: none"> - Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний журмыг боловсруулж батлах, ННҮ-ний аргачлалыг батлах, - БОННҮ-г батлах мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагаа, мэргэжлийн зөвлөлийн зөвхөн сургалтанд хамрагдсан гишүүд, шинжээчид, аудиторт нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх эрх олгож, эрхийг сунгах, баталгаажуулах, холбогдох төлбөр, бүртгэл, ил тод байдлын асуудлыг журмаар зохицуулах, - БОННҮ-г боловсруулах хуулийн этгээд, боловсруулах хамтарсан багийн үйл ажиллагааны журмыг боловсруулж батлах, - БОННҮ-г боловсруулах хуулийн этгээдэд тавигдах шаардлага, эрх, эрхийг олгох, цуцлах нөхцөл, холбогдох төлбөр, бүртгэл, ил тод байдлын асуудал зэргийг тодорхойлсон журмыг боловсруулж батлах, - Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниудын нэгдлийн сангуудын орлого, зарцуулалт, үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй, ил тод болгох зохицуулалтыг хуульд тусгах, - Орон нутгийн хөгжлийн жишиг гэрээнд өөрчлөлт оруулж, Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг олон нийтэд ил тод болгох зохицуулалтыг хийх шаардлагатай ба нутгийн иргэдэд сөрөг нөлөөллийг мэдээллэх, хяналт тавих хэлбэрийг тодорхой болгох, компаниас сөрөг нөлөөлөл ба тэдгээрийг бууруулахад авч хэрэгжүүлэх төлөвлөгөөг тарааж хянахад нь мэдээлэл (брошур) олгож хэвшүүлэх шаардлагатай байна. - БОННҮ-д тусгагдсан ажлын байр бий болгох болон орон нутгийн иргэдийн амьжиргаанд дэмжлэг үзүүлэх, худалдан авалт хийх нөхцөлийг дэлгэрэнгүй тусгаж болохуйц зохицуулах шаардлагатай. Мөн гэрээний хяналтыг жил бүр хийж, үнэлэх, хариуцлагажуулах зохицуулалтыг гэрээнд тусгах шаардлагатай. - Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уухайн төслийн Техник, эдийн засгийн үндэслэл хүлээн авах журамд өөрчлөлт оруулж, БОННТБҮ-д тусгагдсан зарим асуудлыг тайланд тусгах, хяналт тавих, хариуцлагажуулах зохицуулалтыг бүрдүүлэх. - Гадаадын иргэдийн бүртгэлтэй холбоотой хуулийн хэрэгжилтийг сайжруулан, төсөл хэрэгжих орон нутагт ажиллах гадаад иргэдийг тухайн орон нутагт нь бүртгэх шаардлагатай. Учир нь тухайн гадаадын иргэдтэй холбоотой осол, эндэгдэл гарахад бүртгэл нь нийслэлд хийгддэгээс мэдээлэл гаргах төвөгтэй, удаашралттай байна. Мөн тухайн орон нутагт ажиллаж, амьдарч байгаагаас төлөх төлбөр нь тухайн орон нутагт шингэх нь зүйтэй байна.
---	---

	<ul style="list-style-type: none"> - Нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийгдсэний дараа сөрөг нөлөөлөл өндөр бол тухайн орон нутгаас тусгай зөвшөөрлийг цөөлөх саналыг ЗГ-т гаргах, ЗГ нь боломжийг бүрдүүлэх шаардлагатай. - Орон нутаг дахь төрийн захиргааны байгууллагын мэдээлэл өгөх хэлбэр нь малчдад зориулагдсан байхаас гадна мөн нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх компанийн ажилтнуудад зориулагдсан гэсэн ангилалтай байх хэрэгтэй. БОННУ-г боловсруулах судлаач болон багийн иргэдийн төрийн байгууллагаас авах мэдээлэл ил тод, нээлттэй мөн ашиглахад хялбар, ойлгомжтой байх зайлшгүй шаардлагатай. - Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг олон нийтэд ил тод болгох нь ач холбогдолтой байгааг хуулиар баталгаажуулах. - Мөн компаниуд үнэлгээгээ электрон хэлбэрээр, хэрэглэгч харах ба олох боломжтой байдлаар ил тод болгоогүй бол хүлээлгэх хариуцлагыг зохицуулах шаардлагатай. - Хэн, хэзээ, ямар шалгуураар байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг хянах, дүгнэлт гаргах процессыг журамлаж өгөх шаардлагатай. Журамд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журмын хэрэгжилтийг хангах бие даасан шаардлага бий болгож, хэрэгжилтийг хянаж үздэг тусгайлсан шаардлага, механизмыг бий болгох шаардлага байна. Үнэлгээ хийгдээгүй, буруу, дутуу хийгдсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг журмаар зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавих зохицуулалтыг бий болгох, менежментийн төлөвлөгөөтэй уялдаж буй эсэхийг нягтлах, үнэлгээний дагуу үйл ажиллагаа явагдаж байгаа эсэхийг хянах шаардлагатай. - Мэргэжлийн хяналтын байгууллагын батлагдсан уул уурхайн компаниудад хийх хяналт шалгалтын удирдамжид өөрчлөлт оруулах, үнэлгээний дагуу ажлыг гүйцэтгэж буй эсэхийг хянах, туслан гүйцэтгэгчээс мэдээллийг нэхэж гаргуулах болон бусад шаардлагыг нэмж тусгах. - Нөлөөллийн бүс, оролцогч тал, шууд болон шууд бус байдлаар төслийн нөлөөлөлд өртөгч гэх зэрэг Нэр томъёоны тодорхойлолтуудыг тодорхой байдлаар хууль тогтоомжид тусгаж өгөх, ИНХ-аар үнэлгээний багт орох хүмүүсийг сонгох, хуралдаад хэн, яаж шийдвэр гаргах, хэдээр тасалбар болгох гэх зэргийг тодорхойлох. - ННУА-ын төслийг боловсруулахдаа хуримлагдсан нөлөөллийн үнэлгээнд хийхээр тооцоолоогүй тул аргачлалыг туршиж, цаашид хуримтлагдсан нөлөөллийн үнэлгээ болон стратегийн нөлөөллийн үнэлгээний аргачлалыг шинэчлэн боловсруулж, төрөөс эдгээр үнэлгээг боловсруулахад тавигдах шаардлага, байгууллагуудын харилцан хамаарал, хамтын ажиллагаа, зардал болон бусад асуудлыг тусгаж батлах шаардлагатай
16. Бусад байгууллагуудтай хамтран ажиллах	

<ul style="list-style-type: none"> - Нийгмийн нөлөөллийн үнэлгээг бусад олон улсад санхүүжүүлэгч олон улсын санхүүгийн байгууллагуудын стандарт, шаардлагын дагуу компаниуд хийж ирсэн. Мөн манай уул уурхайн компаниуд олон улсын хөрөнгийн зах зээлээс хөрөнгө босгох ажлыг хийж ирсэн ба цаашид ч нэмэгдэх хандлага бий. Харин нийгмийн нөлөөллийн үнэлгээг олон улсын шаардлага, стандартын дагуу нэг, дотоодын стандарт шаардлага болон хууль тогтоомжид зааснаар өөр хийх нь компаниудад санхүү, цаг хугацаа, хүн хүч гэх мэт олон хүндрэл бэрхшээлийг бий болгоно. - Эрдэс баялгийн салбарын компаниуд, дэд бүтцийн төсөл хэрэгжүүлэгчид нийгмийн нөлөөллийн үнэлгээ боловсруулах нь санхүүжүүлэгчийн шаардлага ба олон улсын стандартаар санхүүжүүлэгчдээр дамжуулан шаардан хэрэгжүүлдэг байна. 	<ul style="list-style-type: none"> - Хэдийгээр ННҮ-ний аргачлалыг боловсруулах, Эрх зүйн дүгнэлт боловсруулахдаа олон улсын нийгмийн нөлөөллийн үнэлгээ, хүний эрхийн зарчмуудыг судалсан ч Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй олон улсын хөгжлийн байгууллагуудтай уулзаж, санал солилцох, тэдний мэргэжилтнүүдийн санал зөвлөгөөг авч аргачлалыг нэг мөр, олон улсын шаардлага, стандартын дагуу боловсруулдаг болгож баталгаажуулах, батлах нь зүйтэй. - Дотоодын арилжааны банкуудын уул уурхай, дэд бүтцийн компаниудад тавих шаардлага эсхүл зарчмыг нэвтрүүлэх зорилгоор Банкны холбоо болон арилжааны банкуудтай уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, хамтран ажиллах шаардлагатай
17. Хуримтлагдах нөлөөллийг эхлэлийн шатанд үнэлэх	
<ul style="list-style-type: none"> - Байгаль орчинд нөлөөлх байдлын үнэлгээний тухай хуулийн 4.1.1-т заасан хуримтлагдах нөлөөллийн үнэлгээг 6.3-т зааснаар Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь тодорхой бүс нутаг, сав газарт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас хэрэгжүүлж байгаа төсөлд эрх бүхий мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор хийнэ гэж заасан боловч хуримтлагдах нөлөөллийн үнэлгээг хийж заншаагүй байна. - БОНБҮТХ-ийн 18.2-т Засгийн газрын хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа үндэсний болон бүс нутгийн хэмжээнд баримтлах бодлого, хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөнд стратегийн үнэлгээ хийх явцад олон нийтээс санал авна гэж заасан байна. Гэвч хуримтлагдсан нөлөөллийн болон стратегийн үнэлгээ нь одоогоор хийгдэхгүй байна. 	<ul style="list-style-type: none"> - ЗГ-аар хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайн солбицлыг тогтоож зарлахдаа уул уурхайн тусгай зөвшөөрөл олгогдсон, үйл ажиллагаа явагдаж буй орон нутагт юуны өмнө байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын үүргийнх нь хүрээнд хуримлагдсан нөлөөллийн үнэлгээ боловсруулж ирүүлэх шаардлагыг тавих, уг үнэлгээний зардлыг төсөвт нь суулгах, хуримлагдсан нөлөөллийн үнэлгээний тайланд үндэслэн талбайн солбицлыг тогтоох нь зүйтэй байна. - ННҮА-ын төслийг боловсруулахдаа хуримлагдсан нөлөөллийн үнэлгээнд хийхээр тооцоолоогүй тул аргачлалыг туршиж, цаашид хуримтлагдсан нөлөөллийн үнэлгээ болон стратегийн нөлөөллийн үнэлгээний аргачлал, журмыг сайжруулах боломжтой.

Хавсралт 1. Процессын зураглал: Уул уурхай, дэд бүтцийн төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааны үе шатад нөлөөллийн үнэлгээний талаар тусгагдсан байдал

Тодруулга	Шаардлага	Нөлөөллийн үнэлгээ тусгагдсан болон хийгдэх байдал
Төрийн төлөвлөлтийн үе шат		
Төрөөс хэрэгжүүлэх төсөл	<ul style="list-style-type: none"> Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт батлах тухай Засгийн газрын тогтоолоор уул уурхай, дэд бүтцийн төслийн жагсаалтыг батална. ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийг жагсааж батална. 	Төрийн төлөвлөлтийн шатанд тухайн газар нутагт ашигт малтмалын хайгуулын ажлыг гүйцэтгэх нь: а) улсын нийгэм, эдийн засагт б) тухайн орон нутгийн хүн амд хэрхэн нөлөөлөх нийгмийн нөлөөллийг тогтоох в) техник, эдийн засгийн үздэслэлийг тооцоолох зохицуулалт байхгүй. Тиймд төрөөс хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийг батлах мөн хувийн хэвшилд олгох хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайн сольбицолыг тогтооход тухайн төсөл хэрэгжих орон нутгийн иргэд, нийгэм, эдийн засаг, эрүүл мэнд, байгаль орчны нөлөөллийг тооцоолохгүй ⁶⁷ , иргэдтэй зөвшилцдөггүй.
Хувийн хэвшлийн хэрэгжүүлэх төсөл	<ul style="list-style-type: none"> Хайгуул: ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайн солбицол тогтоох шийдвэрийг ЗГ батална. Бусад уул уурхай, зам барилга, ДЦС зэрэг дэд бүтцийн төсөлд төрийн төлөвлөлт хийгдэхгүй. 	
Сонгон шалгаруулалтын үе шат		
Төсөлд оролцогчийг сонгох	<ul style="list-style-type: none"> Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (2005), Концессын тухай хууль (2010)-д зааснаар сонгон шалгаруулалт эсхүл шууд гэрээ байгуулж, батлагдсан төслийг хэрэгжүүлэх ажлыг гүйцэтгүүлнэ. ЗГ-аас батлагдсан талбайн солбицол дээр Ашигт малтмалын тухай хуулийн 7.1-т зааснаар сонгон шалгаруулалт явуулна. 	Сонгон шалгаруулалтын үйл ажиллагаанд нөлөөллийн үнэлгээ хийх зохицуулалт байхгүй.
Шийдвэр гаргах үе шат		
Хөгжлийн төсөл хөтөлбөрийн Байгаль орчны стратегийн үнэлгээ	<ul style="list-style-type: none"> Концессын тухай хууль (2010)-д зааснаар сонгон шалгаруулалтад шалгарсан компани эсхүл шууд гэрээлэгчтэй гэрээ байгуулна. Хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний төсөлд стратегийн үнэлгээ хийнэ. Засгийн газрын хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа үндэсний болон бүс нутгийн хэмжээнд баримтлах бодлого, хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөнд стратегийн үнэлгээ хийх явцад олон нийтээс ажлын 30-аас дээшгүй өдрийн хугацаанд санал авах ба Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 	Захиргааны акт батлах учраас төрийн захиргааны төв болон бусад байгууллага нь Захиргааны ерөнхий хуулийн сонсох ажиллагаа явагдах үндэслэлтэй бөгөөд оролцогчийн хувьд ач холбогдол бүхий нөхцөл байдлыг тогтоохоор хуульд заасан тул захиргааны акт, гэрээ батлагдсанаар нийгэм, байгаль орчин, эдийн засаг, эрүүл мэндийн нөхцөл байдлыг үнэлэхээр зохицуулсан боловч хэрэгждэггүй. Одоогийн байдлаар орон нутгийн оролцогчдын дунд сонсох ажиллагаа хийдэггүй. Байгаль орчны стратегийн болон

⁶⁷ Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн 19.9 хувьд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох боломжтой. 2020 оны байдлаар нийт нутаг дэвсгэрийн 9 хувийг эзлэж байгаа нь цаашид энэ тоо нэмэгдэх магадлалтайг харуулж байна.

	<p>А-03 тоот Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журмаар зохицуулдаг.</p> <ul style="list-style-type: none"> • Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (2005)-д зааснаар төсвийн ерөнхийлөн захирагч сонгон шалгаруулалтад тэнцсэн этгээд эсхүл шууд гэрээлэгчтэй гэрээ байгуулах эрхтэй. 	<p>хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний журмын 2.2-т “Байгаль орчны стратегийн үнэлгээ хийх явцад дараах зарчмыг баримтална: 2.2.2. байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэл, сөрөг нөлөөллөөс зайлсхийх боломжит хувилбар болон хэрэгжүүлэхээс татгалзах хувилбарыг тодорхойлох гээд 2.9-д “ Стратегийн үнэлгээ хийх мэргэжлийн баг нь ... тайлан дүгнэлт гаргана. Тайлан, дүгнэлт нь дараах мэдээллийг агуулна:... 2.9.3. байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэл, сөрөг нөлөөлөл, түүний үр дагавар, хуримтлагдах сөрөг нөлөөлөлийг тодорхойлно гэсэн.</p>
Хувийн хэвшлийн хэрэгжүүлэх төсөл	<ul style="list-style-type: none"> •Төрийн захиргааны байгууллага ААН-д уул уурхайн хайгуул, ашиглалт, боловсруулах, баяжуулах үйлдвэрлэл эрхлэх, дэд бүтцийн бусад төсөл хэрэгжүүлэх, зам, барилга барих зөвшөөрөл олгох шийдвэр буюу захиргааны акт гаргана. 	<p>Хуримтлагдах нөлөөллөөс байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд үзүүлсэн болон үзүүлж буй гол сөрөг нөлөөлөл, түүний үр дагаврын тухай, төслүүдийн хуримтлагдсан нөлөөллийн эрчим, цар хүрээ (цаг хугацаа, орон зай), тархалтыг тогтоох, нөлөөллийн үнэлгээний үе шатанд олон нийтийн оролцоог зөвлөлгөөн, хэлэлцүүлэг, санал асуулга явуулах замаар төслийн шууд болон шууд бус нөлөөллийг үнэлж, иргэдийн амьжиргаа, нийгмийн асуудлыг тусгахад анхаарах гэж заасан боловч хэрэгжилтийг хангахдаа ерөнхий мэдээлэл оруулж, нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийдэггүй. Гэвч Байгаль орчны стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний журмын 3.4-д “Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийх мэргэжлийн байгууллага нь ... дүгнэлт, зөвлөмж бүхий тайлан гаргах ба тайлан нь дараах мэдээллийг агуулна:... 3.4.2. тухайн бүс нутгийн байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд үзүүлсэн болон үзүүлж байгаа гол сөрөг нөлөөллүүд, тэдгээрийн үр дагаврын тодорхойлолт; 3.4.6. хуримтлагдсан сөрөг нөлөөллөөс үүдэн бий болсон байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндийн хохирлын үнэлгээ;” гэж нийгмийн нөлөөллийн талаар тусгасан.</p>
Тусгай зөвшөөрөл олгох/ цуцлах үе шат		
Шийдвэр	<ul style="list-style-type: none"> • Хайгуул: Ашигт малтмалын тухай хуулийн 7.1-т зааснаар сонгон шалгаруулалтад тэнцсэн ААН-д хайгуулын эсхүл ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгож, цуцална. • Ашигт малтмалыг боловсруулах, баяжуулах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагааг эрхлэх үйлдвэрлэл, дэд бүтцийн бусад төсөл хэрэгжүүлэх, зам, барилга барих тусгай зөвшөөрөл олгож, цуцална. 	<p>Тусгай зөвшөөрөл олгох, цуцлах, түтгэлзүүлэх процесст аливаа нөлөөллийн үнэлгээ хийгдэхгүй, хийх үндэслэл, хэм хэмжээ тогтоогоогүй.</p> <p>Аль ч тохиолдолд БОНБҮТХ-д зааснаар “төсөл” гэдэг ангилалд орж байгаагаас ТЭЗҮ, БОНБҮ-г хуулийн дагуу хийлгэж батлуулсан байх шаардлагатай. ТЭЗҮ болон БОНБҮ-д бодит нөлөөллийг хэрхэн үнэлэх аргачлалгүй учраас нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал</p>

		<ul style="list-style-type: none"> • Үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийг 2 нөхцөлөөр олгодог. <ul style="list-style-type: none"> - Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг хуулийн этгээдэд үйлдвэрлэл эрхлэхэд - Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй хуулийн этгээдэд үйлдвэрлэл эрхлэхэд 	болон нөлөөллийн үнэлгээ нь бүтэц, агуулгын хувь ижил төстэй мэдээлэлтэй, стандартгүй. Түүнчлэн БОНБУ боловсруулах эрхийг байгаль орчны асуудал хариуцсан яамаас авдаг ба зөвшөөрөл авсан хувийн хуулийн этгээд нь зөвхөн байгаль орчны чиглэлээр үнэлгээ хийх чиглэлээр мэргэшсэн байх шаардлагатай боловч бусад чиглэлээр мэргэшсэн, боловсон хүчинтэй, нөлөөллийн үнэлгээ хийх шаардлагагүй. ТЭЗҮ-д дүгнэлт гаргах ЭБМЗ-ийн хөндлөнгийн шинжээч нь геологич мэргэжилтэй байх шаардлагатай учраас зөвхөн геологийн нөөцийн үнэлгээг чухалчилж, нийгэм, байгаль орчин, эрүүл мэндийн нөлөөллийг тооцдоггүй.
Хугацаа		<ul style="list-style-type: none"> • Хайгуулын тусгай зөвшөөрлийн 3 жилийн хугацаатай олгож, 3 удаа сунгаж болно. • Ашиглалтын тусгай зөвшөөрлийг өргөдлийн дагуу 30 жилийн хугацаагаар олгож болно • Ашигт малтмалыг боловсруулах, баяжуулах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэр, цахилгаан станц барих, дэд бүтцийн объект барих, зам гүүр барих эрхийг тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаанд эрхэлж болно. Тусгай зөвшөөрлийг хэдэн ч удаа сунгаж болно. 	
Хайгуулын үе шат			
Байгаль менежментийн төлөвлөгөө	орчны	Хайгуулын тусгай зөвшөөрөл авсаны дараа мөн тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулахдаа буюу жил бүр Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулж мөн шинэчлэн сум, дүүргийн Засаг даргаар батлуулна.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь зөвхөн дараах асуудал болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх зардлын хэмжээг тогтоох асуудлыг хамарна ⁶⁸ : <ul style="list-style-type: none"> - уурхайн ажиллагааг байгаль орчинд хохирол багатай явуулах, агаар мандал болон усны бохирдолт, хүн, амьтан, ургамалд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх цогц арга хэмжээг тусгах; - хортой болон хор хөнөөл учруулж болзошгүй бодис, материалыг хадгалах, хяналт тавих; - газрын гадаргуугийн болон гүний усыг хамгаалах, ашиглах, хуримтлуулах; - уурхайн хаягдлын далан барих, уурхайн талбайн аюулгүй байдлыг хангах; - хүрээлэн байгаа орчны бохирдолтыг зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрүүлэхгүй байх, эвдэгдсэн газрыг булах, тэгшлэх, ургамалжуулах замаар цаашид нийтийн хэрэгцээний зориулалтаар ашиглаж болох нөхөн сэргээх арга хэмжээг тусгах; - тухайн уурхайн ажиллагааны онцлогтой холбогдсон бусад арга хэмжээ. Байгаль орчны стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний журмын 5.1-д “Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд ...дараах зүйлийг тусгана: ... 5.1.4. нүүлгэн шилжүүлэх, нутгийн иргэдийн эрүүл мэнд, эрх ашиг, амьжиргаа, соёлын өвийг хамгаалах болон бусад төлөвлөлттэй хэрхэн уялдсан байдал.” 5.4-д “Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний”

⁶⁸ Ашигт малтмалын тухай хууль, 39.1.3, 39.1.4

		салшгүй бүрэлдэхүүн хэсэг болох орчны хяналт-шинжилгээний ... хөтөлбөрт дараах асуудлыг нарийвчлан тусгасан байна: 5.4.1. нөлөөлөлд өртөж болзошгүй байгаль орчин, хүний эрүүл мэнд, нийгмийн төлөв байдлын суурь мэдээлэл ба төсөл хэрэгжсэнээр түүнд гарч болзошгүй тоон ба чанарын өөрчлөлт;”, 6.4. Мэргэжлийн зөвлөл нь үнэлгээний шинжилгээ хийсэн шинжээчийн дүгнэлт, шийдвэрийн төсөл, үнэлгээний тайлан, байгаль орчны менежментийн төлөвлөгөөтэй танилцаж дараах шийдвэрийн аль нэгийг гаргана: 6.4.3. төсөл нь байгаль орчин, хүний эрүүл мэндэд нэн халтай, нөхөх боломжгүй хохирол учруулна гэж үзсэн тохиолдолд төслийг хэрэгжүүлэхээс татгалзах.” 9.1. Мэргэжлийн зөвлөл нь байгаль орчин, нийгэм, эрүүл мэнд, эдийн засаг, хөгжлийн салбарын төлөөллийг оролцуулсан 10-аас доошгүй гишүүний бүрэлдэхүүнтэй байх ба гишүүд нь тухайн чиглэлээрээ 10-аас дээш жил ажилласан туршлагатай байна.” Гэж байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийхдээ нийгмийн нөлөөллийг хэрхэн тусгах талаар заажээ.
Ашигт малтмалын ордын урьдчилсан техник, эдийн засгийн үнэлгээ (Pre-Feasibility Study).	Ашигт малтмалын ордын урьдчилсан техник, эдийн засгийн үнэлгээ (УТЭЗҮ)-г хайгуулын шатанд гүйцэтгэнэ.	Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн ТЭЗҮ-д тавих үндсэн шаардлагууд, ТЭЗҮ хүлээж авах журмын дагуу зохицуулагдана. Бүтцэд олборлолтын боломж, дэд бүтэц, баяжуулалт, боловсруулалт, хөдөлмөр эрүүл ахуй, нийгмийн асуудал, аюулгүй ажиллагаа, эрсдэлийн менежмент, байгаль орчин, төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө, эдийн засаг, санхүүгийн үнэлгээний шаардлагуудыг тавьдаг. Тэдгээр нь зардлын тооцоо, төлөвлөгөө, эрсдэлийг хэрхэн удирдах аргачлал зэрэг мэдээлэл агуулна гэсэн ч зөвхөн зардлын тооцоог таамаг байдлаар гаргаж өгдөг. Техник, эдийн засгийн үндэслэл (Feasibility Study)-хэсгийг харна уу.
Ашиглалтын үе шат		
Техник, эдийн засгийн үндэслэл (Feasibility Study)	Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрөл авснаас хойш нэг жилийн дотор тухайн ордыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)-ийг эрх бүхий байгууллагаар хийлгэж батлуулна. ТЭЗҮ батлах эрх бүхий байгууллага нь УУХҮ-ийн сайдын тушаалаар батлагдсан Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл (ЭБМЗ) ба ТЭЗҮ-г 5 жил тутамд шинэчилж батлуулна. Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн ТЭЗҮ-	ТЭЗҮ-д талбайн нөөц, нөөцийн тооцоолол, үнэлгээ, хэмжил зүйн асуудлууд багтахаас гадна нийгэм, байгаль орчин, түүний дотор цэвэр ус, байгалийн бусад баялаг, эдийн засгийн үнэлгээ багтдаг. ТЭЗҮ боловсруулах бүтцэд олборлолт, дэд бүтэц, баяжуулалт, боловсруулалт, хөдөлмөр эрүүл ахуй, нийгмийн асуудал, аюулгүй ажиллагаа, эрсдэлийн менежмент, байгаль орчин, төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө, эдийн засаг, санхүүгийн үнэлгээний шаардлагуудыг тавьдаг. Гэвч Ашигт малтмалын баялгийн

	<p>д тавих үндсэн шаардлагууд, ТЭЗҮ хүлээж авах журмыг Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын 2012 оны 74 дүгээр тушаалаар баталсан.</p>	<p>урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн ТЭЗҮ-д тавих үндсэн шаардлагууд, ТЭЗҮ хүлээж авах журмын 6.1.12-т Хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн асуудал, аюулгүй ажиллагаа, эрсдэлийн менежмент-д нийгмийн нөлөөллийн төлөв байдлын үнэлгээгээр тодорхойлогдсон нийгмийн сөрөг нөлөөлөл, тэдгээрээс хамгийн эрсдэлтэй гэж үнэлсэн нөлөөллийг тусгах шаардлагатай гээд, ААН-үүд зөвхөн зардлын тооцооллыг гаргаж өгдөг.ТЭЗҮ-д дүгнэлт гаргах ЭБМЗ-ийн хөндлөнгийн шинжээч нь геологич мэргэжилтэй байх шаардлагатай учраас зөвхөн геологийн нөөцийн үнэлгээг чухалчилж, нийгэм, байгаль орчин, эрүүл мэндийн нөлөөллийг тооцдоггүй. Мөн ТЭЗҮ-г БОНБУ-нээс өмнө баталдаг зохицуулалттай тул аливаа нөлөөллийн үнэлгээг тооцдоггүй байна.</p>
<p>Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ</p>	<p>Төсөл хэрэгжүүлэгч нь холбогдох эрх бүхий байгууллагаар баталгаажсан техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны өнөөгийн төлөв байдлын тодорхойлолт, тухайн сум, дүүргийн Засаг даргын санал болон холбогдох бусад баримт бичгийг бүрдүүлэн энэ хуулийн хавсралтад заасан ангиллын дагуу байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл байгаль орчны албанд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлгэнэ.</p>	<p>Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ нь дүгнэлт хэлбэрээр гардаг ба дараах зүйлийг тусгана:</p> <ul style="list-style-type: none"> - техник, технологи, үйл ажиллагаа нь байгаль орчинд халтай, газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй, стратегийн үнэлгээний дүгнэлт болон холбогдох хууль тогтоомжид нийцээгүй төслийг хэрэгжүүлэхээс татгалзах, эсхүл буцаах; - төслийг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэлгүйгээр тодорхой нөхцөл, болзолтойгоор хэрэгжүүлэх боломжтой гэж үзэх; - байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай гэж үзэх.
<p>Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ</p>	<p>ТЭЗҮ батлагдсанаар ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан этгээд уг зөвшөөрөл авсны дараа байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэж, байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах тухайн уурхайн ажиллагааны явцад хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд учирч болзошгүй хортой нөлөөллийг урьдчилан тодорхойлж, түүнийг багасгах, арилгах арга хэмжээг тодорхойлно.</p> <p>Түүнчлэн БОНБУ боловсруулах эрхийг байгаль орчны асуудал хариуцсан яамаас авдаг ба зөвшөөрөл авсан хувийн хуулийн этгээд нь зөвхөн байгаль орчны чиглэлээр үнэлгээ хийх чиглэлээр мэргэшсэн байх шаардлагатай боловч бусад чиглэлээр мэргэшсэн, боловсон хүчинтэй, нөлөөллийн үнэлгээ хийх шаардлагагүй. Ашиглалтын тусгай зөвшөөрлийг сунгуулах бүрт БОНБУ-г шинэчилж батлуулна.</p>	<p>ТЭЗҮ болон БОНБУ-д бодит нөлөөллийг хэрхэн үнэлэх аргачлалгүй учраас нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал болон нөлөөллийн үнэлгээ нь бүтэц, агуулгын хувь ижил төстэй мэдээлэлтэй, стандартгүй.</p>

<p>Байгаль менежментийн төлөвлөгөө</p>	<p>орчны Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмших үед хийгдэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөтэй ижил жил бүр батлуулна..</p>	<p>Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх зардлын хэмжээг тогтоох асуудлыг хамарна⁶⁹:</p> <ul style="list-style-type: none"> - уурхайн ажиллагааг байгаль орчинд хохирол багатай явуулах, агаар мандал болон усны бохирдолт, хүн, амьтан, ургамалд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх цогц арга хэмжээг тусгах; - хортой болон хор хөнөөл учруулж болзошгүй бодис, материалыг хадгалах, хяналт тавих; - газрын гадаргуугийн болон гүний усыг хамгаалах, ашиглах, хуримтлуулах; - уурхайн хаягдлын далан барих, уурхайн талбайн аюулгүй байдлыг хангах; - хүрээлэн байгаа орчны бохирдолтыг зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрүүлэхгүй байх, эвдэгдсэн газрыг булах, тэгшлэх, ургамалжуулах замаар цаашид нийтийн хэрэгцээний зориулалтаар ашиглаж болох нөхөн сэргээх арга хэмжээг тусгах; - тухайн уурхайн ажиллагааны онцлогтой холбогдсон бусад арга хэмжээ. <p>Байгаль орчны стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний журмын 5.1-д “Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд ...дараах зүйлийг тусгана: ... 5.1.4. нүүлгэн шилжүүлэх, нутгийн иргэдийн эрүүл мэнд, эрх ашиг, амьжиргаа, соёлын өвийг хамгаалах болон бусад төлөвлөлттэй хэрхэн уялдсан байдал.” 5.4-д “Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний салшгүй бүрэлдэхүүн хэсэг болох орчны хяналт-шинжилгээний ... хөтөлбөрт дараах асуудлыг нарийвчлан тусгасан байна: 5.4.1. нөлөөлөлд өртөж болзошгүй байгаль орчин, хүний эрүүл мэнд, нийгмийн төлөв байдлын суурь мэдээлэл ба төсөл хэрэгжсэнээр түүнд гарч болзошгүй тоон ба чанарын өөрчлөлт;”, 6.4. Мэргэжлийн зөвлөл нь үнэлгээний шинжилгээ хийсэн шинжээчийн дүгнэлт, шийдвэрийн төсөл, үнэлгээний тайлан, байгаль орчны менежментийн төлөвлөгөөтэй танилцаж дараах шийдвэрийн аль нэгийг гаргана: 6.4.3. төсөл нь байгаль орчин, хүний эрүүл мэндэд нэн халтай, нөхөх боломжгүй хохирол учруулна гэж үзсэн тохиолдолд төслийг хэрэгжүүлэхээс татгалзах.” 9.1. Мэргэжлийн зөвлөл нь байгаль орчин, нийгэм, эрүүл мэнд, эдийн засаг, хөгжлийн салбарын төлөөллийг оролцуулсан 10-аас доошгүй гишүүний бүрэлдэхүүнтэй байх ба гишүүд нь тухайн чиглэлээрээ 10-аас дээш жил ажилласан туршлагатай байна.” Гэж байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийхдээ нийгмийн нөлөөллийг хэрхэн тусгах талаар заажээ.</p>
--	---	---

⁶⁹ Ашигт малтмалын тухай хууль, 39.1.3, 39.1.4

Орон нутагт гэрээ байгуулах үе шат		
<p>Төсөл хэрэгжүүлэх орон нутагт шууд холбогдох гэрээ</p>	<ul style="list-style-type: none"> Төрийн захиргааны байгууллага нь тусгай зөвшөөрөл бүхий ААН-тэй газар, ус ашиглах гэрээг хайгуулын тусгай зөвшөөрөл олгосны дараа байгуулна. АМТХ-ийн 42 дугаар зүйлд зааснаар орон нутгийн засаг захиргааны байгууллагатай орон нутгийн ажил эрхлэлт, орон нутгийн хөгжлийн гэрээ (“Орон нутгийн гэрээ”) буюу захиргааны гэрээг ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосны дараа байгуулна. Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай ашиглалтын тусгай зөвшөөрөл авмагц гэрээ байгуулж ажиллана⁷⁰. Хуулийн дээрх заалтын дагуу ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон нутгийн захиргааны байгууллагын хооронд байгуулах “Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай гэрээ”-ний загварыг Засгийн газрын 2016 оны 179 дүгээр тогтоолоор баталсан⁷¹. <p>Ердийн ашигт малтмал, түгээмэл тархацтай ашигт малтмал, цацраг идэвхит ашигт малтмал ашиглах, газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулахад БОНБУ, ТЭЗҮ батлуулж, орон нутгийн гэрээг байгуулахаар тус тусын хуульд заасан.</p>	<p>ЗГ нь 2016 онд “Байгаль хамгаалах, уурхайтай холбоотой дэд бүтцийг хөгжүүлэх, үйлдвэр байгуулах, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хийх гэрээний загвар” (цаашид, “Загвар гэрээ”)-ыг батлан гаргасан. Баталсан гэрээний загварт нийгмийн зарим асуудал тусгагдсан ч хяналт хариуцлага хэрэгжүүлэх нөхцөлийг заагаагүй. Мөн загвар гэрээнд талууд хэлэлцэж өөрчлөлт оруулах боломжтой. Гэрээ нь Захиргааны акт батлах учраас төрийн захиргааны байгууллага болон орон нутгийн засаг захиргааны байгууллага нь Захиргааны ерөнхий хуулийн сонсох ажиллагаа явагдах үндэслэлтэй бөгөөд оролцогчийн хувьд ач холбогдол бүхий нөхцөл байдлыг тогтоохоор хуульд заасан тул захиргааны гэрээ байгуулахад нийгэм, байгаль орчин, эдийн засаг, эрүүл мэндийн нөхцөл байдлыг үнэлэхээр зохицуулсан боловч хэрэгждэггүй. Одоогийн байдлаар орон нутгийн оролцогчдын дунд сонсох ажиллагаа хийдэггүй.</p> <p>Орон нутгийн гэрээг ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд орон нутгийн удирдлагатай заавал байгуулж орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тухайн орон нутгийн иргэдийг сургалтад хамруулах, бусад асуудлыг сайн дурын үндсэн дээр тохиролцон шийдвэрлэхээр заасан.</p> <p>Практикт орон нутгийн гэрээний үр дүнг хэзээ, яаж тооцох нь тодорхой бус, тусгай зөвшөөрлийн хугацаанд гэрээг хэрэгжүүлэхээр зохицуулж байгаагаас гэрээний үр дүн, нийгэм, эдийн засагт гарч байгаа үр нөлөө, ач холбогдлыг тооцох аргагүй байна.</p>
Тайлагнах үе шат		
<p>Зохицуулагч байгууллагуудын шаардлагаар тайлагнах</p>	<ul style="list-style-type: none"> Дэд бүтцийн төсөл хэрэгжүүлэх, зам, барилга барих, ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нь хөрөнгө санхүү, нийгмийн даатгал, татвар г.м тайланг хугацаанд нь гаргахаас гадна жил бүр байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт, орон нутагт байгуулсан гэрээ үүргийн биелэлтийг тайлагнах үүрэгтэй. 	<p>Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орон нутагт байгуулсан гэрээний үүрэгт нийгэм болон бусад нөлөөллийн үнэлгээ хийх, тайлагнах нөхцөл тусгагдаагүй.</p> <p>Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайлан, Хайгуулын ажлын жилийн тайлан, ордын нөөц, эрэл, хайгуулын үр дүнгийн тайланд нийгмийн талаас аливаа мэдээлэл оруулахгүй, зөвхөн</p>

⁷⁰ Ашигт малтмалын тухай хууль 42.1

⁷¹ <https://www.legalinfo.mn/annex/details/7245?lawid=11852>

	<ul style="list-style-type: none"> • AMHATT, Хайгуулын ажлын жилийн тайлан, ордын нөөц, эрэл, хайгуулын үр дүнгийн тайланг төрийн захиргааны байгууллагад жилд 1 удаа хүргүүлдэг. • Компанийн жилийн тайланг жилд 1 удаа гаргана. 	<p>тээвэрлэлт, борлуулалт, төлбөрийн мэдээлэл болон хайгуулын илэрц, илэрцийн хэмжээ, тооцоолол зэрэг багтана.</p> <p>Компанийн жилийн тайлангийн стандарт байхгүй. МХБ-д бүртгэлтэй компаниудын дийлэнх нь жилийн тайлангаа нийтэд мэдээлнэ. Тайланд нийгмийн болон бусад нөлөөллийн үнэлгээ ордоггүй⁷².</p>
Хаалтын үе шат		
<p>Уурхайн үйл ажиллагаа дуусгавар болох</p>	<p>Хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, тухайн ордыг ашиглах болон үйлдвэрийн техник эдийн засгийн үндэслэлдээ Ашигт малтмалын тухай хуулийн 26.2.3, 27.1.12-т заасны дагуу хаалтын менежментийн урьдчилсан төлөвлөлтийн талаар тусгана. Харин Төсөл хэрэгжүүлэгч нь уурхай, үйлдвэрийг бүхэлд нь хаахаар бол хаалтын менежментийн нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж, УУХҮЯ, БОАЖЯ-д илгээж санал авсан, АМГТГ-аас зөвшөөрөл авна.</p> <p>АМТХ-ийн 10.1.14-т уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журмыг орон тооны бус бодлогын зөвлөл байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлахаар заасан. <i>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/181, А/458 дугаар хамтарсан тушаалын I хавсралтаар</i> Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журмыг баталсан. Журмын дагуу Хаалтын менежментийн төлөвлөгөөг боловсруулж батлна.</p>	<p>Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхдээ байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон хаалтын менежментийн төлөвлөгөөнл тусгагдсан үүргээ бүрэн биелүүлсэн байх үүргийг төслийн болон уурхайн хаалтаар хэрэгжүүлнэ гэж заасан.</p> <p>2.2. Хаалтын менежментийн төлөвлөгөө нь дараах агуулгатай байна. Үүнд:</p> <p>2.2.1.төслийн тойм, хаалтын зорилго, зорилт;</p> <p>2.2.2.хаалтын дараах газар ашиглах зориулалт;</p> <p>2.2.3.хаалтын дараах гүйцэтгэлийн физикийн тогтвортой байдлын үзүүлэлтүүд;</p> <p>2.2.4.хаалтын дараах гүйцэтгэлийн химийн тогтвортой байдлын үзүүлэлтүүд;</p> <p>2.2.5.дэд бүтэц, техник, тоног төхөөрөмж, барилга байгууламжийг буулгах, нүүлгэн шилжүүлэх, нураах, аюулгүй болгохтой холбоотойгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ;</p> <p>2.2.6.төслийн талбай дээр физик, химийн тогтвортой байдал, иргэдийн эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах, байгаль орчныг хамгаалахад чиглэсэн явцын болон хаалтын нөхөн сэргээлтийн төлөвлөлт;</p> <p>2.2.7.хаалтын өмнө болон дараах тодорхой хугацаанд уурхайн ажиллагсад болон нөлөөлөлд өртөх иргэдийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний нарийвчилсан төлөвлөлт;</p> <p>2.2.8.уурхайн хаалтын бэлтгэл ажлыг хангахад хангалттай хүрэлцэхүйц, шилжилтийн үед авах арга хэмжээний нарийвчилсан төлөвлөлт;</p>

⁷² Listed companies' annual reports evaluation, ARAM Project, FRC and CGDC 2015-2018

		<p>2.2.9.хаалтын дараах аливаа эрсдэлийн үнэлгээ, тэдгээрээс урьдчилан сэргийлэх болон бууруулах арга хэмжээний нарийвчилсан төлөвлөлт;</p> <p>2.2.10.хаалтын дараах орчны хяналт шинжилгээ, арчилгаа, тордолтын ажлын нарийвчилсан төлөвлөгөө;</p> <p>2.2.11.түр болон гэнэтийн хаалтын үед авах арга хэмжээний төлөвлөгөө...</p> <p>Хаалтын эрсдэлийг үнэлэхдээ эрсдлийг аль болох бага хэмжээнд байлгах хяналтын арга хэмжээнүүдийг тусгасан байх, хаалтын менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа хаалтад хамаарах газрыг нийтлэг шинж чанараар (ил, далд малталтууд, хаягдлын байгууламжийн, дэд бүтцийн байгууламжийн г.м.) нь бүлэглэж, бүлэглэсэн газар бүрийг хаалтын өмнө, явцад, дараа яаж өөрчлөгдсөн байх талаар тусгах шаардлагыг тавьсан байна. Хэрэгжилт дээр уул уурхайн салбарт уурхайн хаалтыг хийхдээ байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэлийг нягталж, дээрх хүрээнд стандарт заагаагүй учраас байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэхээргүй бол нийгмийн нөлөөллийг үнэлдэггүй.</p>
Нөхөн сэргээлтийн үе шат		
Хаалтын дараа	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, 2015 оны Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын А-138 тоот тушаалаар баталагдсан Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлалын дагуу гүйцэтгэнэ.	<p>Нөхөн сэргээлтийн үйл ажиллагааг хянах байгууллагуудын эрх хэмжээ, ажил үүргийн давхардал эсхүл цоорхойгоос болж үйл ажиллагааны дунд үе болон хаалтын дараах нөхөн сэргээлтэд тавигдах хяналт хязгаарлагдмал, бусад нийгмийн асуудлыг тооцдоггүй. Жил бүр нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний дагуу ажлаа гүйцэтгэх, гүйцэтгээгүй нөхцөлд тухайн жилийн олборлолтын ажиллагааг зогсоох мөн нөхөн сэргээлтэд байршуулсан төлбөрийг төлөхгүй байх хариуцлагыг хүлээлгэхээр хязгаарлагдсан. Журамд зааснаар газар, хөрс, агаар, газрын шимт давхрагыг сэргээх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг хэрхэн авахыг заасан боловч нийгмийн нөлөөллийн үнэлгээг тооцдоггүй.</p> <p>Бусад төсөлд нөхөн сэргээлт хамаарахгүй ба нийгмийн нөлөөллийг үнэлэхгүй.</p>
Хяналтын үе шат		
Явцын дунд	<ul style="list-style-type: none"> • ААН-ийн үйл ажиллагаанд тавих хяналтыг Мэргэжлийн хяналтын газар зэрэг төрийн захиргааны байгууллагууд өөрсдийн хариуцсан чиглэлээр хэрэгжүүлнэ. 	Хяналтын үйл ажиллагаанд хуулийн хэрэгжилтийг хийх ба нөлөөллийг үнэлэх ажил хийгдэхгүй.

	<ul style="list-style-type: none">• БОМТ-г Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар,• ТЭЗҮ-г Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл,• БОНБЕҮ, БОНБНҮ-г Байгаль орчин аялал жуулчлалын яам хариуцан хянана.	
--	--	--

Хавсралт 2. Саналын товъёог

“ГОВИЙН ЗАГВАР” ТӨСЛИЙН ЗӨВЛӨХ БАГИЙН БОЛОВСРУУЛЖ БУЙ НИЙГМИЙН НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛЫН ТӨСӨЛД ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ТӨВ БОЛОН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, ОРОН НУТГИЙН НӨЛӨӨЛӨЛД ӨРТСӨН МАЛЧИД, ИРГЭД БОЛОН БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭДИЙН ТӨЛӨӨЛЛӨӨС ИРҮҮЛСЭН САНАЛЫН ТОВЪЁОГ

№	Огноо	Харьяалал	Санал	Нийгмийн нөлөөллийн үнэлгээний аргачлалд тусгасан байдал
1	2020.07.05	Дорноговь аймаг, Даланжаргалан сумын Бичигт багийн малчин	Усалгаа, цэвэр усны хомсдол үүсэж байгаа учраас усыг хяналттай болгох	Тусгагдсан. ННҮ-ний гол зарчим нь тухайн бүс нутагт уул уурхайн төслийн нөлөөлөлд өртөж байгаа иргэдийн нийгмийн нөлөөллийг үнэлэх бөгөөд цэвэр усны хосдолоос сэргийлэх, усыг хэмнэх, зарцуулалтыг хянах асуудлыг шууд утгаар хамаарахгүй. Харин ННҮА-ын 6.5-д Төслийн нийгмийн нөлөөллийн менежментийн төлөвлөгөө боловсруулахдаа нийгмийн сөрөг нөлөөллөөс зайлсхийх, түүнийг бууруулах, нөхөн сэргээх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахаар заасан. Мөн нийгмийн нөлөөллийг үнэлэх хяналт-шинжилгээний хөтөлбөрийг боловсруулахдаа шалгуур үзүүлэлтэд <ul style="list-style-type: none"> - Бэлчээр, усны боломжоос шалтгаалан жилд хийх нүүдлийн тоог жил бүрээр мөн - Ширгэсэн, ус нь багассан худгийн тоог жил бүрээр гаргахаар байгаа.
2	2020.07.05	Дорноговь аймаг, Даланжаргалан сумын Элдэв баг хариуцсан байгаль орчныг хамгаалах бүлгийн ахлагч	Нийгмийн асуудлыг ажлын байр бий болгож шийдвэрлэх. Жишээ нь 5 айлын дунд 1 тариалангийн, усалгаатай талбай бий болгох гэх мэт	Тусгагдсан. ННҮА-ын 6.4-т Төслийн нийгмийн нөлөөллөөс зайлсхийх, түүнийг бууруулах, нөхөн сэргээх төлөвлөгөө боловсруулах хэсгийн Төслийн орон нутагт бий болгох өгөөж, үр шимийг нэмэгдүүлэх арга замуудад орон нутагт ажлын байр бий болгох, орон нутгаас худалдан авалт хийх зөвлөмж оруулсан. Зөвлөмжийн дагуу орон нутгийн нөхцөл байдалд тулгуурлан, төсөл хэрэгжүүлэгчийн зүгээс орон нутагт эдийн засгийн үр ашиг авчиргах тухайлсан арга хэмжээнүүдийг авах хэрэгтэй. Үүнд, орон нутгийн иргэдийн ажиллах боломжтой ажлын байруудыг тодорхойлох, мөн орон нутгийн бизнес эрхлэгчдийг төсөлд бараа, үйлчилгээгээ худалдаж, ханган нийлүүлэгч болох боломжийг олгох зэрэг асуудлыг багтаасан. Мөн үнэлгээний энэ хэсгийг орон нутгийн хөгжлийн гэрээнд тусгаж баталгаажуулахаар санал болгон дээрх хөтөлбөрүүдийн хүрээнд бий болсон байнгын болон түр ажлын байрны тоог жил бүрээр гаргаж хянах шалгуур үзүүлэлттэй.
3	2020.07.05	Бичигт багийн ИТХ-ын дарга	Орон нутгийн гэрээ байгуулахаас өмнө нутгийн иргэдээс санал авах, хэлэлцүүлэх шаардлагатай	Тусгах шаардлагагүй. ННҮ-г төсөл эхлэхээс өмнө гүйцэтгэхээр зааж байгаа нь зарчмын хувьд орон нутгийн гэрээ байгуулахаас өмнө хийгдэхээр байна. Мөн ННҮ-гээр тодорхойлогдсон асуудлыг орон нутгийн хөгжлийн гэрээнд тусгаж шийдвэрлэхийг аргачлалын заавраар удирдамж болгосон.

4	2020.07.05	Бичигт багийн малчин	Орон нутгийн иргэдийг нүүлгэн шилжүүлэхэд гарах нөхөн төлбөрийг тооцоолдог болох	Тусгагдсан. АМТХ-ын 41.1 дэхь хэсэгт шилжүүлэн байршуулахтай холбоотой зардлыг ТЗ эзэмшигч төлөх зохицуулалтын дагуу ННҮА-ын 6.4-т Төслийн нийгмийн нөлөөллөөс зайлсхийх, түүнийг бууруулах, нөхөн сэргээх төлөвлөгөө боловсруулах үе шатны зорилго нь төслийн үйл ажиллагаанаас учирч болзошгүй сөрөг нөлөөллөөс зайлсхийх, зайлсхийх боломжгүй бол бууруулах, бууруулах боломжгүй бол орчин, нөхцөлийг нөхөн сэргээх, нөлөөллийн бүсийн иргэдийг нүүлгэн шилжүүлэх, мөнгөн ба мөнгөн бус хэлбэрээр нөхөн төлбөр олгох төлөвлөгөө боловсруулах, арга замуудыг гаргаж, тодорхойлох юм. Мөн гомдол хянан шийдвэрлэх механизмыг бүрдүүлэх, иргэдийн гомдолд хариу өгөхдөө уучлалт гуйх, алдсан эд хөрөнгийг ижил төрлийн зүйлээр нөхөн төлөх, мөнгөн хэлбэрээр нөхөн төлөх, нөхөн сэргээх болон ижил төрлийн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах зэрэг багтааж зөвлөмж байдлаар оруулсан. Тухайлбал газар олгох, нүүлгэн шилжүүлэлттэй холбоотой гарсан бүх зардлыг нөхөн төлөх, тухайн орон нутаг, газарт (орон сууцанд) байнга оршин сууж байсан, газрыг өмчлөх, эзэмших албан ёсны эрхтэй эсэхээс үл хамааран шаардлага хангасан, эрхийн зөрчилгүй орон байраар хангах, амьжиргааг хадгалах, дэмжих, мөн нүүлгэн шилжүүлэгдсэн иргэдэд төслийн үр ашгаас хүртэх боломжийг олгох г.м заасан.
5	2020.07.05	Бичигт багийн малчин	Орон нутгийн иргэдэд учирч байгаа сэтгэл санааны хохирлыг үнэлэх, нөхөн төлбөрийг тооцоолдог болох	Тусгагдаагүй. ННҮА-ын 6.4-т Төслийн нийгмийн нөлөөллөөс зайлсхийх, түүнийг бууруулах, нөхөн сэргээх төлөвлөгөө боловсруулах үе шатны зорилго нь төслийн үйл ажиллагаанаас учирч болзошгүй сөрөг нөлөөллөөс зайлсхийх, зайлсхийх боломжгүй бол бууруулах, бууруулах боломжгүй бол орчин, нөхцөлийг нөхөн сэргээх, нөлөөллийн бүсийн иргэдийг нүүлгэн шилжүүлэх, мөнгөн ба мөнгөн бус хэлбэрээр нөхөн төлбөр олгох төлөвлөгөө боловсруулах, арга замуудыг гаргаж, тодорхойлох боловч сэтгэл санааны хохирлыг үнэлэх баримжаа, чиг хандлага эрх зүйн орчинд суугаагүй учраас уг арга хэмжээг оруулаагүй. Компани, иргэд хоорондын зөвшилцөлөөр энэ асуудлыг хөндөж, шийдвэрлэх талаар арга хэмжээг БОННМТ-нд тусгаж шийдэх гарц санал болгоно.
6	2020.07.05	Бичигт багийн малчин	Байгаль орчны нөхөн сэргээлт хийх төлбөрийг яаж зарцуулахыг ИТХ шийддэгийг болиулах, тухайн багийн иргэдээс санал авч шийддэг болох	Тусгагдаагүй. Бие даасан хуулийн зохицуулалттай. ННҮ-ний гол зарчим нь тухайн бүс нутагт уул уурхайн төслийн нөлөөлөлд өртөж байгаа иргэдийн нийгмийн нөлөөллийг үнэлэх юм. Байгаль орчны нөхөн сэргээлт хийх төлбөрийн асуудлыг зохицуулахгүй. ННҮ-ний аргачлалаар хурлыг газар дээр нь, төслийн өмнө зохион байгуулж хэлэлцэн шийдвэрлэх, харин хяналтыг БОННМТ, орон нутгийн гэрээгээр дамжуулан гүйцэтгэхээр төлөвлөсөн.
7	2020.07.05	Бичигт багийн малчин	Өвөлжөө газарт ороход хаана очих нь тодорхой болгох	Тусгагдаагүй. Малчидын сэлгэн нүүх байршлыг аргачлалаар тогтоох боломжгүй.
8	2020.07.05	Бичигт багийн малчин	Газар чөлөөлөх бүсэд орсон иргэдийн асуудлыг шийдвэрлэх	Тусгагдсан. ННҮА-ын 6.4-т Төслийн нийгмийн нөлөөллөөс зайлсхийх, түүнийг бууруулах, нөхөн сэргээх төлөвлөгөө боловсруулах үе шатны зорилго нь төслийн үйл ажиллагаанаас учирч

				болзошгүй сөрөг нөлөөллөөс зайлсхийх, зайлсхийх боломжгүй бол бууруулах, бууруулах боломжгүй бол орчин, нөхцөлийг нөхөн сэргээх, нөлөөллийн бүсийн иргэдийг нүүлгэн шилжүүлэх, мөнгөн ба мөнгөн бус хэлбэрээр нөхөн төлбөр олгох төлөвлөгөө боловсруулах, арга замуудыг гаргаж, тодорхойлохоор байна. Тухайлбал газар олгох, нүүлгэн шилжүүлэлттэй холбоотой гарсан бүх зардлыг нөхөн төлөх, тухайн орон нутаг, газарт (орон сууцанд) байнга оршин сууж байсан, газрыг өмчлөх, эзэмших албан ёсны эрхтэй эсэхээс үл хамааран шаардлага хангасан, эрхийн зөрчилгүй орон байраар хангах, амьжиргааг хадгалах, дэмжих, мөн нүүлгэн шилжүүлэгдсэн иргэдэд төслийн үр ашгаас хүртэх боломжийг олгох г.м заасан.
9	2020.07.05	Бичигт багийн малчин	Нутгийн уугуул иргэд байтал гэрчилгээ аваагүй гэдгээр хөөгдөх асуудал гараад байна	Зарчмын хувьд тусгагдсан. Газар ашиглах, эзэмших эрхийн асуудлыг аргачлалаар тогтоох боломжгүй. Харин олон улсын туршлагаар бүртгэгдээгүй эрхийг хүлээн зөвшөөрөх, нөхөн олговор олгоход хийгдэх ажлыг БОННМТ-д тусгаж шийдвэрлэх боломжтой.
10	2020.07.05	Бичигт багийн малчин	Уул уурхайн хүнд даацын автомашин айлын үүдээр явах зам гаргах зөвшөөрлийг олгодог байдлыг болиулах	Тусгагдсан. Төслийн нийгмийн нөлөөллийн бүсийг урьдчилсан байдлаар гаргахдаа нөлөөлөлд өртөж буй талуудыг тодорхойлохоор байгаа. Мөн Нийгмийн нөлөөллийг үнэлэх хяналт-шинжилгээний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэхдээ замын дагуу амьдардаг хүмүүс, амьдардаг газрынх нь ойролцоо тэсэлгээ явагддаг хүмүүс гэх мэт төслийн нөлөөлөлд өртөж буй хэсгийнхэнд гарах өөрчлөлтийг хянах шалгууруудыг заавал оруулахаар заасан.
11	2020.07.05	Бичигт багийн малчин	Их хөгжлийн сангийн үйл ажиллагааг нээлттэй, иргэдэд хүртээмжтэй болгох шаардлагатай	Тусгагдаагүй. Нэрлэсэн ТББ-ын үйл ажиллагааг аргачлалаар зохицуулах боломжгүй. Төслийн орон нутагт бий болгох өгөөж, үр шимийг нэмэгдүүлэх арга замуудыг тодорхойлох үе шатанд Нийгмийн хөрөнгө оруулалтын сан байгуулж уул уурхайн үйлдвэрлэлээс олж буй ашгийн тодорхой хувийг орон нутагт стратегийн нийгмийн хөрөнгө оруулалт хэлбэрээр хэрэгжүүлэх, төслөөс орон нутгийн хүртэх үр өгөөжийг хуваалцах, нийгмийн хөрөнгө оруулалт болохын хувьд орон нутагт холбогдох хуулийн дагуу төлдөг татвар, роялти болон хохирлын нөхөн төлбөрөөс тусдаа, нэмэлт үйл ажиллагаа байдлаар хэрэгжих ёстой гэж зарчмыг тусгасан. Цаашид эрх зүйн зохицуулалтыг сайжруулах санал зөвлөмжилнө.
12	2020.07.05	Бичигт багийн малчин	Нөхөн сэргээлтийг жил бүр хянаж, хийгдсэн тохиолдолд тусгай зөвшөөрлийг сунгах зэрэг асуудлыг шийдвэрлэх шаардлагатай.	Тусгагдсан. ННҮА-ын 6.4-т Төслийн нийгмийн нөлөөллөөс зайлсхийх, түүнийг бууруулах, нөхөн сэргээх төлөвлөгөө боловсруулахдаа Төслийн улмаас үүсч болзошгүй сөрөг нөлөөллөөс зайлсхийх, түүнийг бууруулах, нөхөн сэргээх арга замуудыг тодорхойлохдоо нөхөн сэргээх стратеги боловсруулан мөрөг нөлөөллийг бууруулахыг шаардана. Арилгах, бууруулах арга хэмжээ авах ноцтой нөлөөллүүдийг эрэмбэлэн гаргах үе шатанд Төслийн шууд, дам, хуримтлагдах нөлөөллийг тодорхойлсны дараа тэдгээрийг эрэмбэлж, хамгийн ноцтой, нөлөөллөөс зайлсхийх, бууруулах, төслийн улмаас үүсч болзошгүй шууд, дам, хуримтлагдах нөлөөллийг

				гаргасны дараа эрэмбэлэн үнэлэх матрицын арга зүй ашиглан тодорхойлсон бүх нийгмийн нөлөөллийг тохиолдох магадлал, нөлөөллийн зэргээр нь үнэлж, хамгийн ноцтой, нөлөөллөөс зайлсхийх, бууруулах, нөхөн сэргээх арга хэмжээ зайлшгүй авах шаардлагатай нөхцөлүүдийг тогтоохоор заасан.
13	2020.07.05	Бичигт багийн малчин	Ажлын байрны захиалга өгөх, орон нутгийн иргэдийг ажилд авах, авсан хойноо тогтвортой ажиллуулах баталгааг ямар нэгэн байдлаар гаргуулах	Тусгагдсан. ННҮА-ын 6.4-т Төслийн нийгмийн нөлөөллөөс зайлсхийх, түүнийг бууруулах, нөхөн сэргээх төлөвлөгөө боловсруулах хэсгийн Төслийн орон нутагт бий болгох өгөөж, үр шимийг нэмэгдүүлэх арга замуудад орон нутагт ажлын байр бий болгох, орон нутгаас худалдан авалт хийх зөвлөмж оруулсан. Зөвлөмжийн дагуу орон нутгийн нөхцөл байдалд тулгуурлан, төсөл хэрэгжүүлэгчийн зүгээс орон нутагт эдийн засгийн үр ашиг авчиргах тухайлсан арга хэмжээнүүдийг авах хэрэгтэй. Үүнд, орон нутгийн иргэдийн ажиллах боломжтой ажлын байруудыг тодорхойлох, мөн орон нутгийн бизнес эрхлэгчдийг төсөлд бараа, үйлчилгээгээ худалдаж, ханган нийлүүлэгч болох боломжийг олгох зэрэг асуудлыг багтаасан. Мөн үнэлгээний энэ хэсгийг орон нутгийн хөгжлийн гэрээнд тусгаж баталгаажуулахаар санал болгон дээрх хөтөлбөрүүдийн хүрээнд бий болсон байнгын болон түр ажлын байрны тоог жил бүрээр гаргаж хянах шалгуур үзүүлэлттэй.
14	2020.07.05	Бичигт багийн малчин	Ажлын унаа гаргаж өглөө орой хүргэдэг болгох	Тусгах боломжгүй. Компанийн нийгмийн хариуцлагыг аргачлалаар заах биш хяналт-шинжилгээний хөтөлбөрийн дагуу хянах ажиллагаа хийгдэхээр тусгагдсан.
15	2020.07.05	Бичигт багийн малчин	Осол гарах, тоос тоосонцор, шороо бужигнах байдлыг бууруулахын тулд олон замыг багасгах	Тусгагдсан. Төслийн нийгмийн нөлөөллийн бүсийг урьдчилсан байдлаар гаргахдаа нөлөөлөлд өртөж буй талуудыг тодорхойлохоор байгаа. Мөн Нийгмийн нөлөөллийг үнэлэх хяналт-шинжилгээний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэхдээ замын дагуу амьдардаг хүмүүс, амьдардаг газрынх нь ойролцоо тэсэлгээ явагддаг хүмүүс гэх мэт төслийн нөлөөлөлд өртөж буй хэсгийнхэнд гарах өөрчлөлтийг хянах шалгууруудыг заавал оруулахаар заасан.
16	2020.07.05	Бичигт багийн малчин	Компаниуд малчдыг ядаж жилд 2 удаа эмчийн үзлэгт хамруулдаг баймаар байна	Шууд утгаар тусгагдаагүй. Нийгмийн нөлөөллийг үнэлэхдээ багийн хурлыг зохион байгуулж, тухайн багийн иргэдээс санал асуулга явуулан хэрэгцээ шаардлагыг тодорхойлон шийдвэрлэх арга замыг БОННМТ болон орон нутгийн хөгжлийн гэрээнд тусгаж шийдвэрлэхээр зохицуулна. Мөн Нийгмийн нөлөөллийг үнэлэх хяналт шинжилгээний төлөвлөгөө боловсруулахдаа Хүн амын бие махбод, сэтгэцийн эрүүл мэнд, мал, амьтны эрүүл мэнд, нийгмийн амгалан тайван байдалд гарсан өөрчлөлтийг хэмжихээр заасан. Шалгуур үзүүлэлтүүд, хэмжих давтамжид - Орон нутгийн иргэдийн эрүүл мэндэд гарсан өөрчлөлт, төсөл хэрэгжүүлэгчийн хэрэгжүүлсэн эрүүл мэндийн хөтөлбөрийн тоо, хамрагдсан хүмүүсийн тоог жил бүр

				- Төсөл хэрэгжсэнээс хойших хугацаанд иргэдийн эрүүл мэндэд гарсан өөрчлөлтийг жил бүр хэмжиж гаргахаар заасан.
17	2020.07.05	Бичигт багийн малчин	Хөгжлийн сан нэртэй сангуудын үйл ажиллагааг орон нутагт бодитоор нийгмийн асуудлыг шийддэг, ил тод болгох	Зарчмын хувьд тусгагдсан. Тухайн төслийн орон нутагт бий болгох өгөөж, үр шимийг нэмэгдүүлэх арга замуудыг тодорхойлох үе шатанд Нийгмийн хөрөнгө оруулалтын сан байгуулж уул уурхайн үйлдвэрлэлээс олж буй ашгийн тодорхой хувийг орон нутагт стратегийн нийгмийн хөрөнгө оруулалт хэлбэрээр хэрэгжүүлэх, төслөөс орон нутгийн хүртэх үр өгөөжийг хуваалцах, нийгмийн хөрөнгө оруулалт болохын хувьд орон нутагт холбогдох хуулийн дагуу төлдөг татвар, роялти болон хохирлын нөхөн төлбөрөөс тусдаа, нэмэлт үйл ажиллагаа байдлаар хэрэгжих ёстой. Төслөөс оруулж буй нийгмийн хөрөнгө оруулалт нь дараах хэлбэрүүдтэй байж болно: орон нутгийн иргэдийн өөрсдийн удирддаг нийгмийн хөрөнгө оруулалтын санд тодорхой хэмжээний хөрөнгө оруулах, сургууль, эмнэлэг зэрэг нийгмийн дэд бүтцэд хөрөнгө оруулах, зээлийн сан (ялангуяа бичил санхүүгийн) үүсгэж орон нутгийн иргэдэд зээл авах боломж бүрдүүлэх, энэ нь шинэ бизнесийг бий болгож, улмаар төслийн ханган нийлүүлэгч болох боломжтой гэх байдлаар аргачлалыг зөвлөмжилсөн.
18	2020.07.05	Бичигт багийн малчин	Компаний зүгээс нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн ажлыг ил тод болгох	Тусгах боломжгүй. Компанийн нийгмийн хариуцлагыг аргачлалаар заах биш хяналт-шинжилгээний хөтөлбөрийн дагуу хянах ажиллагаа хийгдэхээр тусгагдсан. БОННУ-ий аргачлалд баримтлах зарчим болон тайланах хэсэгт компанийн нийгмийн хариуцлагыг үнэлж болно.
19	2020.07.05	Бичигт багийн малчин	Малчдын бэлчээр хомсдсон, ус багассан, уурхайн тоос шороо, угаар угаанд хордсон талаарх асуудлууд ил тод болж гарч ирсэн учраас малчин өрхүүдээ тусламж дэмжлэг үзүүлэх ёстой	Тусгагдсан. Нийгмийн нөлөөллийг үнэлэхдээ багийн хурлыг зохион байгуулж, тухайн багийн иргэдээ санал асуулга явуулан хэрэгцээ шаардлагыг тодорхойлон шийдвэрлэх арга замыг ННУ, ННМТ болон орон нутгийн хөгжлийн гэрээнд тусгаж шийдвэрлэхээр зохицуулна. Мөн ННУА-ын 6.5-д Төслийн нийгмийн нөлөөллийн менежментийн төлөвлөгөө боловсруулахдаа нийгмийн сөрөг нөлөөллөөс зайлсхийх, түүнийг бууруулах, нөхөн сэргээх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахаар заасан. Нийгмийн нөлөөллийг үнэлэх хяналт-шинжилгээний хөтөлбөрийг боловсруулахдаа шалгуур үзүүлэлтэд бэлчээр, усны боломжоос шалтгаалан жилд хийх нүүдлийн тоог жил бүрээр мөн ширгэсэн, ус нь багассан худгийн тоог жил бүрээр, Өрхийн малын тоонд гарсан өөрчлөлтийг жил бүр гаргахаар байгаа.
20	2020.07.05	Бичигт багийн малчин	Ерөнхийдөө аймагаас бүх шийдвэр гарч, сумын удирдлагуудтай ярилцаад шийдчихсэн байдгийг болиулах	Тусгагдсан. Нийгмийн нөлөөллийг үнэлэхдээ багийн хурлыг зохион байгуулж, тухайн багийн иргэд болон судлаачдын хамтарсан баг бүрдүүлэн үнэлнэ. Уг үнэлгээнд суурилж шийдвэр гаргахаар тусгагдсан.
21	2020.07.05	Бичигт багийн малчин	Иргэдийн хурлаар 1 асуудлыг дэмжтэл нь дахин дахин оруулж хэлэлцүүлдэгийг шийдэх	Тусгагдаагүй. ННУ-ий аргачлалын дагуу нотлох баримтыг үнэлгээнд хавсаргаж, төрийн эрх бүхий байгууллагад хүргүүлэхээр зөвлөмжилнэ. Тиймд багийн хурлын тэмдэглэлд хэдэн удаа

				хуралдсан, ямар асуудал хэлэлцсэн талаарх бүрэн мэдээлэл багтсан байж, ННҮА боловсруулах хамтарсан баг буюу тухайн орон нутгийн нөлөөлөлд өртөх бүсийн иргэд, малчид болон судлаачид хамтран баталж, гарын үсгээр баталгаажуулсан байх шаардлагыг зөвлөмж хэлбэрээр хүргүүлнэ. Мөн зөвлөмжид нийт хуралд оролцсон хүмүүсийн баталгаажуулалтыг шаардах байдлаар иргэдийн оролцоог хангах, хамтарсан багийн гаргасан шийдвэрийг хяналттай байлгах зөвлөмжийг багтаана.
22	2020.07.05	Бичигт багийн малчин	Малчид нүүх газар байхгүй болсон	Тусгагдаагүй. Малчидын сэлгэн нүүх байршлыг аргачлалаар тогтоох боломжгүй. Хуримтлаглах нөлөөллийн үнэлгээний ННҮ аргачлалд тусгах шаардлагатай.
23	2020.07.05	Бичигт багийн малчин	Орон нутгийн гэрээг дүгнэхгүй өдий хүрсэн ба гэрээнд юу гэж тусгасанг бид мэддэггүй. Үүнийг мэддэг болох	Тусгагдаагүй. Орон нутгийн гэрээнд тусгагдах нийгмийн нөлөөллийг үнэлнэ. Харин гэрээний хяналтыг хийх асуудлыг аргачлалд тусгах боломжгүй боловч түүнд тусгах асуудлын үнэлгээг нийгмийн нөлөөллийн үнэлгээгээр тодорхойлно. Цаашлаад орон нутгийн гэрээнд заавал эдгээр асуудлыг шийдэх, жил бүр хянах хэлбэрээр зохицуулалтыг бий болгох санал зөвлөмж хүргүүлнэ.
24	2020.07.05	Бичигт багийн малчин	Компанид гомдол гаргах гэхээр хариуцсан эзэн нь байхгүй, олохгүй, туслан гүйцэтгэгч гэх хүмүүс л байдаг. Гомдол гаргахдаа компани руу шууд хандаж үзээгүй	Тусгагдсан. Гомдол гаргах, гомдол шийдвэрлэх механизмыг бий болгохыг шаардана.
25	2020.07.05	Бичигт багийн малчин	Хуримтлагдсан нөлөөллийг үнэлэх хэрэгтэй	Тусгагдаагүй. Хуримтлагдсан нөлөөллийг үнэлэх аргачлалыг цаашид ННҮ-ний аргачлалд суурилан боловсруулах шаардлагатай.
26	2020.07.05	Бичигт багийн малчин	Энд тэндгүй олон жижиг шороон зам гаргадаг нь иргэдийн амьдралд шууд нөлөөлж, байнга тоос шороон дунд амьдардаг. Нэг компани нөгөө компанийнхаа замаар явдаггүйг болиулах хэрэгтэй байна. Замаа янзалдаггүй.	Тусгагдсан. Төслийн нийгмийн нөлөөллийн бүсийг урьдчилсан байдлаар гаргахдаа нөлөөлөлд өртөж буй талуудыг тодорхойлохоор байгаа. Мөн Нийгмийн нөлөөллийг үнэлэх хяналт-шинжилгээний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэхдээ замын дагуу амьдардаг хүмүүс, амьдардаг газрынх нь ойролцоо тэсэлгээ явагддаг хүмүүс гэх мэт төслийн нөлөөлөлд өртөж буй хэсгийнхэнд гарах өөрчлөлтийг хянах шалгууруудыг заавал оруулахаар заасан.
27	2020.07.05	Дорноговь аймаг, Даланжаргалан сум, Элдэв багийн малчин	Худаг гаргах	Зарчмын хувьд тусгагдсан. ННҮА-ын 6.5-д Төслийн нийгмийн нөлөөллийн менежментийн төлөвлөгөө боловсруулахдаа нийгмийн сөрөг нөлөөллөөс зайлсхийх, түүнийг бууруулах, нөхөн сэргээх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахаар заасан. Нийгмийн нөлөөллийг үнэлэх хяналт-шинжилгээний хөтөлбөрийг боловсруулахдаа шалгуур үзүүлэлтэд <ul style="list-style-type: none"> - Бэлчээр, усны боломжоос шалтгаалан жилд хийх нүүдлийн тоог жил бүрээр мөн - Ширгэсэн, ус нь багассан худгийн тоог жил бүрээр, - Өрхийн малын тоонд гарсан өөрчлөлтийг жил бүр гаргахаар байгаа.

28	2020.07.05	Дорноговь аймаг, Даланжаргалан сум, Элдэв багийн малчин	Зам тавих, замын тэмдэг тэмдэглэгээ хийх	Тусгагдсан. Төслийн нийгмийн нөлөөллийн бүсийг урьдчилсан байдлаар гаргахдаа нөлөөлөлд өртөж буй талуудыг тодорхойлохоор байгаа. Мөн Нийгмийн нөлөөллийг үнэлэх хяналт-шинжилгээний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэхдээ замын дагуу амьдардаг хүмүүс, амьдардаг газрынх нь ойролцоо тэсэлгээ явагддаг хүмүүс гэх мэт төслийн нөлөөлөлд өртөж буй хэсгийнхэнд гарах өөрчлөлтийг хянах шалгууруудыг заавал оруулахаар заасан.
29	2020.07.05	Дорноговь аймаг, Даланжаргалан сум, Элдэв багийн малчин	Эрүүл мэндийн даатгалыг төлж өгдөг болох	Тусгагдаагүй.
30	2020.07.05	Дорноговь аймаг, Даланжаргалан сум, Элдэв багийн малчин	Зам тавихаас өмнө тээвэрлэлт хийхгүй байх	Тусгах шаардлагагүй. ННУ-г төсөл эхлэхээс өмнө гүйцэтгэхээр зааж байгаа нь зарчмын хувьд зам тавих, тээвэрлэлт хийхээс өмнө хийгдэхээр байна.
31	2020.07.05	Дорноговь аймаг, Даланжаргалан сум, Элдэв багийн малчин	Эмнэлэгт жилд 2 удаа үзүүлж баймаар байна	Шууд утгаар тусгагдаагүй. Нийгмийн нөлөөллийг үнэлэхдээ багийн хурлыг зохион байгуулж, тухайн багийн иргэдээс санал асуулга явуулан хэрэгцээ шаардлагыг тодорхойлон шийдвэрлэх арга замыг ННУ, ННМТ болон орон нутгийн хөгжлийн гэрээнд тусгаж шийдвэрлэхээр зохицуулна. Мөн Нийгмийн нөлөөллийг үнэлэх хяналт шинжилгээний төлөвлөгөө боловсруулахдаа Хүн амын бие махбод, сэтгэцийн эрүүл мэнд, мал, амьтны эрүүл мэнд, нийгмийн амгалан тайван байдалд гарсан өөрчлөлтийг хэмжихээр заасан. Шалгуур үзүүлэлтүүд, хэмжих давтамжид: Орон нутгийн иргэдийн эрүүл мэндэд гарсан өөрчлөлт, төсөл хэрэгжүүлэгчийн хэрэгжүүлсэн эрүүл мэндийн хөтөлбөрийн тоо, хамрагдсан хүмүүсийн тоог жил бүр; Төсөл хэрэгжсэнээс хойших хугацаанд иргэдийн эрүүл мэндэд гарсан өөрчлөлтийг жил бүр хэмжиж гаргахаар заасан.
32	2020.07.05	Дорноговь аймаг, Даланжаргалан сум, Элдэв багийн малчин	Хүмүүсийг сургаж ажилд авах	Тусгах боломжгүй. Компанийн нийгмийн хариуцлагыг аргачлалаар заах биш хяналт-шинжилгээний хөтөлбөрийн дагуу хянах ажиллагаа хийгдэхээр тусгагдсан. БОННУ-ий аргачлалд баримтлах зарчим болон тайланах хэсэгт компанийн нийгмийн хариуцлагыг үнэлж болно.
33	2020.07.05	Дорноговь аймаг, Даланжаргалан сум, Элдэв багийн малчин	Компани мэдээлэл өгөх, танилцуулга хийх системтэй болох.	Тусгах боломжгүй. Компанийн нийгмийн хариуцлагыг аргачлалаар заах биш хяналт-шинжилгээний хөтөлбөрийн дагуу хянах ажиллагаа хийгдэхээр тусгагдсан. БОННУ-ий аргачлалд баримтлах зарчим болон тайланах хэсэгт компанийн нийгмийн хариуцлагыг үнэлж болно.
34	2020.07.05	Дорноговь аймаг, Даланжаргалан сум, Элдэв багийн малчин	Малчдаас мах, сүү авах	Тусгагдсан. ННУА-ын 6.4-т Төслийн нийгмийн нөлөөллөөс зайлсхийх, түүнийг бууруулах, нөхөн сэргээх төлөвлөгөө боловсруулах хэсгийн Төслийн орон нутагт бий болгох өгөөж, үр шимийг нэмэгдүүлэх арга замуудад орон нутагт ажлын байр бий болгох, орон нутгаас худалдан авалт хийх зөвлөмж оруулсан. Зөвлөмжийн дагуу орон нутгийн нөхцөл байдалд тулгуурлан, төсөл хэрэгжүүлэгчийн зүгээс орон нутагт эдийн засгийн үр ашиг авчиргах

				тухайлсан арга хэмжээнүүдийг авах хэрэгтэй. Үүнд, орон нутгийн иргэдийн ажиллах боломжтой ажлын байруудыг тодорхойлох, мөн орон нутгийн бизнес эрхлэгчдийг төсөлд бараа, үйлчилгээгээ худалдаж, ханган нийлүүлэгч болох боломжийг олгох зэрэг асуудлыг багтаасан. Мөн үнэлгээний энэ хэсгийг орон нутгийн хөгжлийн гэрээнд тусгаж баталгаажуулахаар санал болгон дээрх хөтөлбөрүүдийн хүрээнд бий болсон байнгын болон түр ажлын байрны тоог жил бүрээр гаргаж хянах шалгуур үзүүлэлттэй.
35	2020.07.05	Дорноговь аймаг, Даланжаргалан сум, Элдэв багийн малчин	Ашигласан усаа эргүүлж ашиглах хэрэгтэй. Түүнийг нь мал уудаг	Тусгах боломжгүй. Компанийн нийгмийн хариуцлагыг аргачлалаар заах биш хяналт-шинжилгээний хөтөлбөрийн дагуу хянах ажиллагаа хийгдэхээр тусгагдсан. Мөн БОННМТ-д тусгаж шийдвэрлэх боломжтой.
36	2020.07.05	Дорноговь аймаг, Даланжаргалан сум, Элдэв баг, хүүхэд	Гэр цэцэрлэгтэй болгох	Шууд утгаар тусгагдагүй. Нийгмийн нөлөөллийг үнэлэхдээ багийн хурлыг зохион байгуулж, тухайн багийн иргэдээс санал асуулга явуулан хэрэгцээ шаардлагыг тодорхойлон шийдвэрлэх арга замыг ННУ, ННМТ болон орон нутгийн хөгжлийн гэрээнд тусгаж шийдвэрлэхээр зохицуулна. Мөн Тухайн төслийн орон нутагт бий болгох өгөөж, үр шимийг нэмэгдүүлэх арга замуудыг тодорхойлох үе шатанд Нийгмийн хөрөнгө оруулалтын сан байгуулж уул уурхайн үйлдвэрлэлээс олж буй ашгийн тодорхой хувийг орон нутагт стратегийн нийгмийн хөрөнгө оруулалт хэлбэрээр хэрэгжүүлэх, төслөөс орон нутгийн хүртэх үр өгөөжийг хуваалцах, нийгмийн хөрөнгө оруулалт болохын хувьд орон нутагт холбогдох хуулийн дагуу төлдөг татвар, рояалти болон хохирлын нөхөн төлбөрөөс тусдаа, нэмэлт үйл ажиллагаа байдлаар хэрэгжих ёстой. Төслөөс оруулж буй нийгмийн хөрөнгө оруулалт нь дараах хэлбэрүүдтэй байж болно: орон нутгийн иргэдийн өөрсдийн удирддаг нийгмийн хөрөнгө оруулалтын санд тодорхой хэмжээний хөрөнгө оруулах, сургууль, эмнэлэг зэрэг нийгмийн дэд бүтцэд хөрөнгө оруулах, зээлийн сан (ялангуяа бичил санхүүгийн) үүсгэж орон нутгийн иргэдэд зээл авах боломж бүрдүүлэх, энэ нь шинэ бизнесийг бий болгож, улмаар төслийн ханган нийлүүлэгч болох боломжтой гэх байдлаар аргачлалыг зөвлөмжилсөн.
37	2020.07.06	Дорноговь аймаг, Айраг сум, Нард багийн малчин	Гомдол гаргахаар шийдвэрлэдэггүй	Тусгагдсан. Гомдол гаргах, гомдол шийдвэрлэх механизмыг бий болгохыг шаардана.
38	2020.07.06	Дорноговь аймаг, Айраг сум, Нард багийн малчин	Уул уурхайн үйл ажиллагаанаас үүдсэн стрессээс салгах арга хэмжээ авах,	Тусгагдагүй. Гэвч Нийгмийн нөлөөллийг үнэлэх хяналт шинжилгээний төлөвлөгөө боловсруулахдаа Хүн амын бие махбод, сэтгэцийн эрүүл мэнд, мал, амьтны эрүүл мэнд, нийгмийн амгалан тайван байдалд гарсан өөрчлөлтийг хэмжихээр заасан. Шалгуур үзүүлэлтүүд, хэмжих давтамжид <ul style="list-style-type: none"> - Орон нутгийн иргэдийн эрүүл мэндэд гарсан өөрчлөлт, төсөл хэрэгжүүлэгчийн хэрэгжүүлсэн эрүүл мэндийн хөтөлбөрийн тоо, хамрагдсан хүмүүсийн тоог жил бүр - Төсөл хэрэгжсэнээс хойших хугацаанд иргэдийн эрүүл мэндэд гарсан өөрчлөлтийг жил бүр хэмжиж гаргахаар

				заасан. Цаашид ЭМНҮ-д нарийвчилан зохицуулах зөвлөмж хүргүүлнэ.
39	2020.07.06	Дорноговь аймаг, Айраг сум, Нард багийн малчин	Жилд 1 удаа амралтанд явуулж амрааж байх хэрэгтэй	<p>Шууд утгаар тусгагдаагүй. Нийгмийн нөлөөллийг үнэлэхдээ багийн хурлыг зохион байгуулж, тухайн багийн иргэдээс санал асуулга явуулан хэрэгцээ шаардлагыг тодорхойлон шийдвэрлэх арга замыг ННҮ, ННМТ болон орон нутгийн хөгжлийн гэрээнд тусгаж шийдвэрлэхээр зохицуулна.</p> <p>Мөн Нийгмийн нөлөөллийг үнэлэх хяналт шинжилгээний төлөвлөгөө 37боловсруулахдаа Хүн амын бие махбод, сэтгэцийн эрүүл мэнд, мал, амьтны эрүүл мэнд, нийгмийн амгалан тайван байдалд гарсан өөрчлөлтийг хэмжихээр заасан. Шалгуур үзүүлэлтүүд, хэмжих давтамжид</p> <ul style="list-style-type: none"> - Орон нутгийн иргэдийн эрүүл мэндэд гарсан өөрчлөлт, төсөл хэрэгжүүлэгчийн хэрэгжүүлсэн эрүүл мэндийн хөтөлбөрийн тоо, хамрагдсан хүмүүсийн тоог жил бүр - Төсөл хэрэгжсэнээс хойших хугацаанд иргэдийн эрүүл мэндэд гарсан өөрчлөлтийг жил бүр хэмжиж гаргахаар заасан.
40	2020.07.06	Дорноговь аймаг, Айраг сум, Нард багийн малчин	Нөхөн сэргээлтийг 100 хувь хийдэг, түүнийг нь хянах хэрэгтэй	<p>Тусгагдсан. ННҮА-ын 6.4-т Төслийн нийгмийн нөлөөллөөс зайлсхийх, түүнийг бууруулах, нөхөн сэргээх төлөвлөгөө боловсруулахдаа Төслийн улмаас үүсч болзошгүй сөрөг нөлөөллөөс зайлсхийх, түүнийг бууруулах, нөхөн сэргээх арга замуудыг тодорхойлохдоо нөхөн сэргээх стратеги боловсруулан мөрөг нөлөөллийг бууруулахыг шаардана. Арилгах, бууруулах арга хэмжээ авах ноцтой нөлөөллүүдийг эрэмбэлэн гаргах үе шатанд Төслийн шууд, дам, хуримтлагдах нөлөөллийг тодорхойлсны дараа тэдгээрийг эрэмбэлж, хамгийн ноцтой, нөлөөллөөс зайлсхийх, бууруулах, төслийн улмаас үүсч болзошгүй шууд, дам, хуримтлагдах нөлөөллийг гаргасны дараа эрэмбэлэн үнэлэх матрицын арга зүй ашиглан тодорхойлсон бүх нийгмийн нөлөөллийг тохиолдох магадлал, нөлөөллийн зэргээр нь үнэлж, хамгийн ноцтой, нөлөөллөөс зайлсхийх, бууруулах, нөхөн сэргээх арга хэмжээ зайлшгүй авах шаардлагатай нөхцөлүүдийг тогтоохоор заасан.</p>
41	2020.07.06	Дорноговь аймаг, Айраг сум, Нард багийн малчин	Менежментийн төлөвлөгөөнд 2-оос доошгүй удаа жилд эрүүл мэндийн үзлэгт оруулах үр дүнгээс хамаарч яах арга хэмжээгээ оруулах шаардлагатай	<p>Шууд утгаар тусгагдаагүй. Нийгмийн нөлөөллийг үнэлэхдээ багийн хурлыг зохион байгуулж, тухайн багийн иргэдээс санал асуулга явуулан хэрэгцээ шаардлагыг тодорхойлон шийдвэрлэх арга замыг</p>

				<p>БОННУ, БОННМТ болон орон нутгийн хөгжлийн гэрээнд тусгаж шийдвэрлэхээр зохицуулна.</p> <p>Мөн Нийгмийн нөлөөллийг үнэлэх хяналт шинжилгээний төлөвлөгөө боловсруулахдаа Хүн амын бие махбод, сэтгэцийн эрүүл мэнд, мал, амьтны эрүүл мэнд, нийгмийн амгалан тайван байдалд гарсан өөрчлөлтийг хэмжихээр заасан. Шалгуур үзүүлэлтүүд, хэмжих давтамжид Орон нутгийн иргэдийн эрүүл мэндэд гарсан өөрчлөлт, төсөл хэрэгжүүлэгчийн хэрэгжүүлсэн эрүүл мэндийн хөтөлбөрийн тоо, хамрагдсан хүмүүсийн тоог жил бүр, Төсөл хэрэгжсэнээс хойших хугацаанд иргэдийн эрүүл мэндэд гарсан өөрчлөлтийг жил бүр хэмжиж гаргахаар заасан.</p>
42	2020.07.06	Дорноговь аймаг, Айраг сум, Нард багийн малчин	Иргэдээс уул уурхайн компаниуд үйл ажиллагаа явуулж эхлэхээс өмнө санал авдаг, мөн аймаг дээр биш сум биш багийн түвшинд асуудлыг ярьж, ярисан асуудлыг шийддэг болох	Тусгагдсан. Нийгмийн нөлөөллийг үнэлэхдээ багийн хурлыг зохион байгуулж, тухайн багийн иргэдээс санал асуулга явуулан хэрэгцээ шаардлагыг тодорхойлон шийдвэрлэх арга замыг БОННУ, БОНМТ болон орон нутгийн хөгжлийн гэрээнд тусгаж шийдвэрлэхээр зохицуулна.
43	2020.07.06	Дорноговь аймаг, Айраг сум, Нард багийн малчин	Өвс тэжээлийн туслалцаа үзүүлэх	Шууд утгаар тусгагдаагүй. Нийгмийн нөлөөллийг үнэлэхдээ багийн хурлыг зохион байгуулж, тухайн багийн иргэдээс санал асуулга явуулан хэрэгцээ шаардлагыг тодорхойлон шийдвэрлэх арга замыг БОННУ, БОНМТ болон орон нутгийн хөгжлийн гэрээнд тусгаж шийдвэрлэхээр зохицуулна.
44	2020.07.06	Дорноговь аймаг, Айраг сумын төрийн албан хаагч	Багийн иргэдийн саналыг авсан уу гэдэг нь БОНБҮ дээр тодорхойгүй байдаг, иргэдийн гомдол аваагүй гээд иргэд ирдэг. Тодорхой болгох шаардлагатай.	Тусгагдсан. Нийгмийн нөлөөллийг үнэлэхдээ багийн хурлыг зохион байгуулж, тухайн багийн иргэдээс санал асуулга явуулан хэрэгцээ шаардлагыг тодорхойлон шийдвэрлэх арга замыг БОННУ, БОНМТ болон орон нутгийн хөгжлийн гэрээнд тусгаж шийдвэрлэхээр зохицуулна. Мөн олон нийтийн оролцооны журмыг сайжруулах чиглэлээр санал, зөвлөмж өгнө.
45	2020.07.06	Газрын даамал	Төлбөр, татвар нь аймаг улс руу ордог. Сумд мөнгө олддоггүй.	Тусгах шаардлагагүй.
46	2020.07.06	ЗДТГ-ын үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн	Гэрээг аймгийн Засаг дарга, сумын Засаг дарга, компани 3 хамтарч гэрээнд гарын үсэг зурдаг. Сумын Засаг даргад багийн дарга нар санал хэлдэг. Гэрээг багийн иргэдийг хуралдуулж, саналыг тусгаж Злсан гэрээг хиймээр байгаа юм.	Тусгагдсан. Нийгмийн нөлөөллийг үнэлэхдээ багийн хурлыг зохион байгуулж, тухайн багийн иргэдээс санал асуулга явуулан хэрэгцээ шаардлагыг тодорхойлон шийдвэрлэх арга замыг БОННУ, БОНМТ болон орон нутгийн хөгжлийн гэрээнд тусгаж шийдвэрлэхээр зохицуулна.
47			Төлбөр нь төв рүү явчихдаг, манай сумд огт ирдэггүй гэвч манай сумын нутагт ажиллаж байгаа гэдэг утгаар хяналт ч төсөв мөнгө нь ч эндээ шингэх хэрэгтэй.	Тусгах шаардлагагүй. Орон нутгаас хураасан төлбөр, хураамжийг тухайн орон нутагт нь шилжүүлж, орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд буцаан хөрөнгө оруулалт хийх зөвлөмжийг хүргүүлнэ.
48	2020.07.06		Гадаадын иргэдийн бүртгэлийг тухайн үйл ажиллагаа явуулж байгаа нутагт нь бүртгэдэг болох	Тусгах шаардлагагүй. Гадаадын иргэдийн бүртгэлтэй холбоотой хуулийн хэрэгжилтийг сайжруулах чиглэлд зөвлөмж хүргүүлнэ.

49	2020.07.06	Нийгмийн халамж, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн	Гэрээнд юу орохыг иргэдийн амнаас нь сонсох ёстой, бодитой тусгах бодитой хянадаг болгох хэрэгтэй.	Тусгагдсан. Нийгмийн нөлөөллийг үнэлэхдээ багийн хурлыг зохион байгуулж, тухайн багийн иргэдээс санал асуулга явуулан хэрэгцээ шаардлагыг тодорхойлон шийдвэрлэх арга замыг БОННУ, БОНМТ болон орон нутгийн хөгжлийн гэрээнд тусгаж шийдвэрлэхээр зохицуулна.
50	2020.07.06	Багийн Засаг дарга нар	Гадаад хүмүүс их байдаг болохоор нохой их гэжээдэг, тэр нь том болоод мал барьдагийг анхаарах.	Тусгах боломжгүй. БОННУ хийхдээ тухайн эрсдэлийг тооцоолж гарган зохицуулах боломжтой.
51	Хуулийн дагуу цөөн компани байвал зүгээр		Тусгагдаагүй. Нийгмийн нөлөөллийн үнэлгээний аргачлалд тусгай зөвшөөрлийг цуцлах, цөөлөх зөвлөмж өгөх боломжгүй. Харин нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийгдсэний дараа сөрөг нөлөөлөл өндөр бол тухайн орон нутгаас санал гаргах боломжийг бүрдүүлэх шаардлагатай.	
52	Олон уурхайг нэгтгээд суманд нэг цэцэрлэг барья, дундаасаа нэгдсэн хөрөнгө оруулалт хиймээр санагддаг		Тусгагдсан. Нийгмийн нөлөөллийг үнэлэхдээ багийн хурлыг зохион байгуулж, тухайн багийн иргэдээс санал асуулга явуулан хэрэгцээ шаардлагыг тодорхойлон шийдвэрлэх арга замыг БОННУ, БОНМТ болон орон нутгийн хөгжлийн гэрээнд тусгаж шийдвэрлэхээр зохицуулна.	
53	Нөлөөллийн бүс 5 км-с дотогш бол шууд нөлөөллийн бүс гэж үзмээр байна		Зарчмын хувьд тусгагдсан. Нөлөөллийг тогтооход багийн иргэдийг оролцуулж үнэлж шийдвэрлэхээр тусгагдсан.	
54	Багийн хурал дээр ярилцаж, ямар асуудлыг яаж шийдэх вэ гэдгээ иргэдээр шийдүүлдэг болгох шаардлагатай		Тусгагдсан. Нийгмийн нөлөөллийг үнэлэхдээ багийн хурлыг зохион байгуулж, тухайн багийн иргэдээс санал асуулга явуулан хэрэгцээ шаардлагыг тодорхойлон шийдвэрлэх арга замыг БОННУ, БОНМТ болон орон нутгийн хөгжлийн гэрээнд тусгаж шийдвэрлэхээр зохицуулна.	
55	Наадмын бай шагнал, хандивын мод тарих хандив өгч байгааг болиулж, хандивын талаар тод заах хэрэгтэй		Тусгагдсан. Нийгмийн нөлөөллийг үнэлэхдээ багийн хурлыг зохион байгуулж, тухайн багийн иргэдээс санал асуулга явуулан хэрэгцээ шаардлагыг тодорхойлон шийдвэрлэх арга замыг БОННУ, БОНМТ болон орон нутгийн хөгжлийн гэрээнд тусгаж шийдвэрлэхээр зохицуулна.	
56	Компаниуд ажилд авсан хүнээ удаан хугацаанд ажиллуулах. Үүний тулд автобус явуулах мөн ахуйн нөхцөлийг сайжруулах шаардлагатай,		Тусгах боломжгүй. БОННУ-ий аргачлалд баримтлах зарчим болон тайланах хэсэгт компанийн нийгмийн хариуцлагыг үнэлж болно.	
57	Төрийн захиргааны байгууллагын мэдээлэл өгөх хэлбэр нь малчдад зориулагдсан байхаас гадна мөн нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх компанийн ажилтнуудад зориулагдсан байх гэсэн ангилалтай байх		Тусгах шаардлагагүй.	

58	2020.07.06	Дорноговь аймаг, Даланжаргалан сумын төрийн албан хаагч	Орон нутгийн гурвалсан гэрээг аймаг мэддэг биш сум, багийн иргэдтэй зөвшилцөж шийддэг болгох	Тусгагдсан. Нийгмийн нөлөөллийг үнэлэхдээ багийн хурлыг зохион байгуулж, тухайн багийн иргэдээс санал асуулга явуулан хэрэгцээ шаардлагыг тодорхойлон шийдвэрлэх арга замыг БОННУ, БОНМТ болон орон нутгийн хөгжлийн гэрээнд тусгаж шийдвэрлэхээр зохицуулна.
59	2020.07.06	Дорноговь аймаг, Даланжаргалан сумын төрийн албан хаагч	Эрүүл мэндийн шинжилгээнд тогтмол хугацаанд оруулах, хянах	Зарчмын хувьд тусгагдсан. Нийгмийн нөлөөллийг үнэлэхдээ багийн хурлыг зохион байгуулж, тухайн багийн иргэдээс санал асуулга явуулан хэрэгцээ шаардлагыг тодорхойлон шийдвэрлэх арга замыг БОННУ, БОНМТ болон орон нутгийн хөгжлийн гэрээнд тусгаж шийдвэрлэхээр зохицуулна.
60	2020.07.06	Дорноговь аймаг, Даланжаргалан сумын төрийн албан хаагч	Сумын тусгай зөвшөөрлийг цөөлөх	Тусгагдаагүй. Тусгай зөвшөөрлийг олгох эсэх нь хууль тогтоомж, төрийн бодлогоор зохицуулагдана. Нийгмийн нөлөөллийн үнэлгээний аргачлалд тусгай зөвшөөрлийг шууд цөөлөх зөвлөмж өгөх боломжгүй. Харин нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийгдсэний дараа сөрөг нөлөөлөл өндөр бол тухайн орон нутгаас санал гаргах боломжийг бүрдүүлэх шаардлагатай. ЗГ салбарын нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх /стратегийн үнэлгээ хийх шаардлагыг зөвлөмжөөр хүргүүлнэ.
61	2020.07.06	Дорноговь аймаг, Даланжаргалан сумын төрийн албан хаагч	Мал аж ахуйг хөгжүүлэх чиглэл рүү нийгмийн хариуцлагыг чиглүүлэх	Зарчмын хувьд тусгагдсан. Нийгмийн нөлөөллийг үнэлэхдээ багийн хурлыг зохион байгуулж, тухайн багийн иргэдээс санал асуулга явуулан хэрэгцээ шаардлагыг тодорхойлон шийдвэрлэх арга замыг БОННУ, БОНМТ болон орон нутгийн хөгжлийн гэрээнд тусгаж шийдвэрлэхээр зохицуулна.
62	2020.07.08	н.Отгонцэцэг, Байгаль орчны иргэний зөвлөл	ННУ-г тухайн орон нутгийн радиуст амьдарч байгаа нутгийн иргэдийг өөрсдийг нь оролцуулаад, хамтын оролцоотой хийгээчээ. Иргэдийн оролцоог хангахын тулд бид сонсох ажиллагаа гэдэг юмыг зайлшгүй хийх ёстой. Орон нутгийн засаг захиргаа нь байж байг, мөн нийгмийн хамгааллын сумын мэргэжилтнүүд байг, ингэж байж үнэлгээ хийх ёстой.	Тусгагдсан. Нийгмийн нөлөөллийг үнэлэхдээ багийн хурлыг зохион байгуулж, тухайн багийн иргэдээс санал асуулга явуулан хэрэгцээ шаардлагыг тодорхойлон шийдвэрлэх арга замыг БОННУ, БОНМТ болон орон нутгийн хөгжлийн гэрээнд тусгаж шийдвэрлэхээр зохицуулна. Багт ямар хүмүүс байх, тухайн орон нутагтаа 10-с доошгүй жил амьдарсан байх шаардлагуудыг оруулсан. Мөн эмэгтэйчүүд, өндөр настан гээд бүх хүний төлөөлөл байх, малчид өөрсдөө чадамжгүй байвал өөрсдийн итгэдэг ИНБ-ыг өөрсдийгөө төлөөлүүлж үнэлгээнд оролцуулж болно гэж оруулсан.

63	2020.07.08	Х.Маамаа	ННУ-г хийх гэхээр энэ том хүрээнд орон нутгийн иргэд хийж чадахгүй. Тодорхой хэмжээний сургалт явагдаад, тэрэнд шат шатны төлөөлөл нь оролцоод, бүс нутгаар нь ангилаад ННУ-г гаргах. Уурхайн лицензтэй газрууд тодорхой болчихож байгаа тул ННУ-г хийхдээ бүсчилээд, жишээ нь Хэнтий аймгийн тэр тэр газруудаар лицензтэй байна гэх юм бол тусгай чадамжтай баг нь ард иргэдийн төлөөлөлтэй яваад, тодорхой хугацаанд энэ төслийн хүрээнд ийм нөлөөлөл үүснэ гэдэг юмыг нь урьдчилаад гаргавал яадаг юм? Тэгэхгүй бол бид багийн хурлыг хуралдуулж чаддаггүй.	Тусгагдсан. Үнэлгээний компани дангаараа хийх боломжгүй тул нутгийн иргэд болон үнэлгээний компанийн судлаачид хамтарсан баг бүрдүүлж үнэлгээг хийхээр тусгасан.
64			Орон нутгийн хүмүүс бүгд л оролцох сонирхолтой, гэхдээ хамтарсан багаа яаж бүрдүүлэх вэ, төслүүдээ ямар ямар төслүүдийн, ямар ямар эрчимтэй гэдэг юм уу тодорхой болгох. 10 хүнтэй, нэг жижигхэн өрөм тавих ч юмуу, чичирхийллийн судалгаа байдаг асуудал үүсгэх эрсдэлтэй.	Тусгагдсан. Нийгмийн нөлөөллийг үнэлэх хяналт-шинжилгээний хөтөлбөр боловсруулах үе шатанд төслийн хяналт-шинжилгээний хөтөлбөрийн индикаторуудыг судлаачид, орон нутгийн иргэд, удирдлага, хүний эрхийн чиглэлээр ажилладаг иргэний нийгмийн төлөөллөөс бүрдсэн баг хамтран ажиллаж гаргана гэж заасан.
65	2020.07.08	Д.Өлзийбаяр – МБОМХ ТББ	Эерэг нөлөөллийг нэмэх	Тусгагдсан. ННЗА-д эерэг болон сөрөг нөлөөллийг аль алиныг үнэлэхээр байгаа.
66			Хийсэн аргачлалаа нэг төсөл дээр үнэлгээ хийгээд үзэх хэрэгтэй байна.	Хүлээж авсан. Тест хийх хугацаа, төслийг Зөвлөх баг тохирно.
67			Яаж хэрэглэх талаар нь сургалтууд хийх хэрэгтэй байна.	Зөвлөх багийн үйл ажиллагаанд хамаарахгүй. Салбарын яамд хариуцах шаардлагатай. Цаашид хийгдэх арга хэмжээний талаар зөвлөмж хүргүүлнэ.
68			Дарааллын хувьд хяналт, шинжилгээ гээд байгаа, байгаль орчны хяналт шинжилгээ гэдэг үгтэй чинь давхцаад байгаа юм шиг байх юм. Мониторинг, үнэлгээ бол хамгийн сүүлдээ орж ирэхээр юм байна. Хяналт үнэлгээг хэн хийх вэ гэдэг дээр анх үнэлгээ хийсэн баг л явж байвал зүгээр.	Тусгагдсан. Нийгмийн нөлөөллийг үнэлэх хяналт-шинжилгээний хөтөлбөр боловсруулах үе шатанд төслийн хяналт-шинжилгээний хөтөлбөрийн индикаторуудыг судлаачид, орон нутгийн иргэд, удирдлага, хүний эрхийн чиглэлээр ажилладаг иргэний нийгмийн төлөөллөөс бүрдсэн баг хамтран ажиллаж гаргана гэж заасан.
69			ТББ-ын төлөөлөл, уул уурхайн төсөл хэрэгжүүлэгч компанийн төлөөллийг заавал оролцуулах хэрэгтэй. Аргачлалыг хэрэгжүүлэх хүмүүс нь уул уурхайн компаниуд өөрсдөө байна.	Саналыг хүлээж авсан. Уулзалтыг зохион байгуулна.
70			Уурхай ажиллаад явж байтал гэнэт эх оронч нутгийн иргэн гарч ирээд, уурхай зогсоох асуудал гарч ирдэг. Тийм учраас баримтжуулалт гэдэг юм яаж явахаар байна бодолцох хэрэгтэй. Нийтийг хамарсан, нийтийн эрх ашгийг хамгаалсан юмнууд байх нь зөв байх шүү. Тэрийг илүү оруулж өгөөрэй.	Зарчмын хувьд тусгагдсан. БОНБУ-ний процесстэй адил хурлын тэмдэглэлийг баримтжуулахыг журмаар зохицуулах шаардлагатайг салбарын яам, агентлагт зөвлөмж байдлаар хүргэнэ.

71			Орон нутгийг оролцуулья гэдэг дээр орон нутгаас яг хэн байх юм, сумын мэргэжилтнүүдээс яг хэн хэн нь оролцох вэ гэдгийг нарийн гаргаж өгөх хэрэгтэй байх. Тэгэхгүй бол улс төрөөс хамаараад солигдоод өөрчлөгдөөд байх талтай.	Тусгагдсан. Орон нутгийн иргэдэд тавигдах шалгуурыг аргачлалд заасан.
72	2020.07.08	Ж.Сэрсмаа – Эртэч наран зөвлөх компани	Говьд бууц нь задгай, хашаа саравчгүй, газар дээр нь үзэхээр овоолсон бууцнаас өөр юм байдаггүй. Гэтэл энэ нь малчдад олон үе дамжиж ирсэн үнэ цэнэтэй, олон давуу талтай хөрөнгө нь байдаг. Нөлөөлөлд өртөгчдийн өмчийг үнэлэх асуудлыг зохицуулах. Тэр бууцан дээрээ хэдэн жил нутаглаж байгаа вэ гэж байгаад, 5 хүртэл, 15 хүртэл, 20-с дээш жил гэж хуваагаад асуумжаар явуулдаг. Хичнээн удаан энэ бууцыг ашигласан байна, тэр хэмжээгээр тухайн бууц энэ хүний хувьд үнэ цэнэтэй гэж үнэлэх зорилгоор ийм асуулга авах.	Зарчмын хувьд тусгагдсан. Хувийн болон өмчийн эрхэд бэлчээр эзэмшилт, ашиглалтын эрх, өмчийн бусад эрхүүд хамаарахаар заасан. ННҮА-ын 6.4-т Төслийн нийгмийн нөлөөллөөс зайлсхийх, түүнийг бууруулах, нөхөн сэргээх төлөвлөгөө боловсруулах үе шатны зорилго нь төслийн үйл ажиллагаанаас учирч болзошгүй сөрөг нөлөөллөөс зайлсхийх, зайлсхийх боломжгүй бол бууруулах, бууруулах боломжгүй бол орчин, нөхцөлийг нөхөн сэргээх, нөлөөллийн бүсийн иргэдийг нүүлгэн шилжүүлэх, мөнгөн ба мөнгөн бус хэлбэрээр нөхөн төлбөр олгох төлөвлөгөө боловсруулах, арга замуудыг гаргаж, тодорхойлох юм. Харин үнэлгээг аргачлалаар тогтоож өгөх боломжгүй бөгөөд судалгааны баг ННМТ-д үнэлж, тусгахаар заасан.
73			Та БОНҮ-ний хуралд хэдэн удаа суусан бэ? гэдэг асуулга асуух. Нэг ч удаа сууж үзээгүй, 2-3 суусан, 4-с дээш суусан, 5-с дээш бол олон удаа сууж үзсэн гэх мэт	Тусгагдсан. Орон нутгийн иргэдэд тавигдах шалгуурыг аргачлалд заасан.
74			Сонсох ажиллагаатай холбоотой төслүүдийг өөрийг нь эрэмбэлмээр санагдаад байгаа юм. Ямар төслийг багийн ИНХ-аар хэлэлцүүлэх юм бэ, ямар төслийг сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэх юм? цар хүрээ өгөөж нь их байгаад, газрын тосны үйлдвэр ч юм уу, үр ашгийг нь улс үндэстнээрээ хэрэглэх, дээрээс нь төсөв бүрдүүлэлт гэх мэт маш ач холбогдолтой том төслүүд сумын ИТХ-аар хэлэлцэгдэж чадахгүйгээсээ болоод удаан хугацаанд гацдаг тохиолдол байгаа.	Төслийг стратегийн болон стратегийн бус гэдгээр л ангилан, БОНБУ-ний жишиг байдлаар нийгмийн нөлөөллийг хамтатган хийнэ.
75			Энэ дээр төсөл хэрэгжүүлэгчийн нийгмийн хариуцлагыг үнэлэх гэдэг асуудал орж ирэх ёстой.	Шууд байдлаар зохицуулах боломжгүй. Харин ОНХГ болон Хяналт шинжилгээ үнэлгэний хөтөлбөрөөр дажуулж хянах эрх нь ННҮ-г гүйцэтгэснээрээ тухайн орон нутаг, нөлөөллийн бүсийн иргэдэд бий болно.
76			Аль хэсэг нь төлөв байдлын үнэлгээнд, аль хэсэг нь нарийвчилсан, аль хэсэг нь хуримтлагдах үнэлгээнд, аль хэсэг нь стратегийн үнэлгээнд асуудлаа авч орох вэ гэдгийг нь зааглаж ялгаж өгөх хэрэгтэй байна.	Тусгагдсан.

77			2 багаас дээш баг дамжсан бол сум хэлэлцдэг байх. Хоёр, гурван сум дамжсан төслүүд байна, тэгвэл тэрийг яах юм бэ гэж эрэмбэлэх ёстой.	Тусгагдсан. Одоогийн БОНБУ-ний зохицуулалтын дагуу ННУ-г хийхдээ 2 баг дамжсан тохиолдолд баг тус бүрээр хэлэлцүүлнэ. Түүнээс дээш тооны баг хамарсан нөхцөлд ННУА-ын 3.5 дахь хэсэгт Төсөл нь хэд хэдэн баг, сумын нутаг дэвсгэрийг хамарч хэрэгжих бол эрх бүхий ААН нь тухайн сумын ИТХ, багийн ИНХ-д тус тус танилцуулж санал авна гэж оруулсан.
78	2020.07.08	Тэмүүлэн, БОАЖЯ-ны мэргэжилтэн	Стратегийн үнэлгээний аргачлалд орох юм уу, эсвэл хуримтлагдах нөлөөллийн үнэлгээнд нэг бүлэг болж орох юм уу, эсвэл нөлөөллийн үнэлгээнд орж явах юм уу? Эсвэл нөлөөллийг урьдчилж тооцдог аргачлалд орж явах юм уу? Одоо байгаа журмууд дээр нэмэгдээд ороод явбал батлагдахад их хялбар болно байх. Хуримтлагдах хэсэгт нь ямар асуудлууд орох юм? Урьдчилж тооцдогт нь ямар асуудлууд орох юм гэдгийг тодруулах	Тусгагдсан. Стратегийн нөлөөлөл болон хуримтлагдсан нөлөөллийн үнэлгээнээс бусад хэсэгт задарч орохоор байна.
79			Батлагдсан журмууд яагаад хэрэгжихгүй, тэр багийн дарга яагаад хурлаа зохион байгуулж чадахгүй байна, сумын засаг дарга яагаад олон нийтийн оролцоог хангаж чадахгүй байна гэдгээс эхлэн судлах хэрэгтэй. Тэгээд аргачлалдаа ямар байдлаар, юу юу тусгах вэ гэдгээ бодох хэрэгтэй.	Саналыг хүлээж авсан. Судалгаа хийгдэж, хэрэгжилтийг сайжруулах чиглэлийн зүйлийг зөвлөмждөө тусгана.
80			Хамтарсан баг болох нь зөв. Тэгэхдээ тэнд хэдэн жил амьдарсан, ямар хүн байх ёстой юм тээ? Тэр хүнийг тэр бүс нутгийнхаа иргэдийг төлөөлнө гэдгийг яаж тодорхойлох ёстой юм гэдгийг тодорхой болгох.	Тусгагдсан. Орон нутгийн иргэдэд тавигдах шалгуурыг аргачлалд заасан.
81	2020.07.08	А.Золжаргал, Өндөрхаан трэйд	ННУ гэж юуг хэлэх вэ? Ямар хүрээг хамарч байж нөлөөлөл болох, ямар цар хүрээг хамарвал үнэлгээ хийнэ гэх тайлбар хэрэгтэй.	Тусгагдана. Аргачлалын нэр томъёоны тайлбар хэсэгт оруулахаар болсон.
82			Нөлөөллийн үнэлгээг хавсралтаар нь зааглаж өгвөл, нэгдүгээр хавсралтаар төлөв байдлын үнэлгээг, нарийвчилсан үнэлгээнд хоёрдугаар хавсралтыг ашиглана ч гэдэг юмуу. Нөлөөллийн бүсийн радиусыг маш сайн тооцсон байх хэрэгтэй. Төслийг эрэмбэлсэн байх нь их чухал. Энгийн үгээр бол томоохон төслүүд, жижиг дунд үйлдвэрийн төслүүд гэдэг шиг ангилах хэрэгтэй. Гурван жил ажиллаад хаагдах алтны шороон ордын төсөл дээр бид нар ингэж суух шаардлагагүй.	Тусгагдсан. Нутгийн иргэд, малчдыг оролцуулсан судалгааны баг нь нөлөөллийн бүсийг хэлэлцэн тодорхойлно. БОНБУтХ-д заасан төсөл бүр нийгмийн нөлөөллийн үнэлгээг хийнэ.

83			Нэг ч хүн байхгүй, 20, 30 га газарт уурхай явууллаа гэхэд тэрэн дээр ч гэсэн нөлөөллийг тооцож ир гээд бид нараас шаардаад байна шдээ. Тэгэхээр аль төсөл дээр нөлөөллийн үнэлгээг хийсэн байх шаардлагатай байх нь вэ, алин дээр нь шаардлагагүй байх нь вэ ялгах хэрэгтэй	Тусгагдсан. Төлөв байдлын үнэлгээний үе шатаас эхлэн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн Хавсралтад заасан тус хуулийн 3.1.1-т заасан төслийн хүрээнд хэрэгжинэ.
84		С.Мойлтмаа, ГХЯ Бизнес ба Хүний эрх ажлын хэсгийн гишүүн, НҮБ-ын Хүүхдийн сангийн КНХ, түншлэл хариуцсан зөвлөх	ГХЯ дээр Бизнес ба хүний эрхийн ажлын хэсэг гараад үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө батлах гээд явж байгаа. Төлөвлөгөөний маань гол зорилго бол уул уурхайгаас үүдэлтэй сөрөг нөлөөллийг орон нутгийн, малчдын түвшинд бууруулах талаар гол акцент бол явна. Яагаад гэхээр НҮБ-аас тийм зөвлөмж манай улсын засгийн газарт өгчихсөн байгаа. Энийг үндэслэл хэсэгтээ тусгах	Саналыг хүлээж авсан. Судалгаа, тайланд тусгагдана.
85			Монгол Улсын хүн амыг талыг төлөөлж байгаа хүүхэд гэдэг энэ том бүлэг өөрөө огт ордоггүй. Энэ маань өөрөө хүүхдийн эрхийн том зөрчил. Үүнийг оруулах	Саналыг хүлээж авсан. Зарчмын хувьд тусгагдсан хэсгийг сайжруулна.
86	2020.07.08	Цэгц, АМГТГ-ын мэргэжилтэн	Бүс тогтооно гээд байгаа, эндээ улс орны юм уу, бүс нутгийн хэмжээний бүс тогтоох талаар байна уу? Жишээ нь, Таван толгойн нүүрсийг УБ-т тээвэрлэж авчиралд, сайжруулсан түлш хийгээд УБ-ын утааг бууруулж байна. Энэ нөлөөллийн үнэлгээ ТТ-н төсөл дээр орох гээд байна уу, орохгүй юу? Бусад зам мам эвдээд байгаа сөрөг нөлөөлөл байгаа, тэрийг бууруулах арга хэмжээг авах уу?	Саналыг хүлээж авч судална.
87			Эерэг нөлөөллийг харагдуулах байдлаар матрицаа нэмж өгөөч.	Тусгагдсан. ННҮА-д эерэг болон сөрөг нөлөөллийг аль алиныг үнэлэхээр байгаа.

88	2020.07.22	Оюун, Байгаль орчны үнэлгээний Зөвлөх	Газрын нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой асуудал гарч ирнэ, усны хангамжтай асуудал гарч ирнэ. Гэтэл эд нар нь чиглэл чиглэлээрээ бас үнэлгээ хийдэг, тайлан гаргадаг, төлөвлөлт хийдэг өөр өөрийн аргачлалтай байгаад байгаа юм. Тэгэхээр эд нар нь энэ дотор хэр зэрэг туссан юм бэ? Би зүгээр энэ юмыг чинь харсан л даа. Тэр зүйлүүд бол харагдаагүй ээ.	Тусгагдсан. Нөлөөллийг матриксаар үнэлж, хамгийн ноцтой нөлөөллүүдийг гарган, хариу арга, зайлсхийх арга хэмжээ авахаар төлөвлөсөн. Гарцаагүй тохиолдолд нүүлгэн шилжүүлэлт байна.
89	2020.07.22		Үе шаттай аргачлалыг шууд барьж аваад хийдэггүй. Эхлээд энэ бүх материалуудыг та нар шиг ингэж судлаад суурь тэгээд тэрийгээ мэргэжилтнүүдийн түвшинд ингэж хэлэлцээд тодотгосоор байгаад туршилтын загвар гаргана. Тэгээд энийгээ туршиж үзээд яг тодорхой жишээ нь дээр туршаад үзсэний дараа болох юм байна энэ нь болохгүй юм байна гэнгүүтээ гурав дахь загварыг гаргана. Тэрийгээ жишиг загвар луу оруулна. Тэр жишиг загвараа яах вэ? гэхээр нөгөө нэлээн хэдэн кэйсүүд дээр тэрийгээ туршиж үзнэ. Өнгөрсөн кэйс байж болно. Одоо байж байгаа кэйс болно. Ингээд жишиг загвар гараад. Ингээд нэлээн сайн боллоо гэвэл одоо энийгээ сайжруулсан загвар болгоно. Ингээд нэг дөрөв таван үе шаттайгаар одоо энэ бол программ хангамжаар боловсруулах юманд хэрэглэдэг байхгүй юу.	Зөвлөмж хэсэгт уг аргачлалыг хэрэхн хэрэгжүүлэх, журам батлагдвал түр журам байх эсэхийг санал болгоно. Төрийн эрх бүхий байгууллага нь шийдвэр гаргахдаа Зөвлөх багийн зөвлөмжийг харгалзаж үзэх шаардлагатай.
90	2020.07.22		Төсөл чинь өөрөө үе шаттай. Тэгвэл нийгэм эдийн засгийн судалгаанд энэ төслийн энэ үе шатуудад ямар ялгаатай байхыг гарга. Шууд эхлээд содон л ийм нарийвчилсан юм хэрэггүй шүү дээ. Өөрөөр хэлбэл тэр төслийнхөө үндсэн үе шатаар нийгэм эдийн засгийн судалгаа нийгмийн судалгаанд ямар ялгаатай байх юм гэдгийг нь зааж өгөх юм энэ чинь амьд болно оо.	Тусгагдсан. ННУ-г БОНБУ-ний аргачлалтай адил түвшинд, салгаж, НН-ийн Төлөв байдлын, Ерөнхий, Нарийвчилсан үнэлгээ, Менежментийн төлөвлөгөө гэж ангилж хийхээр төлөвлөсөн.
91	2020.07.22		Одоо шинжлэх ухаан технологи гайхалтай хөгжиж байна. Ялангуяа энэ дата сайнс. Би юм уу та нар тэрийг мэддэг залуучуудтай холбогдооч ээ хамтарч ажиллаач ээ. Дата сайнс бол зүгээр нэг мэдээлэл боловсруулах технологи биш юм аа. Бодит баримт материал дээр тулгуурлаад үнэнийг тогтоох, олон төрлийн мэдээллийг боловсруулдаг аргууд. Ялангуяа текст анализын аргууд байж байна.	Тусгах шаардлагагүй. Зөвлөмжид харгалзаж үзнэ.

92	2020.07.22	Ц.Адьяасүрэн, Байгаль орчны сайд асан	Гомдол барагдуулах механизм гэдэг бол өөрөө бие даасан нэг чухал хэсэг байдаг, өөрөө аргачлалтай, тэрийг болбол зайлшгүй энэ дотор оруулж өгөхгүй бол болохгүй. Яг энэ дээр яг энэ уул уурхай дээрээ л энийг ярих хэрэгтэй. Тэрнээс одоо аялал жуулчлал ч юм уу дэд бүтцийн төслүүд дээр ийм хүнд юм ороод ирвэл бас аягүй хэцүү болдог. Гомдлоо ямар түвшинд хэлэх юм. Эхний ээлжид хэнд хэлэх юм. Тэр механизмаа орон нутгийн иргэдийн хурал нь ч хийдэг юм уу, засаг аймаг шийдэх юм уу, улс шийдэх юм уу?	Тусгагдсан. Гомдол гаргах, гомдол шийдвэрлэх механизмыг бий болгохыг шаардана. Мөн гомдол хянан шийдвэрлэх механизмыг бүрдүүлэх, иргэдийн гомдолд хариу өгөхдөө уучлалт гуйх, алдсан эд хөрөнгийг ижил төрлийн зүйлээр нөхөн төлөх, мөнгөн хэлбэрээр нөхөн төлөх, нөхөн сэргээх болон ижил төрлийн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах зэрэг багтааж зөвлөмж байдлаар оруулсан.
93	2020.07.22		Компенсаци, нөхөн төлбөрийн өртөг нь юу байх юм. Тэрийг бол үнэлгээний компани өөрөө тогтоож чадахгүй. Зүгээр санал тавиж, ийм ийм компенсац хиймээр байна аа л гэдэг саналуудыг өгөх хэрэгтэй. Тэрийг манай яам ч шийдэж чадахгүй. Тэгэхээр тэр хоорондын тэр асуудлуудыг хоорондоо хэлэлцээд л тохирох хэрэгтэй.	Зарчмын хувьд тусгагдсан. Хувийн болон өмчийн эрхэд бэлчээр эзэмшилт, ашиглалтын эрх, өмчийн бусад эрхүүд хамаарахаар заасан. ННҮА-ын 6.4-т Төслийн нийгмийн нөлөөллөөс зайлсхийх, түүнийг бууруулах, нөхөн сэргээх төлөвлөгөө боловсруулах үе шатны зорилго нь төслийн үйл ажиллагаанаас учирч болзошгүй сөрөг нөлөөллөөс зайлсхийх, зайлсхийх боломжгүй бол бууруулах, бууруулах боломжгүй бол орчин, нөхцөлийг нөхөн сэргээх, нөлөөллийн бүсийн иргэдийг нүүлгэн шилжүүлэх, мөнгөн ба мөнгөн бус хэлбэрээр нөхөн төлбөр олгох төлөвлөгөө боловсруулах, арга замуудыг гаргаж, тодорхойлох юм. Харин үнэлгээг аргачлалаар тогтоож өгөх боломжгүй бөгөөд судалгааны баг ННМТ-д үнэлж, тусгахаар заасан.
94	2020.07.22		Зүгээр аргачлал маягаар эхний удаа туршдаг ч юм уу тийм маягаар явж болно	Зөвлөмжид аргачлалыг хэрхэн хэрэгжүүлэх, түр журмаар зохицуулах талаар тусгагдана.
95	2020.07.22	Б. Батболд, Цаг уур, орчны шинжилгээний газрын дэд дарга	Одоогийн бид нарын яриад байгаа нийгмийн нөлөөллийн үнэлгээ гэдэг юм юун дээр суурилж явах гээд байна вэ? Байгалийн стандарт тогтолцоог бид нар эргэлтэд оруулж тэндээс эдийн засгийн үр ашиг авахыг илүүчлэх үү эсвэл стандарт тогтолцоо хадгалж эдийн засгийн үр ашгаар тогтвортой хөгжлийн бодлого хэрэгжүүлэх үү гэдэг гол концепцуудаа энэ дээр нэлээн сайн гаргаж өгөх нь өнөөдрийн бид нарын яриад байгаа байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, нийгмийн нөлөөллийн үнэлгээ гэдэг хоёрыг маань ялгах зарчмын гол ялгаа эндээс сайн харагдах ёстой	Тусгагдсан. Тогтвортой хөгжлийн концепцид суурилан боловсруулагдсан нийгмийн нөлөөллийн үнэлгээний аргачлал нь БОНБУ хийхтэй зэрэгцэн, компанид нэмэлт дарамт үзүүлэхгүй байдлаар шийдвэрлэгдэнэ.

96	2020.07.22		Энд ерөөсөө тэр чигээрээ байгаль орчны нөлөөллийн үнэлгээний загвар тэр чигээрээ харагдаад яваад байгаа байхгүй. Тэгэхээр энэ дээр жоохон ангилах, ялгах маш нарийн детали нарийвчлах зүйлүүд байна аа л гэж би хараад байгаа юм. Тэгэхээр энэ олон үнэлгээнүүдээ яаж системтэй, цогцоор уялдаа холбоог нь бий болгох вэ гэдэг дээр л анхаармаар байгаа юм.	Тусгагдсан. БОНБУ-ний задаргаа, процессын ангилалаар ННУ нь задарна.
97	2020.07.28	Ш.Мөнхцэрэн, ЗГХЭГ-ийн Салбарын удирдлага, зохицуулалтын газрын дарга	Төрийн байгууллагууд хоорондоо нягт ойлголцож, аргачлалаа батлах, хэрэгжүүлэх тал дээр нь анхаарч ажиллах	Саналыг хүлээж авсан. Зөвлөмжид тусгагдсан.
98	2020.07.28	Болд, ЗГХЭГ	Нийгэм гэдгийг юу гэж ойлгож байна тодорхойлох шаардлагатай. Нийгмийн үнэлгээ бол байгаа шүү дээ, нийгмийн гэдгийг яаж тайлбарлах юм бэ? Нийгэм гэдэг чинь их том ойлголт	Тусгагдсан. Нийгмийн олон талтай харилцаан дотроос яг ямар асуудлыг нь үнэлгээндээ авч үзэхийг хамрах хүрээ гэж оруулж өгсөн. Нийгмийн нөлөөлөл гэдгийг тодорхойлохын тулд олон улсын 23 стандарт шаардлагуудыг хэлэлцүүлгүүд хийн, эдгээрээсээ хэрэгцээ шаардлагаа тодорхойлсон.
99	2020.07.28		Геологи хайгуулын ажил хийгдээд, нөөц нь батлагдаад, ТЭЗҮ хийгдэх үед хаанаа, ямар нөлөөллийн үнэлгээ хийх вэ гэдэг чинь гарч ирэх вэ гэдэг асуудал чинь гарч ирнэ	Тусгагдсан. Зөвлөмжөөр баримт бичгүүдийн учлдааг хангах саналыг хүргүүлнэ.
100	2020.07.28		Уул уурхай ашиг олдог, сөрөг асуудал гардаг гээд, яг ямар кэйс дээр энийгээ яриад байгаа юм бэ? Бадрах энерги дээр яриад байгаа юм уу, ОТ дээр яриад байгаа юм уу, өөр Эрдэнэт дээр яриад байгаа юм уу, энийг тодорхойлох ёстой. Ийм ач холбогдолтой байнаа, импакт нь ийм байна гэж ярихгүй бол нийгэд нийгэм гэж яриад, нийгэм гэхээр хөдөөнийхөн чинь өөрсдийгөө гэж ойлгоод, уул уурхайн компани өөрийгөө ойлгоод, тэгтэл нөгөө импакт нь юу байсан юм?	Тусгагдсан. АМТХ дээр нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговрын тухай заалт байгаа гэхдээ, тэрийг дагасан холбогдох журам, аргачлал нь байхгүй байна, АМТХ-ийн 41-г хэрэгжүүлэх гэхээр бидэнд холбогдох журам аргачлал байхгүй байна. Энэ үнэлгээн дээр бид тухайлсан нэг компанийг авч үзээгүй. Уул уурхайн компанид ачааллыг зайлшгүй шаардлагын хүрээнд нийгмийн нөлөөллийг үнэлдэг болгон бага зэрэг нэмэгдүүлнэ.
101	2020.07.28	Б.Баяржаргал, Грийнтрэндс ХХК	Энийг бид өөрсдөө хийж чадахгүй шүү дээ, цөөхөн хэдэн компани хийсэн, дандаа гадныхан хийгээд өгчихсөн, Монголчууд нь төдийлөн туршлагажиж амжаагүй байна.	Саналыг хүлээж авсан. Сургалт явагдах шаардлагатай гэдгийг зөвлөмжид тусгасан.

102	2020.07.28		1212-с мэдээ авъя гэхээр миний хүсч байгаа датаг боловсруулж гаргаж ирдэггүй. Суурь судалгаа авах гээд олон улсын шаардлагаар явах гэхээр дор хаяж нэг жил явах хэрэгтэй болж байгаа юм.	Тусгасан. Баримт бичгийн суурь зарчим, үйл ажиллагаанд баримтлах зарчимд мэдээллийн шаардлагын талаар тусгасан. Аргачлалыг туршиж үзэх санал, зөвлөмж хүргэнэ.
103	2020.07.28		Хөрөнгө мөнгө, цаг хугацааны хувьд асар том асуудал үүсдэг. Хугацаа, хөрөнгө оруулалтын хувьд ямар байх вэ гэдгийг та хэд бодох хэрэгтэй байх.	Саналыг хүлээж авсан. Зөвлөх үйлчилгээний хамрах хүрээнд багтаагүй боловч төслийн дараагийн шатанд Аргачлалыг туршиж үзэх санал, зөвлөмж хүргэнэ.
104	2020.07.28		Яаран батлуулах гэж байхаар хөрөнгө мөнгө олоод дундаж компани дээр туршиж үзье.	Саналыг хүлээж авсан. Зөвлөх үйлчилгээний хамрах хүрээнд багтаагүй боловч төслийн дараагийн шатанд Аргачлалыг туршиж үзэх санал, зөвлөмж хүргэнэ. Аргачлалыг хэрэгжүүлэх журам нь түр журам байхаар тооцоолж зөвлөсөн.
105	2020.07.28		Олон улсын тийм том стандартад очих шаардлага байхгүй гэж заримдаа боддог. Багасгаж оруулж ирмээр санагдлаа.	Саналыг хүлээж авсан. Аргачлалыг хэрэгжүүлэх журам нь түр журам байхаар тооцоолж зөвлөсөн.
106	2020.07.28	Батбаяр, МХГ-ын Геологи, уул уурхайн хэлтсийн дарга	ННУ-г БОНБУ-тэй хамт хийх нь зохистой байна уу, үгүй юу гэдгийг харах ёстой. Эсвэл тусгай зөвшөөрлийг олгохоос өмнө нийгмийн нөлөөллийг тооцдог байх ёстой юм биш үү гэдэг асуудал байна.	Саналыг хүлээж авсан. Аргачлалыг хэрэгжүүлэх журам нь түр журам байхаар тооцоолж мөн туршиж үзэх зөвлөмж хүргүүлсэн.
107	2020.07.28		Хамрах хүрээ, нөлөөлөлд өртөх бүлгийг хэрхэн тодорхойлох вэ гэдэг асуудал.	Тусгагдсан. Нийгмийн олон талтай харилцаан дотроос яг ямар асуудлыг нь үнэлгээндээ авч үзэхийг хамрах хүрээ гэж оруулж өгсөн. Нийгмийн нөлөөлөл гэдгийг тодорхойлохын тулд олон улсын 23 стандарт шаардлагуудыг хэлэлцүүлгүүд хийн, эдгээрээсээ хэрэгцээ шаардлагаа тодорхойлсон. Нөлөөлөд өртөх бүлгийг тодорхойлох аргачлалыг заасан.
108	2020.07.28	Тунгалагтамир, ХНХЯ	Хамрах хүрээний хувьд задгай, асуудлууд нь холилдсон юм шиг харагдаж байна. Хүн амын бүлгүүд, хүүхэд, эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, уул уурхайн хүн амын удмын сан, ургын гажиг гэх мэт эрүүл мэндийн асуудлуудын агуулга оруулбал зүгээр	Саналыг хүлээж авсан. Нийгмийн олон талтай харилцаан дотроос яг ямар асуудлыг нь үнэлгээндээ авч үзэхийг хамрах хүрээ гэж оруулж өгсөн. Нийгмийн нөлөөлөл гэдгийг тодорхойлохын тулд олон улсын 23 стандарт шаардлагуудыг хэлэлцүүлгүүд хийн, эдгээрээсээ хэрэгцээ шаардлагаа тодорхойлсон. Зөвлөх багаас эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний аргачлалд эдгээрийг харгалзан үнэлэх санал өгнө.
109	2020.07.28		Хүүхдийн боловсролын асуудал, жижиг уурхайн хувьд эцэг эхээ дагаад шороо угааж, сургууль завсарддаг, эрүүл мэндийн асуудал үүсдэг, энийг анхаарч өгөөрэй.	Тусгагдсан. Нийгмийн нөлөөллийг үнэлэхдээ багийн хурлыг зохион байгуулж, тухайн багийн иргэдээс санал асуулга явуулан хэрэгцээ шаардлагыг тодорхойлон шийдвэрлэх арга замыг ННУ, ННМТ болон орон нутгийн хөгжлийн гэрээнд тусгаж шийдвэрлэхээр зохицуулна.

110	2020.07.28		Хүүхдүүд гэртээ орхигддог, эрсдэлд өртдөг, үл хайхрах хүчирхийлэлд өртдөг, ийм тоог гаргаж болох уу	Тусгагдсан. Нийгмийн нөлөөллийг үнэлэх хяналт-шинжилгээний хөтөлбөр боловсруулах үе шатанд төслийн хяналт-шинжилгээний хөтөлбөрийн индикаторуудыг судлаачид, орон нутгийн иргэд, удирдлага, хүний эрхийн чиглэлээр ажилладаг иргэний нийгмийн төлөөлөөс бүрдсэн баг хамтран ажиллаж гаргана гэж заасан.
111	2020.07.28		Нийгмийн үйлчилгээний даац хэтэрдэг асуудлуудыг тусгаж өгөх хэрэгтэй байх.	Тусгах боломжгүй.
112	2020.07.28		Дэд бүтцийн төслүүд, зам, барилгын хүртээмжийн асуудал, хүүхэд, өндөр настан, ХБИ-дэд хүртээмжтэй байх асуудлыг шалгуур үзүүлэлтдээ ч юм уу оруулж өгөхийг хүсч байна.	Зөвлөмжид тусгана. Мөн нийгмийн нөлөөллийг үнэлэхдээ багийн хурлыг зохион байгуулж, тухайн багийн иргэдээс санал асуулга явуулан хэрэгцээ шаардлагыг тодорхойлон шийдвэрлэх арга замыг БОННУ, БОНМТ болон орон нутгийн хөгжлийн гэрээнд тусгаж шийдвэрлэхээр зохицуулна.
113	2020.07.28	Бүлгийн ажил, УУХҮЯ болон төрийн албан хаагчидын 1-р баг	ННҮ-г хийх гол хөдөлгөх хүч нь ерөөсөө төсөв. ҮГА-ны бүх үйл ажиллагаа засгийн газраас санхүүжиж байгаа учраас үйл ажиллагааны төлөвлөгөөнд ННҮ-ний төсвийг суулгаж өгөх хэрэгтэй.	Саналыг хүлээж авсан. Зөвлөмжид тусгахаар болсон.
114	2020.07.28		Үндэсний геологийн алба, Ашигт малтмалын газар нь орон нутагт, геологийн талаар, энэ нь ашигт малтмал гэдэг талаас нь сургалт зохион байгуулах ёстой. АМГТГ төрийн хөрөнгөөр ажиллаж байгаа ААН-үүдийг хариуцдаг, хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн орон нутагт байршуулсан байгаль орчныг хамгаалахаар байршуулсан хөрөнгийг юунд зарцуулдаг нь огт тодорхойгүй. Энэ хөрөнгийг ННҮ-д зарцуулж болж байна, бага хэмжээний мөнгө байж магадгүй.	Саналыг хүлээж авсан. Зөвлөмжид тусгахаар болсон.
115	2020.07.28	Ганбат (УУЯ-ны УУХэлтэс)	ННҮ-г ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохоос өмнө хийх нь зүйтэй. Ордын нөөцийг баглуулахад ТЭЗҮ гэдэг бүлэгт нийгмийн нөлөөллийн тодорхой саналуудыг тусгаад, ийм зардал гаргана гээд тусгуулах нь хамгийн зөв. ТЭЗҮ боловсруулсаны дараа БОНУ-ний бүлэг ННҮ хийгээд ямар арга хэмжээ авах вэ гэдэг юм гарсан мөртлөө ТЭЗҮ-гээ хийсний дараа хийдэг учраас холбоотой зардлыг ТЭЗҮ-д тусгаагүй учраас уялдаа холбоогүй байдал харагдаж байна	Тусгагдсан. ННҮ-г Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийх шатанд зэрэг эхлүүлнэ.

116	2020.07.28		ТЭЗҮ боловсруулсан компаниуд 2 заалт тусгаад ороод ирдэг. Нэг нь бол орон нутагтай хамтран ажиллах зардал, нөгөө нь болохоор нийгмийн хариуцлагын зардал. Тэр зардал бол яг юуг шийдэх гээд байгаа нь тодорхойгүй, зүгээр орон нутгийн хэмжээнд баяр ёслол ч юм уу, орон нутгийн удирдлагатай тохирчихсон заалт байдаг. Нарийвчилсан ТЭЗҮ боловсруулахаас өмнө ННҮ-ний судалгаагаа хийгээд, тэр судалгааг төлөв байдлын судалгаатайгаа цуг батлуулах юм уу, яах юм, тэрийг яаж оруулахаа ярилцана. ННҮ-гээр ийм ийм асуудлууд гарч ирсэн, тэрнийг шийдэхийн тулд ийм ийм зардал гарна гээд тэр зардлыг ТЭЗҮ-д нийгмийн хариуцлагын зардал гэдгийг нь өөрчлөөд, ННҮ-гээр гарсан асуудлуудыг шийдвэрлэх зардал ч гэдэг юм уу, иймэрхүү байдлаар тусгавал хамгийн оновчтой юм болов уу.	Саналыг хүлээж авсан. Зөвлөмжид тусгасан.
117	2020.07.28	Бүлгийн ажил, Хуульч өмгөөлөгчид, байгаль орчны мэргэжилтнүүдийн хамтарсан 2-р баг	Бэлчээрээс хамаараад амьдралын хэв маягт гарч буй өөрчлөлтийг үнэлж үзээч гэдэг санал	Тусгагдсан. Нийгмийн нөлөөллийг үнэлэхдээ багийн хурлыг зохион байгуулж, тухайн багийн иргэдээс санал асуулга явуулан хэрэгцээ шаардлагыг тодорхойлон шийдвэрлэх арга замыг БОННҮ, БОНМТ болон орон нутгийн хөгжлийн гэрээнд тусгаж шийдвэрлэхээр зохицуулна.
118	2020.07.28		Өмчийн эрх гэсэн хэсэгт ус ашиглах эрх, усны эх үүсвэрт хүрэх хүртээмж зэрэг асуудлыг оруулж өгөөч	Тусгагдсан. Нийгмийн нөлөөллийг үнэлэхдээ багийн хурлыг зохион байгуулж, тухайн багийн иргэдээс санал асуулга явуулан хэрэгцээ шаардлагыг тодорхойлон шийдвэрлэх арга замыг БОННҮ, БОНМТ болон орон нутгийн хөгжлийн гэрээнд тусгаж шийдвэрлэхээр зохицуулна.
119	2020.07.28		Уламжлалт газрын эрх, түүнийг хэрэгжүүлж байгаа байдалд ямар өөрчлөлт орох вэ гэдгийг авч үзэх хэрэгтэй	Тусгагдсан. Нийгмийн нөлөөллийг үнэлэхдээ багийн хурлыг зохион байгуулж, тухайн багийн иргэдээс санал асуулга явуулан хэрэгцээ шаардлагыг тодорхойлон шийдвэрлэх арга замыг БОННҮ, БОНМТ болон орон нутгийн хөгжлийн гэрээнд тусгаж шийдвэрлэхээр зохицуулна.
120	2020.07.28		Өртөх этгээдийг тодорхойлохдоо, нөлөөлөлд шууд болон шууд бусаар өртөх талуудыг аль алиныг нь тодорхойлоочээ, лицензийн шууд талбайд байгаа хүмүүс шууд өртөж байгаа бол тээврийн зам дагуу, ханган нийлүүлэлтийн зам дагуу байгаа, тухайн аймаг суманд засаг захиргааныхаа нэгжийн хувьд хамаарахгүй боловч өртөж байгаа бусад талууд байгаа талууд байгаа байх, тэр шууд бусаар өртөж байгаа талуудад анхаарна уу.	Саналыг хүлээж авсан. Аргачлалын туршилтын үед харгалзан үзэх, түр журмын хэрэгжилтийн үе шатанд аргачлалыг сайжруулах талаар зөвлөмжид тусгасан.

121	2020.07.28		Хүний эрхэд суурилсан байдлаар уурхайн төсөл хэрэгжихэд тухайн орон нутагтай холбоотой талуудын ямар эрх хөндөгдөх вэ гэдгийг гаргаж ирж байгаад, тэрнийхээ үндсэн дээр хамрах хүрээгээ тогтоовол орхигдохгүй, цэгцгэй явах болов уу гэдэг санал гарсан.	Саналыг хүлээж авсан. Аргачлалын туршилтын үед харгалзан үзэх, түр журмын хэрэгжилтийн үе шатанд аргачлалыг сайжруулах талаар зөвлөмжид тусгасан.
122	2020.07.28		Менежментийн төлөвлөгөөн дээр хүний эрхийн зөрчлүүдийн тодорхойлохдоо ХЭҮК-т жил бүр гаргасан саналын тоо гэсэн байсан, энэ арай хязгаарлагдмал юмуу, хөдөө амьдарч байгаа малчин хүмүүс тэр болгон аймаг руу ХЭҮК руу хандаж чадахгүй. Багийн дарга, сумын даргадаа ханддаг, компани руу шууд ханддаг. Захиргааны болон бусад шүүхүүдэд уурхайтай холбоотой гарсан гомдлуудыг авч үзэх.	Саналыг хүлээж авсан. Аргачлалын туршилтын үед харгалзан үзэх, түр журмын хэрэгжилтийн үе шатанд аргачлалыг сайжруулах талаар зөвлөмжид тусгасан.
123	2020.07.28		Эвдэрсэн худгийн тоо гэсэн байсан, түүнээс гадна усны задгай эх үүсвэрүүдийг нэмж оруулж өгөх, ширгэж, багасч байгаа асуудал малчдын амьжиргаанд их нөлөөтэй байдаг.	Тусгагдсан. Нийгмийн нөлөөллийг үнэлэхдээ багийн хурлыг зохион байгуулж, тухайн багийн иргэдээс санал асуулга явуулан хэрэгцээ шаардлагыг тодорхойлон шийдвэрлэх арга замыг БОННУ, БОНМТ болон орон нутгийн хөгжлийн гэрээнд тусгаж шийдвэрлэхээр зохицуулна.
124	2020.07.28		Шашин шүтлэгт гарч байгаа өөрчлөлт гэж нэлээд ерөнхий байдлаар оруулсан байна, орон нутгийн иргэдийн тахиж шүтдэг уул овоо, тахилгатай газрууд их өртдөг. Хуулийн хүрээнд тэрийг нь хамгаалах гэхээр улсын чанартай тахилгатай уул бол хамгаалалтанд байдаг, орон нутгийн чанартай, цагаан сараар гардаг уул ч юмуу, ямар ч хамгаалалтгүй байдаг. Мөн оршуулгын газрууд их өртдөг юм байна. Хамгаалал байдаггүйг бий болгох.	Саналыг хүлээж авсан. Зөвлөмжид тусгасан.
125	2020.07.28		Аргачлалынхаа нэрийг аваад үзээрэй, зорилгоо аваад үзэхээр уул уурхай, дэд бүтцийн төслүүдийн нөлөөлөл гээд тавьчихсан, үндсэн нэр маань ННУ гэхээр бүх төслүүдэд хамаарах ч юм шиг болоод байна, хаана байдаг юм ялгааг нь гаргаж өгөх хэрэгтэй.	Саналыг хүлээж авсан. Зөвлөмжид тусгасан.
126	2020.07.28		Уурхайтай холбоотой гарч байгаа малын удмын сан, генетикт гарч байгаа өөрчлөлт, нөлөөллийг авч үзээчээ гэдэг санал байна.	Тусгагдсан. Нийгмийн нөлөөллийг үнэлэхдээ багийн хурлыг зохион байгуулж, тухайн багийн иргэдээс санал асуулга явуулан хэрэгцээ шаардлагыг тодорхойлон шийдвэрлэх арга замыг БОННУ, БОНМТ болон орон нутгийн хөгжлийн гэрээнд тусгаж шийдвэрлэхээр зохицуулна.
127	2020.07.28		Үнэлгээний тайланг хянан баталж байгаа, тэрний хэрэгжилтэнд хяналт тавих тогтолцоон дээр анхаараасай. Яагаад гэхээр бид БОНУ-г 2006 оноос хойш хийсэн, одоо болтол тэр үнэлгээтэй холбоотой асуудал тасардаггүй.	Саналыг хүлээж авсан. Зөвлөмжид тусгасан.

128	2020.07.28	Бүлгийн ажил, ХНХЯ, ХЭҮК хамтарсан 3-р баг	ННҮ, үүнд цаашлаад хүний эрхийн асуудлыг хуульчилж оруулж өгвөл илүү тогтвортой хэрэгжих эрх зүйн орчин бүрдэх болов уу. Түр журам гэхээсээ илүү шууд журам болгож батлах	Зөвлөмжид санал болгоно.
129	2020.07.28	Бүлгийн ажил, Иргэний нийгмийн 4-р баг	Ерөөсөө тусгай зөвшөөрөл өгөхөөсөө өмнө төр өөрөө энийгээ хариуцдаг байя. Олон талын оролцоотой үнэлгээгээ хийгээд, батлуулбал яасан юм бэ гэсэн санаа байна.	Тусгагдсан. ННҮ-г Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийх шатанд зэрэг эхлүүлнэ.
130	2020.07.28	Бүлгийн ажил, Үнэлгээний компаниудын 5-р баг	Түгээмэл хэрэглэгддэггүй нэр томъёо маш их байна, гаднаас шууд орчуулагдаад орж ирсэн нэр томъёог бид нар яаж ойлгох вэ гэдэг асуудал байна. Тухайн утгыг нь дэлгэрэнгүй сайн тайлбарлаж өгмөөр байна.	Саналыг хүлээж авсан. Мөн Зөвлөмж хэсэгт цаашид төрийн байгууллагуудын авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хууль тогтоомжийн өөрчлөлтөд тодорхойлолтыг сайжруулах талаар санал зөвлөмж өгсөн.
131	2020.07.28	Нөлөөлөлд өртөгч, шууд болон шууд бус нөлөөлөл, нөлөөллийн бүс гээд яриад байна, эдгээрийг яаж ойлгох вэ, зам дагуу байгаа иргэд хамаарах уу, үгүй юу, ханган нийлүүлэлтийн асуудал ярихаар глобальный юм болчих гээд байдаг. Энэ дээр чиглэл зааварчилгаа, хязгаарлалтуудаа өгмөөр байна.		
132	2020.07.28		10 жил гэдэг асуудлаа боливол яадаг юм бэ. Би өнөөдөр тэнд нүүгээд очлоо гэхэд миний эрхийг хангахгүй болох гээд байна.	Саналыг хүлээж авсан.
133	2020.07.28		ИНХ-аар үнэлгээний багт орох хүмүүсийг сонгоно гэж байгаа нь хуралдаад хэн, яаж шийдвэр гаргах юм бэ, хэдээр тасалбар болгох юм бэ гэдгээ яаж тодорхойлох вэ. Оролцогч талуудаа тодорхойлно гэхээр аймаар том жагсаалт үүснэ. Энэнээс хэнийг нь болиулаад, ямар саналаар гаргах юм бэ гэдэг нь зохицуулалтын хувьд тодорхойгүй байна.	Саналыг хүлээж авсан. Зөвлөмж хэсэгт санал оруулсан.
134	2020.07.28	Др Эмма Вилсон, Оксфордын их сургууль	Энэ аргачлал хэнд зориулагдсан, хэрхэн хэрэглэх талаар мэдээлэл оруулах	Саналыг хүлээж авсан.
135	2020.07.28		Яагаад ННҮ хэрэгцээтэй болсон, ямар хэмжээтэй хийх, жишээ нь, хэрвээ хайгуулын үйл ажиллагаа хамаарч байгаа бол ямар ямар хэсгийг хамарч үнэлгээ хийгдэх вэ гэдгийг тодорхой болгох хэрэгтэй. Хэрвээ тийм бол гол төслийн нөлөөллийн үнэлгээтэй ижил байх уу нөлөөллийн үнэлгээний зорилгоо тодорхойлох хэрэгтэй.	Саналыг хүлээж авсан.
136	2020.08.03	Др Эмма Вилсон, Оксфордын их сургууль, Маннон Донахо, Газар зүй, байгаль орчны сургуулийн судлаач, Оксфордын их сургууль, Стивен, Кэмбрижийн ИС-ийн судлаач, Трой Стернберг, Говийн загвар төслийн судлаач нарын санал	Хавсралт 100 гаруй санал.	Тусгасан. Саналыг тусад нь боловсруулж, Аргачлалын төсөлд засвар оруулсан.

Хавсралт 3. Олон улсын хүний эрх, байгаль орчин, нийгмийн стандарт, зарчмын задаргаа

№	Баримт бичиг/ Стандартын нэр	Ерөнхий мэдээлэл	Үндсэн зарчим
1	Хүний эрхийн түгээмэл тунхаглал, <i>Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей 1946 (Universal Declaration of Human Rights, UN General Assembly, 1946)</i>	Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1948 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 217/A/III/ тогтоолоор Парист батлагдсан. Энэхүү тунхаглал нь туршлагаас үүдэж "хүн бүхэнд төрөлх заяасан эрх бий" хэмээх санааг анх дэлхийн түвшинд гаргаж ирсэн болно. Нийт гучин зүйл ангиас бүрдсэн энэхүү тунхаглал нь олон улсын болон бүс нутгийн хэмжээний хүний эрхийн гэрээ, хуулиудын үндэс болсон.	<p>Хүний эрхийн үндсэн зарчмуудыг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:</p> <p>ТЭГШ БАЙХ Хүн болж төрснийхөө хувьд хүн бүр ижил үнэ цэнэтэй байж, адил хүндэтгэлийг эдэлнэ.</p> <p>ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАХГҮЙ БАЙХ Арьс өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний болон нийгмийн гарал, өмч хөрөнгө, төрсөн байдлаас үл хамааран хэнийг ч ялгаварлан гадуурхаж болохгүй.</p> <p>ТҮГЭЭМЭЛ, САЛШГҮЙ БАЙХ Хүн оршин байгаа цагт эрхийг хүнээс тусгаарлах, салгах боломжгүй бөгөөд хүнээс салшгүй ойлголт юм. Хүний эрх нь ертөнцийн өнцөг, булан бүрд амьдарч байгаа хүн бүрд хамаатай. Иймд бүх хүн ялгаваргүйгээр тэгш хүртэх түгээмэл шинж чанартай.</p> <p>ХҮН ҮНЭ ЦЭНЭ, НЭР ТӨРТЭЙ БАЙХ Хүний үнэ цэнэ, нэр төр нь бүх хүмүүс хүн болж төрснийхөө хувьд ижил үнэлэгдэж, адил хүндлэл хүлээнэ. Бүх хүн нас, соёл, угсаа гарал, арьс өнгө, хүйс, хүйсийн чиг баримжаа, хэл, боломж чадвар, нийгэмд эзлэх байр суурь, иргэний харьяалал болон улс төрийн үзэл бодлоос үл хамааран ижил хүндлэлийг хүлээнэ.</p> <p>ХУВААГДАШГҮЙ БАЙХ Иргэний, улс төрийн, нийгэм эдийн засаг, соёлын болон хамтын эрх зэрэг хүний бүх эрхүүд нэгдмэл, хуваагдашгүй байдаг.</p> <p>ХАРИЛЦАН ХАМААРАЛТАЙ БАЙХ Хүний эрх нь орон гэр, зах, сургууль, ажлын байр, зэрэг газар бүрд, амьдралын бүхий л хүрээг хамардаг. Өөрөөр хэлбэл аль нэг эрх нь зөрчигдөхөд бусад эрхүүдэд нөлөөлнө нөгөө талаар нэг төрлийн эрхийг хангах явдал сайжрахад өөр эрхийг эдлэх боломж илүү бүрддэг. Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байна. Тэдэнд оюун ухаан, өрлөг сэтгэл заяасан бөгөөд өөр хоорондоо ахан дүүсийн ёсоор харилцах ёстой.</p> <p>Харин компанийн нийгмийн хариуцлагын зарчим нь дараах байдлаар тодорхойлогджээ.</p> <ul style="list-style-type: none"> • Хүний эрх

			<p>1-р зарчим: Аливаа аж ахуйн нэгж нь олон улсын түвшинд хүлээн зөвшөөрсөн хүний эрхийг хамгаалах зарчмыг дэмжих, хүндлэх ёстой. - 2-р зарчим: Хүний эрхийг хөсөрдүүлэхгүй байх ёстой.</p> <ul style="list-style-type: none"> • Ажил хөдөлмөр <p>3-р зарчим: Аливаа аж ахуйн нэгж эвлэлдэн нэгдэх, хамтын хэлцэл хийх эрхийг хүлээн зөвшөөрч, дээдлэх ёстой.</p> <p>4-р зарчим: Хүчээр болон албадан хөдөлмөр эрхлэх бүхий л хэлбэрийг устгана.</p> <p>5-р зарчим: Хүүхдийн хөдөлмөрийг устгана.</p> <p>6-р зарчим: Ажил хөдөлмөр эрхлэлт болон ажил мэргэжлийн талаар ялгаварлан гадуурхалтыг устгана.</p> <ul style="list-style-type: none"> • Байгаль орчин <p>7-р зарчим: Аж ахуйн нэгж нь байгаль орчинд тулгамдсан асуудал учрахаас урьдчилан сэргийлэх зорилго бүхий үйл ажиллагааг дэмжиж ажиллана.</p> <p>8-р зарчим: Байгаль орчны өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа ухамсарлахыг хөхүүлэн дэмжиж, санаачлилга гаргаж ажиллана. - 9-р зарчим: Байгаль орчинд ээлтэй технологийг хөгжүүлэх, дэлгэрүүлэхийг урамшуулж, дэмжиж ажиллана.</p> <ul style="list-style-type: none"> • Авилгын эсрэг <p>10-р зарчим: Аж ахуйн нэгж нь хээл хахуулийг оролцуулаад авилгын бүхий л хэлбэрийг ашиглахын эсрэг ажиллах ёстой.</p>
2	<p>Байгаль орчны асуудлаар мэдээлэл авах, шийдвэр гаргахад оролцох, эрхээ хамгаалуулах талаарх ААРХУС-ын конвенц, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс 1998</p> <p><i>(Convention on Access to Information, Public Participation in Decision-making and</i></p>	<p>Хүн бүрийн болон хойч үеийнхнийхээ эрүүл мэнд, сайн сайхан орчинд амьдрах эрхийг нь хамгаалахад хувь нэмрээ оруулахын тулд Конвенцийн Гишүүн улс бүр энэхүү Конвенцийн зүйл заалтуудын дагуу байгаль орчны асуудлаар мэдээлэл авах, шийдвэр гаргахад оролцох, эрхээ хамгаалуулах эрхийг нь баталгаажуулах зорилгоор батлагдсан олон улсын конвенци юм.</p> <p>Дараах мэдээллийг байгаль орчны мэдээлэл гэж үзэхээр байна. Үүнд:</p> <p>а. Агаар, хийн мандал, ус, хөрс, газар, газрын болон байгалийн тогтоц, биологийн төрөл зүйл, тэдгээрийн бүрдлүүд, үүний дотор, генийн өөрчлөлттэй организмууд зэрэг хүрээлэн буй орчны бүрэлдэхүүн хэсгүүд болон тэдгээрийн харилцан үйлчлэлийн талаарх мэдээлэл;</p>	<p>3 Тулгуурт бодлого:</p> <ol style="list-style-type: none"> 1. Мэдээллийн хүртээмж. 2. Шийдвэр гаргахад олон нийтийн оролцоо 3. Шударга байдлын хүртээмж <ul style="list-style-type: none"> • Байгаль орчны мэдээллийг нээлттэй болгох, мэдээлэл авах, мэдээллийг нэгтгэх, • Хүний үйл ажиллагаа, эсхүл байгалийн хүчин зүйлсээс шалтгаалан хүний эрүүл мэнд, байгаль орчинд болзошгүй аюул учрах үед уг аюулын хор хөнөөлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авахад туслах боломж олон нийтэд олгох үүднээс түүнчлэн төрийн байгууллага, албан тушаалтнаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх бүх мэдээллийг уг аюулд өртөж болох нутгийн иргэдэд нэн даруй, хойшлуулахгүйгээр тараах, • Тодорхой үйл ажиллагаанд оролцох эрх: <ul style="list-style-type: none"> - Байгаль орчны асуудлаар шийдвэр гаргах үйл явцад дор дурдсан асуудлуудын талаар нийтээр нь болон ганцаарчлан хамгийн боломжтой хувилбараар аль болох эрт, цаг хугацааг харгалзсан, үр

	<p><i>Access to Justice in Environmental Matters, UNECE 1998)</i></p>	<p>б. Энэ зүйлийн а-д дурдсан байгаль орчныг бүрдүүлэгч элементүүдэд нөлөөлж байгаа болон нөлөөлж болох бодис, энерги, дуу чимээ болон цацраг, түүнчлэн үйл ажиллагаа, арга хэмжээнүүд, үүний дотор захиргааны арга хэмжээ, байгаль орчны гэрээ хэлэлцээрүүд, бодлого, хууль тогтоомж, хөтөлбөр, төлөвлөгөө, мөн байгаль орчны асуудлаар шийдвэр гаргах гарах зардал, эдийн засгийн бусад анализ, таамаглалууд;</p> <p>в. Байгаль орчныг бүрдүүлэгч элементүүд, эсхүл тэдгээр элементүүдийн нөхцөл байдлаас, мөн энэ зүйлийн б-д дурдсан хүчин зүйлс, үйл ажиллагаа, арга хэмжээний нөлөөлөлд өртөж байгаа, өртөх магадлалтай хүмүүсийн эрүүл мэнд, аюулгүй байдал, хүний амьдралын нөхцөл, соёлын хүчин зүйлсийн талаарх мэдээлэл</p>	<p>дүнтэйгээр, зохих арга замаар, холбогдох талуудад мэдээлнэ. Үүнд:</p> <p>а. Шийдвэрлэх шаардлагатай санал болгож буй үйл ажиллагаа болон өргөдөл б. Гарч болох шийдвэрийн төрөл, шийдвэрийн төсөл в. Шийдвэр гаргах үүрэг бүхий төрийн албан тушаалтан г. Мэдээллээр хангах хугацаа зэргийг багтаасан тойм процесс, үүнд:</p> <p>- Үйл явцыг эхлүүлэх - Олон нийт оролцох боломж - Олон нийтийн хэлэлцүүлэг хийх бол уг арга хэмжээг зохион байгуулах газар, хугацаа - Олон нийтээр хянуулах зорилгоор холбогдох мэдээллийг байршуулсан газар болон мэдээллийг олж авч болох төрийн байгууллага, албан тушаалтныг тодорхой заах - Асуулт, тайлбарыг шилжүүлж болох холбогдох төрийн байгууллага, албан тушаалтан болон бусад албаны этгээдүүд, тийнхүү шилжүүлэх цагийн хуваарь - Санал болгож буй үйл ажиллагаатай холбоотой, байгаль орчны ямар мэдээлэл байгаа тухай болон д. Тухайн үйл ажиллагаа нь үндэсний болон хил дамнасан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний процессын асуудал болох тухай баримт.</p> <ul style="list-style-type: none"> • Байгаль орчны бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, эрх зүйн үр дагавар бүхий хэм хэмжээ тогтоосон акт, зөрчигдсөн эрхээ хамгаалуулах, талуудын уулзалт зохион байгуулах, Санал өгөх эрхийг хангах зэргийг тодорхойлжээ.
3	<p>Уугуул болон омгийн хүмүүсийн тухай 169 конвенци, Олон улсын хөдөлмөрийн байгууллага 1989</p> <p><i>(Convention 169, ILO 1989)</i></p>	<p>Уугуул иргэд болон омогт харъяалагдах ажиллагчид хөдөлмөр эрхлэлтийн хүрээнд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хүртэх тэгш боломж, тэгш хандуулах эрхийг ялгаваргүй эдэлнэ. Уугуул болон омгийн хүмүүсийн тухай 1989 оны 169 дүгээр Конвенцид тэднийг хүний эрх болон үндсэн эрх чөлөөг аливаа ялгаварлалгүй бүрэн эдлэх ёстой гэж заасан байдаг. Энэ нь уугуул болон омгийн эмэгтэйчүүдийн эрхийг хязгаарласан соёл практикийг тухай бүр нь авч үзэх, зогсоох ёстой гэсэн үг юм. 169 дүгээр Конвенц бол бэлгийн дарамтаас хамгаалах асуудлыг тодорхой авч үзсэн олон улсын цорын ганц баримт бичиг (20.3 дугаар зүйл (d)) байна. Тус байгууллагаас 169 дүгээр Конвенцийг соёрхон батлахыг хөхиүлэн дэмжих зорилгоор 1989 онд Уугуул болон омгийн хүмүүсийн талаарх Тогтоол гаргасан</p>	<p>ОУХБ-аас уугуул болон омгийн хүмүүст хандан явуулж буй үйл ажиллагаа нь стандартыг баталж, хяналт тавих, мөн уугуул болон омгийн хүмүүст ба төрд дэмжлэг тусалцаа үзүүлэх гэсэн хоёр хэсэгт хуваагддаг. Уугуул ба омгийн хүмүүс үндсэн эрхээ эдлэхийг баталгаажуулж, тэдний уламжлал, ёс заншил, газрын эрх, уламжлалт газар нутагтаа байгалийн нөөцийг ашиглах, хөдөлмөр эрхлэх, мэргэжлийн сургалтад хамрагдах, хөдөө орон нутагтаа гар урлал, үйлдвэрлэл эрхлэх, нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ хүртэх, хил дамнасан харилцаа тогтоох зэрэг асуудлаар тусгайлан бодлого боловсруулж гаргана. Тэгш байдлыг тогтооход чиглэсэн зориудын арга хэмжээ; Ялгаварлан гадуурхал; Олон янз байдал; Бэлгийн дарамт; Бизнес эрхлэгч эмэгтэй гэсэн хэсгүүдтэй.</p> <p>Уугуул болон омгийн хүмүүсийн эрхийн асуудлыг авч үзсэн 169 дүгээр Конвенц нь 20.3 зүйлдээ тохиолдлын ажил эрхлэгчдийн талаар заасан байна. Хэрэгжүүлэх арга хэмжээ нь дараах зүйлсийг баталгаажуулсан арга хэмжээг багтаасан байх ёстой. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - уугуул болон омгийн ард түмний төлөөлөгч ажиллагчид, улирлын, тохиолдлын, хөдөө аж ахуйн олон бусад салбарын шилжин ажиллагчдыг оролцуулан, мөн хөдөлмөрийн гэрээ

			хийгчдээр дамжуулан хөлслөгдсөн ажиллагчид тухайн салбарынхаа бусад ажиллагчдын үндэсний хууль тогтоомж, дадлын дагуу эдэлж буй хамгааллыг нэгэн адилаар эдэлж, хөдөлмөрийн хууль тогтоомжоор олгогдсон эрхийнхээ болон сэргээх арга хэрэгслийн талаар бүрэн мэдээлэл авч байна.
4	<p>Байгаль орчин ба хөгжлийн тухай Риогийн тунхаг, НҮБ-ын Байгаль орчин ба хөгжлийн хурал 1992</p> <p><i>(Rio Declaration on Environment and Development, UN Conference on Environment and Development 1992)</i></p>	<p>2012 онд Бразил Улсын Рио де жанейро хотноо хуралдсан НҮБ-ын чуулганаас “Бидний хүсч буй ирээдүй” баримт бичгийг баталж, тогтвортой хөгжилд хүрэх, ядуурлыг бууруулах арга зам бол ногоон эдийн засаг юм хэмээн тусгасан. 1992 онд Бразилийн Рио де жанейро хотод чуулсан “Байгаль орчин ба хөгжил” сэдэвт НҮБ-ын дээд хэмжээний чуулга уулзалтаас “Хөгжлийн хөтөлбөр-21” баримт бичгийг баталсанаар тогтвортой хөгжлийн асуудал нь дэлхий нийтийн эрхэм дээд зорилго болсон гэж үздэг. Энэхүү чуулганаар дэлхийн улс орнуудыг тогтвортой хөгжлийн зорилтоо тодорхойлон, Риогийн тунхаглалыг хэрэгжүүлэхийг уриалсан юм.</p>	<p>Риогийн тунхаг хэмээх 27 зүйл, зарчим бүхий баримт бичгийн зарчим:</p> <p>Зарчим 1. Хүн нь тогтвортой хөгжлийн гол цөм юм. Тэд байгаль дэлхийтэй хосолсон эрүүл, үр өгөөжтэй амьдрах эрхтэй.</p> <p>Зарчим 2. НҮБ-ын Дүрэм болон олон улсын хууль тогтоомжид заасан зарчмын дагуу улс орнууд өөрсдийн байгаль орчин, хөгжлийн бодлогын хүрээнд байгалийн баялгийнхаа нөөцийг ашиглах дархан эрхтэй ба тухайн үйл ажиллагаа нь бусад улс орны эсхүл үндэсний хил хязгаарыг давсан газар нутгийн байгаль орчинд хохирол учруулахгүй байхыг хянах үүрэгтэй.</p> <p>Зарчим 3. Хөгжих эрх нь өнөөгийн болон хойч үеийнхний хөгжлийн болон байгаль орчны хэрэгцээ нь харилцан тэнцвэртэйгээр хангагдахуйцаар хэрэгжих ёстой.</p> <p>Зарчим 4. Тогтвортой хөгжлийг хангахад байгаль орчныг хамгаалах нь хөгжлийн салшгүй хэсэг байх ёстой.</p> <p>Зарчим 5. Бүх улс болон бүх хүмүүс амьдралын стандарт, нийгмийн ялгамжтай байдлыг бууруулах, дэлхийн дийлэнх хүн төрөлхтөний хэрэглээнд хүрэх зорилгоор тогтвортой хөгжлийн салшгүй хэрэгцээ болох ядуурлыг бууруулахад хамтран ажиллах хэрэгтэй.</p> <p>Зарчим 6. Хөгжиж буй улс орнууд, ялангуяа буурай хөгжилтэй болон байгаль орчны эмзэг байдалд байгаа улс орнуудын тусгай хэрэгцээ болон онцгой нөхцөлд онцгой анхаарал хандуулж, нэн тэргүүнд тавьна. Олон улсын байгаль орчин болон хөгжлийн арга хэмжээг бүх улс орны ашиг сонирхол, хэрэгцээнд чиглүүлнэ.</p> <p>Зарчим 7. Улс орнууд дэлхийн бөмбөрцөгийн экосистемийн тамир тэнхээ, бие даасан байдлыг хадгалах, хамгаалах, сэргээх зорилгоор дэлхийн хамтын ажиллагааг бэхжүүлэх шаардлагатай. Дэлхийн байгаль орчны доройтлын өөр өөр нөхцөлийг харгалзан улс орнууд нэгдсэн боловч ялгамжтай үүрэг, хариуцлагыг хүлээнэ. Хөгжиж буй улс орнууд олон улсын тогтвортой хөгжлийг хангахад чиглэгдсэн үүрэг хариуцлагыг хүлээхээ хүлээн зөвшөөрч, өөрсдийн технологи, санхүүгийн нөөц хөрөнгийг дэлхийн байгаль орчинд зарцуулах зорилготой ажиллана.</p> <p>Зарчим 8. Тогтвортой хөгжил болон чанартай амьдралыг хүмүүст хүргэхийн тулд улс орнууд үйлдвэрлэл, хэрэглээний хэмнэлттгүй арга барилаас татгалзаж, хүн ам зүйнд тохирсон бодлогыг хэрэгжүүлэх хэрэгтэй.</p>

			<p>Зарчим 9. Улс орнууд шинжлэх ухаан, технологийн мэдлэг, туршлагыг харилцан солилцож, тогтвортой хөгжлийн чадавхийг бэхжүүлэхэд хамтран ажиллан технологи болон шинэ, инновацийг хөгжүүлэх, түүнд дасан зохицох, дамжуулах нөхцөлийг сайжруулах шаардлагатай.</p> <p>Зарчим 10. Байгаль орчны асуудлыг нөлөөлөлд өртөх бүх иргэдийг оролцуулан, зохих түвшинд нь шийдвэрлэх нь зүйтэй. Үндэсний түвшинд хувь хүн бүр байгаль орчинтой холбоотой түүний дотор хамаарах нутаг дэвсгэрт нь явагдаж буй аюултай материал ба үйл ажиллагаатай холбоотой төрийн хадгалж буй мэдээлэлтэй танилцах болон холбогдох шийдвэр гаргахад оролцох боломжтой байх шаардлагатай. Төрөөс олон нийтийн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх, мэдээллийг өргөн нээлттэй байлгаж оролцоог хангахад анхаарах шаардлагатай. Шүүх болон захиргааны үйл ажиллагаа, мөн засаж залруулах ажиллагаанд үр дүнтэй оролцох нөхцөлийг мөн бүрдүүлсэн байна.</p> <p>Зарчим 11. Улс орон бүр байгаль орчны үр дүнтэй хууль тогтоомжийг батлах шаардлагатай. Байгаль орчны стандарт, менежментийн зорилтууд, тэргүүлэх чиглэл нь хамаарах байгаль орчин болон хөгжлийн хөтөлбөртэй уялдсан байх ёстой. Зарим улс орон хэрэгжих стандарт нь бусад ялангуяа хөгжиж буй оронд тохирохгүй, эдийн засаг, нийгмийн зардлыг өсгөхөөр байх магадлалтай анхаарах хэрэгтэй.</p> <p>Зарчим 12. Улс орнууд бүх улсад тогтвортой хөгжлийг дэмжих нээлттэй, харилцан дэмжлэг үзүүлэхүйц эдийн засгийн тогтолцоог хөгжүүлэхэд хамтран ажиллаж, байгаль орчны доройтолтой холбоотой хүндрэлүүдийг хамтдаа даван туулахыг эрмэлзэх хэрэгтэй. Байгаль орчны зорилгоор авч хэрэгжүүлэх худалдааны бодлогын арга хэмжээ нь маргаантай, үндэслэлгүй ялгаварлан гадуурхасан, эсхүл олон улсын худалдаанд далд хориг тавьсан байх ёсгүй. Импорт хийгч улс оронд зөвхөн нэг талаас заасан байналь орчны асуудлыг шийдвэрлэх нөхцөл тавих ёсгүй. Хил дамнасан эсхүл дэлхийн байгаль орчны арга хэмжээний асуудлыг олон улсын зөвшөөрлийн үндсэн дээр хэрэгжүүлнэ.</p> <p>Зарчим 13. Улс орнууд бохирдол болон бусад байгаль орчны гэмтэл, хохирлын нөхөн олговрыг олгох, төлөх дотоодын хуулийг бий болгох хэрэгтэй. Цаашлаад өөрсдийн нутаг дэвсгэрт хийгдсэн үйл ажиллагаанаас бусад нутаг дэвсгэрт хохирол учирсан бол хохирлыг барагдуулах олон улсын хуулийг боловсруулахад нэн яаралтай, тууштай оролцох ёстой.</p> <p>Зарчим 14. Улс орнууд бусад улс орны байгаль орчинд ноцтой хохирол учруулах эсхүл хүний эрүүл мэндэд халтай аливаа үйл ажиллагааг явуулахаас урьдчилан сэргийлэх, эсэргүйцэхэд идэвхитэй хамтран ажиллах хэрэгтэй.</p>
--	--	--	---

			<p>Зарчим 15. Байгаль орчныг хамгаалахын тулд улс орнууд өөрсдийн чадавхиараа урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Буцаашгүй хохирол учирсан эсхүл эрдэм шинжилгээний баттах мэдээлэл байхгүй зэргээр байгаль орчинд учирсан бохирдлыг арилгах зардал-үр ашигтэй арга хэмжээг хойшлуулах ёсгүй.</p> <p>Зарчим 16. Эрх бүхий үндэсний байгууллагууд хүрээлэн буй орчинтой холбогдолтой зардлыг тухайн газар нутагт нь хязгаарлах, эдийн засгийн хөшүүргүүдийг хэрэглэхийг эрмэлзэж, зарчмын хувьд бохирдуулагч нь бохирдуулсныхаа зардлыг нийтийн ашиг сонирхол, олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтад саад учруулахгүйгээр зохих ёсоор харгалзан хариуцах ёстой.</p> <p>Зарчим 17. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ нь байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж болохуйц үйл ажиллагаануудад заавал хийгддэх байх ёстой ба төрийн байгууллагаар баталгааждаг үндэсний баримт бичгийн төрөл байх ёстой.</p> <p>Зарчим 18. Улс орон бүр аливаа улс оронд гэнэтийн хохирол учруулах байгаль орчинд сөрөг үр нөлөөлөл бий болох байгалийн гамшиг эсхүл бусад гэнэтийн нөхцөл байдал үүссэн тохиолдолд нэн даруй мэдэгдэнэ. Энэ нь бусад улсыг эрсдэлд оруулахаас сэргийлэх зорилготой байна.</p> <p>Зарчим 19. Улс орон бүр зэргэлдээ улсынхаа хил дамнасан байгаль орчны сөрөг нөлөөлөл бий болох магадлалт үйл ажиллагааныхаа талаар хөрш улсдаа урьдчилан, цаг тухайд мэдэгдэж, зэргэлдээ улс орнуудтай эрт үед нь нээлттэйгээр зөвлөлдөх шаардлагатай.</p> <p>Зарчим 20. Эмэгтэйчүүд байгаль орчны менежмент болон хөгжилд чухал үүрэгтэй. Тогтвортой хөгжлийг хангахад тэднийг бүрэн дүүрэн оролцоо чухал.</p> <p>Зарчим 21. Залуусын шинэ санаа, үнэт зүйл, эр зоргийг дэлхийн хамтын нөхөрлөлийг бэхжүүлэн, тогтвортой хөгжлийн зорилтод хүрэхэд чиглүүлэн бүх нийтэд илүү сайн ирээдүйг бий болгох хэрэгтэй.</p> <p>Зарчим 22. Уугуул иргэд, уугуул иргэдийн хамтын нийгэмлэг болон орон нутгийн нийгэмлэг нь хуримтлуулсан мэдлэг, уламжлалт арга барилаараа байгаль орчны менежмент болон хөгжилд нэн чухал үүрэгтэй. Улс орнууд тэдний онцлог байдал, соёл, ашиг сонирхлыг дэмжин хамгаалж, тогтвортой хөгжлийг хангахад оролцоог нь хангах шаардлагатай.</p> <p>Зарчим 23. Дарам, ноёрхол, эзлэн түрэмгийлэлд өртсөн иргэдийн байгалийн болон хүрээлэн буй орчны нөөцийг хамгаалах шаардлагатай.</p> <p>Зарчим 24. Дайн байлдаан нь тогтвортой хөгжлийг үндсээр нь сүйтгэдэг. Улс орон бүр зэвсэгт халдлага гарсан тохиолдолд байгаль</p>
--	--	--	--

			<p>орчныг хамгаалах олон улсын хууль тогтоомжийг хүндэтгэн, ирээдүйн хөгжлийн төлөө чадах чинээгээрээ хамтран ажиллах шаардлагатай.</p> <p>Зарчим 25. Энх тайван, хөгжил, байгаль орчныг хамгаалах нь харилцан хамааралтай, салшгүй нэгэн цул зүйл юм.</p> <p>Зарчим 26. Улс орон өөрсдийн дотоод байгаль орчинтой холбоотой бүхий л маргааныг НҮБ-ын Дүрмийн дагуу энхийн замаар, зохистой шийдвэрлэнэ.</p> <p>Зарчим 27. Улс орон болон иргэд нь энэхүү тунхаглалд баталгаажуулсан зарчмыг чин сэтгэлээсээ хамтран ажиллаж, хэрэгжүүлэх хүсэл эрмэлзэлтэй байж, тогтвортой хөгжлийн чиглэлээрх олон улсын хууль тогтоомжийг цаашид ч хэрэгжүүлэн ажиллах хэрэгтэй.</p>
5	<p>Тогтвортой амьжиргааны арга зүй /ТААЗ/, Хөдөөгийн тогтвортой амжиргааны Зөвлөх хороо 2000</p> <p><i>(Sustainable Livelihoods Guidance Sheets, Sustainable Rural Livelihoods Advisory Committee 2000)</i></p>	<p>Уул уурхайн төслийн үе шат бүрийн онцлогоос хамаарч янз бүрийн нийгэмд үзүүлэх нөлөөлөх үүсч болох бөгөөд түүнийг үнэлэх олон янзын аргууд байдаг. Үндсэндээ, орон нутгийн нийгмийн нөлөөлөл, учирч болох эрсдэлийг үнэлэх 2 төрлийн арга зүйн хандлага байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Мэргэжилтнүүдэд түшиглэсэн буюу дээрээс доош чигтэй. - Орон нутгийн иргэдэд түшиглэсэн буюу доороос дээш чигтэй <p>Эхний хандлага нь нийгмийн шинжлэх ухаан болон бусад судалгааны үр дүнд суурилсан, түүнээс эхтэй бол хоёр дахь хандлага нь илүү орон нутгийн онцлогыг харгалзсан, орон нутгийн нийгмийн нөхцөл байдал, үнэлэмж, амьжиргаа зэргийг нарийвчлан авч үзэхэд анхаарна. Энэ 2 хандлагыг сайтар хослуулан хэрэглэх нь уул уурхайн нийгмийн нөлөөлөл, эрсдэлийг урьдчилан тодорхойлж, хариу арга хэмжээ авахад ихээхэн ач холбогдолтой юм. Түүнчлэн нөлөөллийг тодорхойлох, мониторинг хийхэд олон шинжлэх ухааныг хослуулсан хандлага нилээд дэлгэрчээ.</p> <p>Хувь хүн, өрх гэр ба орон нутгийн хувьд ямар капитал ямар хэмжээтэй байх нь янз бүр бөгөөд олон төрлийн, зохих хэмжээний капиталтай нь амьжиргааны илүү баялаг сонголт, боломжуудтай гэж үзнэ. Эмзэг байдлыг бий болгогч олон янзын хүчин зүйлс /жишээ нь</p>	<p>ТААЗ нь орон нутгийн түвшинд иргэдийн амьжиргааг бий болгох, хадгалж байхад дараах 5 капитал чухал үүрэгтэй гэж үздэг байна. Эдгээр нь хүний, нийгмийн, эдийн засгийн буюу санхүүгийн, биет, байгалийн капитал гэж үздэгээрээ Олон улсын нөлөөллийн үнэлгээний ассоссиацийн гарын авлага, аргачлалтай ихээхэн төстэй байна.</p> <ul style="list-style-type: none"> • Хүний капитал – орон нутгийн хүний капиталыг хүн амын хэмжээ, нас, онцлогууд, боловсрол, чадвар, эрүл мэнд зэргээр төлөөлүүлэн авч үзэх, • Нийгмийн капитал – Хувь хүн амьжиргаагаа залгуулахад хэрэгтэй нийгмийн хүчин зүйлс, хүмүүсийн холбоо хэлхээ, бүлэг, байгууллага дахь оролцоо зэрэг юм. Орон нутгийн түвшин дэх нийгмийн капиталыг хн амын шилжих хөдөлгөөн, орон нутгийн хүн амын бүтэц, онцлог, хоршоо, бүлгүүдийн тоо, гэр бүлийн бүтэц, гэмт хэргийн гаралт зэрэг янз бүрийн үзүүлэлтээр авч үзэх, • Эдийн засгийн ба санхүүгийн капитал – амьжиргаагаа хангах, дээшлүүлэхэд шаардлагатай хувь хүний хөрөнгө, санхүүгийн нөөц (жишээ нь ажил, гэр бүлийн орлого, бэлэн мөнгө, хадгаламж, зээл). • Биет капитал – хувь хүний амьжиргаанд шаардлагатай суурь дэд бүтэц, үйлдвэрлэлийн хэрэгсэл. Нийтийн зээмшлийн, бүтээн байгуулсан, орон нутгийн дэд бүтэц (барилга, байгууламж, үйлчилгээ гэх мэт) болон байр сууцанд хүртээмж ямар байдаг, тэдгээрийн төрөл, хэмжээ зэрэг асуудлыг ойлгох, • Байгалийн капитал – орон нутгийн давуу тал, тогтвортой хөгжилд хувь нэмэртэй байгалийн нөөц, орчин юм. Энэ нь эрдэс баялаг, бэлчээр, ус, газар тариалангийн үржил шимт хөрс, ой мод орон нутагт санхүүгийн болон бусад үр ашгийг бий болгож байдаг нөөцүүд болон нуур, гол горхи зэрэг аялал жуулчлалыг дэмжиж, мөн нийгмийн, соёлын, амралтын үнэ цэнийг агуулдаг хүрээлэн буй орчны бусад

		байгаль орчны өөрчлөлт, бэрхшээлт нөхцөл гэх мэт/ нь капиталд шууд нөлөөлнө мөн бодлого, тогтолцоо, засаглалын үйл явц нь капиталтай байх арга замд шууд бусаар нөлөөлдөг гэж үздэг.	нөөцүүд юм. Уул уурхайн төсөл нь эдгээр капиталд нөлөөлөл үзүүлэх, улмаар орон нутгийн амьжиргаанд нөлөөлөх боломжтой гэж үзэх.
8	Даян дэлхийн гэрээ, НҮБ 2000 (UN Global Compact, UN 2000)	Даян дэлхийн гэрээ санаачилгыг НҮБ-аас санаачлан бизнесийн байгууллагуудыг үйл ажиллагаагаа явуулахад тогтвортой хөгжлийн дагуу нийгмийн хариуцлагатай байхад нь туслах зорилгоор хийгдэж анх 1999 оны Дэлхийн эдийн засгийн чуулганаар анх олон нийтэд танилцуулагдаж байсан. Өдгөө эгнээндээ 170 улсын 13000 компанийг нэгтгэсэн тогтвортой хөгжил, нийгмийн хариуцлагын хамгийн том сүлжээ байгууллага болоод байна.	Нийт Хүний эрх, Хөдөлмөр эрхлэлт, Байгаль орчин, Авилгал гэсэн 4 үндсэн хүрээнд 10 зарчмыг тодорхойлсон. Тэдгээр нь: Зарчим 1. Бизнесийн үйл ажиллагаанд хүний эрхийг хамгаалах олон улсын тунхаглалуудыг хүндэтгэх дэмжих; Зарчим 2. Бизнесийн үйл ажиллагааг хүний эрхийн аливаа зөрчлийн хамтрагч болгохгүй байх; Зарчим 3. Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, хамтын хэлэлцээр байгуулах эрхийг үр ашигтайгаар хүлээн зөвшөөрөх; Зарчим 4. Хүчээр болон албадан хөдөлмөрлүүлэх аливаа хэлбэрийг арилгах; Зарчим 5. Хүүхдийн хөдөлмөрийг арилгах; Зарчим 6. Ажил эрхлэх, албан тушаал хашихад ялгаварлан гадуурхах байдлыг арилгах; Зарчим 7. Бизнесийн үйл ажиллагаанд байгаль орчны аливаа өөрчлөлт доройтлоос урьдчилан сэргийлэх; Зарчим 8. Бизнесийн үйл ажиллагаанд байгаль орчны хариуцлагыг өндөржүүлэх; Зарчим 9. Байгаль орчинд ээлтэй технологийг хөгжүүлэх нэвтрүүлэх; Зарчим 10. Авилгал, хээл хахуулийн бүхэл хэлбэрийн эсрэг тууштай үйл ажиллагаа явуулах.
9	Даян дэлхийн тайлагналтын санаачилга, БО хариуцлагатай санаачлага, Tellus, НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр 2014 (GRI Global Reporting Initiative, Ceres (formerly the Coalition for Environmentally Responsible Economies) and	Даян дэлхийн тайлагналтын санаачилга нь анх 1999 онд тогтвортой хөгжлийн тайлангийн гарын авлага хэлбэртэйгээр гарч байсан өдгөө Нидерланд улсын Амстердам хотод ОУ-ын хараат бус стандартчиллын байгууллага болон өргөжиж 2015 оны байдлаар 7500 гаруй байгууллага энэхүү тайлагналын системийг хэрэглэдэг байна. Олон улсын тайлагналын санаачлага гэдэг нь АНУ-ын ашгийн бус байгууллага бөгөөд санхүүжүүлэгч, хэрэглэгчдийн шаардлагаар байгаль орчин, нийгэм, эдийн засгийн үйл ажиллагаагаа илүү нээлттэй болгох зорилгоор тогтвортой байдлын тайлан гаргах санаачлагыг тус байгууллага өрнүүлсэн. Тогтвортой байдлын тайлан нь дэлхийн хамгийн олон оронд түгээмэл	6 үндсэн компанийн асуудлыг онцолж үзэж байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Компанийн засаглал - Санхүүгийн тайлагнал - Хууль тогтоомжийн хянан нийцэл - Эрсдэлийн менежмент - Тайлан, тайлагнал - Дотоод хяналт Дээрх 6 асуудлын хүрээнд байгаль орчин, нийгэм, эдийн засагт нөлөөлөх нөлөөллийн үнэлгээг компани хийсэн, үнэлгээний дагуу удирдлага ба ажилтны хоорондын тайлагнах, тайлан гаргах, хөндлөнгийн шаардлага буюу санхүүжүүлэгчийн гэрээний шаардлага хангах процессын бүртгэл хөтөлөлт, ил тод байдал, талуудын оролцоо, гомдол шийдвэрлэлтийн сувагаар хүлээн авсан гомдол хүлээн авах,

	<p><i>Tellus Institute, with the support of the United Nations Environment Programme (UNEP) 2014)</i></p>	<p>ашиглагдаж, компаниуд тайлангаа гаргадаг формат болсон бөгөөд тайлангийн стандартыг Олон улсын тайлагналын санаачлага буюу GRI гэх болжээ. GRI стандартыг АНУ-ын хөдөлмөрийн стандартад суурилж боловсруулсан ба улмаар ЭЗХАХБ-ын зааварчилгаа, НҮБ-ын зарчмуудыг нөхөн оруулсан байна.</p>	<p>шийдвэрлэх шат, сургалт хөгжлийн асуудал, компанийн сайн засаглал, туршлага нэвтрүүлэлт, техник, технологийн шийдэл зэрэг тайлан багтахар байна.</p>
10	<p>Эквадорын зарчим, 94 санхүүгийн байгууллагууд 2003</p> <p><i>(The Equator Principles, 94 financial institutions 2003)</i></p>	<p>2003 онд ОУСК Эквадорын зарчмын бодлогын хүрээг тодорхойлсон ба 34 орны олон улсын 94 санхүүгийн байгууллагууд уг зарчмыг томоохон төсөл хөтөлбөрийн эрсдэлийн удирдлагын хамрах хүрээг тодорхойлох зорилгоор баталжээ. Стандартыг тогтмол шинэчлж байдаг ба нэг хувилбар нь ОУСК-ийн Байгаль орчин, Нийгмийн тогтвортой байдлын гүйцэтгэлийн стандарт болсон бол өөр нэг хувилбар нь Дэлхийн банкны Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдлын гарын авлага болжээ.</p> <p>Тэдгээр зарчмуудыг санхүүгийн байгууллагуудад ёс зүйтэй, нийгмийн хариуцлагатай хөрөнгө оруулалт хийлгэх зорилгоор баталжээ. Улмаар уг стандартыг баталсан санхүүгийн байгууллагууд санхүүжилт олгохдоо Эквадорын зарчмын хэрэгжилтийг хангахыг компаниудаас хүсдэг байна.</p>	<p>Зарчим 1: Төслийн үнэлгээ ба ангилал Зарчим 2: Байгаль орчин ба нийгмийн үнэлгээ Зарчим 3: Байгаль орчин ба нийгмийн стандартын хэрэгжилт Зарчим 4: Байгаль орчин ба нийгмийн менежментийн систем ба Эквадорын зарчмыг хэрэгжүүлэх төлөвлөгөө Зарчим 5: Оролцогч талуудын оролцоо Зарчим 6: Гомдол шийдвэрлэх механизм Зарчим 7: Хараат бус үнэлгээ Зарчим 8: Заавал биелүүлэх үүрэг Зарчим 9: Хөндлөнгийн хяналт ба тайлан Зарчим 10: Тайлагнал ба ил тод байдал</p> <p>Компаниудаас холбогдох байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг дараах байдлаар хангалттай гэж үзэх хэмжээнд хийж баримтжуулсан байхыг шаардана⁷³ гэвч үүгээр хязгаарлагдахгүй.</p> <ol style="list-style-type: none"> 1. Байгаль орчин болон нийгмийн нөхцөл байдлын урьдчилсан үнэлгээг боловсруулсан байх, 2. Байгаль орчин болон нийгмийн нөхцөл байдлын боломжит хувилбарыг тодорхойлсон байх, 3. Тухайн улсын хууль тогтоомжоор 2015 оны Парисын цаг уурын өөрчлөлтийн хэлэлцээрийг баталсан байх, 4. Био төрөл зүйлийг хамгаалах болон хадгалах зохицуулалтыг бий болгосон байх (ховордсон ан амьтан, ургамал, экосистем, үндсэн болон эмзэг бүлгийн иргэдийн эрх ашгийг хамгаалсан байх), 5. Тогтвортой хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх, сэргээгдэх байгалийн баялгийг ашиглах бодлого хэрэгжүүлэх (байгалийн баялгийг зөв зохистой ашиглах, хөндлөнгийн баталгаажуулалт хийлгэх), 6. Хортой болон аюултай бодис хэрэглэх, ашиглахад баримтлах бодлоготой байх, 7. Томоохон эрсдэлүүдийн үнэлгээ хийх, эрсдэлийг удирдах хангалттай бодлого, зохицуулалт бүрдүүлсэн байх,

⁷³ Exhibit II: Illustrative List of Potential Environmental and Social Issues to be Addressed

			<ol style="list-style-type: none"> 8. Үр өгөөжтэй үйлдвэрлэл явуулах: эрчим хүчний хэрэглээг хянах, хэрчим хүч, хэрэглээ бий болгох нөхцөлийг баримтжуулах, 9. Бохирдол болон хог хаягдлыг бууруулахад авсан арга хэмжээний бодлого, баримт нотолгоо, бохирдлын хяналт тогтмолжуулсан байх (шингэн хог хаягдал болон агаарын бохирдол), хог хаягдлын удирдлага хэрэгжүүлдэг байх, 10. Хүлэмжийн хийн бохирдолын түвшин, бохирдлын нягтралыг тооцоолдог байх, 11. Цэвэр ус, ус ашиглалт, нөөцийн бодлого хэрэгжүүлэх, 12. Газар ашиглахад баримтлах бодлого, нүүлгэн шилжүүлэлттэй холбоотой эрдэл тооцоолсон, нөхөн олговрыг тооцоолох аргачлалыг хэлэлцэж баталсан байх, 13. Цаг агаарын өөрчлөлттэй холбоотой эрдэлийг тооцоолсон, дасан зохицох бодлого, хэрэгжилтийг хангасан, мөн төслийн үйл ажиллагаа цаг агаарын аливаа өөрчлөлтөд хэрхэн явагдах менежментийн бодлоготой байх.
11	<p>ОУСК-ийн Байгаль орчин, Нийгмийн тогтвортой байдлын гүйцэтгэлийн стандарт, ОУСК 2012</p> <p><i>(Performance Standards on Environmental and Social Sustainability, IFC 2012)</i></p>	<p>ОУСК-ийн Байгаль орчин, Нийгмийн тогтвортой байдлын гүйцэтгэлийн стандарт нь ОУВС-ын эрсдэлийн менежментийг хэрэгжүүлэх арга замын нэг бөгөөд энэхүү баримт бичиг нь байгаль орчин болон нийгмийн тогтвортой байдалтай холбоотой ОУВС-ын амлалт, үүрэг хариуцлагыг илэрхийлдэг. Уг стандарт нь олон улсын түвшинд уул уурхайн салбарт жишиг болон хүлээн зөвшөөрөгдөх болсон. Уг байгууллага нь дэргэдээ бие даасан Гомдол маргаан шийдвэрлэх Омбудсманн байгууллагатай бөгөөд тус байгууллагын санхүүгийн оролцоотой төслүүдийн талаарх иргэд, олон нийтийн гомдол хүлээн авч, шийдвэрлэдэг. ОУСК-ийн Байгаль орчин, Эрүүл мэнд, Аюулгүй байдлын зааварчилгаа нь уг стандартын техникийн зөвлөмж юм.</p> <p>ОУСК-аас хөнгөлөлттэй болон бусад зээл, тусламжаар санхүүжилт хүлээн авах, ОУСК-ийн санхүүжилтээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхэд тухайн улс орон, байгууллагад Стандартын хэрэгжилтийг хангахыг шаарддаг байна.</p>	<p>Уг үнэлгээнд төслийн нийгэмд учруулах гол эрсдэл, нөлөөллийн дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Эдийн засгийн нөлөөлөл - Хүн ам ба шилжих хөдөлгөөн - Ажил эрхлэлт - Газар ашиглалт ба нүүлгэн шилжүүлэлт - Соёлын өв - Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдал - Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ <p>Үндсэн зарчмуудыг задалвал:</p> <ul style="list-style-type: none"> • Байгаль орчин, нийгмийн үнэлгээ ба менежментийн систем: хөрөнгө оруулагч болон харилцагч нь өөрсдийн байгаль орчны болон нийгмийн үйл ажиллагааг зөв зохистой зохицуулж, бизнесийн үйл ажиллагааны зарим чухал шийдвэрт санхүүжүүлэгч, үйлчлүүлэгч, харилцагч, ажилчид, орон нутгийн иргэд зэрэг бизнесийн үйл ажиллагаанд ямар нэгэн нөлөөлөлд өртөх магадлалтай бүхий л оролцогч талуудын оролцоог хангах шаардлагатай. Үүнийг менежментийн зохистой бүтэц, бүрэлдэхүүн, үйл ажиллагааны чиглэлд тохирсон тогтолцоог бүрдүүлж шийдвэрлэх бөгөөд ингэснээрээ байгууллагын зардал, үр дүнд эерэгээр нөлөөлнө гэж үздэг байна. • Хөдөлмөр эрхлэлт ба ажлын байрны нөхцөл: Энэ хэсэгт стандартын дагуу байгууллагын ажилтнуудыг үнэтэй хүний нөөц гэж үздэг ба удирдлага-хүний нөөцийн зохистой харилцааг бий болгох нь

			<p>амжилтын гол үндэс гэж үзэж байна. Ажилтнуудын үндсэн эрхийг хамгаалж, шударга цалинжуулах, урамшуулах, эрүүл, аюулгүй орчинд ажиллуулах, талууд тэдний бүтээмж бий болгох процессыг үр өгөөжтэй болгож ажилтнуудын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.</p> <ul style="list-style-type: none"> • Бохирдлоос сэргийлэх ба бохирдлыг саармагжуулах: Хотжилт, дэд бүтэц бий болгох, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, аж үйлдвэржилт нь байгаль орчин, агаар, ус, газрын бохирдлыг нэмэгдүүлж орон нутгийн иргэдэд хор хүргэх эрсдэлтэй гэж үзэх тул бизнесийн үйл ажиллагаанд оролцогч бүх тал нь бохирдлыг бууруулах, хяналтын технологи болон туршлагыг нэвтрүүлэх үүрэг хүлээнэ. Тэдгээрийг өөрийн санхүүгийн боломжит байдалд үндэслэн, аль болох зардал хэмжэх байдлаар шийдвэрлэсэн байхыг шаардана. • Орчны эрүүл мэнд, аюулгүй байдал ба аюулгүйн баталгаа: Бизнесийн байгууллага нь тоног төхөөрөмжийн зүй бус ажиллагаа, хүний нөөцийн хайхрамжгүй байдал, хортой бодис алдах улмаар иргэд, байгалийн баялагт хохирол учрах, өвчин үүсэх, халдвар тархах эрсдэл байх магадлалтай гэж тооцоолж, аюулгүй байдал, аюулгүй ажиллагаа хариуцсан албан тушаалтныг заавал томилсон, төлөвлөгөө, эрсдэлийн үнэлгээг тогтмол хийдэг байх шаардлагатай гэж үздэг. Түүнчлэн оролцогч бүх талыг аюулгүй ажиллагааг хангаж ажиллахыг шаардана. • Газрын эрх олж авах, сайн дурын бус нүүлгэх шилжүүлэлт: төсөл хэрэгжүүлэх газар эзэмших, ашиглах эрхийг олж авах нь зарим иргэд, бүлэг хүмүүсийг нүүлгэн шилжүүлэх улмаар уламжлалт аргаар олдог өрхийн орлогод сөргөөр нөлөөлөх магадлалыг тооцоолох шаардлагатай гэж үзэж байна. Сайн дурын бус нүүлгэн шилжүүлэлт гэдэгт тухайн газар нутагт амьдрах иргэд татгалзах эрхгүйгээр шилжих нөхцөл байдлыг ойлгодог. Энэ нь тухайн иргэдийн амьжиргаа, орлого, байгаль орчинд сөргөөр нөлөөлж, нийгмийн бухимдлыг үүсгэдэг. Тиймд ийм төрлийн сайн дурын бус нүүлгэн шилжүүлэлт хийхээс аль болох зайлсхийх, хэрэв нөхцөл байдал үүсвэл шударга бөгөөд амьжиргаа ба нөхцөл байдалд нь дүйцэхүйц нөхөн олговор олгохыг зохицуулсан байхыг шаарддаг. • Био төрөл зүйлийг хамгаалах ба байгалийн баялгийг тогтвортой хөгжлийн зарчимд нийцүүлэн ашиглах: Био төрөл зүйлийг хамгаалах болон хадгалах зохицуулалтыг бий болгосон байх (ховордсон ан амьтан, ургамал, экосистем, үндсэн болон эмзэг бүлгийн иргэдийн эрх ашгийг хамгаалсан байх).
--	--	--	--

			<ul style="list-style-type: none"> • Нутгийн уугуул иргэд: Нутгийн уугуул иргэд нь бусад нутгийн уугуул иргэдээс өөр эрх, ашиг сонирхол, уламжлал, түүх, соёлтой учраас тухайн нутгийн уугуул иргэдийн хэрэгцээг зөв тодорхойлох шаардлагатай. Ихэвчлэн тэдний эрх зөрчигдсөн, нийгэмд төлөөлөл сул, зарим тохиолдолд өрхийн амьжиргаа, эдийн засгийн боломж тааруу байх нь түгээмэл. Тиймд тэдний ёс заншил, хэрэгцээ, үнэт зүйл, соёл уламжлалыг хүндэтгэн, байгалийн баялгаас ашиглаж амьдрах амьжиргаа, амьдралын нөхцөлийг үргэлжлүүлэх байдлаар төлөвлөлтийг хийх шаардлагатай. • Соёлын өв: Түүх, археологи, соёл, урлаг, шашины үнэт зүйл, онцлогт зүйл, байгалийн дахин давтагдашгүй төрх, байдал, олдвор, соёлын бүтээл болон орон нутгийн иргэдийн амьдралд хийж, урлаж хэвшсэн бүтээл зэрэгт хүндэтгэлтэй хандаж, эвдэж гэмтээх зэргээр бизнесийн үйл ажиллагааны явцад хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх бүхий л арга хэмжээг авсан байна.
12	<p>Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний зааварчилгаа, Европын Сэргээн босголт, хөгжлийн банк (ЕСБХБ) 1998</p> <p><i>(Guidance on ESIA, EBRD 1998)</i></p>	<p>ЕСБХБ -аас хөнгөлөлттэй болон бусад зээл, тусламжаар санхүүжилт хүлээн авах, ЕСБХБ -ны санхүүжилтээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхэд тухайн улс орон, байгууллагад уг зааварчилгааг хэрэгжүүлэхийг санал болгодог боловч хэрэв хэрэгжүүлээгүй нөхцөлд санхүүжилт олгохоос татгалздаг байна.</p>	<p>Үндсэн зарчмуудыг задалвал:</p> <p>Агаар, дуу чимээ, гадаргын болон гүний цэвэр усны нөөц, хөрс, тариалан, бэлчээр, модлог ба бутлаг ургамал, цэцэгт ургамалын төрөл зүйл ба ариутгал, хог хаягдлын асуудлыг чухалчилж үйл ажиллагааны дэлгэрэнгүй нөлөөллийн үнэлгээ хийхийг зааварчилсан байна. ЕСБХБ-ны удирдамжаар техникийн бус дүгнэлт гаргах ба тус дүгнэлтэд дараах асуудлыг тусгасан байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Санал болгож буй төслийн дэлгэрэнгүй танилцуулга, тайлбар, • Тухайн төслийг хэрэгжүүлэх болсон үндэслэл, шалтгаан, зорилго, • Тухайн төсөл хэрэгжих газар зүйн байршил болон нөлөөлөх газар зүйн бүс нутаг, • Үйл ажиллагаа явуулахад нөлөөлж болзошгүй газар зүйн бүсийн одоогийн нөхцөл байдлын тодорхойлолт, дүгнэлт, • Үзүүлж болох аливаа ноцтой байгаль орчны болон нийгмийн нөлөөлөл, • Үүсэж болох аливаа томоохон асуудал эсхүл боломж, • Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны хөтөлбөрийн үндсэн нөхцөлүүд, • Хуримтлагдах нөлөөлөл, эрсдэл • Байгаль орчин ба нийгмийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх системтэй төлөвлөгөө_ хандлага, үйл ажиллагааны талаарх тайлбар болон • Төслийн үйл ажиллагааны хяналт мониторинг

			<p>Мөн холбогдох асуудал хэсэгт тухайн бүс нутгийн дараах асуудлыг тусгасан байх ба тэдгээр нь нөлөөллийн үнэлгээ хийх, техникийн бус дүгнэлт гаргахад ашиглагддаг байна:</p> <ul style="list-style-type: none"> • Цаг уурын нөхцөл байдал, • Цаг уурын өөрчлөлтөд өртөмтгий байдал, магадлалт цэвэр усны нөөцийн түвшинд орох өөрчлөлт, • Геоморфологи ба геологийн хэв шинж • Гүний ба гадаргын усны нөөц, • Биологийн болон экологийн нөөц, • Үндсэн цэцэгт болон модот ургамал, • Дархан цаазтай, хамгаалалтад болон ховордсон амьтны төрөл зүйл, • Хамгаалалтад байх нутгийн оршин суугчид, уугуул иргэд, • Газрын байршил, харагдах байдал, хөрсний шинжилгээ, • Агаарын чанар ба өнөөгийн бохирдлын ачаалал, • Дуу чимээ ба чичирхийлэл, • Нийгэм, эдийн засгийн асуудлууд • Хүн ам зүй (хүн амын тоо, тархалт, хандлага, нас ба хүйсийн ангилал, шилжин суурьшилт), • Нийгмийн бүтэц (үндэстэн, ястан, овог, аймаг, тэдгээрийн бүтэц, цөөнхийн бүлэг, түүнчлэн нутагт уугуул бөгөөд эрсдэлт иргэдийн талаарх мэдээлэл) • Эрх мэдлийн харилцаа ба засаглалын асуудлууд • Зөрчил ба нийгмийн үл ойлголцол, үүсэх үндэслэл, түүх, таамаг, • Газар эзэмших, ашиглах эрх ба хугацаа, • Эдийн засгийн үйл ажиллагаа (албан ба албан бус эдийн засаг) • Боловсрол • Хүн амын эрүүл мэндийн үзүүлэлт, холбогдох мэдээллүүд, • Жендэрийн асуудал, • Эмзэг бүлгийн асуудал, • Соёлын өв, • Иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, хамгаалалт, • Хөдөлмөр эрхлэлтийн асуудал ба хөдөлмөрийн нөхцөл байдал
13	ISO 26000 - Нийгмийн хариуцлагын стандарт, ОУСБ 2010	Дэлхийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах зорилгоор батлагдсан уг удирдамжийг Монгол Улс 2012 онд уг стандартыг баталсан боловч энэ нь сайн дурын стандарт бөгөөд практик дээр хэрэгжилтгүй байна. Нийгмийн хариуцлагын энэхүү сайн дурын удирдамж нь 2010 онд тогтвортой хөгжилд хувь нэмрээ бүх	<p>Уг удирдамжаар 7 үндсэн зарчмыг тодорхойлсон байна.</p> <ul style="list-style-type: none"> • Хариуцлага • Ил тод байдлыг хангах • Ёс зүйтэй байх • Оролцогч талуудын ашиг, сонирхлыг хүндэтгэх (бие хүн эсхүл групп зэрэг байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлж чадах, нөлөөлж болох хэсэг)

	(Corporate social responsibility standard, ISO 2010)	<p>талууд жигд оруулахад чиглэсэн цогц үйл ажиллагаа юм. Энэхүү удирдамж нь бүх салбарыг хамруулсан байдаг тул уул уурхай үйл ажиллагааны хамгийн эмзэг хэсэг болох олон нийтийн оролцоо, байгаль орчин тэр дундаа усны асуудлыг дэлгэрэнгүй тусгаагүй байна. Бүх салбарт хэрэгжүүлж болох суурь шаардлагуудыг багтаасан, бизнесийн байгууллагуудын нийгмийн хариуцлагыг чанаржуулах зорилгоор батлагдсан бөгөөд байгууллагын засаглал, үндсэн эрхийг чухалчилсан зааварчилгаа, удирдамж юм. Үндсэн зарчмын хүрээнд засаглалыг зөв зохистой бий болгосноор менежментээр дамжуулж үйл ажиллагааны эрсдэлийг бууруулж, байгууллагын зардлыг хэмнэх нь зүйтэй гэсэн концепцитай.</p>	<ul style="list-style-type: none"> • Хууль дээдлэх • Олон улсын норм, хэм хэмжээг дээдлэх • Хүний эрхийг дээдлэх <p>Дээрх 7 зарчимд дараах асуудлыг тусгаж өгдөг байна.</p> <ul style="list-style-type: none"> • Байгууллагын засаглал • Хүний эрх • Хөдөлмөрлөх орчин • Байгаль орчин • Шударга үйл ажиллагаа • Хэрэглэгчдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах • Орон нутгийн иргэдийн оролцоо ба хөгжил <p>Стандартаар тодорхойлолт хэсгийг дэлгэрэнгүй, тодорхой гаргаж тодорхойлолтын дагуу оролцогч талтай хэрхэн харилцах болон сэдэв тус бүр дээр асуудлыг хэрхэн задлах, тооцоолох асуудлыг тусгажээ.</p>
14	<p>Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын стандарт 2019, ОУИТБС</p> <p><i>(Extractive Industries Transparency Initiatives Standards 2019 (EITI))</i></p>	<p>Олборлох салбарын засаглалыг сайжруулах, төр болон хувийн хэвшлийг хариуцлагажуулах, улмаар уг салбарын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх ач холбогдолтой, өдгөө дэлхийн 52 улс орныг эгнээндээ элсүүлсэн ОУИТБС-д 2007 онд нэгдэн орсон. 2013 онд Нээлттэй засаглалын түншлэл (НЗТ)-д нэгдэж, төрийн үйл ажиллагааг ухаалаг, нээлттэй, ил тод болгох, төрийн нэгдсэн мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх, олон улсын жишигт нийцүүлэх алхамуудыг хэрэгжүүлж байна. Ялангуяа ОУИТБС нь салбарын оролцогч талуудын хариуцлагыг нэмэгдүүлэх, тэдгээрийн харилцааг тогтолцооны хувьд тэнцвэржүүлэн сайжруулах, олон улсын болон дотоодын хамтын ажиллагааг сайжруулах хамгийн үр дүнтэй стандарт болж байна. Хамгийн гол нь баялаг ихтэй улс орны иргэд ОУИТБС-ын хүрээнд ил болсон мэдээллийг ашиглан төр засаг болон компаниудаас хариуцлага нэхэж, улмаар үүсэж буй хүндрэл бэрхшээлийг бодитой мэдээлэлд тулгуурлан шийдэх төрийн бодлогод нөлөөлөх боломж жилээс жилд нэмэгдэж байгаа юм. Түүнчлэн тус салбарт үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит компаниудын талаар дэлгэрэнгүй</p>	<p>Олон талт оролцогчдын бүлэг бий болгох, гэрээ байгуулах, лиценз олгох зэрэг эрх зүйн болон институцын хамрах хүрээг тодорхойлох, хайгуул ба бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг тооцох, олборлох салбарын орлого ба орлогын хуваарилалтыг тооцох, нийгэм, эдийн засгийн зарцуулалтыг тодорхойлох, үр дүн ба үр нөлөөллийг тодорхойлох зорилгоор 13 төрлийн мэдээллийг төр, аж ахуйн нэгжээс зэрэг авч, мэдээллийг нэгтгэн хянах, зөрүүг тодруулах, олон нийтэд нээлттэй мэдээллийн бааз бүрдүүлэх мөн хамгийн гол нь гурван талын зөвшилцөлийг бүрдүүлэх зорилготой.</p> <p>Энэ стандартын дагуу олборлох салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудын эзэмшиж буй тусгай зөвшөөрлүүд, тэдгээртэй байгуулсан гэрээ хэлцэл, компаниудын эцсийн өмчлөгч, төлж буй татвар төлбөрүүд, бүтээгдэхүүний борлуулалт зэрэг олон төрлийн мэдээллийг тухай бүрд нь нийтлэн олон нийтэд мэдээлж байх шаардлагыг хангах юм. Мөн НЗТ-ийн Үндэсний төлөвлөгөөнд олборлох салбарт гэрээ ба ашиг хүртэгч эцсийн өмчлөгчдийн мэдээллийн ил тод байдлыг хангах асуудлыг тусган хэрэгжүүлэхээр олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө үүрэг амлалт аваад байна.</p>

		мэдээллийг олон нийтэд хүргэх замаар өрсөлдөөний талбарыг тодорхой болгох шаардлагатай гэж үздэг. Салбарын томоохон компаниуд болон хариуцлагатай хөрөнгө оруулагчид энэ санаачилгыг хэрэгжүүлж буй улс орныг ажиллах таатай нөхцөлтэй гэж үзэх явдал нэмэгдэж байна.	
15	Хариуцлагатай уул уурхайн баталгаажилтын стандарт, Хариуцлагатай уул уурхайн баталгаажилтын санаачлага 2016 (Standart for Responsible Mining IRMA-SDT-001 Draft v2.0, IRMA 2016)	Хариуцлагатай уул уурхайн баталгаажилтын санаачилга олон улсын байгууллага IRMA нь 2014 онд Хариуцлагатай уул уурхайн баталгаажилтын стандартыг /IRMA Standard for Responsible Mining IRMA STD-001 Draft v2.0/ санаачлан боловсруулж үйлдвэрчний эвлэл, уул уурхайн компани, мэргэжлийн судлаач, иргэний нийгмийн байгууллага, нөлөөнд өртсөн орон нутгийн иргэдээс санал авч сайжруулах үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд энэхүү стандарт нь уул уурхай эрхлэгчдийн хувьд хүний эрх, байгаль орчны тогтвортой байдалд суурилсан үйлдвэрлэл явуулж буйн баталгаа болох төдийгүй тэр чиглэлд хөтлөх удирдамж нь болгохыг зорилгоо болгожээ. Төслийн хамрах хүрээг тодорхолох, мэдээлэл цуглуулах, сонгосон аргачлалаар дүн шинжилгээ, үнэлгээ хийх, тайлан боловсруулах, Байгаль орчин, нийгмийн менежментийн системийг дотоод бүтэцдээ бий болгох, Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг хянах, дахин үнэлэх, оролцогч талуудын оролцоог Байгаль орчин, нийгмийн нөлөөллийг хянах, удирдахад хангах, Байгаль орчин, нийгмийн мэдээллийн ил тод байдлыг хангах, тайлагнах гэсэн процессын дагуу ажиллахаар заажээ.	Үндсэн 4 хүрээтэй. Энэ нь Нийгмийн хариуцлагын ISO 26000 стандартыг бүхэлд нь 1 хэсэг болгон авч үлдсэн 3 хэсэгт уул уурхайн салбарын чухал асуудлыг оруулж нөхөж өгснөөрөө онцлог, илүү ахисан түвшинд авчирсан. <ul style="list-style-type: none"> - Бизнесийн нэр хүнд - Төлөвлөлт - Нийгмийн хариуцлага - Байгаль орчны хариуцлага Уг стандартыг хэрэгжүүлэх нь Авсрали, Канад зэрэг зарим улсад санхүүжилт босгоход тавигддаг шалгуурын нэг байсан бол АНУ, Африкийн улс орнууд уг стандартыг ашиглах болсон нь мөн санхүүжилт босгохтой холбоотой байна. Нийгмийн хариуцлагын хүрээнд байгууллага нь дараах нөхцөлийг хангасан байх шаардлагыг тавьдаг. Үүнд: <ul style="list-style-type: none"> • Шударга хөдөлмөрлөлт ба хөдөлмөрийн шударга нөхцөл • Ажлын байрны эрүүл ахуйн ба аюулгүй байдал • Орон нутгийн эрүүл мэнд ба аюулгүй байдал • Уул уурхайн болон зөрчилд өртөх эсхүл эрсдэл өндөртэй бүс нутаг • Аюулгүй ажиллагааны зохион байгуулалт • Гар аргаар уул уурхай эрхлэх ба жижиг уурхай • Соёлын өв Эдгээрийг төлөвлөлттэй уялдуулан, Байгаль орчин ба нийгмийн нөлөөллийн үнэлгээ ба менежмент хийх, Нээлттэй, урьдчилан мэдэгдсэн иргэдийн зөвшөөрөл авах ажиллагаа, Олон нийтийн дэмжлэгийг авах ба үр өгөөжийг нийтэд хүргэх бодлого, Нүүлгэн шилжүүлэлт, Яаралтай үеийн бэлэн байдал ба хариу үйлдэл, Хаалтын төлөвлөлт ба санхүүжилтын бодлогоороо дамжуулж хэрэгжүүлж байна. Үндсэн шаардлага нь: <ul style="list-style-type: none"> - Төсөлтэй холбоотой аливаа үйл ажиллагаа эхлэхээс өмнө, төслийн загварыг боловсруулсаны дараа Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг гүйцэтгэхсэн байх,

			<ul style="list-style-type: none"> - Эрсдэлийн түвшинг нэг бүрчлэн задалж үнэлсэн байх, гарах нөлөөллийн хэмжээ зардлын хамт тооцоолох, - Аливаа өөрчлөлт төлөвлөгөөнд, зураг төсөлд, загварт орсон даруйд нөлөөллийн үнэлгээг дахин гүйцэтгэх, - Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг олон нийтэд ил тод аргачлалаар, баримтжуулах боловсруулах шаардлага тавьж байна.
16	<p>Хариуцлагатай уул уурхайн индекс, Хариуцлагатай уул уурхайн нийгэмлэг 2020</p> <p><i>(Responsible Mining Index Methodology, Responsible Mining Foundation 2020)</i></p>	<p>ХУУИ-ийг Нидерланд улсын Амстердам хотод байрлах Хариуцлагатай уул уурхайн сан 2017 онд боловсруулж 2018 онд баталсан бол олон нийтийн хэлэлцүүлэгт тавьж шинэчилж, улмаар 2020 онд сүүлийн хувилбар нь батлагдаж хэвлэгджээ. Уг сан нь Засгийн газар, иргэний нийгмийн байгууллага болон ижил төстэй зорилготой сайн үйлсийн сангуудаас санхүүждэг. Уул уурхайн компаниудаас санхүүжилт авдаггүй байхаар ажиллах зарчмаа тодорхойлсон байна. Эрдэс баялаг, металлын салбарт үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниудыг эдийн засаг, байгаль орчин, нийгэм болон засаглалын үзүүлэлтүүдээр эрэмбэлж, эрдэс баялаг, металлын салбарын шилдэг, сайн туршлагыг илрүүлж олон нийтэд таниулах замаар энэ салбарыг илүү их хариуцлагатай хөгжүүлэх зорилготой.</p>	<p>НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх үндсэн чиглэлтэй байна.</p> <ol style="list-style-type: none"> 1. Уурхайн мэдээллийн ил тод байдлыг хангах 2. Үйл ажиллагааны нээлттэй мэдээллийн зарчмыг хэрэгжүүлэх 3. Компанийн үйл ажиллагаанд санал авах <p>Нийт 6 чиглэлтэй: Эдийн засгийн хөгжил, Бизнесийн үйл ажиллагаа, Тасралтгүй эргэх менежмент, Олон нийтийн сайн сайхан, Хөдөлмөрлөх нөхцөл, Байгаль орчны хариуцлага. Уг стандартын дагуу Компанийн хүсэл эрмэлзэл, Үйл ажиллагаа ба Үр дүн гэсэн 3 чиглэлээр хэмжилт хийнэ. Үнэлгээг компанийн баталсан үзүүлэлтээр хэмжихээр байна. Харин уурхайн үнэлгээг тусад хийх ба нийт үзүүлэлтийн үнэлгээг RMI Report буюу Хариуцлагатай уул уурхайн тайланд нийтэлдэг байна. Стандарт нь компанийг өөрийн хариуцлагаа хэрэгжүүлэхэд дээрх 6 чиглэлээр ил тод, хариуцлагатай мөн олон нийтийн олонорцоог хангаж байгаа эсэхээр хэмжигдэхээр байна.</p>
17	<p>10 зарчим, Уул уурхай ба металлын ОУ-ын зөвлөл 1998, 2003, 2020</p> <p><i>(10 principles, ICMM 1998, 2003, 2020)</i></p>	<p>1998 онд уул уурхайн салбарын 9 том компани хамтарч салбарын тулгамдаж буй асуудлыг хамтарч шийдэх зорилготойгоор ОУ-ын уул уурхайн санаачилга (Global Mining Initiative) хөтөлбөрийг санаачилсан бөгөөд хөтөлбөрийн хүрээнд “Уул уурхайн ба металлын тогтвортой хөгжил” төслийг 2 жилийн хугацаанд хэрэгжүүлсэн. Энэ төслийн явцад компаниуд эрсдэлийг бууруулахаар амбицтай амлалтуудыг өгсөн. Үүний дараагаар Уул уурхай ба металлын ОУ-ын зөвлөл⁷⁴ нь 2003 онд байгуулагдсан. Харин 10 зарчмыг Тогтвортой хөгжлийн 17</p>	<p>Үндсэн зарчим нь:</p> <ul style="list-style-type: none"> • Бизнесийн ёс зүйтэй, эрүүл засаглалыг бий болгох • Шийдвэр гаргалтад тогтвортой хөгжлийн зарчмыг суулгах • Хүний эрхийг хүндэтгэх • Эрсдэлийг үр дүнтэй удирдах • Эрүүл ахуй, аюулгүй ажиллагааг чанаржуулах • Байгаль орчинд ээлтэй ажиллах • Биотөрөл зүйл болон газрын төрхийг хамгаалах, газар ашиглах төлөвлөлтийг боловсронгуй болгох • Эрдэс баялгийг хариуцлагатай ашиглах, хангах • Нийгмийн оролцоог хангах • Оролцооны болон ил тод тайлагналтыг хэрэгжүүлэх

⁷⁴ ОУ-ын International Mining and Metals Council (ICMM)

		зорилтуудыг хэрэгжүүлэх зорилгоор баталсан байдаг.	Мөн уг зарчмаар хэрхэн ил тод, нээлттэй, оролцоог хангаж, тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, зарчмыг хэрэгжүүлэх вэ гэсэн тайлбар оруулсан дотор зайлшгүй шаардлагатай нийгмийн асуудлуудыг тодорхойлж, нийгэм, байгаль орчинд үзүүлэх хортой нөлөөлөл, эрдэлийг бууруулах арга хэмжээ авах зарчмын тодорхойлолтууд тусгагдсан байна.
18	ОУ-ын Нийгмийн хариуцлага 8000, 2008 (<i>Social Accountability International (SAI) 8000, 2008</i>)	ОУ-ын Нийгмийн хариуцлага 8000 нь сайн дурын сертификатжуулалтын стандарт бөгөөд анх АНУ-ын Нийгмийн хариуцлагын ОУ-ын байгууллагаас үйлдвэрчний эвлэл, ТББ-тай хамтарч 2001 онд боловсруулагдаж 2004, 2008 онуудад сайжруулсан байна. Сертификатыг хараат бус, бие даасан баталгаажуулах эрх бүхий Олон улсын Нийгмийн хариуцлага байгууллага нь Нийгмийн хариуцлагын баталгаажуулалтын үйлчилгээ байгууллагын хяналт дор баталгаажуулдаг байна.	АНУ-ын компаниуд, ТББ-ууд уг сертификатын авахын тулд дараах 8 шалгуур үзүүлэлтийг хангасан байх шаардлага тавьдаг байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> • Хүүхдийн хөдөлмөр: хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийг хориглосон байх, бодлого журамдаа хэрэв хүүхэд ажиллаж байгаа нь илэрсэн нөхцөлд авах арга хэмжээг тодорхойлсон байх, тухайн хүүхдийг сурч боловсроход нь зориулсан сан үүсгэсэн байх, • Хүчээр эсхүл албадан хөдөлмөр эрхлэлт: Хүчээр эсхүл албадан хөдөлмөр эрхлэлтийг хориглосон байх, бодлого журамдаа цалингийн суутгал хийх, урьдчилгаа авч үлдэхийг хориглосон, цалин олгох нөхцөлийг тодорхой ил тод болгосон, цалин, хангамж, урамшуулал зэргийг хойшлуулахгүй байх, бичиг баримтыг барьцаалахгүй байх, ажлын цаг дуусгавар болсоноор ажлын байрыг орхин явах нөхцөлийг бүрдүүлсэн, албан тушаалаасаа хэдийд ч чөлөөлөгдөж болох, хүний наймааг дэмжихийг хориглосон байх, • Эрүүл мэнд, аюулгүй байдал: Эрүүл, аюулгүй ажлын байр бүрдүүлэх, ажлын байрны ослоос сэргийлэх арга хэмжээг авсан байх, Эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны ахлах/удирдах ажилтанг томилсон байх, аюулгүй ажиллагааны зааврыг бүх ажилчдад өгөх, эрдэлийг тодорхойлох, үнэлэх, зайлсхийх, удирдах арга хэмжээг тодорхойлсон, ажилчдад мэдүүлсэн байх үүрэгтэй, бүх аюул ослыг бүртгэлжүүлэх, ажлын осол гарсан нөхцөлд хувийн хамгаалалтын тоног төхөөрөмж, эмнэлэгийн багаж бэлэн байлгах, шинээр ээж болсон эсхүл жирэмсэн хүний эрсдэлийг бууруулсан байх, бүртгэлжүүлэх, цэвэр бие засах газар, зөөврийн цэвэр усаар хангах, хоол хүнс хадгалах эрүүл, аюулгүй нөхцөлийг бүрдүүлсэн байх, ажилчдын байрлах байр эрүүл ахуйн шаардлага хангасан, аюулгүй, энгийн хэрэгцээг хангасан байх, ажилтнуудад гэнэтийн аюул бий болоход хийж болох үйлдлийг заасан байх, тэдгээрийг тестлэх, бүртгэлжүүлэх. • Нэгдэх эрх ба нийтээрээ зөвшилцөх: Үйлдвэрчний эвлэл байгуулах, нэгдэх эрх, хамтран хамтын зөвшилцөлийг байгууллагын удирдлагатай хийх эрх нээлттэй байх. Нийт ажилчдын үйлдвэрчний эвлэл өөрийн сонголтоор байгуулах, эвлэлдэн нэгдэх эрхийг баталгаажуулсан байна. Компани нь ажилчдын эрхийг хүндэтгэх, зөвшилцөлд хөндлөнгөөс оролцохгүй, эвлэлдэн нэгдсэн,

			<p>зөвшилцөлийн дагуу санал тавьсан ажилтныг ажлаас халахгүй, ялгаварлан гадуурхахгүй. Ажилтнууд өөрсдийн төлөөллийг сонгох эрхтэй байна.</p> <ul style="list-style-type: none"> • Ялгаварлан гадуурхалт: Арьс өнгө, үндэс угсаа, нийгмийн гарал, нийгмийн ангилал, төрөх байдал, шашин шүтлэг, хөгжлийн бэрхшээл, хүйс, нас, бэлгийн чиг хандлага, гишүүнчлэл, улс төрийн үзэл бодлоор ялгаварлахыг хориглоно. Ажилд авах, урамшуулал олгох, цалин өгөх, сургалтанд хамрагдах, албан тушаал дэвших, дуусгавар болох, тэтгэвэрт гарахад ялгаварлахыг хориглоно. Заналхийлэл, айган сүрдүүлэх, хөдөлмөрийг мөлжих, хүчээр хөдөлмөрлүүлэхийг хориглох, жирэмсэний болон онгон байдлын шинжилгээнд хамруулахыг хориглоно. • Захиргааны арга хэмжээ: Бүх ажилчидтай ёс зүйтэй, хүндэтгэлтэй хандах, шийтгэл хүлээлгэх, биеийн болон сэтгэл зүйн дарам шахалт, хүнлэг бус хандлагыг хориглоно. • Ажлын цаг: Хууль тогтоом, стандартын дагуу ажлын цагийг тооцох ба долоо хоногт 48 цагаас хэтрэхгүй, 1 өдрийн амралтыг 6 ажлын өдрийн дараа заавал олгох, илүү цагаар ажиллах нь сайн дурынх байх ба долоо хоногт 12 цагаас хэтрэхгүй, харилцан тохиролцсон байна. • Урамшуулал: Хувь хүний цалин, урамшуулал, бусад олговрыг хуулийн дагуу олгохдоо хүний энгийн хэрэгцээг хангахаар байна. Хасалтыг сахилгын шийтгэл хэлбэрээр хийхийг хориглох, цалин, олговрын хэмжээг урьдчилан мэдэгдсэн, бэлэн мөнгө, чек, данс гэх мэт тохирох байдлаар төлөх, илүү цагийн хөлсийг батлагдсан стандартын дагуу олгох, зөвхөн хөдөлмөрлөх утга бүхий гэрээ эсхүл богино хугацаанд гэрээлэх, хуурамчаар сургагч бэлтгэх гэрээ байгуулахыг хориглоно.
19	<p>Үндэстэн дамнасан корпорациудын удирдамж, Эдийн засгийн хамтын ажиллагаа ба хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ) 1976</p> <p>(<i>OECD Guidelines for Multinational Enterprises 1976</i>)</p>	<p>2011 оны 5-р сард, ЭЗХАХБ-ын гишүүн ба хэрэгжүүлэгч орнуудын засгийн газруудаас шинэчилсэн ЭЗХАХБ-ын Удирдамжийг баталсан. Хэдийгээр хэрэгжүүлэх механизм байхгүй гэх мэт суурь дутагдлууд оршсон хэвээр байгаа ч шинэчлэлээр зохистой ажиллагаа (due diligence), нийлүүлэлтийн гинжин сүлжээний хариуцлага, хүний эрх ба ҮМН-ийн журам зэргийг сайжруулсан. Эдийн засгийн бүх салбар болон дэлхий дахина үйл ажиллагаа явуулж буй ЭЗХАХБ-ын гишүүн ба хэрэгжүүлэгч орнуудын</p>	<ul style="list-style-type: none"> • Мэдүүлэг, мэдээллийн ил тод байдал Компанийн өөрийн үйл ажиллагаанд холбогдох бүтэц, санхүү ба санхүүгийн бус (нийгэм ба байгаль орчин г.м.) үзүүлэлтүүд, өмчлөл болон засаглалын ач холбогдол бүхий мэдээллийг нийтэд нээлттэй байлгана. Компаниуд бизнесийн харилцаа, үйл ажиллагаа, тэдгээрийн нөлөөллийн талаарх мэдээллийг нийтэд нээлттэй байлгана. • Хүний эрх Компаниуд хүний эрхийг үйл ажиллагаандаа болон бодлогын хүрээнд хүндэтгэнэ. Хүний эрхийн эрсдлийн үнэлгээ хийж бодит болон болзошгүй нөлөөллийг шийдвэрлэж, зөрчигдсөн эрхийг сэргээх механизм бурдуулсан байна. • Хөдөлмөр ба үйлдвэрлэлийн харилцаа

		<p>үндэстэн дамнасан компанийн бүх үйл ажиллагаанд хамаарна.</p>	<p>Компаниуд хөдөлмөрийн үндсэн стандартуудыг хүндэтгэж ажиллагсдад зохистой ажлын байр, ба тэдний гэр бүлийн наад захын хэрэгцээг хангах цалин хөлс олгоно.</p> <ul style="list-style-type: none"> • Байгаль орчин Компаниуд байгаль орчин ба нийгмийн эрүүл мэнд, аюулгүй байдлалд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг тогтоох, урьдчилан сэргийлэх ба нөлөөллийг бууруулах үүрэгтэй. Байгаль орчны менежементийн тогтолцоо бий болгох, байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаагаа байнга сайжруулах, түүнчлэн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулна. • Авилга ба авилгал Компаниуд бусдад шууд болон шууд бусаар авилга өгөхгүй мөн авахгүй байх үүрэгтэй. Авилгалыг тогтоох, урьдчилан сэргийлэх ёс зүйн ба нийцлийн хөтөлбөртэй, дотоод хяналтын тогтолцоотой байх үүрэгтэй. Авилгалтай тэмцэхэд чиглүүлж буй хүчин чармайлтын талаар ил тод тунгалаг байна. • Хэрэглэгчийн ашиг сонирхол Компаниуд борлуулалт ба маркетингийн шудрага практик хэрэгжүүлэх: өөрийн бараа үйлчилгээний чанар ба найдвартай байдлыг хангах; өөрийн бараа, үйлчилгээний тухай тодорхой, нотлогдохуйц болон ойлгомжтой мэдээллийг хэрэглэгчид өгч зөв сонголт хийхэд нь дэмжих үүрэгтэй. • Шинжлэх ухаан ба технологи Компаниуд шинэ технологийн ноу-хау шилжүүлэх, оюуны өмчийн эрхийг ашиглуулах болон нутгийн иргэдийг ажиллуулах замаар орон нутгийн болон үндэсний инновацийн чадавхыг хөгжүүлнэ. • Өрсөлдөөн Компаниуд өрсөлдөөнийг зохицуулах хуулийн зохицуулалтанд нийцэж, өрсөлдөөнийг хаах байдлаар авирлахаас татгалзана. • Татвар Компаниуд хууль ба зохицуулалтыг ягштал биелүүлж, цаг тухайд нь татвараа төлж, үйл ажиллагаа явуулж буй орныхоо нийтийн \төрийн\ санхүүгийн салбарт хувь нэмэр оруулна. Мөн татвар төлөх үүргээс зайлсхийх зорилгоор ашиг ба алдагдлыг шийлжүүлэхээс татгалзана.
20	<p>Аюулгүй байдал ба хүний эрхийн сайн дурын зарчим, АНУ, ИВУИНВУ, олборлох салбарын компаниуд ба ИНБ-ууд хамтарсан 2000</p>	<p>АБХЭСДЗ нь зөвхөн олборлох салбарын аюулгүй байдал, хүний эрхийн талаарх удирдамж юм. Энэ нь компанийн аюулгүй байдлын журам үйл явц нь орон нутгийн иргэдийн хүний эрхэд эрсдэл учруулж болзошгүй гэсэн олон улсын түвшний шүүмжлэлийн эсрэг авч буй хариуц арга хэмжээ төдийгүй компанийн</p>	<p>АБХЭСДЗ нь иргэний ба улс төрийн хүний эрхэд голчлон анхаардаг ба үүнд амьд явах эрх, хууль бус баривчилгаа, саатуулахаас ангид байх эрх чөлөө, хэрцгий, хүнлэг бус, гутаан доромжлох үйлдлийг хориглох зэрэг хамаарна. Иймд АБХЭСДЗ нь одоогийн олон улсын стандарт болон шилдэг туршлагаудад үндэслэгдсэн бөгөөд компаниудад дараахь 3 асуудлаар удирдамж өгдөг.</p>

	<p><i>(Voluntary Principles on Security and Human Rights, Voluntary Principles Initiative (VPI), the US and UK, a group of extractive companies and NGOs 2000)</i></p>	<p>барилга байгууламжийг хамгаалахдаа хүний эрхийг хүндэтгэх талаар компаниудад зөвлөмж удирдамж өгдөг. АБХЭСДЗ нь харилцан суралцах, хамтран асуудлаа шийдэх, аюулгүй байдал ба хүний эрхийн тулгамдсан асуудлуудаар шилдэг туршлага нэвтрүүлж бэхжүүлэх талаар олон талт оролцогч талуудын хамтын ажиллагааны механизм юм. Мөн дээрх асуудлыг олон талт бүтэцтэй орчинд хэрэгжүүлэх гол тоглогчид буюу талуудын чадавх бэхжүүлэх орчин нөхцлийг бүрдүүлдэг.</p> <p>АБХЭСДЗ-ыг хэрэгжүүлэгч компаниуд нь төрийн ба хувийн хэвшлийн аюулгүй байдлын хүчний байгууллагуудын гаргасан хүний эрхийн зөрчлийг мэдээлэх, мөрдөн шалгах системүүд хөгжүүлэх шаардлагатай.</p>	<ul style="list-style-type: none"> • Аюулгүй байдалтай холбоотой хүний эрхийн эрсдлийн үнэлгээ хэрхэн хийх, үүнд хүний эрхийн зөрчилд голчлон анхаарна. <ul style="list-style-type: none"> а. Төрийн болон хувийн хэвшлийн аюулгүй байдлын хүчний байгууллагуудын хүний эрхийн талаарх бүртгэл мэдээллийг үзэж нягтлах б. Хууль дээдлэх/сахиулах, хүчний болон шүүх байгууллагуудын хүчин чадлыг үнэлэх в. Зөрчлийн дүн шинжилгээ хийх, үүнд гол шалтгаан, мөн чанарыг шинжлэх г. Тоног төхөөрөмжийн шилжилтийг хянаж шалгах <ul style="list-style-type: none"> • Олон нийтийн аюулгүй байдлын хүчний байгууллагуудтай хэрхэн хамтран ажиллах: <ul style="list-style-type: none"> а. Аюулгүй байдлын боловсон хүчний хүний эрхийн хэрэгжүүлэлтийн талаарх бүртгэл мэдээллийг урьдчилан сэргийлэх зорилгоор шалгаж нягтлах б. Аюулгүй байдлын байгууллагуудад хүний эрхийн сургалт зохион байгуулах в. Аюулгүй байдлын хүчний байгууллагуудтай харилцсан туршлагаудын талаар оролцогч талуудтай зөвлөлдөх <ul style="list-style-type: none"> • Хувийн хэвшлийн аюулгүй байдлын үйлчилгээний албатай харилцах харилцаа <ul style="list-style-type: none"> а. Аюулгүй байдлын гэрээ, контрактад Сайн дурын санаачлагыг хамруулан тусгах б. Хүчний байгууллагын ашиглалт, хүчний байгууллагын үйлчилгээ болон аюул заналхийллийн харьцааны талаар удирдамж зааварчилгаа өгөх в. Хувийн хэвшлийн аюулгүй байдлын үйлчилгээний байгууллагуудын гаргасан гэх зөрчил дарамтыг бүртгэх, мэдээлэх
21	Хариуцлагатай уул уурхайн санаачилгын тунхаг бичиг, Уул уурхайн ассоиаци 2006 он	Монгол Улсад улсад хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх санаачилга 2006 оноос эхлэлтэй бөгөөд Азийн сангийн дэмжлэгтэйгээр төр, төрийн бус, хувийн болон бизнесийн байгууллагууд, судлаачид бүхий оролцогч талууд 2007 онд үйл ажиллагаандаа дагаж мөрдөх Хариуцлагатай уул уурхайн Санаачилгын Тунхаг бичгийг боловсруулан гаргаж, түүнд 80 гаруй байгууллага, иргэдийн	Олон талт уулзалтын нэгдсэн хуралдаанаар ХУУ-н тодорхойлолт, зарчмыг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд: ⁷⁶ Олон талын оролцоог хангах, <ul style="list-style-type: none"> • Ил тод, нээлттэй байх, • Хуулийг сахин дээдлэх, • Байгаль орчин, хүний аюулгүй байдлын өмнө хариуцлага хүлээх, • Ирээдүйн хөгжилд хөрөнгө оруулах, • Үр өгөөжтэй байх, • Хүмүүнлэг ёс зүйтэй байх,

⁷⁶ A framework for cooperative decision – making. Flyer of Asia foundation. 2007.

		<p>төлөөлөл нэгдэн орж гарын үсгээ зурсан.⁷⁵ Хариуцлагатай уул уурхайн тодорхойлолт - Бүх холбогдох талууд, ялангуяа нутгийн иргэдийн эрхийг хүндэтгэсэн, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, олон улсын шилдэг туршлагад тулгуурласан, хууль сахих ёсыг дээдэлсэн, Монгол Улсад байнгын ашиг орлого оруулж байх эрдэс баялгийн салбар дахь ил тод, цогц үйл ажиллагааг “Хариуцлагатай уул уурхай” гэж ойлгоно гээд эрдэс баялгийг хайх, олборлох үйл ажиллагааг хариуцлагатайгаар гүйцэтгэхэд дараах 8 зарчмыг хэрэгжүүлэх шаардлагатай болохыг тохиролцсон байна.</p>	<ul style="list-style-type: none"> • Дэвшилтэт технологид суурилсан байх. <p>2016 онд энэхүү Хариуцлагатай уул уурхайн зарчмыг санаачлагч ТББ нь НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөрийн тусламжтайгаар Хариуцлагатай уул уурхайн гарын авлага болгон гаргасан.</p>
22	<p>Бизнес ба хүний эрхийн зарчим, НҮБ 2005</p> <p><i>(UN Guiding Principles on Business and Human Rights, UN E/CN.4/RES/2005/69 2005)</i></p>	<p>НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс 2017- 2023 онд хэрэгжүүлж байгаа “Ази дахь Бизнес ба Хүний эрх: Бүс нутгийн түншлэлийг хөгжүүлэх замаар Хариуцлагатай бизнесийн үйл ажиллагааг хөхиүлэн дэмжих нь” төслийн хүрээнд Монгол Улсын ГХЯ болон үндэсний төлөвлөгөө боловсруулах Ажлын баг, бизнес төлөөлөл, үйлдвэрчний эвлэл зэрэг төрийн бус байгууллагууд нутгийн хэмжээнд хэрэгжүүлж байгаа дээрх хөтөлбөртэй тодорхой чиглэлээр хамтран ажиллахаар тогтсон. 2019 онд Гадаад харилцааны сайдын тушаалаар бусад холбогдох байгууллагуудыг оролцуулан Ажлын баг байгуулж төлөвлөгөө боловсруулах үйл явцыг албан ёсоор эхлүүлсэн. “НҮБ-ын Бизнес ба хүний эрхийн зарчим”-ын тухай ойлголтыг түгээх, үндэсний төлөвлөгөө боловсруулах үйл явцад төр, төрийн бус байгууллага, бизнесийнхний идэвхтэй оролцоог хангах, бизнесийн үйл ажиллагааны хүний эрхэд үзүүлж байгаа нөлөөллийг бодитой үнэлж, зорилгоо зөв тодорхойлоход ач холбогдол оршиж байна.</p>	<p>Уг зарчим нь 3 хэсгээс бүрдэх ба үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Төрөөс хүний эрхийг хангах үүрэг 2. Аж ахуйн нэгжээс хүний эрхийг хүндэтгэх үүрэг 3. Зөрчигдсөн эрхийг хамгаалах боломж <p>Дээрх 3 бүтэг нь үндсэн зарчим ба Үйл ажиллагааны зарчмаас бүрдэнэ.</p>
23	<p>Уул уурхайн тогтвортой хөгжлийн замын</p>	<p>Дэлхийн эдийн засгийн форум, НҮБХХ, Тогтвортой хөгжлийн шийдлийн сүлжээ, Тогтвортой хөрөнгө оруулалтын Колумбиа төв.</p>	<p>Энэхүү баримт бичиг нь тогтвортой хөгжлийн 17 зорилтыг уул уурхайн салбарын бүхий л үйл ажиллагаанд хэрхэн тусгаж ойлгож, хэрэгжүүлэх боломжтой сайн туршлагыг зөвлөж, санал болгосон уул уурхайн салбарыг</p>

⁷⁵ Davis, Rachel and Daniel M. Franks. 2014. “Cost of Company-Community Conflict in the Extractive Sector.” Corporate Social Responsibility Initiative Report No.66. Cambridge, MA: Harvard Kennedy School. 13 дахь тал.

<p>зураг: Атлас, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр 2016</p> <p><i>(Mapping Mining to the Sustainable Development Goals: An Atlas, UNDP 2016)</i></p>	<p>Даян дэлхийн хөгжлийн зорилт болох Тогтвортой хөгжлийн зорилтыг хангахад уул уурхайн салбар онцлох үүрэг рольтой гэж үзэж 2016 онд Тогтвортой хөрөнгө оруулалтын Колумбын төв, Тогтвортой хөгжлийн шийдэл сүлжээ, НҮБХХ, Дэлхийн эдийн засгийн форум, ОУГХАН хамтран Тогтвортой хөгжлийн зорилтод хүрэх уул уурхайн газрын зураг баримт бичгийг уул уурхайн компаниудын үйл ажиллагаагаа явуулахдаа тогтвортой хөгжлийн зорилт руу чиглэхэд шаардлагатай холбоосыг бий болгох зорилгоор санаачлан боловсруулсан.</p>	<p>хариуцлагатайгаар хөгжүүлэх чухал удирдамж бүхий санаачилга. Бүтцийн хувьд бүх зорилтуудыг уул уурхайн үйл ажиллагаа эрхлэгч компани, засгийн газар, орон нутгийн захиргааны байгууллага, судалгаа шинжилгээний институциуд хэрхэн ойлгож ажил хэрэгтээ тусгаж, хэрэгжүүлэх талаар дэлгэрэнгүй тайлбартай.</p>
---	---	---

Эх сурвалж:

1. Монгол Улсын Үндсэн хууль 1992, <https://www.legalinfo.mn/law/details/367?lawid=367>;
2. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоол, “Алсын хараа” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг 2020 он;
3. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 121 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө 2016-2020;
4. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль 2020, <https://www.legalinfo.mn/law/details/15403?lawid=15403>
5. Ашигт малтмалын тухай хууль 2006, <https://www.legalinfo.mn/law/details/63?lawid=63>;
6. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль 2012, <https://www.legalinfo.mn/law/details/9750?lawid=9750>;
7. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль 2014, <https://www.legalinfo.mn/law/details/97?lawid=97>;
8. Цөмийн энергийн тухай хууль 2009, <https://www.legalinfo.mn/law/details/97?lawid=97>;
9. Газрын тухай хууль 2002, <https://www.legalinfo.mn/law/details/216?lawid=216>;
10. Барилгын тухай хууль 1998, <https://www.legalinfo.mn/law/details/11705?lawid=11705>;
11. Эрчим хүчний тухай хууль 1995, <https://www.legalinfo.mn/law/details/11705?lawid=11705>;
12. Автозамын тухай хууль, 2017, <https://www.legalinfo.mn/law/details/12656?lawid=12656>;
13. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль 2016, <https://www.legalinfo.mn/law/details/11711?lawid=11711>;
14. Газрын тосны тухай хууль 2014, <https://www.legalinfo.mn/law/details/10484?lawid=10484>;
15. Газрын хэвлийн тухай хууль 1988, <https://www.legalinfo.mn/law/details/218?lawid=218>;
16. Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль 2005, <https://www.legalinfo.mn/law/details/214?lawid=214>;
17. Соёлын өвийг хамгаалах тухай хууль 2014, <https://www.legalinfo.mn/law/details/10439?lawid=10439>;
18. Боловсролын тухай хууль 2002, <https://www.legalinfo.mn/law/details/9020?lawid=9020>;
19. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль 2008, <https://www.legalinfo.mn/law/details/564?lawid=564>;
20. Хог хаягдлын тухай хууль 2017, <https://www.legalinfo.mn/law/details/12652?lawid=12652>;
21. Химийн хорт болон аюултай бодисын тухай 2006, <https://www.legalinfo.mn/law/details/526?lawid=526>;
22. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай 2012, <https://www.legalinfo.mn/law/details/8663?lawid=8663>;
23. Байгаль орчныг хамгаалах тухай хууль 1995, <https://www.legalinfo.mn/law/details/8935?lawid=8935>;
24. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль 2016, <https://www.legalinfo.mn/law/details/11711?lawid=11711>;
25. Хууль тогтоомжийн тухай хууль 2015, <https://www.legalinfo.mn/law/details/11119?lawid=11119>;
26. Захиргааны ерөнхий хууль 2015, <https://www.legalinfo.mn/law/details/11259?lawid=11259>;
27. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль 1995, <https://www.legalinfo.mn/law/details/294?lawid=294>
28. УИХ-ын 2003 оны 41 дүгээр тогтоол, Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр, <https://www.legalinfo.mn/annex/details/3225?lawid=6265>;
29. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн тайлан 2018, <https://archive.audit.mn/wp-content/uploads/2017/12/HBTT-report.pdf>;
30. Байгаль орчны стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний журам, Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт, <https://archive.audit.mn/wp-content/uploads/2017/12/HBTT-report.pdf>;
31. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам, Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт, <http://www.mne.mn/wp-content/uploads/2017/07/2014.7.pdf>;

32. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журам, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 01 дугаар сарын 06-ны өдрийн А-03 тоот тушаал;
33. Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн ТЭЗҮ-д тавих үндсэн шаардлагууд, ТЭЗҮ хүлээж авах журам, Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын 2012 оны 74 дүгээр тушаал;
34. Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/181, А/458 дугаар хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралт;
35. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны А-138 дугаар тушаалын хавсралт;
36. Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт жендэрийн талаар баримтлах бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2019-2026), Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны 5 сарын 6-ны А/114 дүгээр тушаал, <https://mrpam.gov.mn/public/pages/45/bodlogo%20scan.pdf>;
37. Эрүүл мэндийн сайдын 2014 оны 413 тоот тушаал, Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал;
38. Засгийн газрын 2016 оны 179 дүгээр тогтоол, “Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай гэрээ”-ний загвар, <https://www.legalinfo.mn/law/details/11852>;
39. Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А-117 дугаар тушаал, Орчны эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ хүчингүй болох тухай, <https://www.legalinfo.mn/annex/details/5506?lawid=7492>;
40. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагааны журам, <http://www.mmhi.gov.mn/uploads/file/3d694e66524d40319ee9c3dba528c9d5972da627.pdf>;
41. 2005 оны Засгийн газрын 67 тоот захирамж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас шилжүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд дүн шинжилгээ хийх тухай, <https://www.legalinfo.mn/law/details/3022>;
42. Улсын бүртгэлийн нээлттэй мэдээллийн сан, www.opengovernment.mn;
43. Монгол Улсын Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт, хэлэлцүүлэг (UPR), <https://documents-dds-ny.un.org/doc/UNDOC/GEN/G20/061/32/PDF/G2006132.pdf?OpenElement>;
44. 2020 оны 2 дугаар сарын 10-нд Европын парламент ба Европын зөвлөлийн хамтран гаргасан Монгол Улсын 2018-2019 оны Тогтвортой хөгжил, сайн засаглалын чиглэлээрх олон улсын конвенцийн хэрэгжилтийн дүгнэлт, <https://ec.europa.eu/transparency/regdoc/rep/10102/2020/EN/SWD-2020-23-F1-EN-MAIN-PART-1.PDF>;
45. Монгол Улс ТТХТ төсвийн зардал ба эрсдэлийг удирдах нь тайлан 2019, ОУВС;
46. Төрийн өмчийн концессын төслийн аудитын үнэлгээ 2018, Үндэсний хөгжлийн газар;
47. Хүний эрхийн түгээмэл тунхаглал 1946, *Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 217/A/III/ тогтоолоор 1946 оны 12 дугаар сарын 10-ны өдөр*, <https://www.legalinfo.mn/law/details/1271>;
48. Байгаль орчны асуудлаар мэдээлэл авах, шийдвэр гаргахад оролцох, эрхээ хамгаалуулах талаарх ААРХУС-ын конвенц, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс (UNECE) 1998;
49. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Уугуул болон омгийн хүмүүсийн тухай 169 конвенци, ОУХБ (ILO) 1989;
50. Байгаль орчин ба хөгжлийн тухай Риогийн тунхаг, НҮБ-ын Байгаль орчин ба хөгжлийн хурал 1992;
51. Тогтвортой амьжиргааны арга зүй /ТAAЗ/, Хөдөөгийн тогтвортой амьжиргааны Зөвлөх хороо (Sustainable Rural Livelihoods Advisory Committee) 2000;
52. Даян дэлхийн гэрээ, НҮБ 2000;

53. Даян дэлхийн тайлагналтын санаачилга, БО хариуцлагатай санаачлага, Tellus, НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр (UNEP) 2014;
54. Эквадорын зарчим 2003, 94 санхүүгийн байгууллагууд 2003;
55. Байгаль орчин, Нийгмийн тогтвортой байдлын гүйцэтгэлийн стандарт, ОУСК 2012;
56. Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний зааварчилгаа, Европын Сэргээн босголт, хөгжлийн банк (ЕСБХБ/EBRD) 1998;
57. ISO 26000 - Нийгмийн хариуцлагын стандарт, ОУСБ 2010;
58. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын стандарт, ОҮИТБС 2019;
59. Хариуцлагатай уул уурхайн баталгаажилтын стандарт, Хариуцлагатай уул уурхайн баталгаажилтын санаачлага 2016;
60. Хариуцлагатай уул уурхайн индекс, Хариуцлагатай уул уурхайн нийгэмлэг 2020;
61. 10 зарчим, Уул уурхай ба металлын ОУ-ын зөвлөл 1998, 2003, 2020;
62. ОУ-ын Нийгмийн хариуцлага 8000 (SAI) 2008;
63. Үндэстэн дамнасан корпорациудын удирдамж, Эдийн засгийн хамтын ажиллагаа ба хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ) 1976, 2011;
64. Аюулгүй байдал ба хүний эрхийн сайн дурын зарчим, АНУ, ИВУИНВУ, олборлох салбарын компаниуд ба ИНБ-ууд хамтарсан 2000;
65. Хариуцлагатай уул уурхайн санаачилгын тунхаг бичиг, Уул уурхайн ассоиаци 2006;
66. Бизнес ба хүний эрхийн зарчим, НҮБ 2005;
67. Уул уурхайн тогтвортой хөгжлийн замын зураг: Атлас, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр 2016.